



БАЙГАЛЬ ОРЧИН,  
АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ЯАМ

KFW



# “ТӨСЛИЙН НЭГДҮГЭЭР ШАТАНД ТХГН-ИЙН ОРЧНЫ БҮСЭД ХЭРЭГЖҮҮЛСЭН ОБЗЭС-ИЙН ГҮЙЦЭТГЭЛД ХӨНДЛӨНГИЙН ҮНЭЛГЭЭ ХИЙХ ЗӨВЛӨХ ҮЙЛЧИЛГЭЭ”

## СУДАЛГААНЫ ТАЙЛАН

**ЗАХИАЛАГЧ:** БАЙГАЛЬ ОРЧИН, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ЯАМ, “БИОЛОГИЙН ОЛОН ЯНЗ БАЙДЛЫГ ХАМГААЛАХ, УУР АМЬСГАЛЫН ӨӨРЧЛӨЛТӨД ДАСАН ЗОХИЦОХ II, III” ТӨСӨЛ

**САНХҮҮЖҮҮЛЭГЧ:** ГЕРМАНЫ СЭРГЭЭН БОСГОЛТ ХӨГЖЛИЙН БАНК

**ХЭНЭЭС:** ЭС АЙ СИ ЭЙ ХХК



Энэхүү судалгааг Германы сэргээн босголт хөгжлийн банкны санхүүжилтээр хэрэгжиж буй “Биологийн олон янз байдлыг хамгаалах, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох” төслийн нэгдүгээр шатанд ТХГН-ийн орчны бүсэд хэрэгжүүлсэн ОБЗЭС-ийн гүйцэтгэлд хөндлөнгийн үнэлгээ хийх зөвлөх үйлчилгээний ажлын хүрээнд гүйцэтгэв.

Судалгааны мэдээллийг ашиглахтай холбоотой бүх эрхийг БОАЖЯ болон Төсөл хэрэгжүүлэх нэгж эзэмшинэ.

#### Судалгааны багийн ахлагч:

Ө.Амар

“Эс Ай Си Эй” ХХК - ийн Зөвлөх, Доктор

#### Судалгааны багийн гишүүд:

П.Цэрэнбазар

“Эс Ай Си Эй” ХХК - ийн Зөвлөх, Доктор

Г.Эрдэнэ

“Эс Ай Си Эй” ХХК - ийн Дэд захирал, Докторант

Э.Должин

“Эс Ай Си Эй” ХХК - ийн НЭЗСХ-ийн захирал, Докторант

Т.Пүрэвхүү

“Эс Ай Си Эй” ХХК-ийн Үйл ажиллагааны газрын захирал, Магистр

Х.Очирбат

“Эс Ай Си Эй” ХХК - ийн НЭЗСХ-ийн менежер

Б.Түмэндэлгэржав

“Эс Ай Си Эй” ХХК - ийн НЭЗСХ-ийн менежер

#### Мэдээлэл цуглуулалтын баг:

Б. Төрцэцэг

“Эс Ай Си Эй” ХХК - ийн МЦБХ-ийн захирал

Ө.Халиун

“Эс Ай Си Эй” ХХК - ийн МЦБХ-ийн менежер

Э.Доржханд

“Эс Ай Си Эй” ХХК - ийн МЦБХ-ийн менежер

Г.Хангал

“Эс Ай Си Эй” ХХК – ийн Хангамж, үйлчилгээний менежер

Ц.Нямжавдолгор

“Эс Ай Си Эй” ХХК - ийн Гэрээт судлаач

Д.Лхамноргим

“Эс Ай Си Эй” ХХК - ийн Гэрээт судлаач

## ТАЛАРХАЛ

Монгол Улсад хэрэгжиж буй олон төсөл хөтөлбөрүүдийн нэг болох “Биологийн олон янз байдлыг хамгаалах, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох” төслийн нэгдүгээр шатанд ТХГН-ийн орчны бүсэд хэрэгжүүлсэн ОБЗЭС-ийн гүйцэтгэлд хөндлөнгийн үнэлгээ хийсэн судалгааны тайланг хүргүүлж байна.

Уг үнэлгээний ажлыг гүйцэтгэх боломж олгосон болох “Биологийн олон янз байдлыг хамгаалах, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох II, III” төслийн баг, хамт олонд талархал илэрхийлье.

Судалгааны ажлын явцад арга зүйн дэмжлэг үзүүлсэн, зөвлөсөн, хамтран ажилласан багийн гишүүд болон зөвлөхүүддээ талархал илэрхийлье.

Судалгаанд идэвхтэй хамрагдаж, үнэт мэдээллээ хуваалцсан Архангай аймгийн Ихтамир, Цэнхэр сум, Өвөрхангай аймгийн Бат-Өлзий сум, Хөвсгөл аймгийн Улаан-Уул сум, Завхан аймгийн Их-Уул сумын ЗДТГ, ОБЗ, Төрийн банкны хамт олон болон малчин өрхүүдэд талархал илэрхийлье.

Судалгааны ажлын хамгийн чухал бөгөөд хариуцлагатай ажил бол мэдээлэл цуглуулах юм. Уг ажлыг чанарын өндөр түвшинд гүйцэтгэсэн мэдээлэл цуглуулагч нарт тусгайлан талархал илэрхийлье. Та бүхний хичээл зүтгэлээр энэхүү судалгааны үндсэн мэдээлэл цугларч, тайлан бичих боломж бүрдсэн билээ.

Төслийн багийн хамт олныг судалгааны үр дүнтэй танилцаж, өөрсдийн санал зөвлөмжийг нээлттэй ирүүлэхийг хүсье.

Хамтран ажиллаж байгаад талархал илэрхийлье

## ТОВЧИЛСОН ҮГИЙН ТАЙЛБАР

А данс	Мал тооллогын анхдагч мэдээллийн эх үүсвэр
БОАЖЯ	Байгаль орчин, аялал жуулчлалын яам
БЦГ	Байгалийн цогцолборт газар
ДЦГ	Дархан цаазат газар
ЗДТГ	Засаг даргын Тамгын газар
МАА	Мал аж ахуй
МЦБХ	Мэдээлэл цуглуулалт, боловсруулалтын хэлтэс
НЭЗСХ	Нийгэм, эдийн засгийн судалгааны хэлтэс
ОБ	Орчны бүс
ОБЗ	Орчны бүсийн зөвлөл
ОБЗЭС	Орчны бүсийн зээлийн эргэлтийн сан
ОХБЦГ	Орхоны хөндийн байгалийн цогцолборт газар
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани
ТХГН	Тусгай хамгаалалттай газар нутаг
ТХГНХЗ	Тусгай хамгаалалттай газар нутгийн захиргаа
ТХН	Төсөл хэрэгжүүлэх нэгж

## АГУУЛГА

ТАЛАРХАЛ.....	iv
ТОВЧИЛСОН ҮГИЙН ТАЙЛБАР .....	v
ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ .....	vii
ГРАФИКИЙН ЖАГСААЛТ .....	IX
ЗУРГИЙН ЖАГСААЛТ .....	xi
ШИГТГЭЭНИЙ ЖАГСААЛТ .....	xii
ХУРААНГУЙ.....	13
<b>БҮЛЭГ 1. СУДАЛГААНЫ АРГА ЗҮЙ .....</b>	<b>17</b>
1.1.    ЗОРИЛГО, ЗОРИЛТ .....	17
1.2.    ХАМРАХ ХҮРЭЭ .....	20
1.3.    АРГА ЗҮЙ.....	21
1.4.    МЭДЭЭЛЭЛ ЦУГЛУУЛАЛТЫН ЗОХИОН БАЙГУУЛАЛТ, ХЯНАЛТ .....	24
<b>БҮЛЭГ 2. ЗЭЭЛ ОЛГОЛТЫН ҮЙЛ ЯВЦ БОЛОН БАРИМТ БИЧГИЙН ШИНЖИЛГЭЭ ...</b>	<b>27</b>
2.1. ОБЗЭС-ТАЙ ХОЛБООТОЙ БАРИМТ БИЧГИЙН ШИНЖИЛГЭЭ .....	27
2.2. ТӨРИЙН БАНКНААС ГАРГАСАН ЗЭЭЛ ОЛГОЛТЫН ӨНӨӨГИЙН НӨХЦӨЛ БАЙДЛЫН ШИНЖИЛГЭЭ, УЯЛДАА ХОЛБОО.....	44
2.3. ЗОРИЛТОТ СУМДЫН МАЛЫН ТООНЫ ӨӨРЧЛӨЛТ .....	50
2.4. ЗЭЭЛ ОЛГОЛТЫН ҮЙЛ ЯВЦ ДАХ ОРОЛЦОГЧ ТАЛУУДЫН ҮҮРЭГ, ХАРИУЦЛАГЫН ҮНЭЛГЭЭ .....	52
2.5. МЭДЭЭЛЛИЙН ХҮРТЭЭМЖТЭЙ БАЙДАЛ .....	68
<b>БҮЛЭГ 3. ОРЧНЫ БҮСИЙН ЭРГЭЛТИЙН САНГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮНЭЛГЭЭ</b>	<b>72</b>
3.1. АРХАНГАЙ АЙМГИЙН ИХТАМИР СУМЫН ОРЧНЫ БҮСИЙН ЭРГЭЛТИЙН САНГИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ҮНЭЛГЭЭ .....	72
3.2. АРХАНГАЙ АЙМГИЙН ЦЭНХЭР СУМЫН ОРЧНЫ БҮСИЙН ЭРГЭЛТИЙН САНГИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ҮНЭЛГЭЭ .....	75
3.3. ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН БАТ-ӨЛЗИЙ СУМЫН ОРЧНЫ БҮСИЙН ЭРГЭЛТИЙН САНГИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ҮНЭЛГЭЭ .....	78
3.4. ЗАВХАН АЙМГИЙН ИХ-УУЛ СУМЫН ОРЧНЫ БҮСИЙН ЭРГЭЛТИЙН САНГИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ҮНЭЛГЭЭ .....	82
3.5. ХӨВСГӨЛ АЙМГИЙН УЛААН-УУЛ СУМЫН ОРЧНЫ БҮСИЙН ЭРГЭЛТИЙН САНГИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ҮНЭЛГЭЭ .....	85
3.6. ОБЗЭС-ИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ГҮЙЦЭТГЭЛИЙН ҮР ДҮН.....	89
3.7. СУРГАЛТЫН ҮНЭЛГЭЭ, ЦААШДЫН ХЭРЭГЦЭЭ ШААРДЛАГА.....	91
<b>БҮЛЭГ 4. ОРЧНЫ БҮСИЙН ЭРГЭЛТИЙН САНГИЙН ҮР НӨЛӨӨ .....</b>	<b>93</b>
4.1.    СУДАЛГААНД ОРОЛЦОГЧДЫН ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ.....	93
4.2. ОБЗЭС-ийн ЗЭЭЛИЙН ҮР ДҮН .....	97
4.3.    ЗЭЭЛДЭГЧДИЙН ЗЭЭЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНД ӨГСӨН СЭТГЭЛ ХАНАМЖИЙН ҮНЭЛГЭЭ .....	105
<b>БҮЛЭГ 5. САЙН ТУРШЛАГА, СУРГАМЖ, ЭРСДЭЛИЙН ШИНЖИЛГЭЭ .....</b>	<b>111</b>
5.1.    САЙН ТУРШЛАГА БОЛОН СУРГАМЖ .....	111
5.2.    ЭРСДЭЛИЙН ШИНЖИЛГЭЭ.....	115
<b>ДҮГНЭЛТ .....</b>	<b>124</b>
<b>САНАЛ ЗӨВЛӨМЖ.....</b>	<b>129</b>
<b>ХАВСРАЛТ.....</b>	<b>134</b>
ХАВСРАЛТ 1. САЙН ТУРШЛАГА БОЛОН СУРГАМЖ – ДЭЛГЭРЭНГҮЙ ҮР ДҮН .....	134

## ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

Хүснэгт 1. Үндсэн даалгавар болон мэдээлэл цуглуулалтын хүрээг тодорхойлсон байдал .....	17
Хүснэгт 2. Тоон судалгааны түүврийн хуваарилалт .....	23
Хүснэгт 3. Чанарын судалгааны түүврийн хуваарилалт .....	24
Хүснэгт 4. ОБЗЭС-ийн зээлийг дамжуулан зээлдүүлэх гэрээний агуулга .....	27
Хүснэгт 5. “Байгальд ээлтэй малчны зээл”-ийн удирдамж .....	28
Хүснэгт 6. Малчдын хувьд зээл авахад тавигдах нийтлэг шаардлага үзүүлэлтэд тулгардаг бэрхшээл, шийдвэрлэх боломж .....	31
Хүснэгт 7. Удирдамж 2021-ийн дагуу бичсэн ОБЗ-ийн үйл ажиллагааны тайланд хийсэн шинжилгээ, Бүлэг 1.3.1-ийн За-г харна уу. ....	34
Хүснэгт 8. ОБЗЭС-ийн хүүгийн орлогын зарцуулалтын тайлан, үлдэгдэл, төгрөгөөр, сум бүрээр .....	44
Хүснэгт 9. “Орчны бүсийн эргэлтийн сан”-аас олгосон нийт зээлийн хэмжээ, төгрөгөөр .....	45
Хүснэгт 10. 2021-2023 оны хооронд олгосон нийт зээлийн хэмжээ болон зээл авсан малчдын тоо .....	47
Хүснэгт 11. “Орчны бүсийн зээлийн эргэлтийн сан”-ийн зээлийн үлдэгдэл, сумаар, 2023 оны 07 сарын 31-ний өдрийн байдлаар .....	48
Хүснэгт 12. “Орчны бүсийн зээлийн эргэлтийн сан”-аас олгосон зээлийн зориулалт, давхардсан тоогоор, хувиар .....	49
Хүснэгт 13. ОБЗЭС-ийн зорилтот сумдын малын тооны өөрчлөлт .....	51
Хүснэгт 14. ОБЗ-ийн үйл ажиллагааны эрх, үүрэг, оролцоо, хариуцлагад хийсэн шинжилгээ, Бүлэг 1.3.1-ийн 3б хэсгийг харах. ....	53
Хүснэгт 15. Төрийн банкны эрх, үүрэг, оролцоо, хариуцлагад хийсэн шинжилгээ, Бүлэг 1.3.1-ийн 3б хэсгийг харах. ....	60
Хүснэгт 16. Тусгай хамгаалалттай газар нутгийн хамгаалалтын захиргааны эрх, үүрэг, оролцоо, хариуцлагад хийсэн шинжилгээ .....	64
Хүснэгт 17. ТХН болон төслийн зөвлөх багийн төлөөлөлтэй хийсэн ярилцлагад хийсэн дүн шинжилгээ.....	65
Хүснэгт 18. Их-Тамир сумын олгосон нийт зээлийн тоо, олгосон зээлийн хэмжээ, зээлийн үлдэгдэл, төгрөгөөр .....	72
Хүснэгт 19. Их-Тамир сумын зорилтот ашиг хүртэгчдийн зээлд хамрагдсан хувь .....	73
Хүснэгт 20. Их-Тамир сумын өргөдөл өгсөн малчдын тоо, зээл олгосон малчдын тоо, зээлийн нийт санхүүжилтэд эзлэх хувь.....	74
Хүснэгт 21. Их-Тамир сумын болон орчны бүсийн малын тооны өөрчлөлт, хонин толгойд шилжүүлснээр .....	75
Хүснэгт 22. Цэнхэр сумын олгосон зээлийн тоо, хэмжээ, үлдэгдэл, төгрөгөөр .....	76
Хүснэгт 23. Цэнхэр сумын зорилтот ашиг хүртэгчдийн зээлд хамрагдсан хувь .....	77
Хүснэгт 24. Цэнхэр сумын өргөдөл өгсөн малчдын тоо, зээл олгосон малчдын тоо, зээлийн нийт санхүүжилтэд эзлэх хувь.....	77
Хүснэгт 25. Цэнхэр сумын болон орчны бүсийн малын тооны өөрчлөлт, хонин толгойд шилжүүлснээр .....	78
Хүснэгт 26. Бат-Өлзий сумын олгосон зээлийн тоо, хэмжээ, үлдэгдэл, төгрөгөөр .....	79
Хүснэгт 27. Бат-Өлзий сумын зорилтот ашиг хүртэгчдийн зээлд хамрагдсан хувь .....	80
Хүснэгт 28. Бат-Өлзий сумын өргөдөл өгсөн малчдын тоо, зээл олгосон малчдын тоо, зээлийн нийт санхүүжилтэд эзлэх хувь.....	80
Хүснэгт 29. Бат-Өлзий сумын болон орчны бүсийн малын тооны өөрчлөлт, хонин толгойд шилжүүлснээр .....	81
Хүснэгт 30. Их-Уул сумын олгосон зээлийн тоо, хэмжээ, үлдэгдэл, төгрөгөөр.....	82
Хүснэгт 31. Их-Уул сумын зорилтот ашиг хүртэгчдийн зээлд хамрагдсан хувь.....	83
Хүснэгт 32. Их-Уул сумын өргөдөл өгсөн малчдын тоо, зээл олгосон малчдын тоо, зээлийн нийт санхүүжилтэд эзлэх хувь.....	84

Хүснэгт 33. Их-Уул сумын болон орчны бүсийн малын тооны өөрчлөлт, хонин толгойд шилжүүлснээр .....	85
Хүснэгт 34. Улаан-Уул сумын олгосон зээлийн тоо, хэмжээ, үлдэгдэл, төгрөгөөр .....	85
Хүснэгт 35. Улаан-Уул сумын зорилтот ашиг хүртэгчдийн зээлд хамрагдсан хувь .....	86
Хүснэгт 36. Улаан-Уул сумын өргөдөл өгсөн малчдын тоо, зээл олгосон малчдын тоо, зээлийн нийт санхүүжилтэд эзлэх хувь.....	87
Хүснэгт 37. Улаан-Уул сумын болон орчны бүсийн малын тооны өөрчлөлт, хонин толгойд шилжүүлснээр .....	88
Хүснэгт 38. ОБЗЭС-ийн үйл ажиллагааны гүйцэтгэлийн нэгтгэсэн үр дүн.....	89
Хүснэгт 39. Судалгаанд оролцогчдын ерөнхий мэдээлэл, n=107.....	93
Хүснэгт 40. Зээл авч байсан туршлага, арилжааны банкны төрлөөр .....	94
Хүснэгт 41. Сайн туршлага болон сургамжийг нэгтгэсэн хураангуй үр дүн .....	111
Хүснэгт 42. Эрсдэлийн шинжилгээ .....	115



## ГРАФИКИЙН ЖАГСААЛТ

График 1. “Орчны бүсийн зээлийн эргэлтийн сан”-аас олгосон нийт зээлд сумуудын олгосон зээлийн эзлэх хувь, оноор .....	46
График 2. “Орчны бүсийн эргэлтийн сан”-ийн зээлийн үлдэгдэл, төгрөгөөр .....	47
График 3. Малынхаа үүлдэр, угсаа, чанарыг сайжруулах зорилгоор олгосон зээлд сумуудын эзлэх хувь .....	50
График 4. Зээлийн хүсэлт гаргасан ч, татгалзсан хариу авсан малчдын төлөөлөл, татгалзсан хариу авсан байдал.....	67
График 5. ОБЗЭС-ийн мэдээллийг хаанаас авсан бэ, n=76 .....	69
График 6. Орчны бүсийн зээлийн эргэлтийн сан”-ийн “Байгальд ээлтэй малчны зээл”-ийн талаар сонсож байсан эсэх, n=31 .....	69
График 7. Мэдээлэл түгээлт оновчтой байсан эсэх, n=107, (үнэлгээний дээд утга 5) ...	70
График 8. Цаашид мэдээллийг хэрхэн түгээх нь зүйтэй гэж үзэж байна вэ, n=76.....	70
График 9. Цаашид мэдээллийг хэрхэн түгээх нь зүйтэй гэж үзэж байна вэ, n=31(зээл аваагүй малчин өрх), хувиар .....	71
График 10. Их-Тамир сумын ОБЗЭС-аас олгосон зээлийн зориулалт, хувиар .....	73
График 11. Их-Тамир сумын ОБЗЭС-ийн олгосон нийт зээлийн хэмжээ болон эргэн төлөлтийн хэмжээ, сая төгрөгөөр.....	74
График 12. Цэнхэр сумын ОБЗЭС-аас олгосон зээлийн зориулалт, хувиар.....	76
График 13. Цэнхэр сумын ОБЗЭС-ийн нийт олгосон зээлийн хэмжээ болон эргэн төлөлтийн хэмжээ, сая. төгрөг.....	78
График 14. Бат-Өлзий сумын ОБЗЭС-аас олгосон зээлийн зориулалт, давхардсан тоогоор.....	79
График 15. Бат-Өлзий сумын ОБЗЭС-ийн нийт олгосон зээлийн хэмжээ болон эргэн төлөлтийн хэмжээ, сая. төгрөг.....	81
График 16. Их-Уул сумын ОБЗЭС-аас олгосон зээлийн зориулалт, хувиар.....	83
График 17. Их-Уул сумын ОБЗЭС-ийн олгосон нийт зээлийн хэмжээ болон эргэн төлөлтийн хэмжээ, сая.төгрөгөөр.....	84
График 18. Улаан-Уул сумын ОБЗЭС-аас олгосон зээлийн зориулалт, хувиар .....	86
График 19. Улаан-Уул сумын ОБЗЭС-ийн зээлийн эргэн төлөлтийн хувь, оноор .....	87
График 20. ОБЗЭС-ийн талаар ойлголт өгөх сургалтад хамрагдсан эсэх, n=76 .....	91
График 21. Сургалтын хэрэгцээ, шаардлага, n=76 .....	92
График 22. Сургалтын хэрэгцээ, шаардлага, n=31 (зээл аваагүй малчин өрх), хувиар .	92
График 23. Зээл авч байсан туршлага, n=76, хувиар.....	94
График 24. Төрийн банкнаас зээл авч байсан зээлийн зориулалт, n=76.....	94
График 25. ОБЗЭС-аас ямар зорилгоор зээл авсан бэ, n=76.....	95
График 26. Зээлээ зориулалтын дагуу ашигласан эсэх, n=76.....	96
График 27. Зээлээ зориулалтын дагуу зарцуулсан бол юу худалдаж авсан бэ, n=74 ...	96
График 28. ОБЗЭС-аас хүссэн хэмжээгээрээ зээл авч чадсан эсэх, n=76.....	97
График 29. Хүссэн хэмжээгээрээ зээл авч чадаагүй бол шалтгаан нь юу вэ?, n=13 .....	97
График 30. Судалгаанд хамрагдсан малчин өрхүүдийн малын тооны дундаж өөрчлөлт, хувиар .....	98
График 31. Судалгаанд хамрагдсан малчин өрхүүдийн малын тооны бууралт, хонин толгойд шилжүүлсэн дүнгээр .....	98
График 32. Судалгаанд хамрагдсан малчин өрхүүдийн малын тооны бууралт болон зарсан малын тоо.....	99
График 33. Зээл авсан малчин өрхүүдийн малын тооны өөрчлөлт, оноор, сумдаар, хувиар .....	99
График 34. Малын тоо бууруулах зорилгоо биелүүлсэн байдал, зээл авсан оноор .....	100
График 35. Судалгаанд хамрагдсан зээл аваагүй малчин өрхүүдийн малын тооны өөрчлөлт, хувиар,.....	100

График 36. Зээл авсан болон зээл аваагүй малчин өрхүүдийн малын тооны өөрчлөлт, хувиар.....	101
График 37. Зээл авсан болон зээл аваагүй малчин өрхүүдийн малын тооны өөрчлөлт, хонин толгойд шилжүүлсэн дүнгээр, А дансны мэдээллээр.....	101
График 38. Малчин өрхийн орлого, сая төгрөгөөр, n=107 .....	102
График 39. Зээлийн нөлөө, хувиар, n=107.....	102
График 40. Танайх МАА-с гадна орлогын өөр эх үүсвэртэй юу?, n=107, хувиар.....	103
График 41. Малчин өрхүүдэд бий болсон зэрэг нөлөө, n=76 .....	104
График 42. Малчин өрхүүдэд бий болсон сөрөг нөлөө, n=76 .....	104
График 43. ОБЗЭС-ийн зээлийн байгаль орчинд үзүүлсэн нөлөө, n=76.....	105
График 44. ОБЗЭС-ийн зээлийг санхүүжүүлэгчийн талаар мэдэх эсэх, n=76 .....	105
График 45. ОБЗЭС-ийн зээлийн зорилгыг мэдэх эсэх, n=76 .....	106
График 46. ОБЗЭС-аас зээл авахад ямар нэгэн хүндрэл, бэрхшээл учирсан эсэх, n=76 .....	106
График 47. “Байгальд ээлтэй малчны зээл”-ийн зээл авсан малчид малын тоог 5 хувь бууруулах үүргээ биелүүлсэн эсэх, n=76 .....	107
График 48. Зээлтэй холбоотой сэтгэгдэл, хувиар, n=76 .....	107
График 49. Ямар нэгэн нөхцөл таалагдаагүй бол шалтгаан нь юу вэ, n=19.....	107
График 50. Сэтгэл ханамжийн үнэлгээ, n=76 (үнэлгээний дээд утга 5).....	108
График 51. Сэтгэл ханамжийн үнэлгээ, n=31(зээл аваагүй малчин өрх(үнэлгээний дээд утга 5)) .....	108
График 52. ОБЗЭС-ийн зээлийн шалгуурын талаарх сэтгэгдэл, n=107 .....	109
График 53. “Орчны бүсийн зээлийн эргэлтийн сан”-ийн хүрээнд байгаль хамгаалах, малчдын амьжиргааг нэмэгдүүлэх холбоо хамаарлыг сайжруулахын тулд юу хийх шаардлагатай гэж үзэж байна вэ, n=107 .....	110

# ЗУРГИЙН ЖАГСААЛТ

Зураг 1. Судалгааны хамрах хүрээ, газар зүйн байршлаар..... 20

Зураг 2. Зээл авсан болон аваагүй малчин өрхүүдийн өмнөх болон дараах шинжилгээ22

Зураг 3. Мэдээлэл цуглуулалт, боловсруулалтын үе шат дараалал ..... 25

Зураг 4. Зээлийн сонгон шалгаруулалтыг зохион байгуулах үе шат ..... 30

Зураг 5. Архангай аймгийн Их-Тамир сум, Хөхнуур багт байрлуулсан мэдээллийн самбар, таних тэмдэг ..... 39

Зураг 6. Хан-Өндөр багийн нутаг дэвсгэрт байрлуулсан мэдээллийн самбар, таних тэмдэг ..... 40

Зураг 7. Архангай аймгийн Цэнхэр сум, Орхон багийн орчны бүс нутаг “Эх тээл”-д байрлуулсан мэдээллийн самбар, таних тэмдэг ..... 40

Зураг 8. Архангай аймгийн Цэнхэр сум, “Ширдэгийн голын Согоот”-д байрлуулсан мэдээллийн самбар, таних тэмдэг ..... 41

Зураг 9. Архангай аймгийн Цэнхэр сумын ОБЗ-ийн гишүүдийн зээлийн гэрээний биелэлтэд хяналт мониторинг, малчдад зээлийн талаар сурталчилж байгаа байдал .. 41

Зураг 10. Бат-Өлзий сумын байгаль хамгаалах чиглэлээр хийсэн ажил ..... 42

## ШИГТГЭЭНИЙ ЖАГСААЛТ

Шигтгээ 1. Чанарын судалгаанд оролцогч ОБЗ-ийн даргын сэтгэгдлээс.....	52
Шигтгээ 2. Чанарын судалгаанд оролцогч ОБЗ-ийн даргын сэтгэгдлээс.....	58
Шигтгээ 3. Чанарын судалгаанд оролцсон зээл аваагүй малчин иргэдийн төлөөлөл....	67
Шигтгээ 4. Чанарын судалгаанд оролцогч Төрийн банкны төлөөлөл .....	67
Шигтгээ 5. Чанарын судалгаанд оролцогч ОБЗ-ийн төлөөлөл .....	67
Шигтгээ 6. Чанарын судалгаанд оролцогч Хамгаалалтын захиргааны мэргэжилтний сэтгэгдэл.....	68
Шигтгээ 7. Чанарын судалгаанд оролцогч Хамгаалалтын захиргааны мэргэжилтний сэтгэгдэл.....	68

## ХУРААНГУЙ

“Биологийн олон янз байдлыг хамгаалах, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох төслийн I үе шатанд ТХГН-ийн орчны бүсэд хэрэгжүүлсэн ОБЗЭС-ийн гүйцэтгэлд хөндлөнгийн үнэлгээ хийх” зөвлөх үйлчилгээний ажлын хүрээнд төсөл хэрэгжсэн зорилтот 5 сумын ОБЗЭС-ийн үйл ажиллагаа, орчны бүсэд амьдардаг малчдын тогтвортой амьжиргааг дэмжих, малын тоо толгойг бууруулах, бэлчээрийн чанарыг сайжруулахад дэмжлэг үзүүлэх зорилгоор олгосон зээлийн гүйцэтгэлийг үнэлэхийг зорьсон болно. Уг зорилгын хүрээнд зээл олголтын үйл явц болон зээл олгосноор бий болсон үр нөлөө, сум бүрийн ОБЗЭС-ийн үйл ажиллагааг үнэлэх, сайн туршлага болон сургамжуудыг нэгтгэн дүгнэлээ. Зээл олголтын үйл явцыг үнэлэхдээ ОБЗЭС-ийн үйл ажиллагаатай холбоотой бүхий л баримт бичгүүдэд шинжилгээ хийх, мөн оролцогч талуудыг хамруулан ганцаарчилсан болон бүлгийн ярилцлага (чанарын судалгаа) хийх аргыг ашиглан гүйцэтгэсэн бол, ОБЗЭС-ийн үр нөлөөг үнэлэхдээ малчдаас асуулгын аргаар судалгаа авч, малчин өрхийн орлого зээл авахаас өмнө болон авсны дараа хэрхэн өөрчлөгдсөнийг төслийн өмнө болон дараа шинжилгээг ашиглан хийж гүйцэтгэлээ. Ингэхдээ зээл авсан малчин өрхийн зээлийн өмнөх болон дараах орлогын өөрчлөлтийг зээл аваагүй малчин өрхүүдийн тухайн цаг хугацаатай ижил хугацаан дахь орлогын өөрчлөлттэй харьцуулж, зээлээс бий болж байгаа цэвэр өгөөжийг тооцон гаргасан болно. Мөн сум бүрийн ОБЗЭС-ийн үйл ажиллагааг үнэлэхдээ “Байгальд ээлтэй малчны зээл”-ийн удирдамжийн 5.13 заалтад үндэслэн гүйцэтгэлээ.

ОБЗЭС-ийн гүйцэтгэлд хөндлөнгийн үнэлгээ хийхдээ тоон судалгаанд зээлд хамрагдсан малчдын 42.7 хувийг хамруулсан бол, чанарын судалгааны ганцаарчилсан ярилцлагад оролцогч талуудын төлөөлөл 40 хүн, 5 фокус бүлгийн ярилцлагад ойролцоогоор 150 орчим хүнийг хамруулан төслийн зээлийн хэрэгжилтийн байдал, мэдээлэл түгээлт, зорилтот бүлэгтээ хүрч байгаа эсэх, учирсан хүндрэл бэрхшээл, сайн туршлага, сургамж зэргийн талаар тодрууллаа. Үнэлгээний явцад гарсан үр дүнгүүдийг хураангуйлан хүргэж байна. Үүнд:

- Энэхүү төсөл амжилттай хэрэгжихэд ОБЗ-ийн дарга, гишүүдийн үйл ажиллагаа чухал хүчин зүйл болжээ. Тухайлбал, зээлийн талаарх ерөнхий мэдээллийг малчдад хүргэх, зээлийн материал хүлээж авч байгаа талаарх зарыг багийн даргаар нь дамжуулан орчны бүсэд амьдарч байгаа малчдад цаг алдалгүй хүргэх, зээлийн зарцуулалтад хяналтыг тогтмол хийх зэрэг үйл ажиллагаа нь төслийг амжилттай хэрэгжихэд нөлөөлсөн байна.
- “Дамжуулан зээлдүүлэх гэрээ”-ний 1.1 хэсгийн орчны бүсийн малчин, мал бүхий иргэдэд гэж зааж өгсөн нь “Байгальд ээлтэй малчны зээл”-ийн 1.5 хэсэгт заасан малчид, малчны бүлэгт зээлийг олгоно гэсэн заалттай зөрчилдөж байв.
- “Дамжуулан зээлдүүлэх гэрээ”-ний 5.4.3 заалт болох орчны бүсийн иргэдээс зээлийн хүсэлтийг хүлээн авч сард 1-ээс доошгүй удаа хуралдана гэсэн заалт нь “Байгальд ээлтэй малчны зээл”-ийн заалтын 6.2 заалт болох ОБЗ нь иргэдээс материалыг хүлээн авч, сард 2-оос доошгүй хуралдана гэсэн заалтууд нь зөрчилдөж байв.

- ОБЗ-ийн хувьд үйл ажиллагааны тайлан бичих ерөнхий загвар байхгүй тул сумуудын ОБЗ-ийн бичсэн тайлан нь агуулгын хувьд ялгаатай байгаа нь үнэлгээ хийхэд хүндрэл учруулж байв.
- ОБЗЭС-ийн 1.5 хувийн хүүгийн орлогоор ОБЗ-ийн үйл ажиллагааг санхүүжүүлэх бөгөөд үнэлгээний үр дүнд хүүгийн орлогын 53.9 хувийг ОБЗ-ийн үйл ажиллагаанд, 39.7 хувийг байгаль орчныг хамгаалах чиглэлээр зарцуулсан байсан нь “Байгальд ээлтэй малчны зээл”-ийн удирдамжид заасан заалттай нийцэж байв.
- ОБЗ-үүд байгаль орчныг хамгаалах чиглэлээр ТХГН-ийн хил хязгаарыг заасан мэдээллийн болон таних тэмдгийн самбар, хилийн багана хийх, мөн нийгэмд чиглэсэн дараах ажлуудыг хийж гүйцэтгэжээ. Үүнд: Малчдын дунд “Бид өөрсдөө байгаль хамгаалагчид” хэлэлцүүлэг, сургууль, цэцэрлэгийн хүүхдүүдийн дунд “Цэнхэр алтаа хайрлая” сэдвийн дор гар зураг, эсээ бичлэгийн уралдаан, сумынхаа амьжиргааны түвшин доогуур айл өрхийн хүүхдүүдэд хичээлийн хэрэгсэл олгох, мэдээллийн брошур тараах зэрэг үйл ажиллагаануудад зарцуулжээ.
- ОБЗЭС-ийн зээлийн үйл ажиллагааг Төрийн банкаар дамжуулан малчдад олгосон бөгөөд 2023 оны 07 сарын 31-ний байдлаар 5 сумын 289 малчдад нийтдээ 2.5 тэрбум гаруй төгрөгийг олгож, 242 зээлдэгчийн 1.28 тэрбум төгрөгийн үлдэгдэлтэй байгаа ба энэхүү үлдэгдэл нь зээлийн эргэн төлөлтийн хуваарийн дагуу төлөгдөх, хэвийн ангилалд байгаа зээл болно.
- ОБЗЭС-аас олгосон нийт зээлийн 40.9 хувийг малынхаа үүлдэр, угсааг сайжруулах зорилгоор авсан малчдын зээл эзэлж байгаа нь тус зээлийн зорилготой нийцэж байна.
- Төсөл хэрэгжсэн сумдын малын тоо хонин толгойд шилжүүлсэн дүнгээр 5.5 хувиар өссөн бол, орчны бүсийн малын тооны өсөлт 3.2 хувьтай байв.
- Судалгаанд хамрагдсан зээл авсан малчин өрхүүдийн малын тоо хонин толгойд шилжүүлсэн дүнгээр 7.7 хувиар буурсан бол, зээл аваагүй малчин өрхүүдийн малын тоо хонин толгойд шилжүүлснээр 5.6 хувиар өссөн байгаагаас харахад зээл нь малчдын хувьд малын тоогоо бууруулах хөшүүрэг болж байгаа нь харагдаж байна.
- Судалгаанд хамрагдсан малчин өрхүүдийн малын тооны бууралтын 54.9 хувийг зах зээлд борлуулсан малын тоо эзэлж байгаа бол, 55.1 хувийг бусад хүчин зүйлийн нөлөө эзэлж байна.
- Судалгаанд хамрагдсан зээл авсан малчин өрхүүдийн орлого дунджаар 3.8 хувь өссөн байхад зээл аваагүй малчин өрхүүдийн орлого 0.1 хувь өсөж, зээл авсан малчдын хувьд зээлийн нөлөөгөөр 3.7 хувийн орлогын эерэг өөрчлөлт бий болжээ.
- Малчдын хувьд ОБЗЭС-ийн зээлийн хүүгийн төлөлтийг сар бүр төлөх нь хүндрэл учруулдаг байна. Учир нь зарим үед сүлжээгүй, сумын төвөөс хол газар нүүдэллэх нь зээлийн хүүг сар бүр төлж чадахгүйд хүргэдэг.
- Сум болон орчны бүс, зээл аваагүй малчин өрхүүдийн хувьд малын тоо нь өссөн байхад, зээл авсан малчин өрхүүдийн малын тоо буурсан байдлаас харахад зээл

нь малын тоог бууруулах бодит хөшүүрэг болж, бэлчээрийн талхлалт болон бэлчээрийн даацыг бууруулахад тодорхой хэмжээнд хувь нэмрээ оруулж байна гэж дүгнэж байна.

Тиймээс дараах саналуудыг цаашид үйл ажиллагаандаа тусган ажиллах шаардлагатай. Үүнд:

- ОБЗЭС-ийн үйл ажиллагааг зохицуулахтай холбоотой үндсэн баримт бичгүүд болох “Дамжуулан зээлдүүлэх гэрээ” болон “Байгальд ээлтэй малчны зээл”-ийн удирдамжид хийсэн шинжилгээний үр дүнд нэр томъёоны тайлбарт оролцогч талуудын тайлбарыг бүрэн тусгаагүй, зөрчилдөж байгаа зүйл заалтуудыг засварлах, үндсэн оролцогч тал болох малчид гэдэгт хэнийг ойлгох талаарх ойлголтыг нэр томъёоны тайлбар хэсэгт оруулж өгөх шаардлагатай.
- Зээл олгох зориулалтыг нарийвчилж өгөх шаардлагатай. Ялангуяа МАА-н бүтээгдэхүүний нийлүүлэлтийн сүлжээнд оролцох, малаас өөр орлогын шинэ эх үүсвэрийг бий болгох дэд төслүүдийг илүү дэмжиж ажиллах. Мөн байгаль орчныг хамгаалах зорилготой дэд төслүүдийг санхүүжүүлэх, байгаль орчныг хамгаалах чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа иргэн, ААН-үүдийг дэмжих.
- Малчдын хувьд зээлийн хүүг сар бүр төлөх нь сүлжээгүй, сумын төвөөс хол газар нүүдэллэх нь зээлийн хүүг сар бүх төлж чадахгүйд хүргэх эрсдэлтэй байгаа тул цаашид оролцогч талууд хамтран, харилцан тохиролцож, зээлийн хүүг, зээлийн үндсэн төлөлтийн хамт хуваан төлөх боломжийг олгох.
- Өнгөрсөн 2 жилийн хугацаанд төсөл хэрэгжиж байгаа сумуудын орчны бүсэд нийтдээ 816 өрх амьдарч байгаагийн 35.4 хувь нь ОБЗЭС-ийн зээлд хамрагджээ. Гэвч орчны бүсэд амьдардаггүй ч, мал нь орчны бүс рүү бэлчээрлэдэг, орчны бүсийн хил заагт амьдарч байгаа малчин өрхүүд зээлд хамрагдах хүсэлтэй байдаг ч, орчны бүсэд багтдаггүй учраас хамрагдаж чаддаггүй. Тиймээс энэхүү нөхцөл байдлыг ТХН-ийн зүгээс харгалзан үзэх. Мөн нэг удаа зээл авсан малчин өрх дахин зээл авч болох эсэх талаар удирдамжид тодорхой тусгах.
- Төслийн оролцогч талуудыг үүрэг, хариуцлага маш чухал бөгөөд ялангуяа Төрийн банк, ОБЗ-ийн үйл ажиллагаа нь ОБЗЭС амжилттай хэрэгжихэд маш чухал нөлөөтэй байгаа тул ОБЗ-ийн гишүүдийг мэдээллээр бүрэн хангах, ОБЗ-ийн гишүүд ямар үүрэг, хариуцлагатай болох болох талаар сургалт өгөх. Учир нь ОБЗ-ийн гишүүд зээл олгох хурал зохион байгуулах, зээлийн мониторинг хийх үүргээс өөр бусад үүргийн талаарх мэдээлэл дутмаг байсан.
- ОБЗ-ийн үйл ажиллагааны тайлан бичих ерөнхий загвартай болохоос гадна, ОБЗ-ийн гишүүдэд тайлан хэрхэн бичих талаар сургалт явуулах зэрэг саналуудыг дэвшүүлж байна (дэлгэрэнгүйг “Санал” хэсгээс харна уу).

Малчдын хувьд малын тоогоо бууруулж, богино хугацаанд малаа эргэлдүүлэх нь ерхийн орлогыг нэмэгдүүлэхээс гадна, бэлчээрийн даац, доройтлыг багасгахад чухал нөлөөтэй юм байна, олон тооны их малтай байхаас илүүтэй цөөн тооны, чанартай малтай болох нь зөв юм байна гэсэн ойлголттой болсон нь ОБЗЭС-ийн эхний шатны судалгааны үр дүнгээр батлагдсан. ОБЗЭС-ийн “Байгальд ээлтэй малчны зээл” нь малчдын хувьд малын тоогоо бууруулах хөшүүрэг болж байгаа нь судалгаанд

хамрагдсан зээл авсан малчин өрхүүдийн малын тооны бууралтаас харагдаж байна. Тиймээс цаашид байгаль орчныг хамгаалах, бэлчээрийн даацыг багасгах зорилгоор малын тоог 5 хувь бууруулах шалгуурыг баримтлах нь зөв бөгөөд үүнийг зөвхөн зах зээлд борлуулсан малын тоогоор хэмжих нь малын тоог бодитоор бууруулах боломжийг олгож байна. “Байгальд ээлтэй малчны зээл”-ийн удирдамжийн дагуу малчид зах зээлд борлуулсан малдаа мал эмнэлэг, үржлийн албаны гэрчилгээ авч, энэхүү гэрчилгээгээр зах зээлд борлуулсан малын тооны бууралтыг баталгаажуулна гэж байгаа хэдий ч, малчид энэхүү гэрчилгээг авч хэвшээгүй байна. Тиймээс зээл авсан малчдын малын тооны бууралтыг энэхүү гэрчилгээгээр баталгаажуулахын тулд ТХН болон ОБЗ, Төрийн банкнаас хяналтыг тогтмол хийж, гэрчилгээний дүнгээр буурсан малчдын зээлийг хэвээр хадгалан үлдээх заалтын хэрэгжилтийг хангах хэрэгтэй байна.

Тиймээс цаашид төслийг үргэлжлүүлэн хэрэгжүүлэхдээ төслийн үндсэн зорилгоо биелүүлэхийн тулд орчны бүсэд амьдарч байгаа малчдад зээлийг үргэлжлүүлэн олгохоос гадна, малын гаралтай түүхий эдийг боловсруулах, нийлүүлэлтийн сүлжээнд оролцох сонирхлыг нэмэгдүүлэх дэд төслүүдэд зээлийг олгох нь илүү үр дүнтэй байна. Мөн байгаль орчныг хамгаалах, байгаль орчинд ээлтэй үйл ажиллагаа явуулж байгаа иргэд, ААН, ТББ, малчдын бүлэгт зээлийг олгох нь зүйтэй гэж үзэж байна. Энэ нь орон нутгийн малчдын тогтвортой амьжиргааг дэмжихэд чухал нөлөөтэй.



# БҮЛЭГ 1. СУДАЛГААНЫ АРГА ЗҮЙ

## 1.1. ЗОРИЛГО, ЗОРИЛТ

“Биологийн олон янз байдлыг хамгаалах, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох төсөл”-ийн I үе шатанд ТХГН-ийн орчны бүсэд хэрэгжүүлсэн ОБЗЭС-ийн гүйцэтгэлд хөндлөнгийн үнэлгээ хийх” зөвлөх үйлчилгээний ажлын хүрээнд төсөл хэрэгжсэн зорилтот 5 сумын ОБЗЭС-ийн үйл ажиллагаа, орчны бүсэд амьдардаг малчдын тогтвортой амьжиргааг дэмжих, малын тоо толгойг бууруулах, бэлчээрийн чанарыг сайжруулахад дэмжлэг үзүүлэх зорилгоор олгосон зээлийн гүйцэтгэлийг үнэлэх ба энэхүү зорилгын хүрээнд зээл олголтын үйл явц, зээл олгосноор малчдад бий болсон үр нөлөөг үнэлэх, сум бүрийн ОБЗЭС-ийн үйл ажиллагааг үнэлэх, сайн туршлага болон сургамжуудыг тодорхойлохыг зорилоо.

Зээл олголтын үйл явцыг үнэлэхдээ төслийн үйл ажиллагаатай холбоотой статистик тоо мэдээ бүхий тайлан, баримт бичгүүдийг судалж, шүүмжлэлтэй хянан үзэхээс гадна, ОБЗЭС-ийн үндсэн баримт бичгүүд болох “Дамжуулан зээлдүүлэх гэрээ” болон “Байгаль орчинд ээлтэй малчны зээл”-ийн удирдамжийн дагуу ОБЗЭС-ийн зохион байгуулалт, төслийн үйл ажиллагаанд үүрэг хүлээсэн оролцогч талуудын үүрэг, хариуцлагыг үнэлнэ.

ОБЗЭС-ийн үр нөлөөг үнэлэхдээ зээл авсан малчдын амьжиргаа болон малын тоо толгойн бууралтад хэрхэн нөлөөлснийг үнэлэхээс гадна, ОБЗЭС-ийн үйл ажиллагааг үнэлэхдээ “Байгальд ээлтэй малчны зээл”-ийн удирдамж 5.13 заалтын дагуу үнэлэх юм. Эцэст нь төслөөс бий болсон сайн туршлага, сургамжуудыг тодорхойлохыг зорилоо.

Энэхүү зорилгын хүрээнд ажлын даалгаврын дагуу гүйцэтгэх ажил болон тоон мэдээллийг хэрхэн яаж, хаанаас цуглуулах, асуумжийн агуулгын хүрээг дараах байдлаар тодорхойлсон.

### Хүснэгт 1. Үндсэн даалгавар болон мэдээлэл цуглуулалтын хүрээг тодорхойлсон байдал

Даалгавар	Мэдээллийн эх үүсвэр	Судалгааны арга	Асуултын агуулга	Тайлангийн бүлэгтэй уялдах байдал
<b>А. Зээл олголтын үйл явцад үнэлгээ өгөх</b>				
<b>А.1 ОБЗЭС болон холбогдох статистик бүхий бэлэн тайлан, баримт бичгүүдийг судалж, шүүмжлэлтэй хянан үзэх.</b>				
1. ОБЗЭС-ийн гэрээ болон удирдамж (2021)	ОБЗЭС-ийн гэрээ, удирдамж	Баримт бичгийн шинжилгээ	- Ажлын цар хүрээг тодорхойлсон - Асуулгын хүрээг тодорхойлох	Дэд бүлэг 2.1.1 болон 2.1.2
2. Төрийн банкнаас гаргасан нийт зээлийн тоо, зорилго, эргэн төлөлт, найдваргүй зээлдэгчдийн мэдээлэл	Төрийн банк	Баримт бичгийн шинжилгээ	Зөвлөх баг хээрийн судалгаанд явж байхдаа сумдын Төрийн банкнаас мэдээллийг авна.	Дэд бүлэг 2.2
3. ОБЗ-ийн зээл горилогчдыг хэрхэн шалгаруулж, сонгосон тухай тайлан, мөн татгалзсан зээлийн хүсэлтэй холбоотой	ОБЗ-ийн тайлан	Баримт бичгийн шинжилгээ	Зөвлөх баг хээрийн судалгаанд явж байхдаа сумдын Төрийн банкнаас мэдээллийг авна.	Дэд бүлэг 2.1.3

Даалгавар	Мэдээллийн эх үүсвэр	Судалгааны арга	Асуултын агуулга	Тайлангийн бүлэгтэй уялдах байдал
бармт бичгүүд (хурлын тэмдэглэл, протокол)				
4. Удирдамж 2021-ийн 5.12-ийн дагуу бичсэн ОБЗ-ийн тайлан	ОБЗ-ийн тайлан	Баримт бичгийн шинжилгээ	Зөвлөх баг хээрийн судалгаанд явж байхдаа сумдын Төрийн банкнаас мэдээллийг авна.	Дэд бүлэг 2.1.4
5. Зээлийн 1.5 хувийн хүүг хэрхэн ашиглаж байгаа тухай мэдээлэл, (60 хүртэлх хувийг ОБЗ-ийн үйл ажиллагаанд хэрхэн зарцуулж байгаа, 40 - өөс доошгүй хувийг ТХГН-ийн Орчны бүсийн хуулийн 7.4.1-7.4.5-д заасны дагуу зарцуулсан тайлан)	ОБЗ-ийн тайлан болон зарцуулалтын тайлан	Баримт бичгийн шинжилгээ	Зөвлөх баг хээрийн судалгаанд явж байхдаа сумдын Төрийн банкнаас мэдээллийг авна.	Дэд бүлэг 2.1.5
6. Зорилтот сумдын малын тоо	"А" данс, 1212.mn	Харьцуулсан шинжилгээ	Зээл хэрэгжиж эхлэхээс өмнө болон зээл хэрэгжиж эхэлсний дараах малын тоог сумын хэмжээнд харьцуулах.	Дэд бүлэг 2.3
<b>A.2 Дамжуулан зээлдүүлэх гэрээ болон "Байгаль орчинд ээлтэй малчны зээл"-ийн удирдамжийн дагуу ОБЗЭС, зохион байгуулалт, үйл ажиллагаанд үүрэг хүлээсэн талуудын оролцоо, үүрэг, хариуцлагыг үнэлэх.</b>				
1. Орчны бүсийн зөвлөл, Сумын ЗДТГ-ын төлөөлөл, Хамгаалалтын захиргааны дарга, мэргэжилтний төлөөлөлтэй ярилцах.	Чанарын судалгаа	Ганцаарчилсан ярилцлагын арга (KII)	Зээлийн 1.5 хувийн хүүгийн зарцуулалтын талаар: 40-өөс доошгүй хувийн зарцуулалт: ТХГН-ийн Орчны бүсийн тухай хуулийн 7.4.1-7.4.5-ийн заалтын дагуу зарцуулсан тайлан. 60 хүртэл хувийг зарцуулсан зарцуулалт: - ОБЗ-ийн уулзалтад оролцох тээврийн зардал - Хяналт шинжилгээ хийх зорилгоор ажилласан үйл ажиллагаанд зарцуулсан зарцуулалтын тайлан.	Дэд бүлэг 2.4.1
2. Төрийн банк: Төрийн банкны төв оффис болон 5 сумын банкны салбарын хүмүүстэй ярилцах.	Чанарын судалгаа: Төрийн банкны төв оффис болон салбарын төлөөлөл	Ганцаарчилсан ярилцлагын арга (KII)	Төрийн банкны гэрээгээр хүлээсэн үүрэг, гэрээний талуудад сар бүрийн 5-ны дотор гаргаж өгдөг тайлангийн агуулга: - тухайн хугацаанд болон жилийн хугацаанд олгосон зээлийн дүн - зээлийн нийт үлдэгдэл - сангийн зээл олгох боломжтой үлдэгдэл - идэвхтэй зээлдэгчдийн тоо - идэвхтэй зээл зорилгоор ангилсан судалгаа - шаардлага хангасан иргэдэд зээл олгосон эсэх - зээлийн өргөдөл гаргахад шаардлагатай материал	Дэд бүлэг 2.4.2

Даалгавар	Мэдээллийн эх үүсвэр	Судалгааны арга	Асуултын агуулга	Тайлангийн бүлэгтэй уялдах байдал
3. БОАЖЯ-ыг төлөөлөн Тусгай хамгаалалттай бүс нутгийн удирдлагын төлөөлөлтэй ярилцах.	Чанарын судалгаа	Ганцаарчилсан ярилцлагын арга (KII)	Төслийн чухал тал, төслийн ач холбогдол, төслийн үр ашиг гэх мэт.	Дэд бүлэг 2.4.3
4. ТХН болон ЗБ-ийн төлөөлөлтэй ярилцах.	Чанарын судалгаа	Ганцаарчилсан ярилцлагын арга (KII)	“Байгаль орчинд ээлтэй малчны зээл”-ийн бүс нутагт тулгамдаж байгаа асуудлыг шийдвэрлэж байгаа эсэх, зээлийн үйл ажиллагаа амжилттай хэрэгжиж байгаа эсэх, төсөл хэрэгжүүлэх явцад гарсан тааварлаагүй гэнэтийн зүйлс, түүнийг хэрхэн даван туулсан гэх мэт.	Дэд бүлэг 2.4.4
5. Зээл аваагүй малчдын төлөөлөл	Тоон болон чанарын судалгаа	Ганцаарчилсан ярилцлагын арга (KII) болон асуулгын арга	Энэхүү зээлийн талаар сонссон эсэх, яагаад зээл авахаар хандаагүй гэх мэт.	Дэд бүлэг 2.4.5
6. Зээл авахаар хандсан боловч зээл авч чадаагүй малчдын төлөөлөл	Чанарын судалгаа	Ганцаарчилсан ярилцлагын арга (KII)	Ямар шалтгааны улмаас хасагдсан эсэх, шалгаруулалт шударга байсан эсэх гэх мэт.	Дэд бүлэг 2.4.6
<b>В.ОБЗЭС-ийн үр нөлөөг үнэлэх</b>				
<b>В.1 Зээлийн ашиглалт, ашиг хүртэгчдийн амьжиргаа, малын тоо толгой буурснаас гарсан нөлөөллийг үнэлэх</b>				
1. Ашиг хүртэгчдэд суурилсан өрхийн амьжиргааны судалгаа: Эерэг үр дүнг үнэлэх. Өрхийн амьжиргаа болон байгаль орчин, нийгмийн үр дагавар	Анхдагч тоон мэдээлэл, тоон судалгаа, бүлгийн хэлэлцүүлэг	Зээл авсны дараах өөрчлөлтийн харьцуулсан шинжилгээ	1. Өрхийн ерөнхий мэдээлэл 2. Малын тоо 3. Өрхийн МАА-н орлого 4. МАА-н бус орлого 5. Зээлийн зарцуулалт	Дэд бүлэг 4.2
2. Бүлгийн хэлэлцүүлэг		Чиглүүлэх асуултууд		
3. Хэрэглэгчдийн сэтгэл ханамжийн судалгаа		Зөрүүгийн шинжилгээ		
<b>В.2 ОБЗЭС-ийн үйл ажиллагааг үнэлэх</b>				
1. ОБЗЭС-ийн гаргасан зээлийн хэмжээ, зээлийн тоо, зорилго	Баримт бичгийн шинжилгээ, тоон болон чанарын судалгаа, бүлгийн хэлэлцүүлэг	Үр дүнгийн харьцуулалт	Төсөл зорилгодоо хүрсэн эсэх, хүрээгүй бол шалтгаан, үнэлгээний гол шалгууруудыг хангаж байгаа эсэх гэх мэт.	Дэд бүлэг 3.1, 3.2, 3.3, 3.4, 3.5
2. Зорилтот ашиг хүртэгчдэд хүрсэн зээлийн хувь				
3. Зээлийн эргэн төлөлтийн хувь				
4. ОБЗЭС-аас зээл авсан өрхийн тоо				
5. Сум болон орчны бүсийн сүргийн буурсан хувь (биологийн олон янз байдлыг нэмэгдүүлэхэд шууд нөлөөлнө гэж тооцсон) болон сүргийн тоо толгойн бууралт нь ОБЗЭС-тай холбоотой, эсвэл бусад хүчин зүйлийг харгалзан үзэх шаардлагатай эсэхийг тодруулах.				


Даалгавар	Мэдээллийн эх үүсвэр	Судалгааны арга	Асуултын агуулга	Тайлангийн бүлэгтэй уялдах байдал
<b>С. Сургамжуудыг нэгтгэх</b>				
1. Оролцогч талуудын оролцоо, бодит хариуцлагыг хэрхэн сайжруулах талаар зөвлөмж гаргах				Бүлэг 5
2. Шаардлагатай бол дамжуулан зээлдүүлэх гэрээ болон Удирдамжийг сайжруулах зөвлөмж гаргах.				
3. ОБЗЭС-ийн анхны дүгнэлтийг гаргах. Одоогийн ОБЗЭС-ийн тогтолцоо нь хүссэн зорилгод хүрэхэд тохиромжтой юу? Эсвэл сайжруулах шаардлагатай юу?				
4. ОБЗЭС-ийн үйл ажиллагааг үргэлжлүүлснээр байгаль орчин, нийгмийн үр дүнг сайжруулах ажлын талаар зөвлөмж гаргах.	Тоон болон чанарын судалгааны үр дүн	Дүн шинжилгээ хийж, дүгнэн бичих.	Дүгнэлт, санал зөвлөмж	
5. Үнэлгээний явцад амжилтын түүхийг харгалзан төслийн II/III шатанд ОБЗЭС-г өргөжүүлэх зөвлөмж гаргах. Төслийн II/III шатанд өргөжүүлэхэд шаардлагатай сургалтын хэрэгцээ шаардлага, сургалтын үр нөлөөг сайжруулах зөвлөмж гаргах.				
6. Бусад төлөвлөсөн болон төлөвлөөгүй эерэг, сөрөг үр дүнд хүрч болзошгүй зүйлсийг тодруулах.				

Эх үүсвэр: Ажлын даалгавар дээр үндэслэн зөвлөх баг бэлтгэв.

## 1.2. ХАМРАХ ХҮРЭЭ

ОБЗЭС-ийн үйл ажиллагааны баримт бичгийн шинжилгээ болон зээлийн сангийн үйл ажиллагааны гүйцэтгэлийн хөндлөнгийн үнэлгээнд Тарвагатай нурууны БЦГ, Улаантайгын ДЦГ, Орхоны хөндийн БЦГ, Хангайн нурууны БЦГ-ын орчны бүсийн дараах 5 сум хамрагдсан.

### Зураг 1. Судалгааны хамрах хүрээ, газар зүйн байршлаар



### 1.3. АРГА ЗҮЙ

#### 1.3.1. Үнэлгээний ерөнхий загвар

Судалгаагаар тодруулах асуудлуудыг илрүүлэх, дүн шинжилгээ хийхдээ **бид үндсэн 2 төрлийн судалгааны ерөнхий загварыг хослуулан** ашиглахаар төлөвлөсөн. Үүнд:

**1. Зээл авсан болон аваагүй малчин өрхүүдийн өмнөх болон дараах шинжилгээний арга:** Өмнөх ба дараах шинжилгээний арга нь зээл авсан болон аваагүй малчин өрхийн орлогын өөрчлөлтийн шинжилгээнд хоёуланд нь ашиглагдсан. Өөрөөр хэлбэл, малчин өрхийн МАА-н болон МАА-н бус орлогын өөрчлөлтийг зээл авахаас өмнөх үе болон зээл авсны дараах үеийн өөрчлөлттэй харьцуулан шинжлэх бол, зээл аваагүй малчин өрхийн зээл авсан малчин өрхийн тухайн онтой нь давхцах он болон түүний дараах он хоёрын зөрүүгээр МАА-н болон МАА-н бус орлогын өөрчлөлтийг тооцоолсон. Тухайлбал, зээл авсан малчин өрхийн хувьд зээл авахаас өмнө орлого нь ямар байсан, авсны дараа хэрхэн өөрчлөгдсөнийг энэхүү аргыг ашиглан тодорхойлсон. Энэхүү харьцуулалтыг хийхдээ хэд хэдэн үзүүлэлтүүдийг сонгон авч харьцуулна. Жишээ нь, үр дагавар, нөхцөл байдлын өөрчлөлт нь тухайн газар нутгийн нийгэм соёлын хүчин зүйлээс шалтгаалж байдаг. Энэхүү шинжилгээг хийхдээ дараах гол үзүүлэлтүүдийг харьцуулан зээл авсан малчин өрх болон зээл аваагүй малчин өрхүүдийн хувьд харьцуулан авч үзсэн. Үүнд:

- a. *Малын тооны өөрчлөлт (Зээл авсан болон зээл аваагүй малчин өрхүүдийн зээлийн өмнөх болон дараах үеийн малын тооны өөрчлөлт, зээл аваагүй малчин өрхүүдийн хувьд тухайн цаг хугацаан дахь малын тооны өөрчлөлтийг харьцуулсан.)*
- b. *МАА-н гаралтай бүтээгдэхүүний борлуулалтын өөрчлөлт*
- c. *МАА-н бус бүтээгдэхүүний орлогын эх үүсвэрийн өөрчлөлт, орлогын хэмжээний өөрчлөлт*
- d. *Байгаль орчны хүчин зүйлс*
- e. *Нийгмийн хүчин зүйлүүд (Боловсролын түвшин, ажилгүйдлийн өөрчлөлт гэх мэт)*

*Зээл авсан болон зээл аваагүй малчин өрхүүдийн өмнөх болон дараах шинжилгээний арга нь дараах үе шатуудаас бүрдсэн.*


Үүнд:

**Эхний үе шат:** *Зээл авсан малчин өрхүүдийн орлогын өөрчлөлтийг зээл авахаас өмнө болон авсны дараах байдлаар харьцуулсан.*

**Хоёр дахь үе шат:** *Зээл аваагүй малчин өрхүүдийн хувьд зээл авсан малчин өрхийн тухайн онуудын орлогын өөрчлөлтийг тооцоолсон. Тухайлбал, 2020 болон 2021 оны орлогын өөрчлөлт, 2021 болон 2022 оны орлогын өөрчлөлт гэх мэт.*

**Гуравдах шат:** *Зээл авсан болон зээл аваагүй малчин өрхүүдийн орлогын өөрчлөлтийн ялгаврыг тооцож, зээлийн нөлөөг тооцоолсон болно.*

**Зураг 2. Зээл авсан болон аваагүй малчин өрхүүдийн өмнөх болон дараах шинжилгээ**



**2. Статистик шинжилгээ:** Статистик шинжилгээ нь зээл авсан өрх болон зээл аваагүй өрхүүдийн орлогын өөрчлөлт нь статистикийн хувьд ач холбогдолтой эсэхийг шалгахад хоёуланд нь ашиглагдана. Тоон судалгааг SPSS 25 программыг ашиглан боловсруулах ба тоон мэдээллийн ач холбогдол, тасралтгүй байдлыг статистик шинжилгээг ашиглан тодорхойлсон. Тоон судалгаанд дараах үндсэн статистик шинжилгээг ашигласан. Үүнд:

- Статистик үзүүлэлтийн шинжилгээ:
  1. Үзүүлэлтүүдийн дундаж утга
  2. Стандарт хазайлт
  3. Хувьсагчуудын хоорондын хамаарал, статистик ач холбогдлыг шалгах
  4. Хувьсагчуудын ялгаатай байдлын шинжилгээг ANOVA тестээр шалгана.
  5. Бусад статистик тестүүд- T тест, Хи-квадрат тест гэх мэт.
- Чанарын судалгааны хувьд тухайлбал, KII болон оролцогч талуудын ярилцлагыг MS Excel программ ашиглан боловсруулж, тайланд нэмэлт тоон мэдээлэл болгон ашигласан.

**3. Үүрэг, хариуцлагын үнэлгээ:** Үндсэн оролцогч талууд болох Төрийн банк болон ОБЗ-ийн оролцоо, үүрэг хариуцлагыг үнэлэхдээ “Байгальд ээлтэй малчны зээл”-ийн удирдамж 2021 -т тусгагдсан оролцогч талуудын оролцоо, үүрэг, хариуцлагын зүйл, заалт дээр тулгуурлан дараах 2 аргаар үнэлсэн. Үүнд:

**а. ОБЗ-ийн удирдамжийн дагуу бичсэн тайлангийн үнэлгээ:** Удирдамж 2021-ийн дагуу тайланд тусгах ёстой 8 үзүүлэлтүүдээс хэдийг нь тусгасан талаарх үнэлгээг дараах байдлаар тодорхойлж үнэлэв.

$$\text{ОБЗ – ийн тайлангийн үнэлгээ} = \frac{x_i}{X} * 100\%$$

Энд:  $x_i$  – тухайн сумын ОБЗ-ийн тайланд тусгасан үзүүлэлтийн тоо

$X$  – удирдамж 2021 -т тусгасан нийт үзүүлэлтийн тоо,  $X=8$  байна.

ОБЗ-ийн тайлангийн үнэлгээ нь 100 хувь хүртэл үнэлэгдэх бөгөөд тайлангийн үнэлгээ~100% бол тухайн ОБЗ-ийн тайлан Удирдамж 2021-ийн дагуу тусгах ёстой бүх зүйлсийг тусгасан тайлан бичсэнийг илтгэнэ.

б. ОБЗ болон Төрийн банкны оролцоо, үүрэг хариуцлагыг үнэлгээ: Удирдамж 2021-т заасан үзүүлэлтүүдээс тухайн сумын ОБЗ болон Төрийн банк хэдийг нь гүйцэтгэсэн талаарх үнэлгээг дараах байдлаар тодорхойлж үнэлэв.

$$\text{Гүйцэтгэлийн үнэлгээ} = \frac{y_i}{Y}$$

Энд:  $y_i$  – тухайн үзүүлэлтийг гүйцэтгэсэн сумын ОБЗ болон Төрийн банкны тоо

$Y$  – Тухайн үзүүлэлтийг гүйцэтгэх нийт сумын тоо,  $Y=5$  тэнцүү байна.

Гүйцэтгэлийн үнэлгээ нь 5 хүртэл үнэлэгдэх бөгөөд гүйцэтгэлийн үнэлгээ~ 5 байвал тухайн үзүүлэлтийг сумын ОБЗ болон Төрийн банк сайн гүйцэтгэдэг гэсэн утгыг илэрхийлнэ.

### 1.3.2. Мэдээлэл цуглуулсан арга зүй

Үнэн бодитой тэнцвэртэй, шинжлэх ухааны үндэслэл, баталгаатай мэдээлэл авах зорилгоор судалгаанд анхдагч болон хоёрдогч мэдээллийн эх үүсвэрийг ашигласан.

#### А. Тоон судалгааны түүврийн хэмжээ

Бид төслийн үйл ажиллагааны баримт бичигт тулгуурлан тоон судалгааны түүврийн нийт зээл авсан малчдын 30 хувь байхаар тооцож, түүврийн хэмжээг гаргасан. Харин зээл аваагүй малчдын буюу хяналтын түүврийн хувьд зээл авсан малчдын сонгосон түүврийн 40 хувь байхаар тооцоолж гаргасан ба түүврийн хэмжээг дараах хүснэгтээр харууллаа.

#### Хүснэгт 2. Тоон судалгааны түүврийн хуваарилалт

№	Аймаг	Сум	Зээлийн нийт үр шим хүртэгчид	Тоон судалгааны түүвэр		Нийт
				Түүврийн тоо		
				Зээл авсан малчид	Зээл аваагүй малчид	
1	Архангай	Их-Тамир	39	12	5	17
2		Цэнхэр	49	15	6	21
3	Хөвсгөл	Улаан-Уул	49	15	6	21
4	Өвөрхангай	Бат-Өлзий	56	17	7	24
5	Завхан	Их-Уул	55	17	7	24
Нийт			248	76	30	106

#### Хяналтын бүлэг буюу зээл аваагүй малчдыг хэрхэн сонгосон вэ?

Бид зээл аваагүй хяналтын бүлэг буюу малчдыг сонгохдоо магадлалт түүвэрлэлтийн аргыг ашиглан сонгосон. Өөрөөр хэлбэл, энэхүү арга нь санамсаргүй түүвэрлэлтийн аргын нэг хэлбэр бөгөөд хяналтын бүлгийн малчдыг сонгох юм. Санамсаргүй түүвэрлэлтийн арга нь эх олонлогоос төлөөллийн түүврийг сонгодог ба



олонлогийн гишүүн бүр сонгогдох боломжтой байдгаараа онцлог байдаг. Бид сум бүрийн багийн даргатай уулзаж, багийн малчин өрхийн тоог авах бөгөөд үүнээс зээлд хамрагдсан малчин өрхийн тоог хасаж, үлдсэн өрхөөс санамсаргүй байдлаар сонгож, зээл аваагүй малчин өрхийн тоог гаргасан.

**Зээл аваагүй малчин өрхийн тоо= Нийт малчин өрхийн тоо- зээл авсан малчин өрхийн тоо**

Зээл аваагүй малчин өрхийн тооноос MS экселийн RANDBETWEEN командыг ашиглан түүвэрлэгдсэн 30 өрхийг сонгож авсан болно.

**В. Чанарын судалгааны түүврийн хэмжээ**

Ажлын даалгавар дээр чанарын судалгааны түүврийн хэмжээг маш тодорхой зааж өгсөн байсан. Дараах хүснэгтэд чанарын судалгааны түүврийн оролцогчдын мэдээллийг харууллаа.

**Хүснэгт 3. Чанарын судалгааны түүврийн хуваарилалт**

№	Судалгааны төрөл	Түүврийн нэгж	Оролцогчдын тоо
1	Ганцаарчилсан ярилцлага	1. Төрийн банкны сумын салбар бүрээс төлөөлөл – <b>5 хүн</b> 2. Орчны бүсийн зөвлөлийн дарга, ажилтан (сум бүрээс-1) – <b>5 хүн</b> 3. Хамгаалалтын захиргааны дарга, мэргэжилтний төлөөлөл (сум бүрээс-1) – <b>5 хүн</b> 4. Зээл аваагүй малчин биш иргэдийн төлөөлөл (сум бүрээс-2) – <b>10 хүн</b> 5. Зээлийн материал өгсөн боловч авч чадаагүй малчдын төлөөлөл – (сум бүрээс-2) – <b>10 хүн</b> 6. Сумын ЗДТГ-ын төлөөлөл (сум бүрээс-1) – <b>5 хүн</b>	n=40 оролцогч
2	Бүлгийн хэлэлцүүлэг	1. ОБЗ-ийн гишүүдийн төлөөлөл 2. “Байгаль орчинд ээлтэй малчны зээл” авсан малчдын төлөөлөл 3. Сумын ЗДТГ-ын төлөөлөл 4. Малчдын бүлгийн төлөөлөл 5. Жижиг, дунд бизнес эрхлэгчдийн төлөөлөл 6. Төрийн бус байгууллагын төлөөлөл 7. Хүнсний тариалагч иргэдийн төлөөлөл 8. Ажилгүй иргэдийн төлөөлөл	Ойролцоогоор 150 оролцогч

**1.4. МЭДЭЭЛЭЛ ЦУГЛУУЛАЛТЫН ЗОХИОН БАЙГУУЛАЛТ, ХЯНАЛТ**

Бид судалгаандаа **CAPI** (Computer Assisted Personal Interview) буюу Таблетаар мэдээлэл цуглуулах болон **PAPI** (Paper Assisted Personal Interview) буюу цаасан асуулгаар мэдээлэл цуглуулах аргуудыг хоёуланг нь ашигласан бөгөөд CAPI арга нь дараах онцлог давуу талтай. Үүнд:

- Цаасны хэрэглээг бууруулж, судалгааны мэдээлэл шивэх үе шат байхгүй учраас цаг хугацааг хэмнэнэ;
- Мэдээлэл цуглуулалтын явц дунд, дууссаны дараах үе шатанд хянагдаж чанартай мэдээлэл цуглуулах боломжийг бүрдүүлдэг;
- WIFI буюу 3G/4G интернэт ашиглан цуглуулсан мэдээллийг тухай бүрд компанийн дата сервер лүү илгээнэ;



- Мэдээллийн аюулгүй байдлыг хангах боломжтой;
- Ярилцлагын аудио бичлэгийг хийх, фото зураг авч баримтжуулах, үүрэн холбооны сүлжээтэй газарт судлаачийн байршлыг тодруулж мэдээлэл цуглуулалтын явцыг хянаж баталгаажуулна;
- Мэдээлэл цуглуулах программаар логик шалгалтыг хянаж, тухай бүрд шалгаж засварлана;
- Явц дунд үр дүнг харах боломжтой;
- Судалгаанд оролцогчтой илүү ойр байж бодит мэдээлэл цуглуулах боломжтой;


### 1.4.1. Мэдээлэл цуглуулалтын үе шат

Зөвлөх багийн боловсруулсан судалгааны хэрэглэгдэхүүн болох асуулга, ганцаарчилсан ярилцлагын чиглүүлэх асуултуудын дагуу талбарт мэдээлэл цуглуулах, цуглуулсан мэдээллийг компьютерт оруулах ажлыг “Эс Ай Си Эй” ХХК-ийн Мэдээлэл цуглуулалт, боловсруулалтын хэлтэс зохион байгуулж ажиллалаа.

Мэдээлэл цуглуулалтын багт Дэд захирал Г.Эрдэнэ, Зөвлөх Ө.Амар, НЭЗСХ-ийн захирал Э.Должин, менежер Х.Очирбат, Б.Түмэндэлгэржав, МЦБХ-ийн захирал Б.Төрцэцэг, менежер Ө.Халиун, 2 гэрээт мэдээлэл цуглуулагч, 3 жолооч, 5 шивэлтийн оператор ажилласан. Мэдээлэл цуглуулахад 10 хоног зарцууллаа.

Мэдээлэл цуглуулах багийн ажилчдыг судалгааны талбарт амжилттай мэдээлэл цуглуулалт хийхийн тулд бид үндсэн 5 үе шаттайгаар мэдээлэл цуглуулах үе шатыг зохион байгууллаа.

#### Зураг 3. Мэдээлэл цуглуулалт, боловсруулалтын үе шат дараалал



#### 1. Бэлтгэл үе шат

Бэлтгэл ажлын хүрээнд үйл ажиллагааны төлөвлөгөө, асуулгын дагуу мэдээлэл цуглуулах программ боловсруулах, программ турших, техник хэрэгслийн бэлэн байдлыг хангах, судлаачийн иж бүрдлийг **бэлтгэх ажлыг гүйцэтгэсэн.**

#### 2. Сургалтын үе шат

Мэдээлэл цуглуулалтын багийн ахлагч, хянагч судлаачдын **2 удаа танхимаар** зохион байгуулав. Мэдээлэл цуглуулалтын сургалтын агуулгыг судалгааны асуумжийн дагуу боловсруулж, нэг өдрийн сургалтад дараах агуулгыг багтаалаа. Үүнд:

- Төслийн зорилго, зорилт, хүлээгдэж буй үр дүн
- Асуулгын хуудасны бүтэц, судалгаа бөглөх ерөнхий арга зүй
- Асуулгын хуудасны дэлгэрэнгүй зааварчилгаа
- Асуулт хариулт

- Талбарт ажиллах аюулгүй ажиллагааны зааварчилгаа
- Мэдээллийн чанар хянах процесс
- Багийн бүтэц зохион байгуулалт
- Мэдээлэл цуглуулахад анхаарах асуудал, зөвлөмж
- Асуулт хариулт
- Түүврийн хуваарилалт, цалин хөлс, бусад мэдээлэл

### 3. Мэдээлэл цуглуулах үе шат

Мэдээлэл цуглуулах үйл ажиллагаа нь төлөвлөгөөний дагуу мэдээлэл цуглуулах багийн хуваарилалт, зураглалаар эхэлж, өдөр тутамд арга зүйн дагуу хяналт тавьж зохион байгуулсан.

### 4. Мэдээлэл цуглуулалтын хяналт

Мэдээлэл цуглуулалтын явц дунд утсаар, рекорд сонсох болон талбар дээрх хяналт хийсэн. **Нийт түүврийн 10 хувьд анкетыг давхар шивэх хяналт хийсэн.**

### 5. Мэдээллийн сан үүсгэх, шалгах

Арга зүйн болон логик хяналтыг хийж, нээлттэй асуултыг кодлох бүлэглэх процесс явагдсан.

#### 1.4.2. Судлаачдын аюулгүй байдал

Судалгааны мэдээлэл цуглуулах шатанд судлаачдын аюулгүй байдалд нэн тэргүүнд анхаарч судлаач нэг бүрт дараах хэрэгслийг бэлтгэж өгч ажиллаа. Үүнд:

1. Мэдээлэл цуглуулагчийн ажиллах цагийн хуваарийг нарийвчлан гаргаж гэрээнд тусган баталгаажуулж мөрдүүлсэн.
2. Судлаач бүрт албан ёсны үнэмлэх заавал олгосон.
3. Ажлын үнэмлэхний ард “Аюулгүй ажиллагааны зааварчилгаа”-г оруулсан.
4. Судлаачийн үнэмлэхийн ард судалгааны ахлах, хянагч, оффисын утас болон яаралтай тусламжийн утсыг заавал байршуулсан.
5. Судлаач бүрийг даатгалд хамруулсан.
6. Анхан шатны тусламж үйлчилгээ үзүүлэх боломжтой эмийн сан (толгой, гэдэс, өвчин намдаах эм) витамин, бент зэргийг талбарт ажиллаж буй баг тус бүрд бэлтгэн өгсөн.
7. Шүгэл, болон нохой дайрахад хамгаалах хэрэгслийг бэлтгэн өгсөн.

## БҮЛЭГ 2. ЗЭЭЛ ОЛГОЛТЫН ҮЙЛ ЯВЦ БОЛОН БАРИМТ БИЧГИЙН ШИНЖИЛГЭЭ

### 2.1. ОБЗЭС-ТАЙ ХОЛБООТОЙ БАРИМТ БИЧГИЙН ШИНЖИЛГЭЭ

#### 2.1.1. “Орчны бүсийн эргэлтийн сан” (ОБЗЭС)-ийн зээлийг дамжуулан зээлдүүлэх гэрээнд хийсэн шинжилгээ

Энэхүү Дамжуулан зээлдүүлэх гэрээ нь ТХГН-ийн Орчны бүс орчимд амьдарч байгаа малчин өрхөд “Орчны бүсийн эргэлтийн сан” (ОБЗЭС)-аас зээл олгох нөхцөлийг тодорхойлох, санг зориулалтын дагуу ашигласан эсэхийг хянах, санг ажиллуулах харилцааг зохицуулахаар Байгаль орчин, аялал жуулчлалын яам болон Төрийн банк хооронд байгуулсан гэрээ юм. Энэхүү гэрээ нь гэрээний нийтлэг үндэслэл болон гэрээний оролцогч талуудын үүрэг, эрхийг тусгасан 6 үндсэн заалттай. Үүнд:

1. Нийтлэг үндэслэл
2. Орчны бүсийн зээлийн эргэлтийн сан
3. Төрийн банкны эрх, үүрэг
4. Байгаль орчин, аялал жуулчлалын яамны эрх, үүрэг
5. Тусгай хамгаалалттай газар нутгийн хамгаалалтын захиргаа болон Орчны бүсийн зөвлөлийн эрх, үүрэг
6. Бусад

#### Хүснэгт 4. ОБЗЭС-ийн зээлийг дамжуулан зээлдүүлэх гэрээний агуулга

Гэрээний зүйл, заалт	Агуулга	Зөрчилдөж байгаа зүйл, заалт, орхигдуулсан зүйлс
Нийтлэг үндэслэл	Энэ хэсэгт гэрээний үргэлжлэх хугацаа, гэрээний зорилго, гэрээний салшгүй хэсэг болох баримт бичиг, нэр томъёоны тайлбарыг багтаасан байна.	1. Нийтлэг үндэслэлийн 1.1 хэсгийн орчны бүсийн малчин, мал бүхий иргэдэд гэж зааж өгсөн нь зээлийн зааварчилгааны 1.5 хэсгийн малчид, малчдын бүлэгт олгоно гэсэн заалттай зөрчилдөж байна. 2. Нэр томъёоны тайлбар хэсэгт малчин өрх гэдгийг юу гэж ойлгох талаар ойлголтыг орхигдуулсан.
Орчны бүсийн эргэлтийн сан	Энэ хэсэгт ОБЗЭС-ийн үйл ажиллагаа, ОБЗЭС-ийн үүрэг, эрхийн талаар тусгаж өгсөн.	1. Энэ хэсгийн 2.1 хэсэгт байгаа малчин, мал бүхий иргэд гэдгийг тодорхой болгох.
Төрийн банкны эрх, үүрэг	Энэ хэсэгт Төрийн банкны эрх, үүргийн талаар тодорхой тусгаж өгсөн.	Энэ хэсэгт зээлийн эргэн төлөлтийн талаар тодорхой тусгаж өгвөл зүгээр байна. Өөрөөр хэлбэл, малчдын зээлийн эргэн төлөлтийн талаар тодорхой тусгаж өгөх.
Байгаль орчин, аялал жуулчлалын яамны эрх, үүрэг	Энэ хэсэгт Байгаль орчин, аялал жуулчлалын яамны эрх, үүргийн талаар тусгасан байна.	-
Тусгай хамгаалалттай газар нутгийн хамгаалалтын	Энэ хэсэгт Тусгай хамгаалалттай газар нутгийн хамгаалалтын захиргаа болон	5.4.3 заалт нь “Байгальд ээлтэй малчны зээл”-ийн 6.2 заалттай зөрчилдөж байна.

Гэрээний зүйл, заалт	Агуулга	Зөрчилдөж байгаа зүйл, заалт, орхигдуулсан зүйлс
захиргаа болон ОБЗ-ийн эрх үүрэг	ОБЗ-ийн эрх, үүргийн талаар тодорхой тусгаж өгсөн байна.	
Бусад	Гэрээнд тусгагдаагүй бусад зүйлсийн талаар энэ хэсэгт тусгасан.	-

Энд: <sup>a</sup> – Түүвэр судалгаагаар малчидтай, Төрийн банкны төлөөлөл, ОБЗ-ийн төлөөлөл зэрэг чанарын судалгаанд оролцогчдоос гаргаж байсан санал.

Дамжуулан зээлдүүлэх гэрээний хувьд зүйл заалтуудын хувьд ерөнхийдөө болж байгаа бөгөөд дээрх хүснэгтэд тусгагдсан саналын дагуу сайжруулж, өөрчлөхөөс гадна нэр томьёоны агуулга, ойлголтыг ижил болгох нь чухал байна. Тухайлбал, “Байгальд ээлтэй малчны зээл”-ийн удирдамж нь зааварчилгаа, журам гэх мэт үгээр орсон байна.

### 2.1.2. “Байгальд ээлтэй малчны зээл”-ийн удирдамжид хийсэн шинжилгээ

ОБЗЭС-ийн “Байгальд ээлтэй малчны зээл”-ийн удирдамж нь дамжуулан зээлдүүлэх гэрээний салшгүй баримт бичгийн нэг юм. Энэхүү удирдамж нь үндсэн 7 зүйл заалттай. Үүнд:

1. Нийтлэг үндэслэл
2. Орчны бүсийн эргэлтийн сан
3. Зээлийн зориулалт
4. Байгальд ээлтэй малчны зээл
5. Орчны бүсийн эргэлтийн сангийн удирдлага ба хяналт
6. Зээл олгох явц
7. Бусад

“Байгальд ээлтэй малчны зээл”-ийн удирдамжийн агуулга, дамжуулан зээлдүүлэх гэрээний зүйл, заалттай зөрчилдөж байгаа зүйл заалт байгаа эсэхийг дараах хүснэгтээр харууллаа.

#### Хүснэгт 5. “Байгальд ээлтэй малчны зээл”-ийн удирдамж

Гэрээний зүйл, заалт	Агуулга	Зөрчилдөж байгаа зүйл, заалт, орхигдуулсан зүйлс
Нийтлэг үндэслэл	Энэ хэсэгт ОБЗЭС-ийн ТХГН-ийн орчны бүсийн малчид, иргэдийн амьжиргааг дэмжих, бэлчээрийн доройтлыг бууруулах, нөхөн сэргээх, биологийн олон янз байдлыг хамгаалах зорилгоор олгож байгаа зээлийн үйл ажиллагааг зохицуулах, санхүүжилт, зааварчилгаанд ашиглагдах нэр томьёоны тайлбарыг оруулж өгсөн байна.	1. Нийтлэг үндэслэлийн 1.5 хэсэгт зээлийг сонгогдсон сумдын малчид, малчдын бүлэгт олгоно гэсэн нь дамжуулан зээлдүүлэх гэрээний малчин, мал бүхий иргэдийг хамруулна гэсэн заалттай зөрчилдөж байна.
Орчны бүсийн эргэлтийн сан	Энэ хэсэгт ОБЗЭС-ийн санхүүжилт, хүүгийн орлогыг хэрхэн, яаж, юунд зарцуулах талаар тодорхой тусгасан.	-
Зээлийн зориулалт	Энэ хэсэгт “Байгаль орчинд ээлтэй малчны зээл”-ийн зээл олгох зориулалтыг тодорхой зааж өгсөн байна.	-
Байгальд ээлтэй малчны зээл	Энэ хэсэгт “Байгальд ээлтэй малчны зээл”-ийн нөхцөл, нийтлэг шаардлага, шалгуур, зээл	-

Гэрээний зүйл, заалт	Агуулга	Зөрчилдөж байгаа зүйл, заалт, орхигдуулсан зүйлс
	авснаар хүлээх үүргийн талаар тодорхой тусгаж өгсөн байна.	
ОБЗЭС-ийн удирдлага, хяналт	Санг удирдах үндсэн баримт бичиг, гэрээний талуудын хүлээх үүрэг, гэрээний тавих хяналтын талаар энэхүү хэсэгт тусгаж өгчээ.	-
Зээл олгох үйл явц	Энэ хэсэгт зээл олгох үйл явц хэрхэн явагдах, зээл авахад шаардлагатай бүрдүүлэх материалын талаар тусгасан.	6.2 заалт нь дамжуулан зээлдүүлэх гэрээний 5.4.3 хэсэгтэй зөрчилдөж байна.
Бусад	Энэхүү удирдамжид биелэлттэй холбогдох, удирдамжид тусгагдаагүй бусад зүйлсийг хэрхэн, яаж зохицуулах талаар тусгаж өгсөн.	-

ОБЗЭС-тай холбоотой үндсэн 2 баримт бичиг болох ОБЗЭС-ийн “Дамжуулан зээлдүүлэх гэрээ”, “Байгаль орчинд ээлтэй малчны зээл”-ийн удирдамжийн хувьд дараах ойлголт, зүйл заалтууд зөрчилдсөн, орхигдуулсан байна. Үүнд:

- “Дамжуулан зээлдүүлэх гэрээ”-ний агуулгад малчин, мал бүхий иргэнд гэж тодорхойлсон боловч, “Байгальд ээлтэй малчны зээл”-ийн удирдамжид зээлийг малчид, малчдын бүлэгт олгоно гэж заасан нь агуулгын хувьд зөрчилтэй.
- “Дамжуулан зээлдүүлэх гэрээ” болон “Байгальд ээлтэй малчны зээл”-ийн удирдамжийн нэр томъёоны тайлбарт зээлийн үндсэн оролцогч тал болох “малчин” гэдэгт хэнийг ойлгох талаар дурдаагүй, орхигдуулсан.
- “Дамжуулан зээлдүүлэх гэрээ” -ний Монгол хувилбарын 5.4.3 заалт буюу “ОБЗ нь ОБ-ийн иргэдээс ирсэн зээлийн хүсэлтийг хүлээн авч, сард 1-ээс доошгүй удаа хуралдаж, зээл хүссэн санал бүхий жагсаалтыг хорооны шийдвэрийн хамт банканд хүргэнэ” гэсэн заалт нь “Байгальд ээлтэй малчны зээл”-ийн удирдамжийн Монгол хувилбарын 6.2 заалт буюу ОБЗ нь малчид, иргэдээс зээлийн материалыг хүлээн авч сард 2-оос доошгүй удаа хуралдаж, хэлэлцэнэ” гэж заасан байсан нь хоорондоо зөрчилдөж байгаа.
- Зээлийн хугацаа 24 сар хүртэл хэдий ч, зээл авсан малчин малын тоогоо гэрээ байгуулснаас хойш 12 сарын хугацаанд бууруулах үүргийг хүлээнэ гэж байгаа нь малчид зээлээ аваад, зөвхөн эхний жил малын тоогоо бууруулаад, дараа жил нь өсгөх боломжийг бүрдүүлж өгч байна. Тиймээс энэхүү зүйл заалтыг зээлийн хяналтыг хийх хугацаа, үйл ажиллагаатай уялдуулан өөрчлөх.

### **2.1.3. ОБЗ-ийн зээл гориллогчдыг хэрхэн шалгаруулж, сонгосон тухай тайлан (төрийн банкттай холбоотой), мөн татгалзсан зээлийн хүсэлттэй холбоотой баримт бичгүүд (хурлын тэмдэглэл, протокол)**

#### **А. Зээлийн сонгон шалгаруулалтыг зохион байгуулж буй үйл явц**

Тусгай хамгаалалттай газар нутгийн “Орчны бүсийн зөвлөл” нь ОБЗЭС-ийн үйл ажиллагааг зохион байгуулах эрхтэй бөгөөд тус зөвлөлөөр сангийн зээлийн үйл ажиллагааг удирдан зохион байгуулдаг. ОБЗЭС-ийн зээл нь 2021 оны 9 сараас анх олгож эхэлсэн бөгөөд тухайн үед төслийн зүгээс малчдад мэдээлэл түгээсний үндсэн дээр төслийн зорилтот сумууд 2021 оны 11 сар гэхэд сангийн зээлийг бүрэн олгож дууссан байна.

Зээл авахаар материал өгсөн малчдын зээлийн сонгон шалгаруулалтыг дараах үе шатуудаар зохион байгуулж байна. Үүнд:


#### **Эхний үе шат: Зээлийн материал хүлээн авах**

Зээлийн материалыг ОБЗЭС-д мөнгө орж ирсэн талаарх Төрийн банкны мэдээлэл дээр тулгуурлан 14 хоногийн өмнө багийн дарга нараар дамжуулан зарыг малчдад хүргэдэг. Хүлээн авах материалын хувьд “Байгальд ээлтэй малчны зээл”-ийн удирдамжийн дагуу дараах материалуудыг хүлээн авдаг.

- Малчдын “А” дансны хуулбар, сүүлийн 2 жил
- Малын эрүүл мэнд, гарал үүслийн тодорхойлолт
- Орчны бүсэд 2 ба түүнээс дээш жил оршин суугаа нь үнэн гэсэн багийн даргын тодорхойлолт
- Зээлийг ямар зориулалтаар авч байгаа хүсэлт
- Иргэний үнэмлэхийн хуулбар зэрэг материалуудыг хүлээн авч, ОБЗ-ийн хурлаар хэлэлцэн, зээл олгох шийдвэрийг Төрийн банк руу хүргүүлдэг.

Малчдын хувьд үндсэн зээлийн эргэн төлөлтийг ихэвчлэн намар болон хаврын улиралд төлдөг ба үүнтэй уялдан сумуудын ОБЗ нь жилдээ 2-3 удаа хуралддаг байна. Ихэвчлэн зээлийн эргэн төлөлт орж ирсэн хавар, намрын улиралд хурлыг зохион байгуулдаг.

#### **Зураг 4. Зээлийн сонгон шалгаруулалтыг зохион байгуулах үе шат**



#### **Хоёрдугаар үе шат: ОБЗ-ийн хурлаар хэлэлцэн шийдвэрлэх**

ОБЗ-ийн хувьд материалаа ирүүлсэн малчдын хүсэлттэй танилцан “Байгальд ээлтэй малчны зээл”-ийн нийтлэг тавигддаг шалгуураар сонгон шалгаруулжээ. Үүнд:

1. Тухайн орчны бүс нутагт амьдардаг өрх мөн эсэх
2. Тухайн бүс нутагтаа сүүлийн 2 жил амьдарч байгаа эсэх
3. Малын тоо нь зээлийн шалгуурт хүрэх эсэх үндсэн 3 шалгуураар сонгон шалгаруулахаас гадна
4. Зээлийн өргөдөл өгсөн он сарын дарааллаар ангилна
5. Амьжиргааны түвшин, малын тоо, зээлээ эргэн төлөх боломжийг судална.
6. Зээл авах зорилго зэргийг харгалзан үзэж, зээлийн хүсэлтийг сонгон шалгаруулж, зээлийн хүсэлт өгсөн иргэдийн эрэмбийг гарган Төрийн банк руу шилжүүлдэг байна.

**Гуравдугаар үе шат: Шаардлага хангасан малчдын материалыг Төрийн банк руу илгээх**

Төрийн банкнаас мэдэгдсэн ОБЗЭС-ийн нийт дүнд тааруулан малчдын зээлийн хүсэлтийг Төрийн банк руу илгээхээс гадна, ОБЗ-ийн хурлаар шаардлага хангасан малчдыг эрэмбэлэн бүгдийг хүргүүлдэг байна. Учир нь банканд очоод банкны шалгуур хангахгүй хасагдах магадлалтай малчин өрх гардаг учраас дараагийн малчны зээлийн судалгааг хийх боломжийг олгодог. Зарим сумдын хувьд малчдыг өргөдлөө өгөхөөс өмнө Төрийн банкнаас зээл гарах боломжтой эсэхийг асууж, шаардлага хангаж байвал өргөдөл өгөхийг зөвлөдөг байна. Энэ нь тухайн өрхийн цаг хугацааг хэмнэх давуу талтайгаас гадна малчдад хоосон найдвар төрүүлэхээс урьдчилан сэргийлдэг. Тухайлбал, Өвөрхангай аймгийн Бат-Өлзий сумын хувьд малчдадаа дээрх зөвлөгөөг өгснөөр малчдын зээлийн материал бүрдүүлэх цаг хугацааг хэмнэдэг талаар дурдсан байв<sup>1</sup>.

**Дөрөвдүгээр үе шат: Төрийн банк эцсийн шийдвэр гаргах**

Төрийн банк ОБЗ-өөс ирсэн малчдын зээлийн хүсэлт, ОБЗ-ийн шийдвэрийн хамт хүлээн авч, зээлийн судалгааг эхлүүлдэг. Зээл хүссэн малчдын хувьд Төрийн банкны зээлийн шалгуур хангаж байгаа эсэхийг судлан, шаардлага хангаж байгаа нөхцөлд тухайн зээлийг малчинд олгох шийдвэр гардаг бөгөөд малчид руу зээлийн шийдвэр гарсан талаар утсаар мэдэгддэг. Зарим малчдын хувьд давхар зээлтэй байдаг ба ийм малчдын хувьд барьцаа хөрөнгө нь давхар зээлтэй нөхцөлд хүрч байгаа эсэхийг харгалзан үзэж, боломжтой хэмжээгээр нь зээлийг олгодог<sup>2</sup>.

Малчдын хувьд зээл хүсэхэд шаардлагатай бүрдүүлэх материалын хувьд бэрхшээл тулгардаггүй ч, зарим малчдын хувьд зээл авахад тавигдах нийтлэг шаардлагад бэрхшээл тулгардаг байна. Үүнийг дараах хүснэгтэд харууллаа.

**Хүснэгт 6. Малчдын хувьд зээл авахад тавигдах нийтлэг шаардлага үзүүлэлтэд тулгардаг бэрхшээл, шийдвэрлэх боломж**

Нийтлэг шаардлага	Тулгарч буй бэрхшээл	Шийдвэрлэх боломж
Барьцаа хөрөнгийн тодорхойлолт, малын А данс, сүүлийн 2 жилээр	Малчин өрхийн хувьд зээлийн барьцаа хөрөнгө нь мал байдаг учраас малын тоо нь хүсэж байгаа зээлийнх нь шаардлага хангахгүй тохиолдолд зээлийг олгодоггүй. Гэхдээ Төрийн банкнаас барьцаа хөрөнгөд тохирсон хэмжээгээр зээлийн хэмжээг олгодог.	Цөөн малтай өрхийн зээлийн авах хэмжээ бага байна. Тиймээс бага малтай малчин өрхийг хамруулахын тулд зээлийн батлан даалт гаргах боломжтой.
Малын тоог зээлийн гэрээ хийснээс хойш 12 сарын хугацаанд 5 хувь бууруулах.	Малчдын хувьд малын тоогоо бууруулахад ямар нэгэн бэрхшээл тулгардаггүй. Тиймээс малчид энэхүү шалгуурыг боломжийн гэж үзэж байгаа.	Гэхдээ малчдын орлогын эх үүсвэр нь мал байдаг учраас энэхүү зээлээ төлөөд дууссаны дараа банкнаас зээл авах гэхээр малын тоо бага байх нь

<sup>1</sup> Бат-Өлзий сумын ОБЗ-ийн хурлын протокол, 2022 он

<sup>2</sup> Их-Тамир сумын Төрийн банкны эрхлэгчтэй хийсэн ярилцлагаас



Нийтлэг шаардлага	Тулгарч буй бэрхшээл	Шийдвэрлэх боломж
		малчны зээл бага гарах шалтгаан болдог.
Орчны бүсэд 2 буюу түүнээс дээш жил оршин суусан иргэн, малчин байх.	Орчны бүсэд малчин айл нь багтдаггүй ч, мал нь Орчны бүс рүү бэлчдэг малчид өргөдөл өгдөг боловч, хасагддаг байна.	Тухайн ОБ-ийн хилд багтдаггүй ч, мал нь бэлчдэг өрхүүд байдаг. Цаашдаа энэ асуудлыг харгалзан үзэх.
Банк болон бусад санхүүгийн байгууллагад хугацаа хэтэрсэн зээлийн өргүй байх.	Бусад банканд зээлтэй бол Төрийн банкнаас зээл авах боломж нь хязгаарлагдмал. Мөн хугацаа хэтэрсэн зээлийн өртэй бол Төрийн банкны шаардлагыг хангахгүй байна гээд зээлээс хасагддаг.	Банкны шалгуур
Төрийн банкны малчны зээлийн шалгуур хангасан байх.	Банкны тавьж байгаа шалгуурыг хангасан байх. Зарим ОБЗ-ийн хувьд банкны шалгуурыг хангаж байгаа малчдын зээлийн өргөдлийг авдаг байсан. Энэ нь малчдын цагийг хэмнэдэг байна.	Банкны шалгуур
Зээлийн зориулалт	Одоогийн байгаа зориулалт нь малын чанарыг сайжруулах, малын тоо толгойг бууруулах замаар бэлчээр, тэжээлийн хангамжийг сайжруулах, бэлчээрийн ашиглалтаа зүй зохистой болгох, нөхөн сэргээх, бүлэг хамтаараа МAA-н бүтээгдэхүүний үнэлэмжийг дээшлүүлэх зорилгоор байгаа боловч малчдын хувьд малынхаа чанарыг сайжруулах, малын хашаа хороогоо сайжруулах, тэжээл тариалах зорилгоор зээл авчээ. Бүлгээрээ ажиллаж, орлогын шинэ эх үүсвэртэй болох чиглэлээр авсан, олгосон зээл байхгүй байна.	Тиймээс цаашид малчдын бүлэг, МAA-н бүтээгдэхүүний нийлүүлэлтийн сүлжээнд оролцох боломжийг нэмэгдүүлэх байдал руу чиглэсэн дэд төслийн үйл ажиллагаа дэмжих чиглэлээр санхүүжүүлэх. Ингэснээр малчдын хувьд орлогын шинэ эх үүсвэртэй болох боломжийг бүрдүүлж өгнө.
Зээлийн хэмжээ	Зээлийн хэмжээ 10 сая хүртэл төгрөг байгаа нь шинэ бизнес эхлүүлэх, эрхлэхэд хангалттай хэмжээний хөрөнгө оруулалт болохгүй байгаа талаар малчид дурдаж байсан.	Цаашид дэд төслийг шалгаруулах, малчдын бүлгийн үйл ажиллагааг дэмжих чиглэлээр зээлийн хэмжээг нэмэгдүүлэх.
Зээлийн хугацаа	Зээлийн хугацааны хувьд боломжийн.	
Зээлийн хүү	Зээлийн хүүгийн хувьд боломжийн байдаг ч, сар бүр зээлийн хүүгээ төлөх нь хүндрэлтэй байдаг. Учир нь сумын төвөөс хол, сүлжээгүй газар нүүдэллэх нь зээлийн хүүгээ сар бүр төлж чадахгүй нөхцөл байдлыг үүсгэдэг.	Тиймээс ОБЗЭС-ийн зээлийн хүүг улирал бүр хүүгийн хамт төлөх боломжийг бүрдүүлж өгөх.

Малчдын хувьд ОБЗЭС-ийн зээлийн хугацаа 24 сар байгаа нь боломжийн байдаг. Харин зээлийн хүүг сар бүр төлдөг байдал нь сумын төвөөс хол, сүлжээгүй газар амьдардаг малчдын хувьд хүндрэлтэй байдаг байна. Учир нь 1 сар хүүгээ төлөөгүй бол, чанаргүй зээлийн ангилалд орлох магадлалтай байдаг учраас сар бүр төлөхийг хичээдэг.



### ***В. Татгалзсан зээлийн хүсэлттэй холбоотой баримт бичгүүд (хурлын протокол)***

Сумдын ОБЗ-ийн хувьд зээлийн өргөдөл хүлээн авах зарыг хүргэсний дараагаар зээлийн материалыг хүлээн авч, зөвлөлийн хурлыг зохион байгуулдаг. Ихэнх сумдын хувьд “Байгальд ээлтэй малчны зээл”-ийн нийтлэг шалгуураар малчдын өргөдлийг эрэмбэлдэг. Малчдын хувьд голдуу дараах шалтгааны улмаас зээлийн хүсэлт нь татгалздаг байна. Үүнд:

- Тухайн орчны бүсийн хязгаарт амьдардаггүй
- Малын тоо нь банкны шалгуураас хэтэрхий бага

Малчдын хувьд тухайн орчны бүсийн хязгаарт ордоггүй ч, орчны бүсийн зааг дээр амьдардаг малчин өрхүүд зээлд хамрагдах гэж хүсэлтээ өгдөг байна. Орчны бүсийн зааг дээр тухайн өрх амьдардаг ч, мал нь орчны бүс рүү бэлчдэг ч зээлийн нийтлэг шалгуурт нийцдэггүй талаар ОБЗ-ийн төлөөлөлтэй уулзаж байхад дурдаж байв. Харин зарим малчдын хувьд малын тоо хэтэрхий бага байдаг ба энэ нь банкны шалгуурыг хангахгүйгээс гадна зээлээ мал худалдан авахад зориулах магадлалтай байдаг учраас зээл олгодоггүй байна.

#### ***2.1.4. Удирдамж 2021 -ийн дагуу бичсэн ОБЗ-ийн тайлан***

Орчны бүсийн эргэлтийн сангийн “Байгальд ээлтэй малчны зээл”-ийн удирдамжийн дагуу ОБЗ нь дараах агуулгын хүрээнд тайланг гаргах үүрэгтэй. Үүнд:

- Зээлийн хүсэлт хүлээн авах зарыг иргэдэд, ил тод хүртээмжтэй байдлаар хэрхэн яаж хүргэдэг талаар
- Зээлийн хүсэлтийг хүлээн авч, зээл хүссэн зориулалт нь нийгэм, байгаль орчинд сөрөг нөлөөгүй, орчны бүсийн иргэн болохыг баталгаажуулан, жагсаалтыг Төрийн банканд хүргүүлдэг талаар, мөн орчны бүсийн иргэдээс зээлийн хүсэлт авч сард 2-оос доошгүй удаа хуралдаж, зээл хүссэн санал бүхий жагсаалтыг хорооны шийдвэрийн хамт банканд хүргүүлэх
- Зээлийн эргэлтийн сангийн ашиглалт, зээл олголт, эргэн төлөлтөд хяналт тавих, сангийн ашиглалтыг сайжруулахад санал санаачилга гарган ажиллах.
- Зээлийн эргэлтийн сангийн зээл нь зорилтот малчид, иргэдэд хүрч байгаа эсэхэд зайнаас болон газар дээрх хяналтыг тавих. Зээл авсан иргэд, зээлийн эргэн төлөлт, зээлийг зориулалтын дагуу ашиглаж байгаад хэрхэн хяналт тавьсан, мониторинг хийсэн талаар тусгах.
- Зээлийн эргэлтийн сангийн үйл ажиллагаатай холбоотой өргөдөл, гомдлыг хүлээн авч, холбогдох талуудад танилцуулан шийдвэрлүүлэх.
- ОБЗЭС-ийн талаар малчдаас ирсэн гомдол, саналыг хүлээн авч шийдвэрлэсэн байдал
- Зээл авсан малчдын малын тооны бууралт
- Байгаль орчинд гарсан өөрчлөлт зэргийн талаар тусгасан тайланг гэрээний талуудад жил бүрийн эхний улиралд хүргүүлэх үүргийг хүлээсэн.

Сумуудын ОБЗ-ийн өнгөрсөн 2 жилийн хугацаанд хийсэн ажлын тайлангийн бүтэц, агуулгад “Удирдамж 2021”-ийн дагуу хийсэн шинжилгээг дараах хүснэгтээр харууллаа. Тайлангийн агуулга нь удирдамжид тусгагдсан дараах 8 үйл ажиллагааны талаар бичигдсэн эсэхийг шинжиллээ.

**Хүснэгт 7. Удирдамж 2021-ийн дагуу бичсэн ОБЗ-ийн үйл ажиллагааны тайланд хийсэн шинжилгээ, Бүлэг 1.3.1-ийн 3а-г харна уу.**

Тайлангийн бүтэц	Их -Тамир сум	Цэнхэр сум	Бат-Өлзий сум	Их-Уул сум	Улаан-Уул сум
Зээлийн хүсэлт хүлээн авах зарыг иргэдэд, ил тод хүртээмжтэй байдлаар хэрхэн яаж хүргэдэг талаар	Тайланд мэдээлэл тусгаагүй.	Багийн даргаар нь дамжуулан 14 хоногийн өмнө мэдээллийг түгээдэг гэж дурдсан байна.	Зээлийн зарыг хэрхэн түгээдэг талаар тайланд дурдаагүй байв.	Тайланд зээл олголтын талаарх зарыг хэрхэн түгээдэг талаар тусгаагүй байв.	Зээл олголтын талаарх зарыг Төрийн банкнаас санхүүжилт орж ирсэн талаар мэдэгдэнгүүт, багийн даргаар дамжуулан 7 хоногийн өмнө зарыг түгээдэг. Мөн Улаан-Уул сумын зар мэдээ фэйсбүүкт байрлуулан зарыг иргэдэд нээлттэй зарладаг байна.
Зээлийн хүсэлтийг хүлээн авч, зээл хүссэн зориулалт нь нийгэм, байгаль орчинд сөрөг нөлөөгүй, орчны бүсийн иргэн болохыг баталгаажуулан, жагсаалтыг Төрийн банканд хүргүүлдэг талаар, мөн орчны бүсийн иргэдээс зээлийн хүсэлт авч сард 2-оос доошгүй удаа хуралдаж, зээл хүссэн санал бүхий жагсаалтыг хорооны шийдвэрийн хамт банканд хүргүүлдэг эсэх	Өнгөрсөн 2 жилийн хугацаанд Их-Тамир сумын ОБЗ- нь 3 удаагийн хурлыг зохион байгуулжээ.	Цэнхэр сумын ОБЗ-ийн хувьд өнгөрсөн 2 жилийн хугацаанд 4 удаагийн хурлыг зохион байгуулжээ.	Бат-Өлзий сумын ОБЗ-ийн хувьд өнгөрсөн 2 жилийн хугацаанд нийт 4 удаагийн хурал зохион байгуулжээ.	Завхан аймгийн Их-Уул сумын ОБЗ нь өнгөрсөн 2 жилийн хугацаанд нийт 4 удаагийн хурлыг зохион байгуулжээ.	Хөвсгөл аймгийн Улаан-Уул сумын хувьд ОБЗ нь 3 удаагийн хурлыг зохион байгуулжээ.



Тайлангийн бүтэц	Их -Тамир сум	Цэнхэр сум	Бат-Өлзий сум	Их-Уул сум	Улаан-Уул сум
<p>Зээлийн эргэлтийн сангийн зээл нь зорилтот малчид, иргэдэд хүрч байгаа эсэхэд зайнаас болон газар дээрх хяналтыг тавих. Зээл авсан иргэд, зээлийн эргэн төлөлт, зээлийг зориулалтын дагуу ашиглаж байгаад хэрхэн хяналт тавьсан, мониторинг хийсэн талаар тусгах.</p>	<p>Зээл авсан малчдаар явж хяналт мониторинг хийсэн гэж байгаа боловч, яг хэдэн удаа хяналтыг хийсэн талаар дурдаагүй. Зээл авсан малчдын хувьд зээлээ зориулалтын дагуу хашаа хороогоо сэлбэж хашиж, бэлчээр ашиглалт, хамгаалалтаа сайжруулсан талаар дурдсан байв.</p>	<p>Зээл авсан малчин өрхүүдээр 4 удаагийн хяналт, мониторингийг хийж гүйцэтгэсэн бөгөөд зээлийн гэрээний биелэлт, зээлээ зориулалтын дагуу зарцуулсан эсэхэд хяналт тавин ажилласан байна.</p>	<p>ОБЗ-ийн гишүүд өнгөрсөн 2 жилийн хугацаанд 4-5 удаагийн явцын хяналтыг хийж гүйцэтгэсэн байна. Хяналтын үеэр зээл авсан өрхүүд малын үүлдэр угсааг сайжруулан эргэлтэд оруулах, малын хашаа саравчаа сэлбэх, шинээр барих, малын ногоон тэжээл тарих зэрэг ажлуудыг хийсэн тухай тусгасан байв.</p>	<p>Зээл авсан малчин өрхүүдээр хяналт, мониторингоор ажилласан бөгөөд 2021 онд 9 малчин өрхийн малын тоо өссөн үзүүлэлттэй байсан бол, 2022 онд 1 малчин өрхийн малын тоо өссөн үзүүлэлттэй байжээ. Мөн малчдын зээлийн зарцуулалтын талаар авч үзвэл хашаа хороогоо засаж сэлбэсэн өрх нийт зээлдэгчдийн 60 орчим хувь, хадлангийн талбай хашаалсан өрх 10 хувь, ногоон тэжээл тариалсан өрх 13 орчим хувь, өвс тэжээл худалдан авсан өрх 17 орчим хувийг эзэлж байсан байна.</p>	<p>Өнгөрсөн 2 жилийн хугацаанд 2 удаагийн мониторингийн ажлыг зээд авсан малчдаар явж, хийсэн бөгөөд зээл зориулалтын дагуу ашиглаж байгаа эсэх, мал тооллогын явцтай танилцаж, малчдын хувьд холбогдох баримт бичгийн бүрдлийг эрчимжүүлэх талаар зөвлөгөө өгөн ажилласан байна.</p>
<p>Зээл авсан малчдын малын тооны бууралт</p>	<p>Нийт зээл авсан малчдын тоо нь 5-8 хувиар буурсан гэж байгаа боловч зээл авсан малчин тус бүрээр гаргасан малын тооны</p>	<p>Тайланд мэдээлэл тусгаагүй.</p>	<p>Зээл авсан малчин бүрийн малын тоог хонин толгойд шилжүүлснээр малын тоо нь 2022 онд 6 хувиар буурсан талаар тайланд тусгажээ.</p>	<p>Малын тооны бууралтын талаар зээл авсан он тус бүрээр харуулсан бөгөөд өнгөрсөн 2 жилийн хугацаанд 6427 малаар буурсан талаар дурдсан</p>	<p>Тайланд зээл авсан малчин өрхүүдийн малын тооны бууралтын талаар дэлгэрэнгүй тусгасан байв. 2021 оны хяналт мониторингоор зээл авсан бүх зээлдэгч малын тоогоо дунджаар 8 хувь буюу 1976</p>



Тайлангийн бүтэц	Их -Тамир сум	Цэнхэр сум	Бат-Өлзий сум	Их-Уул сум	Улаан-Уул сум
	бууралтын талаар мэдээлэл байхгүй.			байна. Нийт сумын хэмжээнд малын тоо өссөн байхад, зээл авсан малчин өрхийн хувьд малын тоо нь буурсан талаар онцолсон байв.	малаар буурсан талаар тусгасан байв.
Байгаль орчинд гарсан өөрчлөлт	Мэдээлэл тусгаагүй.	Мэдээлэл тусгаагүй.	Мэдээлэл тусгаагүй.	Мэдээлэл тусгаагүй.	Мэдээлэл тусгаагүй.
ОБЗЭС-аас үр шим хүртсэн өрхийн тоо	Нийт 44 малчинд 405.0 сая төгрөгийн зээлийг олгосон байна.	Нийт 57 малчдад 523.5 сая төгрөгийн зээлийг олгосон байна. Малын тоо толгой өсгөх бус бага хүүтэй зээлээр өрхийн хэрэгцээгээ хангахад тодорхой дэмжлэг болсон талаар дурдсан байв.	Нийт 66 малчин өрхөд 564.1 сая төгрөгийн зээлийг олгосон байна.	Нийт 60 малчдад 558.1 сая төгрөгийн зээлийг олгосон байна.	Нийт 62 зээлдэгчдэд 489.2 сая төгрөгийн зээл олгоод байгаа талаар дурдсан байна.
Иргэдийн ОБЗЭС-тай холбоотой санал, гомдлыг хүлээн авч, шийдвэрлэсэн эсэх	Мэдээлэл тусгаагүй.	Мэдээлэл тусгаагүй.	Мэдээлэл тусгаагүй.	Мэдээлэл тусгаагүй.	Улаан-Уул сумын хувьд Төрийн банкны үйл ажиллагаанаас болоод малчид зээлээ авах үйл ажиллагаа удаашралтай байсан тул энэхүү үйл ажиллагаатай холбоотой санал гомдол ирсэн байсан.
Төрийн банктай хамтран ажилласан талаар	Мэдээлэл тусгаагүй.	Мэдээлэл тусгаагүй.	Мэдээлэл тусгаагүй.	Мэдээлэл тусгаагүй.	ОБЗ-ийн 2022 оны намар шийдвэрлэсэн зээл дараа оны 1 сард олгогдсон нь Төрийн банкны үйл ажиллагаанаас болж хугацаа хоцорсон талаар дурдсан байв.

Судалгааны тайлан



Тайлангийн бүтэц	Их -Тамир сум	Цэнхэр сум	Бат-Өлзий сум	Их-Уул сум	Улаан-Уул сум
Тайлангийн үнэлгээ, тоогоор*	4/8	4/8	4/8	4/8	7/8
Тайлангийн үнэлгээ, хувиар	50.0%	50.0%	50.0%	50.0%	87.5%
Тайлбар	Их-Тамир сумын хувьд нийт 8 үйл ажиллагаанаас 4 үйл ажиллагааны талаар тайланд тусгасан байв.	Цэнхэр сумын хувьд мөн 8 үйл ажиллагаанаас 4 үйл ажиллагааны талаар тайланд дурдсан байв.	Бат-Өлзий сумын хувьд тайланд 8 үйл ажиллагаанаас 4 үйл ажиллагааг дурдсан байв.	Их-Уул сумын хувьд тайланд 8 үйл ажиллагаанаас 4 үйл ажиллагааны талаар тусгасан байв.	Улаан-Уул сумын хувьд тайланд тусгах ёстой 8 үйл ажиллагаанаас 7 үйл ажиллагааны талаар дурдсан байв.

\*- Удирдамж 2021 -ийн дагуу ОБЗ-ийн тайланд тусгах ёстой 8 зүйл байгаа бөгөөд үүнээс ОБЗ-үүдийн бичсэн тайланд тусгагдсан зүйлсийн тоо. Өөрөөр хэлбэл, Удирдамж 2021-ийн дагуу дээрх 8 агуулгын хүрээнд тайлан бичигдсэн байх ёстой байсан. Тайлангийн үнэлгээний томъёоллыг арга зүй хэсгээс харна уу.

Сумдын ОБЗ-ийн бичсэн тайланд үндэслэн дараах шүүмжүүдийг өгч байна. Үүнд:

1. Удирдамж 2021-ийн дагуу жил бүрийн эхний улиралд багтаан өнгөрсөн жилийн тайланг гэрээний оролцогч талуудад хүргэх ёстой ч, хяналт байхгүй байсан учраас ОБЗ-ийн хувьд 2021-2023 он хүртэл ажилласан нэг л тайлан бичсэн байв.
2. Тайлангийн агуулга нь яг ямар бүтцээр бичих нь тодорхойгүй учраас ОБЗ-үүдийн хувьд хийж, гүйцэтгэсэн ажлынхаа талаар бичсэн байсан нь ОБЗ-ийн тайлангийн бүтэц, агуулгын хувьд ялгаатай байв.
3. Зарим ОБЗ-ийн хувьд малчдад Төрийн банкнаас мэдээлэл ирэнгүүт малчдад зарыг 7-14 хоногийн өмнө багийн даргаар дамжуулан түгээж, зээлийн материалыг хүлээн авдаг байна. Өвөрхангай аймгийн Бат-Өлзий сум, Архангай аймгийн Их-Тамир сум, Завхан аймгийн Их-Уул сумын ОБЗ-ийн ирүүлсэн тайланд малчдад зараа хэрхэн түгээдэг талаар тусгаагүй байв.
4. Хяналт, мониторингийг зарим сумдын хувьд 4-5 удаа хийсэн талаар тайландаа бичсэн байхад, зарим сумдын хувьд 1 удаа, зарим сумдын хувьд хэдэн удаа мониторинг хийсэн талаар тодорхой тусгаагүй байв.
5. Мониторингоор ямар зөрчил илэрсэн талаар тайланд огт тусгаагүй. Зөрчил илэрсэн бол ямар арга хэмжээ авсан талаар огт байхгүй. Завхан аймгийн Их-Уул сумын хувьд хяналт хийхэд малын тоо нь өссөн айл байсан талаар дурдсан байсан ч, эдгээр айлуудад яг ямар арга хэмжээ авсан талаар огт тусгаагүй байв. Бусад сумдын хувьд илэрсэн зөрчил байсан эсэх талаар тайланд огт мэдээлэл байхгүй байв.
6. Удирдамж 2021 -ийн дагуу бол ОБЗ нь малын тооны бууралтыг зээл авсан малчин өрх тус бүрээр гаргах үүрэгтэй боловч, Хөвсгөл аймгийн Улаан-Уул, Завхан аймгийн Их-Уул сумдын тайланд малын тооны талаар тусгаж, буурсан малын тоог оруулсан байсан. Харин бусад 3 сумдын хувьд яг хэдэн малаар буурсан нь тодорхойгүй байв.
7. Мөн Удирдамж 2021 -ийн дагуу ОБЗ нь байгаль орчинд ямар өөрчлөлт гарч байгаа талаар, малчны бүлэгтэй байгуулсан гэрээний биелэлтийн талаар тусгах ёстой байсан боловч энэ талаар тайланд мэдээлэл огт тусгаагүй байв.
8. Удирдамж 2021-ийн үндсэн чиглэлийн дагуу ажиглагдсан байгаль орчны өөрчлөлтийг тусгаж, малчдын бүлэгтэй байгуулсан гэрээний биелэлтийг дүгнэсэн байх ёстой гэж үзэж байна. Харамсалтай нь тайланд эдгээр талуудын талаар мэдээлэл дутмаг байна.

### **2.1.5. Зээлийн 1.5 хувийн хүүг хэрхэн ашиглаж байгаа тухай тайлан**

ОБЗ нь улирал тутамдаа 1.5 хувийн хүүгийн зарцуулалтын тайланг талуудад тайлагнах үүрэгтэй. Энэхүү үүргийнхээ дагуу ОБЗ нь зарцуулалтын тайланг улирал бүр гаргадаггүй ч, тодорхой ажлуудыг хийж гүйцэтгэсэн тайланг гаргаж өгсөн. ОБЗЭС-ийн зорилтот сумдын ОБЗ-ийн хувьд сангийн 1.5 хувийн санхүүжилтийг өнгөрсөн 2 жилийн хугацаанд зээлийн удирдамжийн дагуу 60 хүртэл хувийг зөвлөлийн үйл ажиллагааг санхүүжүүлэхэд, 40 хүртэл хувийг ТХГН-ийн Орчны бүсийн тухай хуулийн 7.4.1-7.4.5 -д заасан заалтын дагуу дараах ажлуудыг хийж гүйцэтгэсэн байна. Үүнд:

Байгаль орчныг хамгаалах чиглэлээр:

- ТХГН-ийн зааг хязгаарыг таниулах зорилгоор мэдээллийн самбар, таних тэмдгүүдийг байрлуулсан.
- ТХГН-ийн зааг хязгаарыг таних багана байршуулсан.
- “Тэрбум мод” үндэсний хөтөлбөрийн хүрээнд мод тарьсан.

Нийгэмд зориулсан үйл ажиллагааны чиглэлээр:

- “Бид өөрсдөө байгаль хамгаалагч” хэлэлцүүлгийг малчдын дунд зохион байгуулсан.
- “Цэнхэр алтаа хайрлая” гар зураг, эсээ бичлэгийн уралдааныг дунд сургууль, цэцэрлэгийн хүүхдүүдийн дунд “Эх үрсийн баяр”-ыг угтан зохион байгуулсан.
- Амьжиргааны түвшнээс доогуур өрхийн хүүхдүүдэд 9 сарын 1-ийг угтаж хичээлийн хэрэгсэл, цүнх өгөр зэрэг ажлуудыг гүйцэтгэсэн байна.

Ингээд 1.5 хувийн хүүгийн зарцуулалтыг сум тус бүрээр авч үзье.

### **А. Архангай аймгийн Их-Тамир сум**

#### **Байгаль орчныг хамгаалах чиглэлээр хийсэн ажил**


Архангай аймгийн Их-Тамир сумын хувьд сангийн 1.5 хувийн хүүгийн орлогын 40 хувийг байгаль орчныг хамгаалах чиглэлээр Хөхнуур болон Хан – Өндөр багуудад мэдээллийн самбар болон таних тэмдгүүдийг хийж байрлуулсан байна. Үүнд: Хөхнуур багийн Урд гол, Хойд гол зэрэг газруудад мэдээллийн самбар 1 ширхэг, таних тэмдэг 5 ширхгийг, Хан-Өндөр багийн нутаг дэвсгэрт мэдээллийн самбар 1 ширхэг, таних тэмдэг 5 ширхгийг мөн хийж байрлуулсан байна.

**Зураг 5. Архангай аймгийн Их-Тамир сум, Хөхнуур багт байрлуулсан мэдээллийн самбар, таних тэмдэг**





**Зураг 6. Хан-Өндөр багийн нутаг дэвсгэрт байрлуулсан мэдээллийн самбар, таних тэмдэг**



### **ОБЗ-ийн үйл ажиллагааны чиглэлээр хийсэн ажил**

Их-Тамир сумын ОБЗ нь өнгөрсөн хугацаанд зээл авсан 46 малчин өрхөөр хяналт тавин, зээлээ зориулалтын дагуу зарцуулж хэрхэн зарцуулж байгаа талаар 100 хувь хүрч зөвлөгөө өгөн ажилласан байна.

### **В. Архангай аймгийн Цэнхэр сум**

#### **Байгаль орчныг хамгаалах чиглэлээр хийсэн ажил**

Архангай аймгийн Цэнхэр сумын ОБЗ-ийн хувьд 1.5 хувийн хүүгийн орлогын 40 хүртэл хувиар ТХГН-ийн Орчны бүсийн таних тэмдэг, хориглох тэмдгүүдийг нийт 2.4 сая төгрөгийн өртгөөр хийж гүйцэтгэжээ. Үүнд: Цэнхэр сумын Орхон багийн орчны бүс нутаг “Эх тээл” гэх газар мэдээллийн самбар 1 ширхэг, хориглох тэмдэг 3 ширхгийг хийж байрлуулсан.

**Зураг 7. Архангай аймгийн Цэнхэр сум, Орхон багийн орчны бүс нутаг “Эх тээл”-д байрлуулсан мэдээллийн самбар, таних тэмдэг**



Энэхүү Орчны бүс ТХГН-ийн таних тэмдгүүдийг байрлуулснаар иргэдийн хувьд ТХГН, Орчны бүсэд нэвтэрч байгааг мэдэх боломжийг бүрдүүлж өгсөн байна. Мөн Цэнхэр багийн орчны бүс нутаг “Ширдэгийн голын Согоот” гэх газар мэдээллийн самбар 1 ширхэг, хориглох тэмдэг 3 ширхгийг хийж байрлуулсан.



**Зураг 8. Архангай аймгийн Цэнхэр сум, “Ширдэгийн голын Согоот”-д байрлуулсан мэдээллийн самбар, таних тэмдэг**



**ОБЗ-ийн үйл ажиллагааны чиглэлээр хийсэн ажил**

Харин 1.5 хувийн хүүгийн орлогын 60 хүртэл хувиар өнгөрсөн Орчны бүсийн эргэлтийн сангаас зээл авсан малчдын зээлийн гэрээний биелэлтэд хяналт мониторинг хийх, зөвлөх үйлчилгээ үзүүлэх, сургалт сурталчилгаа хийх ажлаар Орчны бүсийн зөвлөлийн гишүүд 4 удаа малчин өрхүүдэд 100% хүрч ажиллан, энэхүү ажилд 2 сая 300 мянган төгрөгийн зардал гарсан. Тус сумын хувьд зээлд хамрагдсан малчдад хяналтаар явж ажиллахад зам бартаа ихтэй байдаг учраас хүүгийн орлогын зарцуулалтын ихэнх хувийг шатахууны зардал эзэлдэг байна.

**Зураг 9. Архангай аймгийн Цэнхэр сумын ОБЗ-ийн гишүүдийн зээлийн гэрээний биелэлтэд хяналт мониторинг, малчдад зээлийн талаар сурталчилж байгаа байдал**




Архангай аймгийн Цэнхэр сумын хувьд 1.5 хувийн хүүгийн орлогыг бүрэн зарцуулан, дээрх үйл ажиллагаануудыг хийж гүйцэтгэжээ.

### **С. Өвөрхангай аймгийн Бат-Өлзий сум**

#### **Байгаль орчныг хамгаалах чиглэлээр хийсэн ажил**

Өвөрхангай аймгийн Бат-Өлзий сумын хувьд 1.5 хувийн хүүгийн 40.0 хувийг байгаль орчныг хамгаалах чиглэлээр ТХГН-ийн хил заагийг 10 шон босгож, заагласан байна.

**Зураг 10. Бат-Өлзий сумын байгаль хамгаалах чиглэлээр хийсэн ажил**



#### **ОБЗ-ийн үйл ажиллагааны чиглэлээр хийсэн ажил**

ОБЗЭС-ийн хүүгийн орлогын 60 хувиар ОБЗ-ийн бичиг хэрэг, урамшуулал, зээл авах өрхийн сургалт, орчны бүсийн гишүүдийн сургалт, хяналт, мониторингийн үеийн шатахууны зардалд зарцуулсан байна.

### **Д. Завхан аймгийн Их-Уул сум**

#### **Байгаль орчныг хамгаалах чиглэлээр хийсэн ажил**

Завхан аймгийн Их-Уул сумын хувьд байгаль хамгаалах чиглэлээр дараах ажлуудыг хийж гүйцэтгэжээ. Үүнд:

- “Бид өөрөө байгаль хамгаалагчид” хэлэлцүүлгийг ТХГН-т болон орчны бүсэд амьдарч байгаа малчдын дунд зохион байгуулсан.
- Тэрбум мод үндэсний хөтөлбөрийн 350 ширхэг мод тарьжээ.
- Байгаль хамгаалах, эргүүл шалгалт, байгальтайгаа зөв зохистой харьцах, эссе бичлэг, зургийн тэмцээнийг цэцэрлэг, сургуулийн хүүхдүүдийн дунд зохион байгуулсан.
- Хуурайшилтын үед иргэдэд ойн хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх, хавар намрын удиралд оторт явах, ирэх үед улсын чанартай авто замаар зорчиж байгаа жолооч нарт авто замаар, ердийн хөсгөөр, мал тууварлаж байгаа гэсэн сэрэмжлүүлэг, брошурыг хэвлэн тараах зэрэг ажлуудыг хийж гүйцэтгэсэн байна.

### **ОБЗ-ийн үйл ажиллагааны чиглэлээр хийсэн ажил**

Зээлийн зарцуулалтад хяналт тавих зорилгоор хяналт, мониторингоор ажиллах шатахууны зардал, сургалт сурталчилгаа явуулах, эх үрсийн баяр, хичээлийн шинэ жилийн үеэр сумын амьжиргааны түвшнээс доогуур орлоготой өрхүүдийн хүүхдүүдэд хичээлийн хэрэглэл, цүнх, хүүхдийн баяраар бэлэг өгөх, бичиг хэргийн зардал, өвлийн улиралд сумын төвд өвөлжиж байгаа малчдад Монгол бичиг заах, “Хуулиа дээдэлье” АХА тэмцээн, ахмадуудын урлаг соёлын арга хэмжээ зэрэгт зарцуулсан байна.

#### ***Е. Хөвсгөл аймгийн Улаан-Уул сум***

### **Байгаль орчныг хамгаалах чиглэлээр хийсэн ажил**

Хөвсгөл аймгийн Улаан-Уул сумын ОБЗ нь “Улаан тайгын орчны бүс” нэртэй ТББ-ыг байгуулж, байгаль орчныг хамгаалах чиглэлээр байгаль орчны бохирдлоос хамгаалсан дахивар хог хаягдлыг дахин ашиглах тоног төхөөрөмж авч үйл ажиллагаа явуулахаар төлөвлөн 1.5 хувийн хүүгийн орлогыг хуримтлуулж, өнөөдрийн байдлаар 5.6 сая төгрөгийг хуримтлуулсан байна.

### **ОБЗ-ийн үйл ажиллагааны чиглэлээр хийсэн ажил**

ОБЗ-ийн хувьд 2021 оны 10 сард зээл авсан малчдын зээлийн хяналт, шалгалтыг хийх зорилгоор ажилласан бөгөөд энэхүү ажлын шатахууны зардал, зөвлөлийн гишүүдийн урамшуулал, бичиг хэргийн зардалд хүүгийн орлогыг зарцуулжээ.

#### ***Г. Зээлийн хүүгийн зарцуулалттай холбоотой дүгнэлт***

2021 оны 4-р улирлаас 2023 оны 3-р улирлыг дуустал нийт 8 удаагийн хүүгийн орлого тухайн сумын ОБЗЭС-ийн дансанд төвлөрсөн ба орлогын зарцуулалтыг сумдын ОБЗ-ийн өгсөн зарцуулалтын тайланд үндэслэн зарцуулалтад ОБЗ-ийн үйл ажиллагааны зардал болон байгаль хамгаалах чиглэлээр хийсэн ажилд зарцуулсан зардлын нийт зардалд эзлэх хувийг тооцон дараах хүснэгтээр харууллаа.

Архангай аймгийн Их-Тамир сумын хувьд нийт зарцуулсан зардлын 48.9 хувийг ОБЗ-ийн үйл ажиллагаанд зарцуулсан бол, 51.0 хувийг байгаль хамгаалах чиглэлд зарцуулсан нь Удирдамж 2021-ийн заалтын дагуу зарцуулагдсан болох нь харагдаж байна.



Архангай аймгийн Цэнхэр сумын хувьд ОБЗ-ийн үйл ажиллагаанд 60 хувийг, байгаль орчныг хамгаалах чиглэлээр хийсэн ажилд 40 хувийг нь зарцуулсан нь удирдамжийн дагуу зарцуулжээ.

**Хүснэгт 8. ОБЗЭС-ийн хүүгийн орлогын зарцуулалтын тайлан, үлдэгдэл, төгрөгөөр, сум бүрээр**

Сумын нэр	Зарцуулсан зардлын нийт дүн		Үлдэгдэл
	ОБЗ-ийн үйл ажиллагаа эзлэх хувь	Байгаль хамгаалах чиглэлээр хийсэн ажлын эзлэх хувь	
Их-Тамир	48.9	51.0	-
Цэнхэр	60.0	40.0	-
Бат-Өлзий	85.8	13.0	107,730.0
Их-Уул	46.1	54.9	-
Улаан-Уул	29.0	0.0	5,602,585.0
<b>Дундаж</b>	<b>53.9</b>	<b>39.7</b>	

Харин Өвөрхангай аймгийн Бат-Өлзий сумын хувьд ОБЗ-ийн үйл ажиллагаа нь нийт зарцуулалтын 85.8 хувийг эзэлж байгаа нь удирдамжийн зөвлөсөн 60.0 хувиас хэтэрсэн үр дүнтэй байна. Байгаль хамгаалах чиглэлээр зарцуулсан зардал нь дөнгөж 13.0 хувийг эзэлж, өнөөдрийн байдлаар 107.7 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байна.

Завхан аймгийн Их-Уул сумын хувьд ОБЗ-ийн үйл ажиллагааны зардал нь нийт зарцуулсан зардлын 46.1 хувийг эзэлж байгаа бол, байгаль хамгаалах чиглэлээр зарцуулсан зардал нь 54.9 хувийг эзэлж байна.

Хөвсгөл аймгийн Улаан-Уул сумын хувьд ОБЗ-ийн үйл ажиллагааны зардал нь нийт зардлын 29.0 хувийг эзэлж байгаа бол, өнөөдрийн байдлаар байгаль орчны чиглэлээр мөнгө зарцуулаагүй байна. Учир нь тус сумынхан дахивар хог хаягдал боловсруулдаг тоног төхөөрөмж худалдан авах зорилготойгоор хүүгийн орлогоо хуримтлуулж байгаа бөгөөд өнөөдрийн байдлаар 5.6 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна.

## **2.2. ТӨРИЙН БАНКНААС ГАРГАСАН ЗЭЭЛ ОЛГОЛТЫН ӨНӨӨГИЙН НӨХЦӨЛ БАЙДЛЫН ШИНЖИЛГЭЭ, УЯЛДАА ХОЛБОО**

### **2.2.1. Төрийн банкнаас гаргасан нийт зээлийн тоо, зорилго, эргэн төлөлт, найдваргүй зээлдэгчдийн тоо**

“Орчны бүсийн эргэлтийн сан”-аас 2023 оны 07 сарын 31-ний байдлаар Архангай, Өвөрхангай, Завхан, Хөвсгөл 4 аймгийн 5 сумын 289 малчдад нийтдээ 2.5 тэрбум гаруй төгрөгийг олгоод байна. 2021 онд анх зээлийг олгоход сум бүрд Германы Сэргээн Босголт зээлийн банкнаас 86000 еврогийн<sup>3</sup> санхүүжилтийг олгосон бөгөөд тухайн ханшаас шалтгаалан сумуудын хувьд ойролцоогоор 280 гаруй сая төгрөгийн санхүүжилтийг хүлээн авсан байна.

### **2.2.2. Олгосон нийт зээлийн тоо, хэмжээ**

2021 онд Завхан аймгийн Их -Уул сумын хувьд 32 малчин өрхөд 298.5 сая төгрөгийг, Архангай аймгийн Их -Тамир сумын хувьд 30 малчин өрхөд 277.5 сая

<sup>3</sup> - “Орчны бүсийн эргэлтийн сан”-ийн зээлийг дамжуулан зээлдүүлэх гэрээ, 2021 он

төгрөгийг, Цэнхэр сумын хувьд 32 малчин өрхөд 287.5 сая төгрөгийг, Өвөрхангай аймгийн Бат-Өлзий сумын хувьд 35 малчин өрхөд 286.8 сая төгрөгийг, Хөвсгөл аймгийн Улаан-Уул сумын хувьд 38 малчин өрхөд 287.5 орчим сая төгрөгийг тус тус олгожээ. Хөвсгөл аймгийн Улаан-Уул сумын хувьд бусад сумуудтай харьцуулахад хамгийн олон малчдад тус зээлийг олгосон байна..

“Орчны бүсийн эргэлтийн сан”-ийн зээл нь малчдад олгосон зээлийн эргэн төлөлтөөр санхүүжих бөгөөд Төрийн банкны хувьд тухайн зээлийн эргэн төлөлтийг орж ирэнгүүт нь Орчны бүсийн зөвлөлд мэдэгдэж, сангийн үлдэгдлийг түргэн эргэлдүүлэх үүргийг хүлээсэн. Энэхүү ажлын хүрээнд 2022 онд Завхан аймгийн Их-Уул сумын хувьд 94.9 сая төгрөгийн, Архангай аймгийн Их-Тамир сумын хувьд 78.0 сая төгрөгийн, Цэнхэр сумын хувьд 148.0 сая төгрөгийн, Өвөрхангай аймгийн Бат-Өлзий сумын хувьд 154.8 сая төгрөгийн, Хөвсгөл аймгийн Улаан-Уул сумын хувьд 64.37 сая төгрөгийн, нийт 540.1 сая төгрөгийн эргэн төлөлт төвлөрчээ. Эргэн төлөлт хамгийн сайн байсан нь Өвөрхангай аймгийн Бат-Өлзий сум бөгөөд 2021 онд олгосон нийт зээлийн 54.0 хувь нь 2022 онд эргэн төлөгдсөн бол, Архангай аймгийн Цэнхэр сумын хувьд 51.5 хувь, Завхан аймгийн Их-Уул сумын хувьд 31.8 хувь, Архангай аймгийн Их-Тамир сумын хувьд 28.1 хувь, Хөвсгөл аймгийн Улаан-Уул сум 22.4 хувь буюу хамгийн бага байсан байна. Зээлийн эргэн төлөлт нь тухайн малчин өрхтэй хийж байгаа зээлийн гэрээний эргэн төлөлтөөс хамаарах бөгөөд малчид голдуу үндсэн зээлээ жилдээ 2 удаа хуваан төлөх үүргийг хүлээсэн байна<sup>4</sup>.

Тухайлбал, тухайн жилийн хавар болон намрын улиралд жилдээ 2 удаа зээлийн эргэн төлөлт орж ирэх бөгөөд мөн ОБЗ нь жилдээ 2 удаа хуралдан, зээлийг олгодог байна.

**Хүснэгт 9. “Орчны бүсийн эргэлтийн сан”-аас олгосон нийт зээлийн хэмжээ, төгрөгөөр**

Он	Сум	Олгосон зээлийн тоо	Олгосон зээлийн хэмжээ	Зээлийн эргэн төлөлтийн хувь
2021	Их -Уул	32	298,500,000.0	-
	Их-Тамир	32	287,000,000.0	-
	Цэнхэр	32	287,541,860.0	-
	Бат-Өлзий	35	286,800,000.0	-
	Улаан - Уул	38	287,470,000.0	-
	<b>Нийт</b>	<b>169</b>	<b>1,447,311,860.0</b>	
2022	Их -Уул	11	94,940,000.0	31.8
	Их-Тамир	8	78,000,000.0	28.1
	Цэнхэр	16	148,000,000.0	51.5
	Бат-Өлзий	18	154,800,000.0	54.0
	Улаан - Уул	8	64,370,000.0	22.4
	<b>Нийт</b>	<b>61</b>	<b>540,110,000.0</b>	
2023	Их -Уул	17	164,700,000.0	55.2
	Их-Тамир	4	40,000,000.0	14.4
	Цэнхэр	9	88,000,000.0	30.6
	Бат-Өлзий	13	122,500,000.0	42.7
	Улаан - Уул	16	137,390,000.0	47.8
	<b>Нийт</b>	<b>59</b>	<b>552,590,000.0</b>	
<b>Нийт</b>	<b>289</b>	<b>2,540,011,860.0</b>		

<sup>4</sup> - Чанарын судалгаанд оролцогч, Төрийн банкны төлөөлөл


2022 онд олгосон зээлийг авч үзвэл эргэн төлөлтөөр бүх сумын хэмжээгээр нийт 540.1 сая төгрөг цугларсан бөгөөд үүнийг нийт 61 малчин өрхөд олгосон байна. Үүнээс Завхан аймгийн Их-Уул сумын хувьд 11 малчин өрхөд 94.9 сая төгрөгийг, Архангай аймгийн Их-Тамир сумын хувьд 8 малчин өрхөд 78.0 сая төгрөгийг, Цэнхэр сумын хувьд 16 малчин өрхөд 148.0 сая төгрөгийг, Өвөрхангай аймгийн Бат-Өлзий сумын хувьд 18 малчин өрхөд 154.8 сая төгрөгийг, Хөвсгөл аймгийн Улаан-Уул сумын хувьд 8 малчин өрхөд 64.37 сая төгрөгийг тус тус олгосон нь дээрх хүснэгтээс харагдаж байна.

2023 онд зээлийн эргэн төлөлтөөр бүх сумын хэмжээгээр нийт 552.59 сая төгрөг цугларсан бөгөөд үүнийг нийт 59 малчин өрхөд олгосон байна. Үүнээс Завхан аймгийн Их-Уул сумын хувьд 17 малчин өрхөд 164.7 сая төгрөг, Архангай аймгийн Их-Тамир сумын хувьд 4 малчин өрхөд 40.0 сая төгрөг, Цэнхэр суманд 9 малчин өрхөд 88.0 сая төгрөг, Өвөрхангай аймгийн Бат-Өлзий суманд 13 малчин өрхөд 122.5 сая төгрөг, Хөвсгөл аймгийн Улаан-Уул суманд 16 малчин өрхөд 137.39 сая төгрөгийн зээлийг тус тус олгосон байна.

2021 онд олгосон зээлийн хэмжээнд нэг сумын эзлэх хувь ойролцоо буюу 20.0 хувь орчим байгаа бол, 2022 онд олгосон зээлийн 27.4 хувийг Архангай аймгийн Цэнхэр сум, 28.7 хувийг Өвөрхангай аймгийн Бат-Өлзий сум, 17.6 хувийг Завхан аймгийн Их-Уул сум, 14.4 хувийг Архангай аймгийн Их-Тамир сум, 11.9 хувийг Хөвсгөл аймгийн Улаан-Уул сум эзэлж байгаагаас харахад олгосон зээлийн эргэн төлөлтийн ялгаатай байдлаас хамаарч тухайн сумын олгосон зээлийн хэмжээ нь тухайн жилд олгосон нийт зээлд эзлэх хувь нь ялгаатай байгаа юм.

Харин 2023 онд олгосон зээлийн 29.8 хувийг Завхан аймгийн Их-Уул сум, 24.9 хувийг Хөвсгөл аймгийн Улаан-Уул сум, 22.2 хувийг Өвөрхангай аймгийн Бат-Өлзий сум, 15.9 хувийг Архангай аймгийн Цэнхэр сум, үлдсэн 7.2 хувийг Архангай аймгийн Их-Тамир сум тус тус эзэлж байна. Үүнээс харахад 2023 онд Завхан аймгийн Их-Уул сумын хувьд зээлийн эргэн төлөлт хамгийн өндөр байсан нь харагдаж байна. Харин Архангай аймгийн Их-Тамир сумын хувьд хамгийн бага зээлийг 2023 онд олгосон байгаа нь тухайн сумын хувьд зээлийн эргэн төлөлт 2023 онд хамгийн бага буюу 14.4 хувьтай байсан байна.

**График 1. “Орчны бүсийн зээлийн эргэлтийн сан”-аас олгосон нийт зээлд сумуудын олгосон зээлийн эзлэх хувь, оноор**



2021 оноос зээл анх олгож эхэлснээс хойш 2023 оны 07 сарын 31 -ний байдлаар Завхан аймгийн Их-Уул сумын хувьд нийт 60 малчин өрхөд 558.14 сая төгрөгийн, Архангай аймгийн Их-Тамир сумын хувьд 44 малчин өрхөд 405.0 сая төгрөгийн, Цэнхэр сумын хувьд 57 малчин өрхөд 523.54 сая төгрөгийн, Өвөрхангай аймгийн Бат-Өлзий сумын хувьд 66 малчин өрхөд 564.1 сая төгрөгийн, Хөвсгөл аймгийн Улаан-Уул сумын хувьд 62 малчин өрхөд 489.23 сая төгрөгийн зээлийг тус тус олгожээ.

**Хүснэгт 10. 2021-2023 оны хооронд олгосон нийт зээлийн хэмжээ болон зээл авсан малчдын тоо**


Сум	Нийт зээл авсан малчид		Нийт олгосон зээлийн хэмжээ		
	Тоо	Эзлэх хувь	Төгрөгөөр	Эзлэх хувь	1 малчин өрхөд ногдох
Их -Уул	60	20.9	558,140,000.0	22.1	9,302,333.3
Их-Тамир	44	14.6	405,000,000.0	15.6	9,416,666.7
Цэнхэр	57	19.9	523,541,860.0	20.7	9,184,944.9
Бат-Өлзий	66	23.0	564,100,000.0	22.3	8,546,969.7
Улаан - Уул	62	21.6	489,230,000.0	19.3	7,890,806.5
<b>Нийт</b>	<b>289</b>	<b>100.0</b>	<b>2,540,011,860.0</b>	<b>100.0</b>	<b>-</b>

Архангай аймгийн Их-Тамир сумын хувьд хамгийн бага малчдыг зээлд хамруулсан бол Өвөрхангай аймгийн Бат-Өлзий сумын хувьд хамгийн олон малчин өрхийг зээлд хамруулсан байна. Нэг малчин өрхөд олгосон дундаж зээлийн хэмжээг авч үзвэл Архангай аймгийн Их-Тамир сумын хувьд нэг малчин өрхөд дунджаар 9.416 сая төгрөгийн зээл олгосон бол, Хөвсгөл аймгийн Улаан-Уул сумын хувьд хамгийн бага буюу нэг малчин өрхөд дунджаар 7.89 сая төгрөгийн зээлийг дунджаар олгожээ.

**2.2.3. Зээлийн үлдэгдэл**

2023 оны 07 сарын 31-ний өдрийн байдлаар “Орчны бүсийн зээлийн эргэлтийн сан”-ийн зээлийн үлдэгдлийг авч үзвэл нийт 242 зээлдэгчийн 1.284 тэрбум төгрөгийн үлдэгдэлтэй байна. Үүний 32.6 хувийг 2021 онд олгосон зээлийн үлдэгдэл, 27.3 хувийг 2022 онд олгосон зээлийн үлдэгдэл, 40.1 хувийг 2023 онд олгосон зээлийн үлдэгдэл эзэлж байна.

**График 2. “Орчны бүсийн эргэлтийн сан”-ийн зээлийн үлдэгдэл, төгрөгөөр**



Он тус бүрээр нь авч үзвэл 2021 онд олгосон зээлийн 29.1 хувь, 2022 онд олгосон зээлийн 64.8 хувь, 2023 онд олгосон зээлийн 93.2 хувийн тус тус үлдэгдэлтэй байна.

Зээлийн үлдэгдлийг сум тус бүрээр авч үзвэл 2023 оны 07 сарын 31-ний өдрийн байдлаар Завхан аймгийн Их-Уул сумын хувьд 46 малчин өрхийн 267.48 сая төгрөгийн, Архангай аймгийн Их-Тамир сумын хувьд 39 малчин өрхийн 246.86 сая төгрөгийн, Цэнхэр сумын хувьд 51 малчин өрхийн 274.12 сая төгрөгийн, Өвөрхангай аймгийн Бат-Өлзий сумын хувьд 53 малчин өрхийн 259.6 сая төгрөгийн, Хөвсгөл аймгийн Улаан-Уул сумын хувьд 236.4 сая төгрөгийн тус тус зээлийн үлдэгдэлтэй байна. Үүнийг дараах хүснэгтээр харууллаа.

**Хүснэгт 11. “Орчны бүсийн зээлийн эргэлтийн сан”-ийн зээлийн үлдэгдэл, сумаар, 2023 оны 07 сарын 31-ний өдрийн байдлаар**

Сум	Зээлтэй малчдын тоо	Зээлийн үлдэгдэл	
		Төгрөгөөр	Хувиар
Их -Уул	46	267,485,999.5	20.8
Их-Тамир	39	246,867,115.5	19.2
Цэнхэр	51	274,124,200.5	21.3
Бат-Өлзий	53	259,599,922.6	20.2
Улаан - Уул	53	236,360,000.0	18.4
<b>Нийт</b>	<b>242</b>	<b>1,284,437,238.1</b>	<b>100.0</b>

Зээлийн үлдэгдэлд сумдын эзлэх хувийг авч үзвэл нийт үлдэгдлийн 21.3 хувийг Архангай аймгийн Цэнхэр сум, 20.8 хувийг Завхан аймгийн Их-Уул сум, 20.2 хувийг Өвөрхангай аймгийн Бат-Өлзий сум, 19.2 хувийг Архангай аймгийн Их-Тамир сум, 18.4 хувийг Хөвсгөл аймгийн Улаан-Уул сум тус тус эзэлж байна. Үүнээс харахад сумуудын зээлийн үлдэгдэл ойролцоо байгаа нь харагдаж байна. 2023 оны 07 сарын 31-ний байдлаар нийт олгосон байсан 287 зээлийн 45 буюу 15.7 хувь нь зээлээ бүрэн төлж дуусгажээ.

#### 2.2.4. Зээлийн зориулалт

“Орчны бүсийн зээлийн эргэлтийн сан”-аас олгох “Байгальд ээлтэй малчны зээл”-ийн удирдамжийн дагуу зээлийг орлого нэмэгдүүлэх бизнес болон байгаль орчинд ээлтэй ямар ч үйл ажиллагаанд ашиглаж болох ба дараах чиглэлээр ашиглахыг зөвлөмж болгожээ<sup>5</sup>. Үүнд:

1. Малын тоо толгойг бууруулах замаар бэлчээр, тэжээлийн хангамж, ашиг шимийг сайжруулах
2. Малын чанарыг сайжруулах, мал, малын гаралтай бүтээгдэхүүний эрүүл ахуй, хүнсний аюулгүй байдлын стандартын шаардлагыг хангах замаар бүтээгдэхүүний үнэлэмжийг дээшлүүлэх
3. Бүлэг хамтаараа МАА-н бүтээгдэхүүнийг боловсруулах жижиг цех, боловсруулах үйлдвэр байгуулах, худалдан авагчидтай түншийн гэрээгээр борлуулах замаар зардал хэмнэх, бүтээгдэхүүний үнэлэмжийг нэмэгдүүлэх.
4. Бэлчээрийн ашиглалтаа зүй зохистой болгох, нөхөн сэргээх (олон настын үр цацах) зэрэг зорилгоор ашиглахыг зөвшөөрсөн байна.

2023 оны 07 сарын 31-ний байдлаар 4 аймгийн нийт 289 зээлдэгчдийн зээлийн мэдээллээс зээлийн зориулалтаар авч үзвэл давхардсан тоогоор нийт зээлийн 40.9 хувь нь малынхаа үүлдэр, угсаа, чанарыг сайжруулах зорилгоор, 31.6 хувь нь малын хашаа

<sup>5</sup> - Байгальд ээлтэй малчны зээлийн удирдамж, 2021 он



саравч, байр барих, шинээр барих зориулалтаар, 12.8 хувь нь өрхийн хэрэгцээнд, 7.1 хувь нь хадлангийн талбай хашаалах, өвс тэжээл бэлтгэх, 2.2 хувь нь малын тэжээл тарих, худалдан авах, ногоон тэжээл тариалах, 0.4 хувь нь байгалийн нөөцийг хамгаалах, булаг хамгаалах чиглэлээр авсан бол 1.3 хувь нь малын түүхий эд боловсруулах, хүнсний ногоо тариалах зэрэг зорилгоор олгосон байна. Нийт зээлийн зорилгод өндөр хувийг эзэлж байгаа малын үүлдэр угсаа, чанарыг сайжруулах зорилгоор олгосон зээл нь сангийн зээлийн зорилготой бүрэн нийцэж байна.

**Хүснэгт 12. “Орчны бүсийн зээлийн эргэлтийн сан”-аас олгосон зээлийн зориулалт, давхардсан тоогоор, хувиар**


№	Зээлийн зориулалт	Хувь
1	Малынхаа үүлдэр, угсаа, чанарыг сайжруулах	40.9
2	Малын хашаа саравчаа засах, барих	31.6
3	Өрхийн хэрэгцээнд (Оюутны сургалтын төлбөр төлөх)	12.8
4	Хадлангийн талбай хашаалах, өвс тэжээл бэлтгэх	7.1
5	Ногоон тэжээл тариалах, малын тэжээл худалдан авах	2.2
6	Сүү цагаан идээ боловсруулах	2.2
7	Бэлчээр хамгаалах, сайжруулах	1.5
8	Малын түүхий эд боловсруулах	1.1
9	Байгалийн нөөцийг нөхөн сэргээх (булаг хашаалах)	0.4
10	Хүнсний ногоо тариалах	0.2
<b>Нийт</b>		<b>100.0</b>

Харин нийт зээлийн багцын 40 хувиас илүүгүйг “Хувийн хэрэглээний зориулалтаар олгож болно” гэсэн заалтын дагуу 12.8 хувийг малчид өрхийн хэрэглээ, оюутны сургалтын төлбөр төлөх зорилготой авсан нь сангийн зээлийн зорилгоос хэтрээгүй байгаа нь харагдаж байна.

Бэлчээрийн ашиглалтаа зүй зохистой болгох, нөхөн сэргээх чиглэлээр олгосон зээл нь нийт зээлдэгчдийн дөнгөж 1.9 хувийг эзэлж байгаа нь энэ зорилгоор зээл авсан малчид бага байгаа нь харагдаж байна. Мөн өрхийн нэмэлт орлого олох боломжтой МАА-н бүтээгдэхүүнийг боловсруулах, бүлэг хамтаараа бүтээгдэхүүнээ борлуулж, зардлаа хэмнэх, бүтээгдэхүүний үнэлэмжийг нэмэгдүүлэх зорилго бүхий чиглэлээр олгосон зээл нь дөнгөж нийт зээлийн 3.5 хувийг эзэлж байгаагаас харахад малын тоогоо бууруулснаар малчин өрхийн орлогоо тогтмол нэмэгдүүлэх орлогын эх үүсвэрийг бий болгох боломж хязгаарлагдмал байгаа нь харагдаж байна.

“Орчны бүсийн зээлийн эргэлтийн сан”-ийн “Байгальд ээлтэй малчны зээл”-ийн гол шалгуур болсон малын тоогоо бууруулах зорилгоор малынхаа үүлдэр, угсааг сайжруулах, чанаржуулах зорилготой авсан зээлийг зорилтот зээлийн сумдаар авч үзвэл Бат-Өлзий сум 47.1 хувийг, Цэнхэр сум 28.3 хувийг, Их-Тамир сум 16.7 хувийг, 6.5 хувийг Улаан-Уул сум, 1.4 хувийг Их-Уул сум тус тус эзэлж байна.

**График 3. Малынхаа үүлдэр, угсаа, чанарыг сайжруулах зорилгоор олгосон зээлд сумуудын эзлэх хувь**



### 2.2.5. Чанаргүй зээлийн хэмжээ

Чанаргүй зээлийн ангилалд орсон зээл одоогийн байдлаар байхгүй байна. (2023 оны 09 сард хийсэн чанарын судалгааны үр дүн).

## 2.3. ЗОРИЛТОТ СУМДЫН МАЛЫН ТООНЫ ӨӨРЧЛӨЛТ

ОБЗЭС-ийн төслийн зорилтот сумдын хувьд нийт малын тоог хонин толгойд шилжүүлсэн дүнгээр авч үзэхэд 2021 онд нийт сумдын хувьд 6.7 хувь өссөн бол, 2022 онд өмнөх оноос 3.5 хувиар өссөн нь төслийн зорилтод сумдад малын тооны өсөлт саарч байгаа нь ажиглагдаж байна. 2020-2023 оны хугацаанд нийтдээ дунджаар 5.5 хувиар өссөн байна. Сум бүрээр сүүлийн 3 жилээр малын тоог авч үзвэл, Архангай аймгийн Их-Тамир сумын хувьд 2020 онд хонин толгойд шилжүүлснээр 844.7 мянган толгой малтай байсан бол 2021 онд 864.2 мянган толгой болж, 2.3 хувиар өсжээ. Харин 2022 онд 947.2 мянган толгой болж, өмнөх оноос 9.6 хувь өссөн байна. Архангай аймгийн Цэнхэр сумын хувьд 2021 онд хонин толгойд шилжүүлсэн малын тоо нь 2020 онтой харьцуулахад 6.1 хувиар өссөн бол, 2022 онд 8.4 хувиар тус тус өсжээ. Хөвсгөл аймгийн Улаан-Уул сумын хувьд 2021 онд өмнөх онтой харьцуулахад 7 хувиар өссөн бол, 2022 онд 10.3 өссөн байна. Өвөрхангай аймгийн Бат-Өлзий сумын хувьд 2021 онд өмнөх оноос 13.4 хувь өссөн бол, 2022 онд өмнөх оноос 15.4 хувиар буурчээ. Харин Завхан аймгийн Их-Уул сумын хувьд 2021 онд 5.6 хувиар өссөн бол, 2022 онд өмнөх оноос 7.4 хувиар тус тус өсжээ.

## Хүснэгт 13. ОБЗЭС-ийн зорилтот сумдын малын тооны өөрчлөлт

№	Аймаг	Сум	Баг	Малын тоо ( хонин толгойд шилжүүлснээр)			Өсөлт, бууралт (хувиар)		Дундаж өөрчлөлт, хувиар	
				2020	2021	2022	2020-2021	2021-2022		
1	Архангай	Их-Тамир	Хөхнуур	170,177.8	168,868.7	179,033.3	-0.8	6.0	2.6	
			Хан-Өндөр	154,895.1	155,176.9	170,253.2	0.2	9.7	4.9	
		<b>Нийт</b>			<b>844,723.4</b>	<b>864,173.9</b>	<b>947,162.8</b>	<b>2.3</b>	<b>9.6</b>	<b>6.0</b>
		Цэнхэр	Орхон	197,962.3	208,235.0	211,030.3	5.2	1.3	3.3	
		<b>Нийт</b>			<b>823,628.9</b>	<b>873,596.4</b>	<b>947,096.1</b>	<b>6.1</b>	<b>8.4</b>	<b>7.2</b>
2	Хөвсгөл	Улаан-Уул	Мунгараг	90,483.5	95,942.9	103,011.9	6.0	7.4	6.7	
			Гун	37,970.5	42,097.0	47,270.9	10.9	12.3	11.6	
			Соёо	75,271.7	76,607.6	86,636.8	1.8	13.1	7.4	
		<b>Нийт</b>			<b>430,968.1</b>	<b>461,077.1</b>	<b>508,353.0</b>	<b>7.0</b>	<b>10.3</b>	<b>8.6</b>
3	Өвөрхангай	Бат-Өлзий	Бүрэгтий	154,524.5	173,050.6	150,241.9	12.0	-13.2	-0.6	
		<b>Нийт</b>			<b>696,210.3</b>	<b>789,378.8</b>	<b>668,077.8</b>	<b>13.4</b>	<b>-15.4</b>	<b>-1.0</b>
4	Завхан	Их-Уул	Цэцүүх	118,565.3	116,248.8	118,608.6	-2.0	2.0	0.0	
			Зарт	122,195.8	124,647.6	130,931.0	2.0	5.0	3.5	
		<b>Нийт</b>			<b>521,258.1</b>	<b>550,594.0</b>	<b>591,322.0</b>	<b>5.6</b>	<b>7.4</b>	<b>6.5</b>
<b>Нийт</b>				<b>3,316,788.8</b>	<b>3,538,820.2</b>	<b>3,662,011.7</b>	<b>6.7</b>	<b>3.5</b>	<b>5.5</b>	

Эх үүсвэр: www.1212.mn

Төсөлд хамрагдсан орчны бүсийн багийн малын тоог авч үзвэл 2021 онд Архангай аймгийн Их-Тамир сумын Хөхнуур баг, Завхан аймгийн Их-Уул сумын Цэцүүх багуудын хувьд малын тоо нь өмнөх оноос буурсан байгаа бол, бусад багуудын хувьд малын тоо нь өссөн харагдаж байна. Харин 2022 онд Өвөрхангай аймгийн Бат-Өлзий сумын Бүрэгтий багийн хувьд малын тоо нь өмнөх оноос 13.2 хувиар буурсан бол, бусад багуудын хувьд өссөн нь дээрх хүснэгтээс харагдаж байна. Дээрх хүснэгтээс харахад 2020 оноос хойш нийт сумдаар малын тоо өссөн бөгөөд хонин толгойд шилжүүлснээр Архангай аймгийн Их-Тамир сумын хэмжээнд 102439.2 толгойгоор, Цэнхэр сумын хэмжээнд 123467.2 толгойгоор, Хөвсгөл аймгийн Улаан-Уул сумын хэмжээнд 77384.9 толгойгоор, Завхан аймгийн Их-Уул сумын хэмжээнд 70063.9 толгой малаар тус тус өссөн бол, харин Өвөрхангай аймгийн Бат-Өлзий сумын хэмжээнд 28132.5 толгой малаар буурчээ.

## 2.4. ЗЭЭЛ ОЛГОЛТЫН ҮЙЛ ЯВЦ ДАХ ОРОЛЦОГЧ ТАЛУУДЫН ҮҮРЭГ, ХАРИУЦЛАГЫН ҮНЭЛГЭЭ

Энэхүү хэсэгт ОБЗЭС-ийн үйл ажиллагаанд үүрэг хүлээсэн талуудын үйл ажиллагаа ямар байсан, оролцогч талуудын оролцоо, үүрэг, хариуцлага ямар байсан талаар орууллаа.

### 2.4.1. ОБЗ-ийн ажилласан байдалд хийсэн шинжилгээ

ОБЗ-ийн хувьд зээл олгох үйл ажиллагааг удирдан зохион байгуулах, малчдын өгсөн өргөдлийг үндэслэн зөвлөлийн хурлаар зээл олгох шийдвэрийг гаргах, мөн зээл олгохтой холбоотой мэдээллийг малчдад хүргэх, зээлийн хяналт мониторингийг хийх үүргийн хүрээнд сумуудын ОБЗ нь ажиллаж байна. “Байгальд ээлтэй малчны зээл” нь тухайн сумын хувьд тулгамдаад байгаа бэлчээрийн даацын асуудал, ургамлын бүтэц өөрчлөгдөөд, ургадаг олон төрлийн ургамал нь ургахгүй цөөрөөд байгаа асуудлыг шийдэхэд тодорхой хэмжээнд нөлөөлсөн гэж үзжээ. Учир нь зээл авсан малчид үүргийнхээ хүрээнд малынхаа тоог бууруулж, малынхаа чанарт анхаарч эхэлсэн нь тухайн орчны бүсэд амьдарч байгаа малын тоог бууруулахад чухал хөшүүрэг болсон гэж үзэж байна.

Сумуудын ОБЗ нь хавар, намрын улиралд буюу жилдээ 2 удаа ОБЗ-ийн хурлыг зохион байгуулж байна. Учир нь зээл авсан малчдын зээлийн үндсэн төлөлт нь жилдээ 2 удаа орж ирдэгтэй холбоотойгоор санхүүжилт орж ирсэн даруйд хуралдаж, зээлийг олгон сангийн үйл ажиллагааг тогтвортой явуулахад чиглэн ажиллаж байна. Мөн сумуудын хувьд зээл олгох талаар зарыг 7-14 хоногийн өмнө багийн дарга нараар дамжуулан малчдад зар түгээдэг бөгөөд зарим сумдын хувьд давхар сумынхаа фэйсбүүк хуудсаар дамжуулан зарыг нийтэд нээлттэй хүргэж байна.

Зээл авсан малчдын хувьд хяналтыг сумуудын ОБЗ-ийн хувьд өнгөрсөн 2 жилийн хугацаанд янз бүр хийсэн байна. Зарим сумуудын жилдээ 1 удаа хяналт хийсэн байхад, зарим сумуудын хувьд улиралдаа 1 удаа, хагас жилдээ 1 удаа хяналтаар ажилласан байна. Хяналтаар явахад ямар нэгэн зөрчил илрээгүй байна.

#### **Шигтгээ 1. Чанарын судалгаанд оролцогч ОБЗ-ийн даргын сэтгэгдлээс**

*Зээл авснаас хойш 2 удаа мониторинг хийсэн. Тэрнээс хойш ихэнхдээ багийн даргаар утсан хэлбэрээр болон малын хөлийн тоо толгойн татварын тоон дээр ажлын хэсэг гаргаж хянадаг байсан. Багийн дарга нар энэ тоон дээр хяналт тавьдаг байсан. Миний хувьд бол өөрөө малын тоо болгон дээр хяналт хийдэг. Хагас жил дээр бол хяналт хийдэггүй.*

“ОБЗЭС-ийн зээлийг дамжуулан зээлдүүлэх гэрээ”-ий дагуу ОБЗ нь 11 үүрэг, “Байгальд ээлтэй малчны зээл”-ийн удирдамжийн дагуу ОБЗ нь 12 заалтын дагуу үйл ажиллагааг явуулах үүрэгтэй байна. Эдгээр үүргүүдээс утга санаа давхацсан заалтуудыг нэгтгэн дараах хүснэгтэд нэгтгэн харууллаа. ОБЗ-ийн үйл ажиллагааны гүйцэтгэлийг үнэлэхдээ сумын ОБЗ нь тухайн ажлыг хийж гүйцэтгэсэн бол нийт хэдэн сумын ОБЗ нь тухайн ажлыг хийж гүйцэтгэсэн болохыг тооцож, үнэллээ.

**Хүснэгт 14. ОБЗ-ийн үйл ажиллагааны эрх, үүрэг, оролцоо, хариуцлагад хийсэн шинжилгээ, Бүлэг 1.3.1-ийн 36 хэсгийг харх.**

№	Эрх, үүрэг	Их- Тамир сумын ОБЗ	Цэнхэр сумын ОБЗ	Бат-Өлзий сумын ОБЗ	Их-Уул сумын ОБЗ	Улаан-Уул сумын ОБЗ	Гүйцэтгэлийн үнэлгээ*, оноогоор	Тайлбар
1	<b>Зээлийн хүсэлт хүлээн авах зарыг иргэдэд, ил тод хүртээмжтэй байдлаар хэрхэн яаж хүргэдэг талаар (Мэдээллийг 14 хоногийн өмнө түгээх)</b>	Төрийн банкнаас мэдээлэл өгсөн даруйд 7 хоногийн өмнө зээл авахыг сонирхож байсан малчдадаа багийн даргаар нь дамжуулан мэдээлэл түгээдэг. Мөн ОБ-д багтдаг 2 багийн фэйсбүүк хуудсаар зарыг түгээдэг.	Багийн даргаар нь дамжуулан 14 хоногийн өмнө мэдээллийг түгээдэг ба багийн хурлаар, тараах материал.	Багийн хурал болон янз бүрийн хурал, сургалтын үеэр зээлийн талаарх мэдээллийг тухайн орчны бүсэд амьдарч байгаа малчдад хүргэдэг.	Зээлийн хүсэлт авах болсон талаар багийн даргаар дамжуулан мэдээллийг түгээдэг.	Багийн дарга болон сүлжээ орсон багийн малчдад олон нийтийн сүлжээг дамжуулан зараа түгээдэг. Мөн зээлийн талаар сонирхож ирсэн малчин бүрд мэдээллийг дэлгэрэнгүй тайлбарлан хүргэдэг.	5/5	ОБЗ нь Төрийн банкнаас санхүүжилт орж ирсэн талаар мэдээлэл авангуут малчдад зээлийн материал хүлээн авах талаарх мэдээллийг тодорхой хэмжээнд, ямар нэгэн байдлаар хүргэдэг байна.
2	<b>Зээлийн хүсэлтийг хүлээн авч, ОБЗ-ийн хуралддаг давтамж (сард 2-оос доошгүй хуралдах)</b>	Малчид голдуу зээлийн хүүгээ сар бүр төлөөд, үндсэн зээлээ улиралдаа нэг удаа төлдөг болохоор хагас жилдээ 1, жилдээ 2 удаа хуралдаж зээлийг олгож байна.	Жилдээ намар, хавартаа 2 удаа хуралдаж зээлийг олгодог.	Зээлийн эргэн төлөлтийн мөнгө бага байвал хуралддаггүй, тиймээс мөнгө 60-70 сая орчим болоод ирэхээр нь хуралддаг. Хагас жилдээ 1 хуралддаг.	Жилдээ 2 удаа хуралддаг. 6-7 сарын дараа эргэн төлөлтийн мөнгө 60 орчим сая төгрөг болдог.	Дансны үлдэгдлээс хамаарч, хуралдах эсэхээ шийддэг. Голдуу зун, намартаа хуралддаг. Журмын дагуу улиралдаа 1 хуралдах шаардлагатай.	5/5	ОБЗ нь ОБЗЭС-ийн үйл ажиллагааг тогтвортой явуулах зорилгоор сангийн мөнгө орж ирсэн үед хуралддаг ба жилдээ 2-3 удаа хуралддаг байна.
3	<b>1.5 хувийн хүүгийн орлогын зарцуулалтыг гэрээний талуудад улирал бүр тайлагнах.</b>	1.5 хувийн хүүгийн орлогын зарцуулалтыг улирал бүр оролцогч талуудад тайлагнадаггүй. Хүүгийн орлогын 60 хүртэлх хувийг	1.5 хувийн хүүгийн орлогын зарцуулалтыг улирал бүр оролцогч талуудад тайлагнадаггүй. Өнөөдрийн байдлаар тус	1.5 хувийн хүүгийн орлогын зарцуулалтыг улирал бүр оролцогч талуудад тайлагнадаггүй. Хүүгийн орлогоос ОБЗ-ийн үйл	1.5 хувийн хүүгийн орлогын зарцуулалтыг улирал бүр оролцогч талуудад тайлагнадаггүй. Хүүгийн орлогоос ОБЗ-ийн үйл ажиллагаанд	1.5 хувийн хүүгийн орлогын зарцуулалтыг улирал бүр оролцогч талуудад тайлагнадаггүй. Өнөөдрийн байдлаар хүүгийн	4/5	ОБЗ нь 1.5 хувийн хүүгийн орлогыг улирал бүр Төрийн банкнаас хүлээн авдаг бөгөөд хүүгийн орлогын 60 хүртэлх хувийг

№	Эрх, үүрэг	Их- Тамир сумын ОБЗ	Цэнхэр сумын ОБЗ	Бат-Өлзий сумын ОБЗ	Их-Уул сумын ОБЗ	Улаан-Уул сумын ОБЗ	Гүйцэтгэлийн үнэлгээ*, оноогоор	Тайлбар
		ОБЗ-ийн үйл ажиллагаанд, 40 хүртэл хувийг байгаль хамгаалах үйл ажиллагаанд зарцуулжээ. Тухайлбал, ТХГН-ийн мэдээллийн самбар хийсэн байна.	орлогоос ТХГН-т мэдээллийн самбар хийх, ОБЗ-ийн үйл ажиллагаанд зарцуулсан.	ажиллагаанд зарцуулахаас гадна өнөөдрийн байдлаар ТХГН-ийн хил заагийг тусгаарлах чулуун шон хийсэн.	зарцуулахаас гадна байгаль орчныг хамгаалах чиглэлээр Тэрбум мод үндэсний хөтөлбөрийн хүрээнд мод тарьсан, мөн сурагч, багачуудад зориулсан гар зургийн уралдаан, малчдын дунд хэлэлцүүлэг зохион байгуулах зэрэг нийгэмд чиглэсэн үйл ажиллагаануудыг зохион байгуулж, зарцуулсан.	орлогын тодорхой хэсгээр ОБЗ-ийн үйл ажиллагаанд зарцуулсан бол, байгаль орчныг хамгаалах чиглэлээр яг ямар ажил хийж болох талаар ойлголтгүй байгаа. Тиймээс 5.6 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна.		ОБЗ-ийн үйл ажиллагаанд, 40 хүртэлх хувийг байгаль хамгаалах үйл ажиллагаанд зарцуулсан байна. Хөвсгөл аймгийн Улаан-Уул сумын хувьд байгаль орчин хамгаалах чиглэлээр тодорхой ажил гүйцэтгээгүй байна.
3	<b>Зээл авсан иргэд, зээлийн эргэн төлөлт, зээлийг зориулалтын дагуу ашиглаж байгаад хэрхэн хяналт тавьсан, мониторинг хийсэн талаар тусгах.</b>	Төрийн банкны төлөөлөл болон ОБЗ-ийн хамтарсан баг хяналт хийхээр явдаг. Хяналт хийхдээ бүх өрхүүдээр орж амждаггүй тул, түүвэрлэж хийдэг.	Хавар, намартаа жилдээ 2 удаа явж мониторинг хийдэг. Төрийн банкны төлөөлөл болон ОБЗ-ийн 2 хүн нийтдээ 3 багийн гишүүнтэйгээр мониторинг хийдэг.	Хагас жилийн тооллогоор зээл авсан малчдынхаараа орж, хяналт хийдэг. Хянахдаа эцэг мал худалдан авсан бол түүний зураг, мал худалдан авсан гэрээний маягт дээр малчны тамга байгаа эсэхийг хянадаг.	Багийн дарга, банктэйгаа хамтраад улиралдаа 1 удаа хийдэг. Зээлээ зориулалтын дагуу ашигласан эсэхийг зургаар баталгаажуулан банканд өгдөг.	Зээлийн зориулалтыг анхнаас нь хэлж өгсөн учраас айлуудаас авсан зээл юунд зарцуулсан талаар баримт цуглуулж авдаг. Жишээ нь, сайн үүлдрийн эцэг мал худалдан авсан бол эцэг мал худалдан авсан гарал үүслийн бичгийг авдаг. Мөн биечлэн очиж амжихгүй тохиолдолд	5/5	ОБЗ нь зээл авсан малчдын зээлээ зориулалтын дагуу ашигласан эсэх, зээлээр хүлээсэн үүргээ биелүүлж, малын тоогоо бууруулж байгаа эсэх талаарх хяналтыг тодорхой хугацаанд жилдээ ядаж 1 удаа хийдэг байна. Хяналтыг

№	Эрх, үүрэг	Их- Тамир сумын ОБЗ	Цэнхэр сумын ОБЗ	Бат-Өлзий сумын ОБЗ	Их-Уул сумын ОБЗ	Улаан-Уул сумын ОБЗ	Гүйцэтгэлийн үнэлгээ*, оноогоор	Тайлбар
						утсаар хяналт хийж байна.		хийхдээ Төрийн банкны төлөөлөлтэй хамт явдаг.
4	ОБЗ нь ОБЗЭС-ийн ашиглалтад хяналт тавих, нөхцөл шаардлагыг хангасан иргэдийг сангийн зээлд хамруулахад идэвхтэй ажиллана.	ОБ-д амьдарч байгаа малчин өрхүүдэд багийн даргаар нь дамжуулан мэдээлэл өгөхөөс гадна, зөвхөн ОБ-д амьдарч байгаа малчдыг зээлд хамруулж байна.					5/5	ОБЗ нь журмын дагуу зээлийг ОБ-д амьдарч байгаа малчин өрхүүдэд олгож байгаа нь шаардлага хангасан малчдыг хамруулж, идэвхтэй ажиллаж байгааг харуулж байна.
5	ОБЗ нь улиралд нэг удаа ОБ-ийн иргэдтэй уулзаж, шаардлага хангасан иргэд мэдээлэл авсан, зээлээ авсан байгаа эсэхийг тодруулна.	Мониторинг хийх явцдаа мэдээллийг түгээдэг.	Өнгөрсөн 2 жилийн хугацаанд 4 удаа мониторинг хийсэн ба 4 удаа зээлийн талаарх мэдээллийг малчдад хүргэсэн.	Өнгөрсөн хугацаанд 4-5 удаагийн мониторингийг хийхдээ мэдээллийг түгээсэн.	Мониторинг хийх явцдаа мэдээллийг түгээсэн.	Өнгөрсөн хугацаанд 2 удаагийн мониторингийг хийх явцдаа мэдээллийг түгээсэн.	5/5	Сумуудын ОБЗ-ийн хувьд улиралдаа 1 удаа малчидтай уулзалт зохион байгуулж чаддаггүй ч, хяналт хийх явцдаа малчдад зээлийн талаарх мэдээллийг хүргэдэг.
6	ОБЗ нь ОБЗЭС-ийн үйл ажиллагааг эрсдэл багатай, үндсэн зорилгын дагуу ажиллахад	Төрийн банктай хамтран ажиллахад ямар нэгэн хүндрэл бэрхшээл тулгардаггүй.	Төрийн банктай хамтран ажиллахад ямар нэгэн хүндрэл бэрхшээл тулгардаггүй.	Төрийн банктай хамтран ажиллахад ямар нэгэн хүндрэл бэрхшээл тулгардаггүй.	Төрийн банктай хамтран ажиллахад ямар нэгэн хүндрэл бэрхшээл тулгардаггүй.	Төрийн банктай ажиллахад удаашралтай байсан.	4/5	Сумуудын ОБЗ-ийн хувьд Төрийн банктай хамтран ажиллахад ямар нэгэн саад бэрхшээл



№	Эрх, үүрэг	Их- Тамир сумын ОБЗ	Цэнхэр сумын ОБЗ	Бат-Өлзий сумын ОБЗ	Их-Уул сумын ОБЗ	Улаан-Уул сумын ОБЗ	Гүйцэтгэлийн үнэлгээ*, оноогоор	Тайлбар
	Төрийн банктэй хамтран ажиллана.							байдаггүй байна. Харин Улаан-Уул сумын хувьд Төрийн банк
7	ОБЗ нь иргэдээс ирсэн санал гомдлыг хүлээн авч шийдвэрлэсэн байдал	Орчны бүсийн зааг хязгаарт багтахгүй ч, ТХГН-т амьдардаг малчид яагаад хамрагдах боломжгүй байгаа талаар асууж их ирдэг ба журмын дагуу олгож байгаа гэсэн тайлбарыг өгдөг.	Малчдаас ОБ-ийн заагт багтдаггүй ч, мал нь ОБ-рүү бэлчдэг малчдын хувьд яагаад хамрагдах боломжгүй талаар гомдол их ирдэг байна. ОБЗ-ийн хувьд журмын дагуу олгож байгаа гэсэн хариуг өгдөг.	Өргөдөл гомдол одоогоор ирээгүй.	Одоогоор ямар нэгэн өргөдөл гомдол ирээгүй байна.	Төрийн банкны үйл ажиллагаа удаашралтай байгаа талаар гомдол ирсэн.	5/5	Төсөл хэрэгжиж байгаа 5 сумдын 3 суманд малчдаас ОБЗЭС-тай холбоотой өргөдөл гомдол иржээ. Тухайлбал, зээлийн шийдвэр гарчхаад байхад яагаад зээл олгогдохгүй байгаа талаар, ОБ-ийн хилийн заагт амьдарч байгаа иргэд яагаад энэхүү зээлд хамрагдаж болохгүй байгаа талаар гомдлууд ирдэг байна.
8	ОБЗ нь жил бүрийн эхний улиралд багтаан зээл тус бүрд бууруулсан малын тоо, нийт						0/5	Улирал бүр тайлан бэлтгэдэг ОБЗ нэг ч байгаагүй. Харин өнгөрсөн 2 жилийн





№	Эрх, үүрэг	Их- Тамир сумын ОБЗ	Цэнхэр сумын ОБЗ	Бат-Өлзий сумын ОБЗ	Их-Уул сумын ОБЗ	Улаан-Уул сумын ОБЗ	Гүйцэтгэлийн үнэлгээ*, оноогоор	Тайлбар
	сум, ОБ-ийн хэмжээнд бууруулсан малын тоо, ОБЗЭС-аас үр шим хүртсэн өрхийн тоо, бэлчээрийн биологийн олон янз байдалд гарсан өөрчлөлт, гэрээний биелэлтийн талаар тайлагнах.	Жил бүрийн эхний улиралд эдгээр мэдээллүүдийг гаргадаггүй ч, тус зээл нь малчдын малын тоог бууруулах хөшүүрэг болж байгаа талаар дурдаж байв. Харин бэлчээр, биологийн олон янз байдалд гарч байгаа өөрчлөлтийг хэмжинэ гэж байгаа ч, яаж, ямар үзүүлэлтээр хэмжих нь тодорхойгүй. Мөн бэлчээр, биологийн олон янз байдалд гарч байгаа өөрчлөлт нь удаан хугацаанд мэдрэгдэх тул, энэхүү 2 жилийн хугацаанд гарсан бодит өөрчлөлт байхгүй талаар дурдаж байв.						хугацаанд 1 удаагийн ажлын гүйцэтгэлийн тайланг бичсэн байсан.

Эх үүсвэр: Сумдын ОБЗ-ийн дарга, мэргэжилтнүүд, сумын ЗДТГ-ын төлөөлөлтэй хийсэн ярилцлага

\*- 5/5 гэж байгаа нь 5 сум бүгд үүрэг хариуцлагаа биелүүлсэн гэдэг утгыг илэрхийлнэ. Харин 0/5 гэж байгаа нь тухайн зүйл заалтын талаар тухайн ОБЗ ямар нэгэн үүрэг хариуцлагаа биелүүлээгүйг илтгэнэ.

Сумуудын ОБЗ-ийн хувьд дээрх 8 үзүүлэлтийн хүрээнд тухайн ажлыг хийж гүйцэтгэсэн байдлыг авч үзвэл, нийт 40 ажлаас 34 ажлыг нь гүйцэтгэсэн гэж үзэж байна. Өөрөөр хэлбэл, сумуудын ОБЗ нь өөрсдийн хүлээсэн үүрэг, хариуцлагын хүрээнд үйл ажиллагаагаа тодорхой хэмжээнд гүйцэтгэсэн бөгөөд улирал бүр тайлагнах тайлангийн хувьд нэг ч ОБЗ нь тайланг бэлтгэдэггүй байсан. Мөн нэг сумын хувьд Төрийн банктай хамтын ажиллагаа удаашралтай байдаг талаар дурдаж байлаа. Тухайлбал, ОБЗ-өөс шийдээд өгсөн малчдын материал Төрийн банк дээр очоод уддаг талаар дурдаж байв. Тухайлбал, зарим сумдын хувьд ОБЗЭС-ийн үлдэгдэл өндөр байна, яагаад зарцуулахгүй байгаа талаар төслөөс хүртэл асууж байсан байна. Төрийн банкны хувьд хүн хүч бага, зээлийг судлах хугацаа гардаггүй гэсэн тайлбарыг өгч байжээ.

### **Шигтгээ 2. Чанарын судалгаанд оролцогч ОБЗ-ийн даргын сэтгэгдлээс**

*ОБЗ-өөс зээл авах малчдын жагсаалтыг Төрийн банк руу хүргүүлсэн ч, малчдаас Төрийн банк судалж өгөхгүй байна гэдэг иймэрхүү гомдол маш их ирдэг. Зээлийн гацаа бол маш их үүсэж байна. Дараагийн малчдыг хурдан судлах ёстой. Мөнгө үлдсэн шүү дахиад та нар малчдаасаа саналаа аваад санхүүжилт байгаа гэдгийг хэлэх ёстой. Өмнөх малчид аваагүй байхад санхүүжилт байгаа ч гэсэн ахиж зар тарааж чаддаггүй. Учир нь зээлийн материалаа өгөөд, эрэмбэлэгдээд дараагийн зээл олголтыг хүлээгээд байж байгаа зөндөө малчид байдаг.*

ОБЗ-ийн үйл ажиллагаанд хийсэн шинжилгээний үр дүнд дараах саналуудыг дэвшүүлж байна. Үүнд:

1. Удирдамжийн дагуу ОБЗ нь мэдээллийг малчид, иргэдэд 14 хоногийн өмнө түгээх үүрэгтэй хэдий ч, сумуудын ОБЗ-ийн хувьд мэдээлэл түгээх хугацаа, мэдээлэл түгээж буй хэлбэрүүд нь янз бүр байна. Тухайлбал, зарим ОБЗ-ийн хувьд багийн хурлаар дамжуулан зараа түгээн тухайн үедээ зээлийн материалаа хүлээн авдаг тохиолдол ч байна. Тиймээс зээл олгох хугацааг нь тодорхой болгочихвол малчдад мэдээллийг нэг удаа түгээснээр малчид тухайн хугацаанд нь материалаа өгөх бүрэн боломжтой.
2. Удирдамжийн дагуу ОБЗ нь малчдын зээлийн өргөдлийг хүлээн авч, сардаа 1-ээс доошгүй хуралдах үүрэгтэй. Гэвч ОБЗЭС-ийн зээлийн эргэн төлөлттэй уялдан жилдээ 2-3 удаа хуралдаж байна. Тиймээс ч энэхүү нөхцөл байдалтай уялдан ОБЗ-үүд хагас жилдээ 1 удаа хуралдаж байна. Цаашдаа малчдын зээлийн эргэн төлөлттэй уялдуулан ОБЗ-ийн зээлийн шийдвэр гаргах хурлын тоог сард 1-ээс доошгүй гэж байгааг багасгаж, хагас жилдээ тогтмол 1 удаа хуралдах гэж өөрчлөх.
3. Зээл авсан иргэдийн зээлийн зарцуулалт ямар байгаа талаар мониторингийг ОБЗ хийнэ гэж байгаа ч, жилдээ хэдэн удаа, яаж хийх нь удирдамжид тодорхой заагаагүй. Харин ОБЗ нь улиралдаа нэг удаа ОБ-ийн иргэдтэй уулзаж, шаардлага хангасан иргэд мэдээлэл авсан, зээлээ авч байгаа эсэхийг тодруулна гэж заасан байгаа. Гэвч ОБЗ нь мониторингийг тодорхой түвшинд хийж, малчид гэрээгээр хүлээсэн үүргээ хэрхэн биелүүлж байгаа талаар хянаж байгаа ч, зээлийн гэрээгээр зөрчсөн иргэд байгаа эсэх, зөрчсөн тохиолдолд ямар арга хэмжээ авсан талаар тодорхойгүй байв. Тиймээс төсөл хэрэгжүүлэх нэгжээс хяналтыг тогтмол тавьж, ОБЗ-ийн үйл ажиллагааг сайжруулах шаардлагатай байна.
4. ОБЗ-д сангийн үйл ажиллагаатай холбоотой өргөдөл, гомдлоос илүүтэйгээр яагаад манай баг хамрагдахгүй байгаа, яагаад ОБ гэж хязгаарласан талаарх

гомдол их ирдэг байна. ОБЗ-ийн хувьд журмын дагуу ОБ-д амьдардаг малчин, өрхүүд хамрагддаг гэсэн тайлбарыг өгдөг.

#### **2.4.2. Төрийн банкны үйл ажиллагаанд хийсэн шинжилгээ**

Төрийн банкны хувьд ОБЗЭС-ийн үйл ажиллагааны үндсэн оролцогч талуудын нэг бөгөөд бид сум бүрийн Төрийн банкны салбарын төлөөлөлтэй уулзан Төрийн банкны оролцоо, үүрэг, хариуцлагын талаар ярилцлаа. Төрийн банкны хувьд гэрээний дагуу ОБЗЭС-ийн үйл ажиллагааг тогтвортой явуулах үүргийг хүлээдэг бөгөөд энэхүү үүргийнхээ дагуу орж ирсэн зээлийн эргэн төлөлтийн дүнг ОБЗ-д мэдээлэх, ОБЗ-тэй хамтран зээл авсан малчдаар явж хяналт хийх, зээлийн хүүгээ сар бүр төлөх талаар малчдад мэдээлэл өгөх, улирал бүр ОБЗЭС-ийн хүүгийн орлогыг данс руу нь шилжүүлэх гэх мэт хамтын ажиллагаагаа сайн биелүүлж байна гэж Төрийн банкны чанарын судалгаанд оролцогчдын төлөөлөл дурдаж байв.

Хариуцлагын тухайд Төрийн банк нь зээлийн шалгуур хангасан малчдад зээлийг олгож, ОБЗЭС-ийн үйл ажиллагааг тогтвортой явуулах үүргийг хүлээдэг учраас малчдын зээлийн эргэн төлөлт, зээлийн зориулалт зэрэгт ОБЗ-тэй хамтран ажиллаж байна. Мөн зээлийн шалгуур хангасан, барьцаа хөрөнгө болох малын тоо нь хүрч байгаа малчдад зээлийг олгосоор байгаа.

Зарим сумдын Төрийн банкны хувьд хүн хүчний дутмаг байдлаас болоод зээлийн судалгаа хийх дээр ачаалал үүсдэг талаар дурдаж байв. Тиймээс банканд ирэх ачааллыг бага байлгавал зүгээр байна. Учир нь эцсийн шийдвэрийг банк гаргадаг болохоор зээлдэгчдэд тавих хяналтыг хийж чадахгүй байх нь харилцагчтайгаа үл ойлголцох асуудлыг үүсгэдэг.

Сумдын Төрийн банкны үүрэг, оролцоо ямар байсан талаар дараах хүснэгтээр харууллаа.

**Хүснэгт 15. Төрийн банкны эрх, үүрэг, оролцоо, хариуцлагад хийсэн шинжилгээ, Бүлэг 1.3.1-ийн 36 хэсгийг харах.**

Эрх, үүрэг	Их- Тамир сумын Төрийн банк	Цэнхэр сумын Төрийн банк	Бат-Өлзий сумын Төрийн банк	Их-Уул сумын Төрийн банк	Улаан-Уул сумын Төрийн банк	Гүйцэтгэлийн үнэлгээ*, оноогоор	Тайлбар
ОБЗЭС-аас зээл олгох эсэх шийдвэрийг ОБЗ-ийн саналд үндэслэн зээлийн судалгааг хийн гаргах.	Төрийн банк нь ОБЗ-өөс ирсэн зээлийн материалыг хүлээн авч, банкны шаардлагын дагуу зээлийн судалгааг хийдэг.					5/5	Сумуудын Төрийн банкны салбар нь ОБЗ-өөс ирсэн материал үндэслэн зээлийн судалгааг банкны шалгууртаа тулгуурлан хийдэг бүх банкнуудын хувьд адилхан байдаг байна.
Зээлийн эргэн төлөлтийг идэвхжүүлэх, банкны журмын дагуу барьцаа хөрөнгө шаардах.	Малчдын зээлийн эргэн төлөлтийг байнга сануулж утсаар холбогдох, мөн ОБЗ-тэй хамтран хяналтыг хийдэг нь зээлийн эргэн төлөлтийг тогтмолжуулж, чанаргүй зээлийг үүсэхээс сэргийлдэг. Учир нь нэг сар мөнгөө төлөөгүй бол тухайн зээл нь чанаргүй зээлийн ангилалд ордог учраас түүнээс сэргийлэн малчид руу сар бүр хүүгээ төлөхийг байнга сануулдаг. Банкны журмын дагуу малчдын барьцаа хөрөнгө нь малын тоо байдаг.					5/5	Банкны бүх салбарын хувьд малчдын зээлийг чанаргүй зээлд оруулахгүйн тулд ОБЗ болон малчидтай маш сайн хамтран ажилладаг.
“Байгальд ээлтэй малчны зээл”-ийн дагуу үүргээ биелүүлээгүй малчдын зээлийг ОБЗЭС-ийн зээлээс хасаж, банкны энгийн зээл рүү шилжүүлэх.	Одоогийн байдлаар үүргээ биелүүлээгүйн улмаас зээл нь энгийн зээл рүү шилжсэн малчид байхгүй байна.	Одоогийн байдлаар чанаргүй, муу зээл байхгүй байна. Зээл авсан нэг малчин малынхаа тоог өсгөсөн байсан ч, тухайн малчин зээлээ шууд	Манай салбарын хувьд малчид дээр тэр бүр очиж хяналт тавьж чаддаггүй. Одоогийн байдлаар чанаргүй, муу зээл гараагүй байна.	Сар бүр төлдөг хүүгийн төлөлт дээр хэд хоног хоцордог ч, энэ нь чанаргүй зээлд орох нөхцөл болдоггүй. Харин 1 сараар төлөхгүй хоцорвол энэ нь чанаргүй зээлд багтдаг. Одоогийн	Зээлийг зориулалтын дагуу ашиглаагүй акт тавиулсан тохиолдлууд шалгалтаар илэрч байсан.	5/5	Зориулалтын дагуу зээлээ ашиглаагүй тохиолдлууд илэрсэн ч, тухайн үед нь тухайн зөрчлийг арилгуулсан байна. Тухайлбал, малаа өсгөсөн зарим малчдын хувьд зээлээ шууд хаасан байна.

Эрх, үүрэг	Их-Тамир сумын Төрийн банк	Цэнхэр сумын Төрийн банк	Бат-Өлзий сумын Төрийн банк	Их-Уул сумын Төрийн банк	Улаан-Уул сумын Төрийн банк	Гүйцэтгэлийн үнэлгээ*, оноогоор	Тайлбар
		хаасан тохиолдол бий.		байдлаар гэрээний үүргээ биелүүлээгүйн улмаас хасагдсан зээл байхгүй байна.			
ОБЗЭС-ийн зээл олгох нөхцөлийн дагуу зээлийг олгох.	ОБЗЭС-ийн зээл олгох нөхцөлийн дагуу, мөн Төрийн банкны малчны зээлийн шалгуурыг хангасан малчдад зээлийг олгодог. Зарим малчдын хувьд давхартай зээлтэй байгаад зээл хүссэн байдаг ба малчдын зээлээ төлөх чадварыг харгалзан үзээд хүссэн хэмжээнээс нь бага хэмжээний зээлийг тохируулан олгодог.					5/5	ОБЗЭС-ийн зээл олгох нөхцөлийн дагуу олгодог.
Зорилтот сумдын ОБЗЭС-аас хуваарилсан эх үүсвэрт оногдох жилийн 1.5 хувийн хүүгийн орлогыг улирал бүр олгох.	Улирал бүр хүүгийн орлогыг сумын ОБЗ-ийн данс руу тогтмол шилжүүлдэг.					5/5	Улирал бүр сумдын ОБЗ-ийн ТББ-ийн данс руу хүүгийн орлогыг тогтмол шилжүүлдэг.
ОБЗ-өөс зээл хүсэгчдийн жагсаалт авснаас хойш 10 хоногийн дотор зээл батлах, эс батлах шийдвэрийг гаргах.	Зээлийн судалгаа нь янз бүрийн хугацаанд хийгддэг. Энэ нь банкны ачааллаас хамаарах бөгөөд зарим сумдын салбарын хувьд ОБЗ-өөс материал ирсэн даруйд судалгааг явуулан зээлийг олгодог байхад зарим сумдын хувьд ОБЗ-өөс ирсэн материалын судалгаа хийгдээгүй хэдэн сар ч болсон тохиолдлууд байна. Тухайлбал, Улаан-Уул сумын Төрийн банкны хувьд ажилчдын ачааллаас болж, зээлийн судалгаа 3-4 сар хоцорсон тохиолдлууд гарчээ.					4/5	Зээлийн судалгааны хугацаа нь янз бүр байдаг нь тухайн салбарын ачааллаас хамаардаг.

Эрх, үүрэг	Их- Тамир сумын Төрийн банк	Цэнхэр сумын Төрийн банк	Бат-Өлзий сумын Төрийн банк	Их-Уул сумын Төрийн банк	Улаан-Уул сумын Төрийн банк	Гүйцэтгэлийн үнэлгээ*, оноогоор	Тайлбар
Төрийн банк нь гэрээний талуудад сар бүрийн 5-ны өдрийн дотор олгосон зээлийн дүн, нийт үлдэгдэл, сангийн зээл олгох боломжтой үлдэгдэл, идэвхтэй зээлдэгчдийн тоо, зээлийн зорилгын ангилал гэх мэт.	Эдгээр мэдээллийг гаргаж өгөхөд ямар нэгэн хүндрэл бэрхшээл тулгардаггүй байна. Салбаруудын хувьд дээрх мэдээллийг гарган төв салбар луу явуулахаас гадна сумын ОБЗ-рүү мэдээллийг зээлийн төлөлт орж ирсэн даруйд утсаар болон бичгээр мэдэгддэг байна.					5/5	Мэдээллийг гаргаж өгөхөд ямар нэгэн хүндрэл тулгардаггүй.
Төрийн банк нь шаардлага хангасан иргэдэд зээл олгож, ОБЗЭС-ийн үйл ажиллагаа тогтвортой удирдан явуулна.	Төрийн банк нь олгосон зээлийн эрсдэлийг бүрэн хариуцаж байгаа бөгөөд банкны шаардлага хангасан малчдад зээлийг олгохыг олгодог байна. Зарим малчдын хувьд давхар зээлтэй мөртөө ОБЗЭС-аас зээл авахыг хүссэн байдаг ба шалгуур хангаж байгаа тохиолдолд тохирох хэмжээний зээлийг олгодог. Харин өмнө нь чанаргүй зээлийн ангилалд багтаж байсан болон малын тоо нь банкны шалгуур хангахгүй байгаа өрхүүдэд зээл олгох боломжгүй байдаг.					5/5	Шаардлага хангасан малчдад зээлийг олгох нь цаашид сангийн үйл ажиллагааг тогтвортой явуулахад нөлөөлдөг.

Эх үүсвэр: Төрийн банкны салбарын төлөөллийн ярилцлагаас

\*- 5/5 гэж байгаа нь 5 сум Төрийн банк бүгд үүрэг хариуцлагаа биелүүлсэн гэдэг утгыг илэрхийлнэ. Харин 0/5 гэж байгаа нь тухайн зүйл заалтын талаар Төрийн банк үүрэг хариуцлагаа биелүүлээгүйг илтгэнэ.



Төрийн банк нь хүлээсэн үүргийн дагуу үйл ажиллагааны үнэлгээг хийсэн бөгөөд нийт 8 чиглэлийн дагуу 5 сумын Төрийн банкны салбарын үйл ажиллагааг үнэлсэн. Өөрөөр хэлбэл, сумдын Төрийн банкны салбаруудын хувьд хүлээсэн үүргийн дагуу ОБЗЭС-ийн үйл ажиллагаанд оролцдог байна.

### 2.4.3. Тусгай хамгаалалттай газар нутгийн хамгаалалтын захиргааны ажилласан байдалд хийсэн шинжилгээ

ОБЗ-ийн үйл ажиллагаанд оролцдог сумдын Тусгай хамгаалалттай газар нутгийн захиргааны мэргэжилтнүүдтэй уулзаж, тэдний оролцоо, үүрэг, хариуцлагын талаар ярилцлаа. Хамгаалалтын захиргааны мэргэжилтнүүдийн хувьд ОБЗ-ийн хурал болон хяналт шалгалтаар явахад бүрэн оролцдог байна. ОБЗ-ийн хувьд Төрийн банкнаас санхүүжилт орж ирсэн талаар мэдээлэл өгсөн даруйд хуралддаг бөгөөд өргөдөл өгсөн малчдын хувьд шалгуурыг хангаж байгаа тохиолдолд өргөдөл өгсөн он, сар, өдрөөр нь эрэмбэлэн жагсаалтыг Төрийн банканд хүргүүлдэг. Төрийн банкны хувьд эцсийн шийдвэрийг гаргадаг. Оролцогч талуудын хамтын ажиллагааны хувьд мэдээлэл сайн хүрдэг ба хамтран зээлийн мониторингоор явдаг, мониторингоор явахад янз бүрийн зөрчил илэрдэггүй талаар дурдаж байв.

#### Хүснэгт 16. Тусгай хамгаалалттай газар нутгийн хамгаалалтын захиргааны эрх, үүрэг, оролцоо, хариуцлагад хийсэн шинжилгээ

Эрх, үүрэг	Биелэлт
ОБЗЭС-ийн холбогдох тайлан, хэрэгжилттэй холбоотой холбогдох мэдээллийг авах.	ОБЗЭС-ийн холбогдох тайлан мэдээллийг тухай бүр ОБЗ-ийн хуралд оролцох явцдаа авдаг.
ОБЗ-ийн үйл ажиллагаанд хяналт тавих.	Сумдын ТХГНХЗ-ны төлөөлөгчдийн хувьд зээлийн мониторинг хийх багт орж, ажилладаг.
ОБЗ-ийг журмын дагуу үйл ажиллагаагаа явуулахыг шаардах.	ТХГНХЗ нь ОБЗ -тэй хамтран ажилладаг учраас ОБЗ-ийн үйл ажиллагааг дэмжин ажиллахыг хичээдэг.
Сангаас санхүүжүүлсэн зээл нь байгаль орчинд сөрөг нөлөө үүсгэж байвал зээлийг зогсоох хүртэл арга хэмжээ авахыг талуудаас шаардах.	Одоогийн байдлаар байгаль орчинд сөрөг нөлөө үүсгэж байгаа зээл байхгүй байна.
ОБЗЭС-ийн үйл ажиллагааг орон нутагт тогтвортой явуулахад дэмжлэг үзүүлэх.	Зээл олголтын ажлын хэсгийн хуралд оролцох, зээл хүссэн хүмүүсийн хүсэлтийг хэлэлцэх ажилд байнга оролцдог. Мөн хамгаалалтын захиргааны зүгээс хяналт, мониторинг хийх заавар зөвлөмж өгч ажилладаг.
ОБЗ нь ОБЗЭС-ийн гэрээ болон холбогдох журмын дагуу ажиллаж байгаад хяналт тавих.	ОБЗ-ийн хуралд байнга сууж, ОБЗ нь журмын дагуу ажиллаж байгаад хяналт тавих, журмын дагуу ажиллахыг зөвлөдөг.

ТХГНХЗ-ны хувьд төслийн ОБЗ-ийн зээл олголтын ажлын хэсгийн хуралд оролцох, хяналт, мониторингийн үйл ажиллагаанд тогтмол оролцдог байна.

### 2.4.4. ТХН болон төслийн зөвлөх багийн төлөөлөл

Төсөл хэрэгжүүлэх нэгж болон төслийн зөвлөх багийн төлөөлөлтэй “Байгаль орчинд ээлтэй малчны зээл” бүс нутагт тулгамдаж буй ямар асуудлыг шийдвэрлэж байгаа талаар, зээлийн үйл ажиллагаа амжилттай хэрэгжиж байгаа эсэх, төсөл хэрэгжүүлэх явцад гарсан тааварлаагүй гэнэтийн зүйлс гарсан эсэх, хэрэв тийм түүнийг хэрхэн даван туулсан талаар асуудлыг тодруулахын тулд ганцаарчилсан ярилцлага хийсэн. Ярилцлагын гол үр дүнг дараах хүснэгтэд боловсруулан орууллаа.



**Хүснэгт 17. ТХН болон төслийн зөвлөх багийн төлөөлөлтэй хийсэн ярилцлагад хийсэн дүн шинжилгээ**

№	Агуулга	Дүн шинжилгээ
1	“Байгаль орчинд ээлтэй малчны зээл”-ийн бүс нутагт тулгамдаж байгаа асуудлыг шийдвэрлэж байгаа эсэх	<p>ОБЗЭС-аас зээл авснаар малчдын хувьд байгаль орчин болон бэлчээрийг хамгаалах талаар ойлголт, мэдлэгтэй болсон нь хөндлөнгийн үнэлгээний үр дүнгээр батлагдсан. Харин ТХН болон төслийн зөвлөх багийн төлөөллүүдийн үзэж буйгаар байгаль орчныг хамгаалъя гэвэл малчид, иргэдийн ухамсар хандлагыг л өөрчлөх хэрэгтэй гэж дурдаж байсан нь бидний судалгааны үр дүнтэй нийцэж байв. Үүнээс үзэхэд “Байгаль орчинд ээлтэй малчны зээл”-ийн бүс нутгуудад шийдвэрлэж чадсан хамгийн чухал асуудал бол үр нөлөө хүртэгчдийн ухамсар, хандлагад эерэг өөрчлөлтийг бий болгосон явдал байлаа. Энэ нөлөөллийн ажлыг зөвхөн малчдаар хязгаарлалгүйгээр дараах хүрээнд өргөжүүлэх нь үр дүнтэй гэж үзлээ.</p> <ol style="list-style-type: none"> <li>1. Хүүхэд байхаас нь иргэдэд байгаль орчны мэдлэг мэдээллийг түгээх хэрэгтэй. Байгаль орчныг гэмтээхгүйгээр хийх боломжтой олон үйлдвэрлэл, үйл ажиллагаа эрхлэх боломж байдаг гэдэг сэтгэлгээг суулгахад анхаарах;</li> <li>2. Орон нутгийн засаг захиргаа нь энэхүү зээлийг илүү системтэйгээр авч сумандаа үйлдвэрлэл байгуулж өөрийн сумын брэнд бүтээгдэхүүнтэй болох хэрэгтэй. Нэг нэгээрээ зээл авахаар хүүхдийн төлбөр төлөх ч юм уу өөр үйл ажиллагаанд зарцуулдаг. Үйлдвэрлэлийг л дэмжиж, үйлдвэр байгуулах хэрэгтэй. Жишээ нь сүүний үйлдвэртэй байсан бол хажуудаа бяслаг, ааруулын үйлдвэрлэл хийх, дэлгүүртэй болох зэргээр үйл ажиллагаагаа өргөжүүлэх боломжтой. Түүхий эдийнхээ нөөцөд тулгуурлаад хоршиж, цех, жижиг дунд үйлдвэрлэлийг хөгжүүлэх;</li> <li>3. Байгаль орчинд эерэг үйл ажиллагаа эрхэлж буй эсвэл байгаль орчныг хамгаалах чиглэлд тодорхой нөлөөлөл болж чадахуйц үйл ажиллагаа эрхэлж буй иргэд, бизнес эрхлэгчдийг дэмжих;</li> </ol>
2	Зээлийн үйл ажиллагаа амжилттай хэрэгжиж байгаа эсэх	<p>Ярилцлагад оролцогчдын үзэж буйгаар ОБЗЭС-ийн зээл олголтын үйл ажиллагаа зорилгоо тодорхой түвшинд биелүүлсэн, амжилттай хэрэгжсэн гэж үзэж байна. Харин дараагийн үе шатуудад ОБЗЭС-аас зээл олгох үйл ажиллагаа одоогийн амжилтаа хадгалах, илүү сайжруулахын тулд хэд хэдэн асуудалд анхаарах шаардлагатай байна. Үүнд:</p> <ol style="list-style-type: none"> <li>1. Зээл зорилтот хүмүүстээ хүрсэн хэдий ч зорилтот хүмүүс нь яг зорилгодоо нийцүүлэн ашигласан эсэх нь эргэлзээтэй байгаа тул үр шим хүртэгчдийн цар хүрээг нэмэх, зээлийн зарцуулалтын талаарх хяналт шалгалтыг илүү сайжруулах хэрэгтэй;</li> <li>2. Зээл авсан иргэдийн ихэнх нь малын хашаа саравчаа засах, малын тэжээл тариалах, хадлангийн талбай хаших зэрэг мал аж ахуйн үйл ажиллагаагаа сайжруулахад л анхаарсан. Эдгээр үйл ажиллагаа нь зарим талаараа байгаль орчинд ээлгүй байсан. Яагаад гэвэл талбай хаших нь зэрлэг амьтдын хөдөлгөөнд тодорхой хэмжээгээр саад учруулж байдаг. Тиймээс зээлийн түгээлт</li> </ol>

№	Агуулга	Дүн шинжилгээ
		<p>амжилттай байсан, харин байгальд ээлтэй байсан эсэх нь эргэлзээтэй байна.</p> <p>3. Малчин биш ч малтай иргэд олон байдаг. Нөгөө талаараа малгүй өрхүүд амьжиргааны орлого муутай байдаг тул байгалийн нөөц рүү халдах магадлал их байдаг. Жишээ нь хууль бусаар мод огтлох, хулгайгаар ан хийх, самар түүх гэх мэт. Тиймээс малгүй, орлого муутай, жижиг бизнес бий болгох мал бүхий сумын төвийн иргэдэд олгосон бол илүү үр дүнтэй байх магадлалтай юм.</p> <p>4. Малын гаралтай бүтээгдэхүүний үнэ цэнийг нэмэгдүүлэх чиглэлээр хэрэгжих төслүүдийг дэмжих. Малын гаралтай бүтээгдэхүүний зах зээлд үнэлэмж багатай байна. Үүний үнэлгээг нэмээд өгөх юм бол малчид олон малтай байхаас илүүтэй ашиг шим ихтэй, үнэлэмж өндөртэйг сонгоно. Заавал олон малтай байх шаардлагагүй болно. Тиймээс малын гаралтай түүхий эдийн үнэ цэн үнэлэмжийг нэмэгдүүлэх жижиг үйлдвэрлэлийг бий болгох хэрэгтэй. Сүү, тараг, ноос, арьс ширийг боловсруулж бүтээгдэхүүн боловсруулах зэрэг үйлдвэрлэлд зээлээ өгч дэмжвэл зээлийн үр өгөөж, нэр хүнд илүү өснө гэж дүгнэж байна.</p>
3	Зээл олголтын явцад гарсан тааварлаагүй гэнэтийн зүйлс, түүнийг хэрхэн даван туулсан талаар	<p>Зээлийн үйл ажиллагаа явагдаж байх хугацаанд тааварлаагүй гэнэтийн зүйлс гараагүй хэдий ч дараах асуудлуудад анхаарах шаардлагатай байна. Үүнд:</p> <p>1. Хамтын ажиллагаа оролцоог сайжруулах чиглэлээр олон талт ажил зохион байгуулах шаардлагатай. Цаашид төслийн үе шатанд хяналт мониторингийг хэрхэн сайжруулах талаар ажлуудыг төлөвлөж ажиллах хэрэгтэй байна.</p> <p>2. Хамгаалалтын захиргааны хариуцан ажилладаг газар нутаг том, байгаль хамгаалагчид цөөн байдаг учир ачаалал, хийх ажил ихтэй байдаг тул орон тоог нэмэгдүүлэх боломжийг судлах шаардлагатай гэж дүгнэлээ.</p>

#### 2.4.5. Зээлийн хүсэлт гаргаагүй хүмүүсийн төлөөлөл

Зээлийн хүсэлт гаргаагүй малчин биш хүмүүсийн төлөөлөл сум бүрээс 2 хүнийг санамсаргүй байдлаар сонгон ярилцлага хийсэн. Судалгаанд хамрагдсан хүмүүсийн хувьд янз бүрийн бизнес эрхэлдэг хүмүүс хамрагдсан байв. Үүнд: Оёдол хийдэг, аялал жуулчлалын бизнес эрхэлдэг, сүү цагаан идээ боловсруулдаг, цайны газар дэлгүүр ажиллуулдаг зэрэг хүмүүс хамрагдсан. Зээлийн хүсэлт гаргаагүй хүмүүсийн хувьд “Байгаль орчинд ээлтэй малчны зээл”-ийн сонсож байсан эсэхийг тодруулахад чанарын судалгаанд оролцсон 10 хүнээс 2 нь энэ зээлийн талаар сонсоогүй байв. Мэдээллийн сонсож байсан хүмүүсийн хувьд янз бүрийн эх үүсвэрээс тухайлбал, ОБЗ-өөс, тараах материалаас, найз нөхдөөсөө гэх мэт олон эх үүсвэрээс мэдээллийг авсан байна.

Зээлийн хүсэлт гаргаагүй малчин биш хүмүүсээс тухайн зээлийг зөвхөн малчдад өгсөн нь хэр оновчтой байгаа талаар тодруулахад судалгаанд хамрагдсан 10 оролцогчдоос бүгд оновчтой, оновчгүй гэхээс илүүтэйгээр тухайн суманд амьдардаг бүх л хүнд тэгш олгох хэрэгтэй гэж үзэж байв. Өөрөөр хэлбэл, малчид, бизнес эрхлэгчид гэх мэт бүхий л хүмүүст нээлттэй байх нь зөв гэж байв.


### **Шигтгээ 3. Чанарын судалгаанд оролцсон зээл аваагүй малчин иргэдийн төлөөлөл**

Орчны бүст амьдардаг, амьдардаггүй гэж ялгалгүйгээр тухайн зээл хэрэгтэй байгаа бүх хүнд нь олгодог болгох хэрэгтэй.

#### **2.4.6. Зээлийн хүсэлт гаргасан ч тэнцээгүй малчид**

Зээлийн өргөдөл өгсөн ч зээл авч чадаагүй малчдын төлөөллөөс сум бүрээс 2 хүнийг сонгон ярилцсан болно. Судалгаанд нийт 5 сумын татгалзсан хариу авсан 9 хүн хамрагдлаа. Зээлийн өргөдөл өгсөн ч зээл авч чадаагүй малчдын хувьд зээлийн материалыг бүгд 1 удаа бүрдүүлж өгсөн хүмүүс хамрагдсан ба зээлийн татгалзсан хариуг авсан байдал нь ялгаатай байв. Тухайлбал, судалгаанд хамрагдсан хүмүүсийн 55.6 хувь нь Төрийн банкнаас татгалзсан хариу авсан бол, 44.4 хувь нь ОБЗ-өөс татгалзсан хариу авсан байв. Зээлээ авч чадаагүй малчдын хувьд Төрийн банкны шалгуурт голдуу нийцэхгүй байдаг байна.

**График 4. Зээлийн хүсэлт гаргасан ч, татгалзсан хариу авсан малчдын төлөөлөл, татгалзсан хариу авсан байдал**



- Төрийн банкнаас татгалзсан хариу авсан
- ОБЗ-өөс татгалзсан хариу авсан

### **Шигтгээ 4. Чанарын судалгаанд оролцогч Төрийн банкны төлөөлөл**

Давхар зээлтэй эсвэл өмнө зээл аваад зээлээ төлөөгүй чанаргүй зээлдэгч болсон хүмүүсийн зээлийн хүсэлтийг банкны зээлийн дагуу шалган буцаадаг.

Харин ОБЗ-өөс татгалзсан хариу авдаг иргэдийн хувьд голдуу тухайн орчны бүсэд хамаарагддаггүй, хилийн зааг дээр оршин суудаг иргэд байдаг байна. Мөн зарим сумдын хувьд хэтэрхий цөөхөн малтай, гэр бүлийн хүн нь төрийн албан хаагч гэх мэт шалтгаанаар ОБЗ-ийн хурлаар батлан шийдвэрийг гаргадаг.

### **Шигтгээ 5. Чанарын судалгаанд оролцогч ОБЗ-ийн төлөөлөл**

Зээл авахаар өргөдөл өгсөн малчид нь зээлийн шалгуурыг бүрэн хангасан малчин өрхүүд бол бид өргөдөл өгсөн он сар өдрийн дарааллаар эрэмбэлэн, Төрийн банканд хүргүүлдэг. Учир нь Төрийн банк дээр зээлийн шаардлагыг хангахгүй малчин гарвал эрэмбэлэгдсэн дараагийн малчны материалыг Төрийн банк судлаад явдаг. Аль болох малчдадаа тэгш боломж олгохыг хичээдэг учраас материалаа өгсөн он, сар өдрөөр нь эрэмбэлдэг.

#### **2.4.7. Байгаль орчин, малчдын амьжиргаанд гарч байгаа өөрчлөлт, зэрэг үр дүн**

“Байгальд ээлтэй малчны зээл”-ийн малчдын амьжиргаа болон байгаль орчны хувьд гарч байгаа өөрчлөлтийн талаар ярилцахад малчдын амьжиргаанд маш сайн

нөлөөлж, үр дүн гарч байгаа талаар дурдаж байв. Учир нь малчдын хувьд малчны зээлээс өөр төрлийн зээл авах боломж байдаггүй учраас энэхүү зээл нь малчдад маш том боломжийг олгож байна. Тухайлбал, малчид бага хүүтэй зээл аван малынхаа үүлдэр угсааг сайжруулах, чанартай цөөхөн малтай байх сэтгэлгээтэй болж эхэлж байгаа, ногоон тэжээл тариалах, мөн энэхүү зээлийнхээ 40 хүртэл хувийг өрхийн хэрэглээндээ зориулж зарцуулах боломжтой учраас оюутан хүүхдийнхээ сургалтын төлбөрийг төлөх гэх мэт боломжуудыг олгож байна.

Мөн малчин өрхүүдийн орлого нэмэгдэж байна. Учир нь малаа 5 хувь бууруулах үүрэг хүлээсэн нь малчид малаа хурдан эргэлтэд оруулж, малаа зарах байдлыг нэмэгдүүлж байгаа нь малчдын орлого нэмэгдэх боломжийг бүрдүүлж байна.

Харин байгаль орчны хувьд гарч байгаа өөрчлөлт 2хон жилийн хугацаанд харагдахгүй. Учир нь зээл авсан малчдын хувьд малын тоогоо 5 хувь бууруулах шаардлага тавьж байгаа нь бэлчээрийн даацыг бууруулахад тодорхой хэмжээнд нөлөө үзүүлж байгаа хэдий ч бэлчээр талхлалтын хувьд ийм хурдан үр дүн гарна гэж бодохгүй байгаа талаар судалгаанд оролцогчид үзэж байв. Орчны бүсэд амьдарч байгаа малчдын хувьд малынхаа тоог цөөлж, орчны бүсийн бэлчээрийн даац багасаж байгаа хэдий ч, тухайн орчны бүсийн хилийн заагт амьдарч байгаа малчдын хувьд мал нь тухай орчны бүс рүү бэлчдэг учраас бэлчээрийн талхлалт буурахгүй байгаа гэж үзэж байв. Тиймээс тууштай энэхүү зээлийг олгосноор байгаль орчинд гарч байгаа өөрчлөлт, үр дүнг хэмжих боломжтой болно.

#### **Шигтгээ 6. Чанарын судалгаанд оролцогч Хамгаалалтын захиргааны мэргэжилтний сэтгэгдэл**

*Малчид маань малын тоо толгойг 5 хувиар бууруулах гэрээ хийж байгаа, гэрээнийхээ дагуу нэгэнт малчид маань малаа бууруулна, энэ зээлийг авна болж байна гээд хүсэлтээ өгөөд ОБЗ-ийн хурлаар дэмжигдээд, банкныхаа шалгуурыг даваад зээлээ авч байгаа. Бууруулсныхаа оронд зээлийн шаардлагын дагуу эцэг мал авах, газар тариалан ногоон тэжээл тарих ажлыг хийж байгаа. Хамгийн тод жишээ бол саравчныхаа хажууд ногоон тэжээл тарьсан айл байна, хуучин худалдаж авдаг байсан бол тэжээлийнхээ 50 хувийг ногоон тэжээлээр орлуулж авч байна. Өөрөөр хэлбэл худалдан авах, хадах ажлаа хөнгөвчилж өөрөө тарьж байна гэсэн үг. Эдгээр нь малчдын орлогыг нэмэгдүүлэх, хөдөлмөрийг хөнгөвчлөх давуу талуудтай.*

Гэхдээ тодорхой хэмжээний эерэг өөрчлөлт гарч байгаа гэж бодож байгаа талаар оролцогчид дурдаж байв. Мөн бэлчээрийн хувьд ургамлын төрөл зүйл нэмэгдсэн үү, хэвийн байгаа юу гэдгийг тогтоож мэдэхгүй байгаа талаар хэлж байлаа.


#### **Шигтгээ 7. Чанарын судалгаанд оролцогч Хамгаалалтын захиргааны мэргэжилтний сэтгэгдэл**

*Миний хувьд байгаль орчинд оруулж байгаа хувь нэмрийг тухайн орчны бүсийн бэлчээр талхагдлын судалгаа гэж хиймээр санагддаг. Бэлчээрийн талхагдлын хувьд урт хугацаандаа үр өгөөж гарах байх, малын тоо буурч байгаа учраас тодорхой хэмжээнд үр дүн гарч байгаа.*

### **2.5. МЭДЭЭЛЛИЙН ХҮРТЭЭМЖТЭЙ БАЙДАЛ**


Судалгаанд оролцсон зээл авсан малчин өрхийн төлөөллөөс ОБЗЭС-ийн мэдээллийг хаанаас авсан эсэхийг тодруулахад 50.0 хувь нь Орчны бүсийн зөвлөлөөс, 17.1 хувь нь найз нөхдөөс, 14.5 хувь нь Төрийн банкнаас, 10.5 хувь нь Захиргааны ажилчдаас авсан гэж хариулжээ.

**График 5. ОБЗЭС-ийн мэдээллийг хаанаас авсан бэ, n=76**




Зээл аваагүй малчин өрхийн төлөөллөөс ОБЗЭС-ийн талаарх мэдээллийг сонсож байсан эсэхийг тодруулахад 93.4 хувь “тийм” гэж хариулжээ. Үр дүнг сумдаар задалж харвал хамгийн их хувь нь буюу Их-Уул сумаас судалгаанд хамрагдсан малчдын 85.7 хувь нь “үгүй” гэж хариулсан байлаа. Зээлийн талаарх мэдээлэл авсан хэр нь яагаад зээл авч чадаагүй шалтгааныг тодруулахад тухайн зээл нь танил талаар дамжуулан олгогдсон, давхар зээлтэй байсан, Төрийн банкны шалгуурыг хангаагүй гэж хариулсан байна.

**График 6. Орчны бүсийн зээлийн эргэлтийн сан"-ийн “Байгальд ээлтэй малчны зээл”-ийн талаар сонсож байсан эсэх, n=31**



Судалгаанд хамрагдсан нийт малчин өрхөөс зээлийн талаарх мэдээлэл түгээлт хэр оновчтой байсныг 1-5 оноогоор үнэлүүлэхэд 2.5 оноогоор үнэлэгджээ. Энэ нь мэдээллийг малчдад түгээсэн хэлбэр оновчтой биш байсныг илэрхийлж байна. Үнэлгээг оролцогчдын төрлөөр харьцуулбал зээл авсан малчдын үнэлгээ 3.0, зээл аваагүй малчдын үнэлгээ 2.0 байв.

**График 7. Мэдээлэл түгээлт оновчтой байсан эсэх, n=107, (үнэлгээний дээд утга 5)**




Зээл авсан малчдын хувьд цаашид мэдээллийг хэрхэн түгээх нь оновчтой байх талаар тодруулахад 19.7 хувь нь хурал, цуглааны үеэр, 17.1 хувь нь багийн дарга нараар дамжуулан, 17.1 хувь нь биечилж уулзах, 15.8 хувь нь тараах материал, гарын авлагаас мэдээлэл авахыг хүсэж байгаагаа илэрхийлсэн байна.

**График 8. Цаашид мэдээллийг хэрхэн түгээх нь зүйтэй гэж үзэж байна вэ, n=76**



Харин зээл аваагүй малчдын хувьд 22.6 хувь нь хурал, цуглааны үеэр, 16.1 хувь нь багийн дарга нараар дамжуулан, 12.9 хувь нь биечилж уулзах зэргээр хариулсан байна.

**График 9. Цаашид мэдээллийг хэрхэн түгээх нь зүйтэй гэж үзэж байна вэ, n=31(зээл аваагүй малчин өрх), хувиар**



Мэдээлэл түгээлтийн оновчтой хувилбарын тухайд зээл авсан болон аваагүй малчдын хувьд төдийлөн ялгаатай хариулт ажиглагдахгүй байна. Харин судалгаанд хамрагдсан нийт малчдын хувьд хэрхэн мэдээлэл авахаа мэдэхгүй гэж хариулсан хариултын хувь нэлээд өндөр байгаа нь<sup>6</sup> малчид өөрсдийн хэрэгцээ шаардлагаа төдийлөн ойлгож илэрхийлж чадахгүй байгааг харуулж байна.

<sup>6</sup> Зээл авсан малчдын 15.8 хувь, зээл аваагүй малчдын 19.4 хувь нь мэдэхгүй гэж хариулжээ.



## БҮЛЭГ 3. ОРЧНЫ БҮСИЙН ЭРГЭЛТИЙН САНГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮНЭЛГЭЭ

### 3.1. АРХАНГАЙ АЙМГИЙН ИХТАМИР СУМЫН ОРЧНЫ БҮСИЙН ЭРГЭЛТИЙН САНГИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ҮНЭЛГЭЭ

#### 3.1.1. Олгосон зээлийн хэмжээ, зээлийн тоо, зорилго

Архангай аймгийн Их-Тамир сумын ОБЗ нь Хангайн нурууны БЦГ-ын Орчны бүсэд оршин суудаг малчдад ОБЗЭС-ийн зээлийг зээлийн журам зааврын дагуу олгож байгаа бөгөөд 2023 оны байдлаар нийт 44 малчдад 405.0 сая төгрөгийн зээлийг олгоод байна. Үүнээс 2021 онд 287.0 сая төгрөгийн санхүүжилтийг 32 малчин өрхөд, 2022 онд 8 малчин өрхөд 78.0 сая төгрөг, 2023 онд 4 малчин өрхөд 40.0 сая төгрөгийн зээлийг тус тус олгожээ.


**Хүснэгт 18. Их-Тамир сумын олгосон нийт зээлийн тоо, олгосон зээлийн хэмжээ, зээлийн үлдэгдэл, төгрөгөөр**

Он	Олгосон зээлийн тоо	Олгосон зээлийн хэмжээ	Зээлийн үлдэгдлийн тоо	Зээлийн үлдэгдэл	Эзлэх хувь
2021	32	287,000,000.0	27	146,898,013.1	59.5
2022	8	78,000,000.0	8	60,000,000.0	24.3
2023	4	40,000,000.0	4	39,969,102.4	16.2
<b>Нийт</b>	<b>44</b>	<b>405,000,000.0</b>	<b>39</b>	<b>246,867,115.5</b>	<b>100.0</b>

2023 оны 07 сарын 31-ний өдрийн байдлаар 39 зээлдэгчийн 246.8 сая төгрөгийн үлдэгдэлтэй байгаа бөгөөд 2021 онд олгосон зээлийн үлдэгдэл нийт үлдэгдлийн 59.5 хувь буюу 146.9 сая төгрөг, 2022 онд олгосон зээлийн үлдэгдэл 24.3 хувь буюу 60.0 сая төгрөг, 2023 онд олгосон зээлийн үлдэгдэл нийт үлдэгдлийн 16.2 хувь буюу 39.9 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна. Нийт олгосон зээлдэгчдээс 5 зээлдэгч зээлээ бүрэн хаасан байна.

Их-Тамир сумын ОБЗЭС-аас олгосон зээлийн зориулалтыг авч үзвэл давхардсан тоогоор авч үзвэл нийт зээлдэгчдийн 29.5 хувь нь малынхаа үүлдэр угсааг сайжруулах, малын тоог бууруулах зорилгоор, 26.2 хувь нь малын хашаа хороогоо засах, барих зорилгоор, 11.5 хувь нь өвс тэжээл бэлтгэх, 9.8 хувь нь өрхийн хэрэглээний зориулалтаар буюу оюутны сургалтын төлбөр төлөх, 8.2 хувь нь бэлчээр хамгаалах, хадлангийн талбай хаших, 8.2 хувь нь сүү цагаан идээ боловсруулах(аарц худалдан авч ааруул хийх), 4.9 хувь нь ногоон тэжээл тариалах, 1.6 хувь нь байгалийн нөөцийг нөхөн сэргээх буюу булаг хашаалах зорилгоор зээлийг авсан байна. Зээлийн 30 орчим хувийг малынхаа үүлдэр угсааг сайжруулах, малын тоог бууруулах зорилгоор авсан байгаа нь энэхүү сангийн зорилготой бүрэн нийцсэн байгаа нь харагдаж байна.

График 10. Их-Тамир сумын ОБЗЭС-аас олгосон зээлийн зориулалт, хувиар



- Малынхаа үүлдэр угсааг сайжруулах, малын тоог бууруулах
- Хашаа хороогоо засах, барих
- Өвс тэжээл бэлтгэх
- Оюутны сургалтын төлбөр төлөх
- Бэлчээр хамгаалах, хадлангийн талбай хашаалах
- Сүү цагаан идээ боловсруулах (аарц худалдан авах)
- Ногоон тэжээл тариалах
- Байгалийн нөөцийг нөхөн сэргээх (булаг хашаалах)

Нийт олгосон зээлийн 40 хувиас илүүгүй хувийг хэрэглээний зорилгоор олгож болох ба нийт зээлдэгчдийн 9.8 хувь нь зээлийн тодорхой хэсгийг оюутны сургалтын төлбөр төлөх зориулалтаар авсан нь энэхүү зорилгоос хэтрээгүй болох нь харагдаж байна.

### 3.1.2. Зорилтот ашиг хүртэгчдэд хүрсэн зээлийн хувь, зээл авсан өрхийн тоо

Их-Тамир сумын ТХГН-ийн Хан-Өндөр болон Хөхнуур багийн орчны бүсэд амьдардаг нийт 137 малчин өрх хамрагддаг бөгөөд 2023 оны байдлаар нийт 44 малчин өрх буюу 32.1 хувь нь ОБЗЭС-ийн зээлд хамрагдаад байна. Үүнээс Хан-Өндөр багийн малчин өрхийн 36.4 хувь нь, Хөхнуур багийн малчин өрхийн 63.6 хувь нь зээлд хамрагджээ.

Хүснэгт 19. Их-Тамир сумын зорилтот ашиг хүртэгчдийн зээлд хамрагдсан хувь

Багийн нэр	Нийт малчдын тоо	Зээл авсан малчдын тоо	Эзлэх хувь
Хан-Өндөр	34	16	36.4
Хөхнуур	103	28	63.6
<b>Нийт</b>	<b>137</b>	<b>44</b>	<b>32.1</b>

Их-Тамир сумын ОБЗ-ийн хувьд жилдээ 2 удаа буюу хавар, намар санхүүжилт орсны дараагаар хуралдаж зээлийг малчдын өргөдөл ирсэн дарааллаар эрэмбэлэн Төрийн банканд хүргүүлдэг бөгөөд эрэмбийн дарааллаар Төрийн банкнаас зээлийг олгодог байна. Зээл олгох эцсийн шийдвэрийг Төрийн банк гаргах ба банкны шалгуур хангаагүй бол эрэмбийн дарааллаар дараагийн малчин өрхөд зээл авах боломж бүрддэг.

Хавар, намрын улиралдаа 2 удаа хуралдахдаа орж ирсэн санхүүжилтийн хэмжээгээр нийт зээлийн өргөдлийг шийдвэрлэдэг ба орж ирсэн санхүүжилтийг 100 хувь эргүүлэн малчдад олгодог байна.

**Хүснэгт 20. Их-Тамир сумын өргөдөл өгсөн малчдын тоо, зээл олгосон малчдын тоо, зээлийн нийт санхүүжилтэд эзлэх хувь**


Он	Санхүүжилтийн хэмжээ	Өргөдөл өгсөн малчдын тоо	Зээл авсан малчдын тоо	Зээл авсан малчдын өргөдөл өгсөн нийт малчдад эзлэх хувь	Олгосон зээлийн хэмжээ	Олгосон зээлийн нийт санхүүжилтэд эзлэх хувь
2021	287,000,000.0	35	32	91.4	287,000,000.0	100.0
2022	78,000,000.0	9	8	88.9	78,000,000.0	100.0
2023	40,000,000.0	6	4	66.7	40,000,000.0	100.0
<b>Нийт</b>	<b>405,000,000.0</b>	<b>50</b>	<b>42</b>	<b>84.0</b>	<b>405,000,000.0</b>	<b>100.0</b>

2021 онд анх 35 малчин өрх өргөдлөө ирүүлсэн бөгөөд үүнээс 3 иргэн орчны бүсийн нутагт оршин суудаггүй өрх байсан тул хасаж, үлдсэн 32 өрхөд тэгш хүртээмжтэй олгох зорилгоор шийдвэрлэсэн бол<sup>7</sup>, 2022 онд 9 малчин өрх өргөдлөө ирүүлснээс<sup>8</sup> өргөдөл өгсөн он, сар, өдрөөр нь эрэмбэлж Төрийн банканд хүргүүлсэн бөгөөд эрэмбийн дарааллаар зээлийг 8 малчин өрхөд олгосон, 2023 онд 6 малчин өрх өргөдлөө ирүүлснээс<sup>9</sup> өргөдөл өгсөн он, сар, өдрөөр нь эрэмбэлж Төрийн банканд хүргүүлэн, эрэмбийн дарааллаар зээлийг 4 малчин өрхөд олгосон байна. Их-Тамир сумын ОБЗ-ийн хувьд орж ирсэн санхүүжилтийг тухай бүрд нь эргүүлэн 100 хувь малчдад олгож ажиллаж байна.

**3.1.3. ОБЗЭС-ийн эргэн төлөлтийн хувь**

Архангай аймгийн Их-Тамир сумын хувьд 2021 онд орж ирсэн санхүүжилтийг 100 хувь олгосон бөгөөд гаргасан зээлийн эргэн төлөлтийн хувийг<sup>10</sup> дараах графикаар харууллаа. 2023 оны 07 сарын 31-ны өдрийн байдлаар 2021 онд олгосон зээлийн 48.8 хувь буюу 140.1 сая төгрөг эргэн төлөгдсөн, 2022 онд олгосон зээлийн 23.1 хувь буюу 18 сая төгрөг эргэн төлөгдсөн, 2023 онд олгосон зээлийн 0.1 хувь 0.03 сая төгрөг тус тус эргэн төлөгджээ. Эргэн төлөгдөөгүй зээлийн хувьд бүгд зээлийн эргэн төлөлтийн хуваарийн дагуу төлөгдөх, хэвийн зээл байгаа юм.

**График 11. Их-Тамир сумын ОБЗЭС-ийн олгосон нийт зээлийн хэмжээ болон эргэн төлөлтийн хэмжээ, сая төгрөгөөр**



<sup>7</sup> - Их - Тамир сумын ОБЗ-ийн хурлын протокол, 2021 он

<sup>8</sup> - Их- Тамир сумын ОБЗ-ийн хурлын протокол, 2022 он

<sup>9</sup> - Их- Тамир сумын ОБЗ-ийн хурлын протокол, 2023 он

<sup>10</sup> - Одоогийн зээлийн эргэн төлөлтийн хувь нь тухайн жилд олгосон зээлийн хэдэн хувь нь эргэн төлөгдөж байгаагаар илэрхийлэгдэнэ. Өөрөөр хэлбэл, хуваарийн дагуу эргэн төлөлт хийгдсэн мөнгөн дүн юм. Тухайлбал, 2021 онд олгосон зээлийн 48.8 хувь нь эргэн төлөгдөж, үлдсэн хувь нь хуваарийн дагуу эргэн төлөлт нь хэвийн байгаа гэсэн утгыг илэрхийлнэ.

Харин нийт олгосон зээлийн 39.0 хувь буюу 158.1 сая төгрөг эргэн төлөгдсөн байна.

### 3.1.4. Их-Тамир сумын болон орчны бүсийн малын тоо толгойн бууралт

Архангай аймгийн Их-Тамир сумын хэмжээнд 2022 оны байдлаар<sup>11</sup> хонин толгойд шилжүүлснээр 947.2 мянган толгой мал байгаа бөгөөд энэ нь 2021 оноос 9.6 хувиар, 2020 оноос 10.8 хувиар тус тус өссөн байна. Харин ТХГН-ийн Орчны бүсийн малын тоог авч үзвэл 2022 оны байдлаар хонин толгойд шилжүүлснээр 349.3 мянган толгой мал байгаа нь 2021 оноос 7.8 хувиар, 2020 оноос 6.9 хувиар тус тус өссөн байна.

**Хүснэгт 21. Их-Тамир сумын болон орчны бүсийн малын тооны өөрчлөлт, хонин толгойд шилжүүлснээр**

Сумын нэр	Багийн нэр	Малын тоо ( хонин толгойд шилжүүлснээр)			Өсөлт, бууралт (хувиар)		Дундаж өөрчлөлт, хувиар
		2020	2021	2022	2020-2021	2021-2022	
Их-Тамир	Хөхнуур	170,177.8	168,868.7	179,033.3	-0.8	6.0	2.6
	Хан-Өндөр	154,895.1	155,176.9	170,253.2	0.2	9.7	4.9
<b>Орчны бүсийн хэмжээнд</b>		<b>325,072.9</b>	<b>324,045.6</b>	<b>349,286.5</b>	<b>-0.3</b>	<b>7.8</b>	<b>3.7</b>
<b>Сумын хэмжээнд</b>		<b>844,723.4</b>	<b>864,173.9</b>	<b>947,162.8</b>	<b>2.3</b>	<b>9.6</b>	<b>6.0</b>

2021 онд Их-Тамир сумын Орчны бүс орчмоор нийт 324.04 мянган мал (хонин толгойд шилжүүлснээр) байгаа нь өмнөх 2020 оноос 0.3 хувиар буурсан ч, 2022 онд өмнөх оноос 7.8 хувиар өссөн үзүүлэлттэй байна. Хөхнуур багийн хувьд 2021 онд өмнөх оноос малын тоо 0.8 хувиар буурсан ч, 2022 онд 6 хувь, харин Хан-Өндөр багийн хувьд 2021 онд малын тоо 0.2 хувиар өссөн ч, 2022 онд 9.7 хувиар өсжээ. Үүнээс харахад Хөхнуур багийн хонин толгойд шилжүүлсэн малын тоо жилд дунджаар 2.6 хувиар өссөн бол, Хан-Өндөр багийн малын тоо жилд дунджаар 4.9 хувиар өссөн нь харагдаж байна.

ОБЗЭС-ийн зээлийн гол зорилго нь Орчны бүс орчмын малын тоог бууруулж, бэлчээрийн даацыг багасгах зорилготой хэдий ч, албан ёсны статистик үзүүлэлтээр малын тоо нэмэгдсэн нь дээрх хүснэгтээс харагдаж байна. Тиймээс зээлийн нөлөө нь малын тоог бууруулахад төдийлөн сайн нөлөөлөхгүй байна гэж үзэж болох юм.

## 3.2. АРХАНГАЙ АЙМГИЙН ЦЭНХЭР СУМЫН ОРЧНЫ БҮСИЙН ЭРГЭЛТИЙН САНГИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ҮНЭЛГЭЭ

### 3.2.1. Олгосон зээлийн хэмжээ, зээлийн тоо, зорилго

Архангай аймгийн Цэнхэр сумын ОБЗ нь Хангайн нурууны БЦГ-ын Орчны бүсэд оршин суудаг малчдад ОБЗЭС-ийн зээлийг зээлийн журам зааврын дагуу олгож байгаа бөгөөд 2023 оны байдлаар нийт 57 малчдад 523.5 сая төгрөгийн зээлийг олгоод байна. Үүнээс 2021 онд 287.5 сая төгрөгийн санхүүжилтийг 32 малчин өрхөд, 2022 онд 16 малчин өрхөд 148.0 сая төгрөг, 2023 онд 9 малчин өрхөд 88.0 сая төгрөгийн зээлийг тус тус олгожээ.

<sup>11</sup> - 2023 оны мал тооллогын дүн гараагүй байгаа

**Хүснэгт 22. Цэнхэр сумын олгосон зээлийн тоо, хэмжээ, үлдэгдэл, төгрөгөөр**

Он	Олгосон зээлийн тоо	Олгосон зээлийн хэмжээ	Зээлийн үлдэгдлийн тоо	Зээлийн үлдэгдэл	Эзлэх хувь
2021	32	287,541,860.0	27	87,869,598.5	32.1
2022	16	148,000,000.0	15	98,254,602.0	35.8
2023	9	88,000,000.0	9	88,000,000.0	32.1
<b>Нийт</b>	<b>57</b>	<b>523,541,860.0</b>	<b>51</b>	<b>274,124,200.5</b>	<b>100.0</b>

2023 оны 07 сарын 31-ний өдрийн байдлаар 51 зээлдэгчийн 274.1 сая төгрөгийн үлдэгдэлтэй байгаа бөгөөд 2021 онд олгосон зээлийн үлдэгдэл нийт үлдэгдлийн 32.1 хувь буюу 87.9 сая төгрөг, 2022 онд олгосон зээлийн үлдэгдэл 35.8 хувь буюу 98.2 сая төгрөг, 2023 онд олгосон зээлийн үлдэгдэл нийт үлдэгдлийн 32.1 хувь буюу 88.0 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна. Нийт олгосон зээлдэгчдээс 6 зээлдэгч зээлээ бүрэн хаасан байна.

Цэнхэр сумын ОБЗЭС-аас олгосон зээлийн зориулалтыг авч үзвэл давхардсан тоогоор нийт зээлдэгчдийн 40.0 хувь нь малынхаа үүлдэр угсааг сайжруулах, малын тоог бууруулах зорилгоор, 7.8 хувь нь малын хашаа хороогоо засах, барих зорилгоор, 4.3 хувь нь өвс тэжээл бэлтгэх, 43.5 хувь нь өрхийн хэрэглээний зориулалтаар, 3.5 хувь нь ногоон тэжээл тариалах, 0.9 хувь нь хүнсний ногоо тариалах зорилгоор зээлийг авчээ. Малынхаа үүлдэр угсааг сайжруулах, малын тоог бууруулах зорилгоор олгосон зээл нь нийт зээлдэгчдийн 40 хувийг эзэлж байгаа нь ОБЗЭС-гийн малын чанарыг сайжруулах зорилготой нийцэж байна. Харин өрхийн хэрэглээний зориулалтаар олгосон зээл нь 43.5 хувь байгаа нь өрхийн хэрэглээний зорилгоор олгох 40 хувиас хэтэрсэн байна. Гэхдээ Төрийн банкны хувьд тухайн зээлдэгчийн зээлийн 40.0 хувиас хэтрэхгүй байхаар өрхийн хэрэглээний зориулалтаар ашиглаж болно гэдгийг баримталж байсан нь нөлөөлсөн гэж үзэж байна.

**График 12. Цэнхэр сумын ОБЗЭС-аас олгосон зээлийн зориулалт, хувиар**



### 3.2.2. Зорилтот ашиг хүртэгчдэд хүрсэн зээлийн хувь, зээл авсан өрхийн тоо

Цэнхэр сумын ТХГН-ийн Орхон багийн орчны бүсэд амьдардаг нийт 154 малчин өрх хамрагддаг бөгөөд 2023 оны байдлаар нийт өрхийн 57 малчин өрх буюу 37.0 хувийг ОБЗЭС-ийн зээлд хамрагджээ.

#### Хүснэгт 23. Цэнхэр сумын зорилтот ашиг хүртэгчдийн зээлд хамрагдсан хувь

Багийн нэр	Нийт малчдын тоо	Зээл авсан малчдын тоо	Эзлэх хувь
Орхон	154	57	37.0
<b>Нийт</b>	<b>154</b>	<b>57</b>	<b>37.0</b>

Цэнхэр сумын ОБЗ-ийн хувьд жилдээ 2 удаа буюу хавар, намар санхүүжилт орсны дараагаар хуралдаж зээлийг малчдын орчны бүсэд амьдардаг нь үнэн эсэхийг тодорхойлсны дараа, өргөдөл ирсэн дарааллаар, эрэмбэлэн Төрийн банканд хүргүүлдэг бөгөөд эрэмбийн дарааллаар Төрийн банкнаас зээлийг олгодог байна. Зээл олгох эцсийн шийдвэрийг Төрийн банк гаргах ба тухайн малчин өрх банкны шалгуур хангаагүй бол эрэмбийн дарааллаар дараагийн малчин өрхөд зээлийг олгодог. Орж ирсэн санхүүжилтийг 100 хувь эргүүлэн малчдад олгодог байна.

Цэнхэр сумын ОБЗ-ийн хувьд 2023 оны 07 сарын 31-ний байдлаар нийт 114 малчин өрх зээл авах хүсэлтээ өгсөн бөгөөд хүсэлт өгсөн малчдын 50 хувь ОБЗЭС-ийн зээлд хамрагдаад байна.

#### Хүснэгт 24. Цэнхэр сумын өргөдөл өгсөн малчдын тоо, зээл олгосон малчдын тоо, зээлийн нийт санхүүжилтэд эзлэх хувь


Он	Санхүүжилтийн хэмжээ	Өргөдөл өгсөн малчдын тоо	Зээл авсан малчдын тоо	Зээл авсан малчдын өргөдөл өгсөн нийт малчдад эзлэх хувь	Олгосон зээлийн хэмжээ	Олгосон зээлийн нийт санхүүжилтэд эзлэх хувь
2021	287,541,860.0	65	32	49.2	287,541,860.0	100.0
2022	148,000,000.0	21	16	76.2	148,000,000.0	100.0
2023	88,000,000.0	28	9	32.1	88,000,000.0	100.0
<b>Нийт</b>	<b>523,541,860.0</b>	<b>114</b>	<b>57</b>	<b>50.0</b>	<b>523,541,860.0</b>	<b>100.0</b>

2021 онд 65 малчин өрх зээлд хамрагдах хүсэлтээ өгсөн бөгөөд үүнээс 32 өрх буюу 49.2 хувь нь, 2022 онд 21 малчин өрх өргөдлөө өгснөөс 16 өрх буюу 76.2 хувь нь, 2023 онд 28 малчин өрх өргөдлөө өгснөөс 9 өрх буюу 32.1 хувь нь зээлд хамрагджээ. Цэнхэр сумын ОБЗ-ийн хувьд орж ирсэн санхүүжилтийг тухай бүрд нь эргүүлэн 100 хувь малчдад олгож байна.

### 3.2.3. ОБЗЭС-ийн эргэн төлөлтийн хувь

Архангай аймгийн Цэнхэр сумын хувьд 2021 онд орж ирсэн санхүүжилтийг 100 хувь олгосон бөгөөд гаргасан зээлийн эргэн төлөлтийн хувийг дараах графикаар харууллаа. 2023 оны 07 сарын 31-ны өдрийн байдлаар 2021 онд олгосон зээлийн 69.4 хувь буюу 199.7 сая төгрөг эргэн төлөгдсөн, 2022 онд олгосон зээлийн 33.6 хувь буюу 49.7 хувь эргэн төлөгдсөн, 2023 онд олгосон зээлийн эргэн төлөлт 0.0 хувь өнөөдрийн байдлаар эргэн төлсөн зээлийн хэмжээ байхгүй байна. Тус сумын хувьд бүх зээл эргэн төлөлтийн хуваарийн дагуу хийгдэж байна.

**График 13. Цэнхэр сумын ОБЗЭС-ийн нийт олгосон зээлийн хэмжээ болон эргэн төлөлтийн хэмжээ, сая. төгрөг**



Харин нийт олгосон зээлийн 47.6 хувь буюу 249.4 сая төгрөг эргэн төлөгдсөн байна.

### 3.2.4. Цэнхэр сумын болон орчны бүсийн малын тоо толгойн бууралт

Архангай аймгийн Цэнхэр сумын хэмжээнд 2022 оны байдлаар<sup>12</sup> хонин толгойд шилжүүлснээр 947.1 мянган толгой мал байгаа бөгөөд энэ нь 2021 оноос 8.4 хувиар, 2020 оноос 14.9 хувиар тус тус өссөн байна. Харин Цэнхэр сумын ТХГН-ийн Орчны бүсийн малын тоог авч үзвэл 2022 оны байдлаар хонин толгойд шилжүүлснээр 211.0 мянган толгой мал байгаа нь 2021 оноос 1.3 хувиар, 2020 оноос 6.6 хувиар тус тус өсжээ.

**Хүснэгт 25. Цэнхэр сумын болон орчны бүсийн малын тооны өөрчлөлт, хонин толгойд шилжүүлснээр**

Сумын нэр	Багийн нэр	Малын тоо ( хонин толгойд шилжүүлснээр)			Өсөлт, бууралт (хувиар)		Дундаж өөрчлөлт, хувиар
		2020	2021	2022	2020-2021	2021-2022	
Цэнхэр	Орхон	197,962.3	208,235.0	211,030.3	5.2	1.3	3.3
Орчны бүсийн хэмжээнд		197,962.3	208,235.0	211,030.3	5.2	1.3	3.3
Сумын хэмжээнд		823,628.9	873,596.4	947,096.1	6.1	8.4	7.2

Орхон багийн хувьд 2021 онд малын тоо өмнөх оноос 5.2 хувиар өссөн ч, 2022 онд энэхүү өсөлт саарч өмнөх 1.3 хувиар өссөн байгаагаас харахад малчид малынхаа тоог бууруулж байгаа нь харагдаж байна.

## 3.3. ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН БАТ-ӨЛЗИЙ СУМЫН ОРЧНЫ БҮСИЙН ЭРГЭЛТИЙН САНГИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ҮНЭЛГЭЭ

### 3.3.1. Олгосон зээлийн хэмжээ, зээлийн тоо, зорилго

Өвөрхангай аймгийн Бат-Өлзий сумын ОБЗ нь Орхоны хөндийн БЦГ-ын Орчны бүсэд оршин суудаг малчдад ОБЗЭС-ийн зээлийг зээлийн журам зааврын дагуу олгож байгаа бөгөөд 2023 оны байдлаар нийт 66 малчдад 564.1 сая төгрөгийн зээлийг олгожээ. Үүнээс 2021 онд 286.8 сая төгрөгийн санхүүжилтийг 35 малчин өрхөд, 2022 онд 18 малчин

<sup>12</sup> -2023 оны мал тооллогын дүн гараагүй байгаа



өрхөд 154.8 сая төгрөг, 2023 онд 13 малчин өрхөд 110.0 сая төгрөгийн зээлийг тус тус олгожээ.


**Хүснэгт 26. Бат-Өлзий сумын олгосон зээлийн тоо, хэмжээ, үлдэгдэл, төгрөгөөр**

Он	Олгосон зээлийн тоо	Олгосон зээлийн хэмжээ	Зээлийн үлдэгдлийн тоо	Зээлийн үлдэгдэл	Эзлэх хувь
2021	35	286,800,000.0	23	50,949,922.6	19.6
2022	18	154,800,000.0	18	98,650,000.0	38.0
2023	13	122,500,000.0	12	110,000,000.0	42.4
<b>Нийт</b>	<b>66</b>	<b>564,100,000.00</b>	<b>53</b>	<b>259,599,922.60</b>	<b>100.0</b>

2023 оны 07 сарын 31 -ний өдрийн байдлаар нийт 53 зээлдэгчийн 259.6 сая төгрөгийн зээлийн үлдэгдэлтэй байна. Үүнээс 2021 онд олгосон зээлийн үлдэгдэл нийт үлдэгдлийн 19.6 хувийг, 2022 онд олгосон зээлийн үлдэгдэл нийт үлдэгдлийн 38.0 хувийг, 2023 онд олгосон зээл нийт үлдэгдлийн 42.4 хувийг тус тус эзэлж байна. Нийт олгосон зээлдэгчдээс 13 зээлдэгч зээлээ бүрэн хаажээ. Зээл хаасан малчдын хувьд янз бүрийн шалтгаанаар зээлээ урьдчилж хаасан бөгөөд голдуу малаа чанаржуулж эргэлтэд оруулсан гэсэн байв<sup>13</sup>.

Бат-Өлзий сумын ОБЗ-ийн олгосон зээлийн зориулалтыг авч үзвэл нийт олгосон зээлийн 47.4 хувийг малынхаа үүлдэр угсааг сайжруулах, малын тоог бууруулах зорилгоор, 48.2 хувийг малын хашаа саравч барих, сайжруулах, 3.6 хувь нь малын тэжээл, 0.7 хувь нь өрхийн хэрэглээний зориулалтаар тус тус олгожээ.

**График 14. Бат-Өлзий сумын ОБЗЭС-аас олгосон зээлийн зориулалт, давхардсан тоогоор**



- Малынхаа үүлдэр угсааг сайжруулах, малын тоог бууруулах
- Малын хашаа саравч барих, сайжруулах
- Малын тэжээл
- Өрхийн хэрэглээний зориулалтаар

Өрхийн хэрэглээний зориулалтаар олгосон зээл нь 40 хувиас илүүгүй байх шалгуурыг хангажээ. Мөн нийт зээлийн 47.4 хувийг малын чанарыг сайжруулах

<sup>13</sup> - Бат-Өлзий сумын ОБЗ-ийн тайлан, 2023 он



зорилгоор эцэг мал худалдан авах, үүлдэржүүлэх зорилго эзэлж байгаа нь ОБЗЭС-ийн зээлийн зорилготой нийцэж байна.

### 3.3.2. Зорилтот ашиг хүртэгчдэд хүрсэн зээлийн хувь, зээл авсан өрхийн тоо

Бат-Өлзий сумын ОХБЦГ-ийн Бүрэгтий багийн орчны бүсэд амьдардаг нийт 130 малчин өрх хамрагддаг бөгөөд 2023 оны байдлаар нийт өрхийн 66 малчин өрх буюу 50.8 хувийг ОБЗЭС-ийн зээлд хамрагджээ.

#### Хүснэгт 27. Бат-Өлзий сумын зорилтот ашиг хүртэгчдийн зээлд хамрагдсан хувь

Багийн нэр	Нийт малчдын тоо	Зээл авсан малчдын тоо	Эзлэх хувь
Бүрэгтий	130	66	50.8
<b>Нийт</b>	<b>130</b>	<b>66</b>	<b>50.8</b>

Бат-Өлзий сумын ОБЗ-ийн хувьд 2023 оны 07 сарын 31-ний байдлаар нийт 81 малчин өрх зээл авах хүсэлтээ өгсөн бөгөөд хүсэлт өгсөн малчдын 81.5 хувь нь ОБЗЭС-ийн зээлд хамрагдаад байна. Бат-Өлзий сумын ОБЗ-ийн хувьд өргөдөл өгөх малчдыг эхлээд өөрсдөө Төрийн банктай уулзан хэдэн төгрөгийн зээл гарах боломжтой асууж, судалсны дараа өргөдлөө өгөх шаардлагыг тавьдаг<sup>14</sup> байна. Учир нь ОБЗ-ийн хурлаар зээл олгохыг шийдвэрлэсэн ч, Төрийн банк дээр очоод банкны шаардлагыг хангаж чадахгүй болж зээлээ авч чаддаггүй байна. Тиймээс бичиг баримт бүрдүүлж цаг хугацаа алдах нөхцөлийг бууруулжээ. Бат-Өлзий сумын ОБЗ-ийн хувьд банкны шаардлага хангаад зээлийн хүсэлтээ өгсөн малчин өрхүүдийн хүсэлтийг өргөдөл ирүүлсэн он, сар, өдрийн дарааллаар нь Төрийн банканд хүргүүлдэг байна.

#### Хүснэгт 28. Бат-Өлзий сумын өргөдөл өгсөн малчдын тоо, зээл олгосон малчдын тоо, зээлийн нийт санхүүжилтэд эзлэх хувь

Он	Санхүүжилтийн хэмжээ	Өргөдөл өгсөн малчдын тоо	Зээл авсан малчдын тоо	Зээл авсан малчдын өргөдөл өгсөн нийт малчдад эзлэх хувь	Олгосон зээлийн хэмжээ	Олгосон зээлийн нийт санхүүжилтэд эзлэх хувь
2021	286,800,000.0	47	35	74.5	286,800,000.0	100.0
2022	154,800,000.0	19	18	94.7	154,800,000.0	100.0
2023	122,500,000.0	15	13	86.7	122,500,000.0	100.0
<b>Нийт</b>	<b>564,100,000.0</b>	<b>81</b>	<b>66</b>	<b>81.5</b>	<b>564,100,000.0</b>	<b>100.0</b>

2021 онд өргөдөл өгсөн малчин өрхүүдийн 74.5 хувь нь зээлд хамрагдсан бол, 2022 онд өргөдөл өгсөн малчин өрхүүдийн 94.7 хувь нь, 2023 онд өргөдөл өгсөн малчин өрхүүдийн 86.7 хувь нь зээлд тус тус хамрагджээ. Бат-Өлзий сумын ОБЗ-ийн хувьд орж ирсэн санхүүжилтийг 100 хувь эргүүлэн малчдад зээлээр олгон ажиллаж байна.


### 3.3.3. ОБЗЭС-ийн эргэн төлөлтийн хувь

Өвөрхангай аймгийн Бат-Өлзий сумын хувьд 2021 онд орж ирсэн санхүүжилтийг 100 хувь олгосон бөгөөд он, оноор олгосон зээлийн эргэн төлөлтийн хувийг дараах графикаар харууллаа. 2023 оны 07 сарын 31-ны өдрийн байдлаар 2021 онд олгосон зээлийн 82.2 хувь буюу 235.9 сая төгрөг эргэн төлөгдсөн, 2022 онд олгосон зээлийн 36.3

<sup>14</sup> - Бат-Өлзий сумын ОБЗ-ийн хурлын протокол, 2022 он

хувь буюу 56.2 сая төгрөг эргэн төлөгдсөн, 2023 онд олгосон зээлийн 10.2 хувь буюу 12.5 сая төгрөг тус тус эргэн төлөгджээ. Эргэн төлөгдөөгүй зээлийн хувьд бүгд зээлийн эргэн төлөлтийн хуваарийн дагуу төлөгдөх, хэвийн зээл байгаа юм.

**График 15. Бат-Өлзий сумын ОБЗЭС-ийн нийт олгосон зээлийн хэмжээ болон эргэн төлөлтийн хэмжээ, сая. төгрөг**



Харин нийт олгосон зээлийн 54.0 хувь буюу 304.5 сая төгрөг эргэн төлөгдсөн байна.

### 3.3.4. Бат-Өлзий сумын болон орчны бүсийн малын тоо толгойн бууралт

Өвөрхангай аймгийн Бат-Өлзий сумын хэмжээнд 2022 оны байдлаар<sup>15</sup> хонин толгойд шилжүүлснээр 668.1 мянган толгой мал байгаа бөгөөд энэ нь 2021 оноос 15.4 хувиар, 2020 оноос 4.0 хувиар тус тус буурсан байна. Бат-Өлзий сумын Орчны бүсийн малын тоог авч үзвэл 2022 оны байдлаар хонин толгойд шилжүүлснээр 150.2 мянган толгой мал байгаа нь 2021 оноос 13.2 хувиар, 2020 оноос 2.8 хувиар тус тус буурчээ. Сумын хэмжээнд малын тоо хонин толгойд шилжүүлснээр жилдээ дунджаар 1.0 хувиар буурсан нь дараах хүснэгтээс харагдаж байна.

**Хүснэгт 29. Бат-Өлзий сумын болон орчны бүсийн малын тооны өөрчлөлт, хонин толгойд шилжүүлснээр**

Сумын нэр	Багийн нэр	Малын тоо ( хонин толгойд шилжүүлснээр)			Өсөлт, бууралт (хувиар)		Дундаж өөрчлөлт, хувиар
		2020	2021	2022	2020-2021	2021-2022	
Бат-Өлзий	Бүрэгтий	154,524.5	173,050.6	150,241.9	12.0	-13.2	-0.6
<b>Орчны бүсийн хэмжээнд</b>		<b>154,524.5</b>	<b>173,050.6</b>	<b>150,241.9</b>	<b>12.0</b>	<b>-13.2</b>	<b>-0.6</b>
<b>Сумын хэмжээнд</b>		<b>696,210.3</b>	<b>789,378.8</b>	<b>668,077.8</b>	<b>13.4</b>	<b>-15.4</b>	<b>-1.0</b>

Бат-Өлзий сумын хувьд 2021 онд малын тоо нь 2020 оноос 13.4 хувиар өссөн ч, 2022 онд өмнөх оноос 15.4 хувиар, Орчны бүсийн хэмжээнд 2021 онд өмнөх оноос 12.0 хувиар өссөн ч, 2022 онд өмнөх оноос 13.2 хувиар, жилдээ дунджаар 0.6 хувиар буурсан байгаагаас харахад төслийн үр дүн ажиглагдаж байна. Энэхүү зээл нь малчдад маш их таалагдаж байгаа, малчид энэхүү зээлд хамрагдсанаар малынхаа чанарт илүү анхаарч,

<sup>15</sup> -2023 оны мал тооллогын дүн гараагүй байгаа

эргэлтэд оруулснаар мал нь багтахаа байсан газрын малын тоо буурч, бэлчээр талхлалт буурч байгаа талаар малчид хэлж байв<sup>16</sup>.

### 3.4. ЗАВХАН АЙМГИЙН ИХ-УУЛ СУМЫН ОРЧНЫ БҮСИЙН ЭРГЭЛТИЙН САНГИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ҮНЭЛГЭЭ

#### 3.4.1. Олгосон зээлийн хэмжээ, зээлийн тоо, зорилго

Завхан аймгийн Их-Уул сумын ОБЗ нь Тарвагатай нурууны БЦГ-ийн Орчны бүсэд оршин суудаг малчдад ОБЗЭС-ийн зээлийг зээлийн журам зааврын дагуу олгож байгаа бөгөөд 2023 оны байдлаар нийт 60 малчдад 558.1 сая төгрөгийн зээлийг олгожээ. Үүнээс 2021 онд 298.5 сая төгрөгийн санхүүжилтийг 32 малчин өрхөд, 2022 онд 11 малчин өрхөд 94.9 сая төгрөг, 2023 онд 17 малчин өрхөд 164.7 сая төгрөгийн зээлийг тус тус олгожээ.

#### Хүснэгт 30. Их-Уул сумын олгосон зээлийн тоо, хэмжээ, үлдэгдэл, төгрөгөөр


Он	Олгосон зээлийн тоо	Олгосон зээлийн хэмжээ	Зээлийн үлдэгдлийн тоо	Зээлийн үлдэгдэл	Эзлэх хувь
2021	32	298,500,000.0	20	66,327,643.3	24.8
2022	11	94,940,000.0	10	59,558,356.2	22.3
2023	17	164,700,000.0	16	141,600,000.0	52.9
<b>Нийт</b>	<b>60</b>	<b>558,140,000.0</b>	<b>46</b>	<b>267,485,999.5</b>	<b>100.0</b>

2023 оны 07 сарын 31 -ний өдрийн байдлаар нийт 46 зээлдэгчийн 267.5 сая төгрөгийн зээлийн үлдэгдэлтэй байна. Үүнээс 2021 онд олгосон зээлийн үлдэгдэл нийт үлдэгдлийн 24.8 хувийг, 2022 онд олгосон зээлийн үлдэгдэл нийт үлдэгдлийн 22.3 хувийг, 2023 онд олгосон зээл нийт үлдэгдлийн 52.9 хувийг тус тус эзэлж байна. Нийт олгосон зээлдэгчдээс 14 зээлдэгч зээлээ бүрэн хаажээ.

Их-Уул сумын ОБЗ-ийн олгосон зээлийн зориулалтыг авч үзвэл нийт олгосон зээлийн 51.4 хувийг малын хашаа саравч барих, засах, 25.7 хувийг хадлангийн талбай хашаалах, 8.6 хувийг малын тэжээл авах, 7.1 хувийг малынхаа үүлдэр угсааг сайжруулах, 5.7 хувийг ногоон тэжээл тариалах, 1.4 хувийг байгалийн нөөцийг хамгаалах, булаг хашаалах зорилгоор тус тус олгожээ.

<sup>16</sup> - Бат-Өлзий сумын хурлын протокол, 2022 он

**График 16. Их-Уул сумын ОБЗЭС-аас олгосон зээлийн зориулалт, хувиар**



- Хашаа хороогоо засах, барих
- Хадлангийн талбай хашаалах
- Малын тэжээл авах
- Малынхаа үүлдэр угсааг сайжруулах, малын тоог бууруулах
- Ногоон тэжээл тариалах
- Байгалийн нөөцийг нөхөн сэргээх (булаг хашаалах)

Их-Уул сумын хувьд Төрийн банкны гаргаж өгсөн мэдээллээр өрхийн хэрэглээний зориулалтаар олгосон зээл одоогийн байдлаар байхгүй байна. Харин зээлийн гол зорилго болох малын тоог бууруулах, малын чанарыг сайжруулах зорилгоор олгосон зээлийн эзлэх хувь бусад сумуудтай харьцуулахад харьцангуй бага буюу нийт зээлийн зориулалтын дөнгөж 7.1 хувийг эзэлж байна.

### **3.4.2. Зорилтот ашиг хүртээгчдэд хүрсэн зээлийн хувь, зээл авсан өрхийн тоо**

Их-Уул сумын Тарвагатай нурууны БЦГ-ын Цэцүүх, Зарт багийн орчны бүсэд амьдардаг нийт 114 малчин өрх хамрагддаг бөгөөд 2023 оны байдлаар нийт өрхийн 60 малчин өрх буюу 52.6 хувийг ОБЗЭС-ийн зээлд хамрагджээ.

#### **Хүснэгт 31. Их-Уул сумын зорилтот ашиг хүртээгчдийн зээлд хамрагдсан хувь**

Багийн нэр	Нийт малчдын тоо	Зээл авсан малчдын тоо	Эзлэх хувь
Цэцүүх, Зарт	114	60	52.6
<b>Нийт</b>	<b>114</b>	<b>60</b>	<b>52.6</b>

Их-Уул сумын ОБЗ-ийн хувьд 2023 оны 07 сарын 31-ний байдлаар нийт 128 малчин өрх зээл авах хүсэлтээ өгсөн бөгөөд хүсэлт өгсөн малчдын 46.9 хувь нь ОБЗЭС-ийн зээлд хамрагдаад байна. Их-Уул сумын ОБЗ-ийн хувьд өргөдөл өгөх малчдыг малын тоо болон өргөдөл өгсөн он, сар, өдрөөр нь эрэмбэлэн жагсаалтыг Төрийн банканд хүргүүлдэг. Голдуу өмнө эрэмбэлэгдсэн дарааллаар зээлийг гүйцээн олгодог<sup>17</sup>.

<sup>17</sup> - Их-Уул сумын ОБЗ-ийн хурлын протокол, 2022 он

**Хүснэгт 32. Их-Уул сумын өргөдөл өгсөн малчдын тоо, зээл олгосон малчдын тоо, зээлийн нийт санхүүжилтэд эзлэх хувь**

Он	Санхүүжилтийн хэмжээ	Өргөдөл өгсөн малчдын тоо	Зээл авсан малчдын тоо	Зээл авсан малчдын өргөдөл өгсөн нийт малчдад эзлэх хувь	Олгосон зээлийн хэмжээ	Олгосон зээлийн нийт санхүүжилтэд эзлэх хувь
2021	298,500,000.00	57	32	56.1	298,500,000.00	100.0
2022	94,940,000.00	71	11	15.5	94,940,000.00	100.0
2023	164,700,000.00	-*	17	-*	164,700,000.00	100.0
<b>Нийт</b>	<b>558,140,000.00</b>	<b>128</b>	<b>60</b>	<b>46.9</b>	<b>558,140,000.00</b>	<b>100.0</b>


Энд: \* - 2023 оны хурлын протокол ирүүлээгүй учраас хэдэн малчин өргөдөл өгсөн нь тодорхойгүй байна.

2021 онд өргөдөл өгсөн малчин өрхүүдийн 56.1 хувь нь зээлд хамрагдсан бол, 2022 онд өргөдөл өгсөн малчин өрхүүдийн 15.5 хувь нь зээлд тус тус хамрагджээ. Их-Уул сумын ОБЗ-ийн хувьд орж ирсэн санхүүжилтийг 100 хувь эргүүлэн малчдад олгон ажиллаж байна.

**3.4.3. ОБЗЭС-ийн эргэн төлөлтийн хувь**

Завхан аймгийн Их-Уул сумын хувьд 2021 онд орж ирсэн санхүүжилтийг 100 хувь олгосон бөгөөд он, оноор олгосон зээлийн эргэн төлөлтийн хувийг дараах графикаар харууллаа. 2023 оны 07 сарын 31-ны өдрийн байдлаар 2021 онд олгосон зээлийн 77.8 хувь буюу 232.2 сая төгрөг эргэн төлөгдсөн, 2022 онд олгосон зээлийн 37.3 хувь 35.4 сая төгрөг эргэн төлөгдсөн, 2023 онд олгосон зээлийн 14.0 хувь буюу 23.1 сая төгрөг тус тус эргэн төлөгджээ. Тус сумын хувьд эргэн төлөгдөөгүй зээлийн хувьд хуваарийн дагуу эргэн төлөгдөх, хэвийн зээлүүд байна.

**График 17. Их-Уул сумын ОБЗЭС-ийн олгосон нийт зээлийн хэмжээ болон эргэн төлөлтийн хэмжээ, сая.төгрөгөөр**



Харин нийт олгосон зээлийн 52.1 хувь буюу 290.7 сая төгрөг эргэн төлөгдсөн байна.

### 3.4.4. Их-Уул сумын болон орчны бүсийн малын тоо толгойн бууралт

Завхан аймгийн Их-Уул сумын хэмжээнд 2022 оны байдлаар<sup>18</sup> хонин толгойд шилжүүлснээр 591.3 мянган толгой мал байгаа бөгөөд энэ нь 2021 оноос 7.4 хувиар, 2020 оноос 13.4 хувиар тус тус өссөн байна. Их-Уул сумын Орчны бүсийн малын тоог авч үзвэл 2022 оны байдлаар хонин толгойд шилжүүлснээр 249.5 мянган толгой мал байгаа нь 2021 оноос 3.6 хувиар, 2020 оноос мөн 3.6 хувиар тус тус өсжээ. Сумын хэмжээнд малын тоо хонин толгойд шилжүүлснээр жилдээ дунджаар 6.5 хувиар өссөн нь дараах хүснэгтээс харагдаж байна.

#### Хүснэгт 33. Их-Уул сумын болон орчны бүсийн малын тооны өөрчлөлт, хонин толгойд шилжүүлснээр

Сумын нэр	Багийн нэр	Малын тоо ( хонин толгойд шилжүүлснээр)			Өсөлт, бууралт (хувиар)		Дундаж өөрчлөлт, хувиар
		2020	2021	2022	2020-2021	2021-2022	
Их-Уул	Цэцүүх	118,565.3	116,248.8	118,608.6	-2.0	2.0	0.0
	Зарт	122,195.8	124,647.6	130,931.0	2.0	5.0	3.5
<b>Орчны бүсийн хэмжээнд</b>		<b>240,761.1</b>	<b>240,896.4</b>	<b>249,539.6</b>	<b>0.1</b>	<b>3.6</b>	<b>1.8</b>
<b>Сумын хэмжээнд</b>		<b>521,258.1</b>	<b>550,594.0</b>	<b>591,322.0</b>	<b>5.6</b>	<b>7.4</b>	<b>6.5</b>

Их-Уул сумын хувьд 2021 онд малын тоо нь 2020 оноос 5.6 хувиар, 2022 онд өмнөх оноос 7.4 хувиар, Орчны бүсийн хэмжээнд 2021 онд өмнөх оноос 0.1 хувиар, 2022 онд өмнөх оноос 3.6 хувиар, жилдээ дунджаар 1.8 хувиар өссөн байгаагаас харахад төслийн үр дүн сум болон орчны бүсийн хэмжээнд харагдахгүй байна.

### 3.5. ХӨВСГӨЛ АЙМГИЙН УЛААН-УУЛ СУМЫН ОРЧНЫ БҮСИЙН ЭРГЭЛТИЙН САНГИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ҮНЭЛГЭЭ

#### 3.5.1. Олгосон зээлийн хэмжээ, зээлийн тоо, зорилго

Хөвсгөл аймгийн Улаан-Уул сумын ОБЗ нь Улаан тайгын ДЦГ-ын Орчны бүсэд оршин суудаг малчдад ОБЗЭС-ийн зээлийг зээлийн журам зааврын дагуу олгож байгаа бөгөөд 2023 оны байдлаар нийт 62 малчдад 489.2 сая төгрөгийн зээлийг олгожээ. Үүнээс 2021 онд 287.5 сая төгрөгийн санхүүжилтийг 38 малчин өрхөд, 2022 онд 8 малчин өрхөд 64.4 сая төгрөг, 2023 онд 16 малчин өрхөд 137.4 сая төгрөгийн зээлийг тус тус олгожээ.

#### Хүснэгт 34. Улаан-Уул сумын олгосон зээлийн тоо, хэмжээ, үлдэгдэл, төгрөгөөр

Он	Олгосон зээлийн тоо	Олгосон зээлийн хэмжээ	Зээлийн үлдэгдлийн тоо	Зээлийн үлдэгдэл	Эзлэх хувь
2021	38	287,470,000.0	29	66,900,000.0	28.3
2022	8	64,370,000.0	8	33,670,000.0	14.2
2023	16	137,390,000.0	16	135,790,000.0	57.5
<b>Нийт</b>	<b>62</b>	<b>489,230,000.0</b>	<b>53</b>	<b>236,360,000.0</b>	<b>100.0</b>


2023 оны 07 сарын 31 -ний өдрийн байдлаар нийт 53 зээлдэгчийн 236.4 сая төгрөгийн зээлийн үлдэгдэлтэй байгаа бөгөөд үүнээс 2021 онд олгосон зээлийн үлдэгдэл нийт үлдэгдлийн 28.3 хувийг, 2022 онд олгосон зээлийн үлдэгдэл нийт үлдэгдлийн 14.2

<sup>18</sup> -2023 оны мал тооллогын дүн гараагүй байгаа

хувийг, 2023 онд олгосон зээл нийт үлдэгдлийн 57.5 хувийг тус тус эзэлж байна. Нийт олгосон зээлдэгчдээс 9 зээлдэгч зээлээ бүрэн хаажээ.

Улаан-Уул сумын ОБЗ-ийн олгосон зээлийн зориулалтыг авч үзвэл нийт олгосон зээлийн 52.1 хувийг малын хашаа саравч барих, засах, 26.0 хувийг малынхаа үүлдэр угсааг сайжруулах, 9.6 хувийг мах, сүү цагаан идээ боловсруулах, 8.2 хувийг хадлангийн талбай хашаалах, 4.1 хувийг малын түүхий эд боловсруулах зорилгоор тус тус олгожээ.

**График 18. Улаан-Уул сумын ОБЗЭС-аас олгосон зээлийн зориулалт, хувиар**



- Малынхаа үүлдэр угсааг сайжруулах, малын тоог бууруулах
- Хашаа хороогоо засах, барих
- Малын түүхий эд боловсруулах
- Хадлангийн талбай хашаалах
- Мах, сүү цагаан идээ боловсруулах

Улаан-Уул сумын хувьд Төрийн банкны гаргаж өгсөн мэдээллээр өрхийн хэрэглээний зориулалтаар олгосон зээл одоогийн байдлаар байхгүй байна. Харин зээлийн гол зорилго болох малын тоог бууруулах, малын чанарыг сайжруулах зорилгоор олгосон зээлийн эзлэх хувь 26.0 хувийг эзэлж байна.

### **3.5.2. Зорилтот ашиг хүртэгчдэд хүрсэн зээлийн хувь, зээл авсан өрхийн тоо**

Улаан-Уул сумын Улаан тайгын ДЦГ-ын Мунгараг, Гун, Соёо зэрэг багийн орчны бүсэд амьдардаг нийт 281 малчин өрх хамрагддаг бөгөөд 2023 оны байдлаар нийт өрхийн 62 малчин өрх буюу 22.1 хувийг ОБЗЭС-ийн зээлд хамрагджээ.

**Хүснэгт 35. Улаан-Уул сумын зорилтот ашиг хүртэгчдийн зээлд хамрагдсан хувь**

Багийн нэр	Нийт малчдын тоо	Зээл авсан малчдын тоо	Эзлэх хувь
Мунгараг, Гун, Соёо	281	62	22.1
<b>Нийт</b>	<b>281</b>	<b>62</b>	<b>22.1</b>

Улаан-Уул сумын ОБЗ-ийн хувьд 2023 оны 07 сарын 31-ний байдлаар нийт 117 малчин өрх зээл авах хүсэлтээ өгсөн бөгөөд хүсэлт өгсөн малчдын 53.0 хувь нь ОБЗЭС-ийн зээлд хамрагдаад байна. Улаан-Уул сумын ОБЗ-ийн хувьд өргөдөл өгөх малчдыг орчны бүсэд оршин суудаг эсэх шалгуураар өргөдөл өгсөн малчдыг шалгаруулдаг бөгөөд үүний дараа өргөдөл өгсөн он, сар, өдрөөр нь эрэмбэлэн жагсаалтыг Төрийн банканд хүргүүлэн ажиллаж байна. 2021 онд 64 малчин өрх өргөдөл өгснөөс 38 малчин өрх буюу

59.4 хувь нь, 2022 онд өргөдөл өгсөн 32 өрхөөс 8 өрх буюу 25.0 хувь нь, 2023 онд өргөдөл өгсөн 21 өрхөөс 16 өрх буюу 76.2 хувь нь тус тус зээлд хамрагджээ.

**Хүснэгт 36. Улаан-Уул сумын өргөдөл өгсөн малчдын тоо, зээл олгосон малчдын тоо, зээлийн нийт санхүүжилтэд эзлэх хувь**


Он	Санхүүжилтийн хэмжээ	Өргөдөл өгсөн малчдын тоо	Зээл авсан малчдын тоо	Зээл авсан малчдын өргөдөл өгсөн нийт малчдад эзлэх хувь	Олгосон зээлийн хэмжээ	Олгосон зээлийн нийт санхүүжилтэд эзлэх хувь
2021	287,470,000.0	64	38	59.4	287,470,000.0	100
2022	64,370,000.0	32	8	25.0	64,370,000.0	100
2023	137,390,000.0	21	16	76.2	137,390,000.0	100
<b>Нийт</b>	<b>489,230,000.0</b>	<b>117</b>	<b>62</b>	<b>53.0</b>	<b>489,230,000.0</b>	<b>100</b>

Улаан-Уул сумын ОБЗ-ийн хувьд орж ирсэн санхүүжилтийг 100 хувь эргүүлэн малчдад олгон ажиллажээ. Тухайлбал, 2021 онд 287.5 сая төгрөг, 2022 онд 64.4 сая төгрөг, 2023 онд 137.4 сая төгрөгийн зээлийг тус тус малчдад бүрэн олгосон байна.

**3.5.3. ОБЗЭС-ийн эргэн төлөлтийн хувь**

Хөвсгөл аймгийн Улаан-Уул сумын хувьд 2021 онд орж ирсэн санхүүжилтийг 100 хувь олгосон бөгөөд он, оноор олгосон зээлийн эргэн төлөлтийн хувийг дараах графикаар харууллаа. 2023 оны 07 сарын 31-ны өдрийн байдлаар 2021 онд олгосон зээлийн 76.7 хувь буюу 220.6 сая төгрөг эргэн төлөгдсөн, 2022 онд олгосон зээлийн 47.7 хувь буюу 30.7 сая төгрөг эргэн төлөгдсөн, 2023 онд олгосон зээлийн 1.2 хувь буюу 1.6 сая төгрөг тус тус эргэн төлөгджээ. Эргэн төлөгдөөгүй зээлийн хувьд бүгд хэвийн, хуваарийн дагуу төлөгдөж байна.

**График 19. Улаан-Уул сумын ОБЗЭС-ийн зээлийн эргэн төлөлтийн хувь, оноор**



Харин нийт олгосон зээлийн 51.7 хувь буюу 252.9 сая төгрөг эргэн төлөгдсөн байна.

**3.5.4. Улаан-Уул сумын болон орчны бүсийн малын тоо толгойн бууралт**

Хөвсгөл аймгийн Улаан-Уул сумын хэмжээнд 2022 оны байдлаар<sup>19</sup> хонин толгойд шилжүүлснээр 508.4 мянган толгой мал байгаа бөгөөд энэ нь 2021 оноос 10.3 хувиар,

<sup>19</sup> -2023 оны мал тооллогын дүн гараагүй байгаа



2020 оноос 17.9 хувиар тус тус өссөн байна. Улаан-Уул сумын Орчны бүсийн малын тоог авч үзвэл 2022 оны байдлаар хонин толгойд шилжүүлснээр 236.9 мянган толгой мал байгаа нь 2021 оноос 10.4 хувиар, 2020 оноос мөн 16.3 хувиар тус тус өсжээ. Сумын хэмжээнд малын тоо хонин толгойд шилжүүлснээр жилдээ дунджаар 8.5 хувиар өссөн нь дараах хүснэгтээс харагдаж байна.

**Хүснэгт 37. Улаан-Уул сумын болон орчны бүсийн малын тооны өөрчлөлт, хонин толгойд шилжүүлснээр**

Сумын нэр	Багийн нэр	Малын тоо (хонин толгойд шилжүүлснээр)			Өсөлт, бууралт (хувиар)		Дундаж өөрчлөлт, хувиар
		2020	2021	2022	2020-2021	2021-2022	
Улаан-Уул	Мунгараг	90,483.5	95,942.9	103,011.9	6.0	7.4	6.7
	Гун	37,970.5	42,097.0	47,270.9	10.9	12.3	11.6
	Соёо	75,271.7	76,607.6	86,636.8	1.8	13.1	7.4
<b>Орчны бүсийн хэмжээнд</b>		<b>203,725.7</b>	<b>214,647.5</b>	<b>236,919.6</b>	<b>5.4</b>	<b>10.4</b>	<b>7.9</b>
<b>Сумын хэмжээнд</b>		<b>430,968.1</b>	<b>461,077.1</b>	<b>508,353.0</b>	<b>7.0</b>	<b>10.3</b>	<b>8.6</b>

Улаан-Уул сумын хувьд 2021 онд малын тоо нь 2020 оноос 7.0 хувиар, 2022 онд өмнөх оноос 10.3 хувиар, Орчны бүсийн хэмжээнд 2021 онд өмнөх оноос 5.4 хувиар, 2022 онд өмнөх оноос 10.4 хувиар, жилдээ дунджаар 7.9 хувиар өссөн байгаагаас харахад төслийн үр дүн сум болон орчны бүсийн хэмжээнд харагдахгүй байна.

### 3.6. ОБЗЭС-ИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ГҮЙЦЭТГЭЛИЙН ҮР ДҮН<sup>20</sup>

Төсөл хэрэгжсэн ТХГН-ийн орчны бүсийн сумуудын ОБЗЭС-ийн үйл ажиллагааны гүйцэтгэлийн үнэлгээг “Байгальд ээлтэй малчны зээл”-ийн удирдамжид заасан 5.13 заалтын дагуу ОБЗЭС-ийн гүйцэтгэлийг үнэлсэн үр дүнг дараах хүснэгтээр харууллаа.

**Хүснэгт 38. ОБЗЭС-ийн үйл ажиллагааны гүйцэтгэлийн нэгтгэсэн үр дүн**

№	Сумын нэр	Тухайн ОБ-д амьдарч байгаа нийт өрхийн тоо	Олгосон зээлийн тоо <sup>a</sup>	ОБЗЭС-аас олгосон нийт зээлийн хэмжээ, сая. төгрөг <sup>a</sup>	Олгосон зээлийн зориулалт <sup>a</sup>		ОБЗЭС-ийн эргэн төлөлтийн хувь <sup>*b</sup>	Зорилтот ашиг хүртэгчдэд хүрсэн зээлийн хувь <sup>c</sup>	Орчны бүсийн хэмжээнд малын тооны жилийн дундаж өөрчлөлт, хувиар <sup>d</sup>	Сумын малын тооны өөрчлөлт, хувиар <sup>d</sup>
					Малын чанар сайжруулах, сайн үүлдрийн эцэг мал худалдан авах, хувиар	Өрхийн хэрэглээний зориулалтаар олгосон зээлийн эзлэх хувь				
1	Их-Тамир	137	44	405.0	29.5	9.8	39.0	32.1	3.7	6.0
2	Цэнхэр	154	57	523.5	40.0	43.5	47.6	37.0	3.3	7.2
3	Бат-Өлзий	130	66	564.1	47.4	0.7	54.0	50.8	(0.6)	(1.0)
4	Их-Уул	114	60	558.1	7.1	-	52.1	52.6	1.8	6.5
5	Улаан-Уул	281	62	489.3	26.0	-	51.7	22.1	7.9	8.6
<b>Нийт</b>		<b>816</b>	<b>289</b>	<b>2,540.0</b>	<b>30.0</b>	<b>18.0</b>	<b>48.9</b>	<b>38.9</b>	<b>3.2</b>	<b>5.5</b>

Энд: \* - Зээлийн эргэн төлөлтийн хувь нь тухайн жилд олгосон зээлийн хэдэн хувь нь эргэн төлөгдөж байгаагаар илэрхийлэгдэнэ. Өөрөөр хэлбэл, хуваарийн дагуу эргэн төлөлт хийгдсэн мөнгөн дүн юм.

<sup>a</sup> - ОБЗЭС-аас олгох “Байгальд ээлтэй малчны зээл”-ийн удирдамж, 5.13 заалтын а үзүүлэлт

<sup>b</sup> – ОБЗЭС-аас олгох “Байгальд ээлтэй малчны зээл”-ийн удирдамж, 5.13 заалтын б үзүүлэлт. Зээлийн эргэн төлөлтийн хувийг тооцоолохдоо нийт олгосон зээлээс одоо байгаа зээлийн үлдэгдлийг хасаж, эргэн төлөгдсөн зээлийн хэмжээг тооцсон.

<sup>c</sup> - ОБЗЭС-аас олгох “Байгальд ээлтэй малчны зээл”-ийн удирдамж, 5.13 заалтын с үзүүлэлт.

<sup>d</sup> - ОБЗЭС-аас олгох “Байгальд ээлтэй малчны зээл”-ийн удирдамж, 5.13 заалтын д үзүүлэлт.

<sup>20</sup> - ОБЗЭС-аас олгох “Байгальд ээлтэй малчны зээл”-ийн удирдамж, 5.13 заалтын дагуу

1. **Тухайн ОБ-д амьдарч байгаа нийт өрхийн тоо:** Тухайн сумын ОБ-д амьдарч байгаа нийт 816 өрх байгаа бөгөөд үүнийг 137 нь Архангай аймгийн Их-Тамир суманд, 154 нь Цэнхэр суманд, 130 нь Өвөрхангай аймгийн Бат-Өлзий суманд, 114 нь Завхан аймгийн Их-Уул суманд, 281 нь Хөвсгөл аймгийн Улаан-Уул суманд тус тус харьяалагдаж байна.
2. **Олгосон зээлийн тоо:** ОБЗЭС-аас олгосон нийт зээлийн тоог авч үзвэл нийтдээ 289 өрхөд олгосон бөгөөд үүнээс Өвөрхангай аймгийн Бат-Өлзий сум хамгийн олон малчдад буюу 66 өрхөд зээл олгосон бол, Архангай аймгийн Их-Тамир сумын хувьд хамгийн цөөн буюу 44 малчин өрхөд зээл олгосон байна.
3. **Зорилтот ашиг хүртэгчдэд хүрсэн зээлийн хувь:** Тухайн сумдын Орчны бүс орчмоор амьдардаг нийт малчин өрхийн зээлд хамрагдсан малчин өрхийн хувиар энэхүү үзүүлэлтийг тооцсон ба ОБ-д амьдарч байгаа нийт өрхийн 38.9 хувь нь зээлд хамрагджээ. Үүнээс Завхан аймгийн Их-Уул сумын хувьд орчны бүс орчмоор амьдардаг нийт өрхүүдийн 52.6 хувь нь ОБЗЭС-ийн зээлд хамрагдсан байгаа нь хамгийн өндөр үзүүлэлт бол, Хөвсгөл аймгийн Улаан-Уул сумын хувьд хамгийн бага буюу 22.1 хувийг хамруулжээ.
4. **ОБЗЭС-аас олгосон нийт зээлийн хэмжээ:** ОБЗЭС-аас нийтдээ 2.5 тэрбум төгрөгийн зээл олгоод байгаа бөгөөд үүнээс Өвөрхангай аймгийн Бат-Өлзий сумын хувьд хамгийн их буюу 564.1 сая төгрөгийг олгосон бол, Архангай аймгийн Их-Тамир сумын хувьд хамгийн бага буюу 405.0 сая төгрөгийг өнөөдрийн байдлаар олгосон байна.
5. **Олгосон зээлийн зориулалтаар авч үзвэл** ОБЗЭС-аас олгосон нийт зээлийн дунджаар 30 орчим хувийг малын чанар сайжруулах, сайн үүлдрийн эцэг мал худалдан авах зориулалтаар олгосон бол, нийт зээлийн дунджаар 18 орчим хувийг өрхийн хэрэглээний зориулалтаар олгожээ. Өвөрхангай аймгийн Бат-Өлзий сумын хувьд нийт олгосон зээлийн 47.4 хувь нь байгаа бол, хамгийн бага нь Завхан аймгийн Их-Уул сум нийт олгосон зээлийн 7.1 хувийг эзэлж байна. *Өрхийн хэрэглээний зориулалтаар олгосон зээлийн хувь нь* Архангай аймгийн хувьд хамгийн өндөр буюу нийт олгосон зээлийн 43.5 хувийг эзэлж байгаа бол, Завхан аймгийн Их-Уул болон Хөвсгөл аймгийн Улаан-Уул сумын хувьд энэ зориулалтаар зээл олгоогүй байна.
6. **ОБЗЭС-ийн эргэн төлөлтийн хувь:** Эргэн төлөлтийн хувийг тооцоолохдоо нийт олгосон зээлээс одоо байгаа зээлийн үлдэгдлийг хасаж, тооцсон. Одоогийн байдлаар нийт олгосон зээлийн 48.9 хувь нь эргэн төлөгджээ. Эргэн төлөгдөөгүй байгаа зээлийн хувьд хэвийн, хуваарийн дагуу төлөгдөж байна. Эргэн төлөлтийн хувийг авч үзвэл Өвөрхангай аймгийн Бат-Өлзий сумын хувьд хамгийн өндөр буюу 54.0 хувь байгаа бол, Архангай аймгийн Их-Тамир сумын хувьд хамгийн бага буюу 39.0 хувь байна.
7. **Орчны бүсийн хэмжээнд гарсан малын тооны өөрчлөлт:** Өвөрхангай аймгийн Бат-Өлзий сумын хувьд хамгийн сайн үзүүлэлт буюу 0.6 хувиар малын тоо нь буурсан бол, Хөвсгөл аймгийн Улаан-Уул сумын хувьд хамгийн муу буюу 7.9 хувиар малын тоо нь өсжээ.


- 8. Сумын малын тооны өөрчлөлт:** Хөвсгөл аймгийн Улаан -Уул сумын хувьд малын тоо нь хамгийн ихээр буюу 8.6 хувиар өссөн бол, Өвөрхангай аймгийн Бат-Өлзий сумын хувьд хамгийн бага буюу 1 хувиар буурсан байна.

### 3.7. СУРГАЛТЫН ҮНЭЛГЭЭ, ЦААШДЫН ХЭРЭГЦЭЭ ШААРДЛАГА

Судалгаанд хамрагдсан зээл авсан малчин өрхийн төлөөллөөс ОБЗЭС-ийн талаар ойлголт өгөх сургалтад хамрагдсан эсэхийг тодруулахад 44.7 хувь нь хамрагдсан үлдсэн хувь нь хамрагдаагүй гэж хариулсан байна. Үр дүнг сумдаар задалж харахад Цэнхэр сумын хувьд хамгийн бага буюу 6.7 хувь нь сургалтад хамрагдсан бол Улаан-Уул сумын малчдын 73.3 хувь нь хамрагдсан байгаа нь хамгийн өндөр хувийг эзэлж байна.

Зээл аваагүй малчин өрхүүдээс 3 өрхийн төлөөлөл л энэ төрлийн сургалтад хамрагдсан байлаа.

**График 20. ОБЗЭС-ийн талаар ойлголт өгөх сургалтад хамрагдсан эсэх, n=76**




Зээл авсан малчин өрхүүдийн төлөөллөөс цаашид ямар сургалтын хэрэгцээ байгааг нь тодруулахад 25.0 хувь нь ОБЗ-ийн тухай илүү дэлгэрэнгүй мэдээлэл авах, 25.0 хувь нь төрөл бүрийн, 18.4 хувь нь МАА-тай холбоотой, 13.2 хувь нь нэмэлт орлого олох сургалтад хамрагдахыг хүсэж байгаагаа илэрхийлжээ.

**График 21. Сургалтын хэрэгцээ, шаардлага, n=76**



Зээл аваагүй 2 малчин тутмын 1 нь ОБЗ-ийн талаар сургалтад хамрагдахыг хүссэн байна.

**График 22. Сургалтын хэрэгцээ, шаардлага, n=31 (зээл аваагүй малчин өрх), хувиар**



## БҮЛЭГ 4. ОРЧНЫ БҮСИЙН ЭРГЭЛТИЙН САНГИЙН ҮР НӨЛӨӨ

### 4.1. СУДАЛГААНД ОРОЛЦОГЧДЫН ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

Судалгаанд нийт 107 малчин өрх хамрагдсан бөгөөд үүний 76 нь зээл авсан, 31 нь зээл аваагүй малчин өрх байсан. Дараах хүснэгтэд судалгаанд оролцогчдын хүн ам зүйн ерөнхий мэдээллийг хураангуйлан харууллаа.


**Хүснэгт 39. Судалгаанд оролцогчдын ерөнхий мэдээлэл, n=107**

Ангилал	Төрөл	Зээл авсан		Зээл аваагүй	
		Тоо	Хувь	Тоо	Хувь
Нийт дүн		76.0	100.0%	31.0	100.0%
Байршил	Их Тамир сум	12.0	15.8%	5.0	16.1%
	Цэнхэр сум	15.0	19.7%	6.0	19.4%
	Улаан-уул	15.0	19.7%	6.0	19.4%
	Бат-Өлзий	17.0	22.4%	7.0	22.6%
	Их-Уул	17.0	22.4%	7.0	22.6%
Өрхийн ам бүлийн гишүүдийн тоо	1-2 гишүүнтэй	16.0	21.1%	7.0	22.6%
	3-4 гишүүнтэй	23.0	30.3%	12.0	38.7%
	5-6 гишүүнтэй	31.0	40.8%	11.0	35.5%
	7-оос дээш гишүүнтэй	6.0	7.9%	1.0	3.2%
Ярилцлага өгсөн хүн	Өрхийн тэргүүн	50.0	65.8%	24.0	77.4%
	Эхнэр / Нөхөр	26.0	34.2%	6.0	19.4%
	Эцэг эх	-	0.0%	1.0	3.2%
Судалгаанд оролцогчдын хүйс	Эрэгтэй	71.0	93.4%	29.0	93.5%
	Эмэгтэй	5.0	6.6%	2.0	6.5%
Судалгаанд оролцогчдын нас	18-25	-	0.0%	1.0	3.2%
	26-30	3.0	3.9%	4.0	12.9%
	31-40	18.0	23.7%	6.0	19.4%
	41-50	25.0	32.9%	12.0	38.7%
	51-60	14.0	18.4%	6.0	19.4%
	60-аас дээш	16.0	21.1%	2.0	6.5%
Гэрлэлтийн байдал	Гэрлээгүй	2.0	2.6%	4.0	12.9%
	Гэрлэсэн	68.0	89.5%	26.0	83.9%
	Бэлэвсэн	6.0	7.9%	1.0	3.2%
Боловсролын түвшин	Сургуульд яваагүй	10.0	13.2%	1.0	3.2%
	Бага ангид сурсан	9.0	11.8%	6.0	19.4%
	Дунд ангид сурсан	2.0	2.6%	17.0	54.8%
	Ахлах сургуульд сурсан	44.0	57.9%	5.0	16.1%
	Тусгай дунд	6.0	7.9%	1.0	3.2%
	Их дээд сургуульд сурсан	5.0	6.6%	1.0	3.2%
Мал малласан туршлага	3 хүртэл жил	1	1.3%	1	3.2%
	4-7 жил	2	2.6%	3	9.7%
	8-10 жил	3	3.9%	3	9.7%
	11-15 жил	9	11.8%	2	6.5%
	16-20 жил	12	15.8%	9	29.0%
	20-оос дээш жил	49	64.5%	13	41.9%

Зээл авсан малчдаас зээлийн туршлагыг нь тодруулахад 43.4 хувь нь нэг удаа, 34.2 хувь нь 2 удаа, 22.4 хувь 3-аас олон удаа зээл авч байсан гэж хариулсан. Нэг удаа

зээл авсан гэж хариулсан малчдын тухайд ОБЗЭС-аас зээл авсан байгаа нь онцлох үр дүн байлаа.

**График 23. Зээл авч байсан туршлага, n=76, хувиар**




Судалгаанд хамрагдсан зээл авсан малчин өрхүүд нийт 93 удаа зээл авч байсан бөгөөд үүний 76 нь Төрийн банкнаас авсан зээл байсан.

**Хүснэгт 40. Зээл авч байсан туршлага, арилжааны банкны төрлөөр**

Төрөл	2020	2021	2022	2023	Нийт
Хаан банк	7	2	3	5	17
Төрийн банк	7	50	13	6	76

Төрийн банкнаас зээл авсан малчид ОБЗЭС-ийн зээл, малчны зээл, тэтгэврийн зээл авч байжээ.

**График 24. Төрийн банкнаас зээл авч байсан зээлийн зориулалт, n=76**



Харин ОБЗЭС-аас ямар зорилгоор зээл авсныг нь тодруулахад 72.4 хувь нь буюу дийлэнх нь “малын чанарыг сайжруулах, мал, малын гаралтай бүтээгдэхүүний үнэ цэнийг нэмэгдүүлэх”-ээр, 40.8 хувь нь бэлчээр, тэжээлийн хангамж, газрын бүтээмжийг сайжруулах зорилгоор гэж хариулсан байна. Судалгааны энэхүү үр дүн нь Төрийн банкны болон ОБЗ-ийн тайланд дурдагдсан зээлийн зорилгоос бага зэрэг ялгаатай байв.


**График 25. ОБЗЭС-аас ямар зорилгоор зээл авсан бэ, n=76**



ОБЗЭС-аас авсан зээлээ зориулалтын дагуу ашигласан уу гэсэн асуултад нийт зээл авсан малчдын 2.6 хувь нь “үгүй” гэсэн байв. Их-Уул, Бат-Өлзий, Улаан-Уул сумын хувьд зээлээ зориулалтын дагуу ашиглаагүй зээлдэгч байгаагүй. Харин Цэнхэр сумын хувьд 6.7 хувь нь, Ихтамир сумын 8.3 хувь нь авсан зээлээ зориулалтын дагуу ашиглаагүй гэж хариулжээ.




**График 26. Зээлээ зориулалтын дагуу ашигласан эсэх, n=76**




Зээлээ зориулалтын дагуу ашигласан 74 малчин өрхийн 47.3 хувь нь авсан зээлээрээ эцэг, мал худалдан авсан, 32.4 хувь нь малын хашаа зассан, 27.0 хувь нь өрхийн хэрэгцээндээ зарцуулжээ.

**График 27. Зээлээ зориулалтын дагуу зарцуулсан бол юу худалдаж авсан бэ, n=74**




Судалгаанд хамрагдсан зээл авсан малчдын 85.5 хувь нь ОБЗЭС-аас хүссэн хэмжээгээрээ зээл авчээ. Цэнхэр сумын зээлдэгч нарын хувьд бүгд хүссэн хэмжээгээрээ зээл авсан бол Бат-Өлзий сумын хувьд бусад сумтай харьцуулахад хүссэн хэмжээгээрээ зээл авч чадаагүй гэж хариулсан харилтын хувь илүү байв.

**График 28. ОБЗЭС-аас хүссэн хэмжээгээрээ зээл авч чадсан эсэх, n=76**



Хүссэн хэмжээгээрээ зээл авч чадаагүй шалтгааныг тодруулахад малын тоо, барьцаа хүрээгүй, зээлийн хэмжээ анхнаасаа бага байсан зэрэг шалтгааныг нэрлэжээ.

**График 29. Хүссэн хэмжээгээрээ зээл авч чадаагүй бол шалтгаан нь юу вэ?, n=13**



## 4.2. ОБЗЭС-ийн ЗЭЭЛИЙН ҮР ДҮН


### 4.2.1. Малын тоо толгойд гарсан өөрчлөлт

ОБЗЭС-ийн зээлийн гол зорилго нь Орчны бүсэд амьдарч байгаа малчин өрхүүдийн малын тоог бууруулах замаар малчдын амьжиргааг дээшлүүлэх, бэлчээрийг хамгаалах зорилготой. ОБЗЭС-ийн зээлд хамрагдсан, судалгаанд оролцсон малчин өрхүүдийн хувьд малын тооны А данс болон асуулгаар өгсөн малын тооны бууралттай харьцуулан дараах графикаар харууллаа. Судалгаанд хамрагдсан малын өрхүүдийн хувьд 2023 оны байдлаар малын тоогоо А дансаар дунджаар 8.6 хувиар бууруулсан бол, асуулгаар 5.4 хувь бууруулсан байна. Энэхүү өөрчлөлтөөс харахад 5 хувь малаа бууруулна гэсэн зээлийн зорилгоо биелүүлсэн нь харагдаж байна. Энэхүү малын бууралт нь зарсан болон үхсэн бүх малыг оруулсан бууралт бөгөөд бид зээлийн нөлөөгөөр яг хэдэн малаар буурсныг тооцохдоо малчдын малаа зах зээлд борлуулсан мэдээлэлд тулгуурлана.

Дараах графикаас харахад Өвөрхангай аймгийн Бат-Өлзий сум, Архангай аймгийн Их-Тамир сумдын хувьд малчдын өгсөн аман судалгаагаар малын тоо нь А данснаас бага зэрэг өндөр байгаа нь харагдаж байна. Бат-Өлзий сумын хувьд 2023 онд

зээл авсан малчин өрхүүдийн хувьд малын тоогоо бууруулсан хувь нь бага байсан нь малын тооны бууралт эерэг гарахад нөлөөлжээ.


**График 30. Судалгаанд хамрагдсан малчин өрхүүдийн малын тооны дундаж өөрчлөлт, хувиар**



Эх үүсвэр: Түүвэр судалгааны үр дүн, А дансны мэдээлэл  
Түүвэр судалгааны малын тооны өөрчлөлт нь 0.05- хувийн ач холбогдолтой нь батлагдсан.

Зээл авсан малчдын малын тоог хонин толгойд шилжүүлснээр 2020-2023 онд нийт 13528.8 малаар буурсан байна. Үүнээс Архангай аймгийн Цэнхэр сумын хувьд хамгийн олон малаар буюу хонин толгойд шилжүүлсэн дүнгээр 6433.6 толгой малаар бууруулсан бол, Өвөрхангай аймгийн Бат-Өлзий сумын хувьд хамгийн цөөн буюу 441.4 толгой малаар бууруулсан байна. Харин Завхан аймгийн Их-Уул сум болон Хөвсгөл аймгийн Улаан-Уул сумдын хувьд харгалзан 1679.8 болон 1665.5 толгой малаар тус тус бууруулжээ. Бид судалгааны явцад малчдаас малын тоог асуусан бөгөөд асуулгын үр дүнгээр нийтдээ 9510.9 толгой малаар буурчээ. Энэхүү үр дүнгээс харахад малчдын А данс болон аман тоогоор өгсөн малын тоо нь 29.3 хувийн зөрүүтэй байна (Асуулгын судалгааны тоон мэдээллийн т-тестийг шалгахад 0.05 хувийн түвшинд ач холбогдолтой байсан). Архангай аймгийн Цэнхэр сумын хувьд хонин толгойд шилжүүлсэн дүнгээр хамгийн их мал бууруулсан буюу нийт бууруулсан малын 47.8 хувийг эзэлж байгаа бол, Өвөрхангай аймгийн Бат-Өлзий сумын хувьд хамгийн бага буюу 3.3 хувийг эзэлж байна.


**График 31. Судалгаанд хамрагдсан малчин өрхүүдийн малын тооны бууралт, хонин толгойд шилжүүлсэн дүнгээр**



Эх үүсвэр: Түүвэр судалгааны үр дүн, А дансны мэдээлэл  
Түүвэр судалгааны малын тооны өөрчлөлт нь 0.05- хувийн ач холбогдолтой нь батлагдсан.

Малын тооны бууралтын хэдэн хувь нь төслийн үр дүнгээс шалтгаалсныг тооцоолохдоо судалгаанд хамрагдсан 76 малчин өрхийн малаа зах зээлд борлуулсан мэдээлэл дээр тулгуурлан тооцооллоо. Судалгаанд хамрагдсан өрхүүдийн хувьд нийтдээ 7401 малыг зах зээлд борлуулсан бөгөөд энэ нь нийт буурсан малын 54.9 хувийг тайлбарлаж байна.


**График 32. Судалгаанд хамрагдсан малчин өрхүүдийн малын тооны бууралт болон зарсан малын тоо**



Өөрөөр хэлбэл, үлдсэн 45.1 хувь нь байгалийн бусад хүчин зүйлээс болж буурсан гэж үзэж байна.

Зээл авсан малчин өрхүүдийн зээл авсан хугацаанаас хойш малын тооны өөрчлөлтийг оноор авч үзвэл, 2021 онд малын тоо 11.8 хувиар буурсан бол, 2022 онд 7.7 хувь, 2023 онд 6.4 хувиар тус тус буурснаас харахад малчид зээл авсан эхний жил буюу 12 сарын хугацаанд малаа 5 хувь бууруулах үүргээ биелүүлээд, дараа жил өсгөдөг нь судалгааны үр дүнд ажиглагдсан нь нөлөөлсөн байж болох юм.

**График 33. Зээл авсан малчин өрхүүдийн малын тооны өөрчлөлт, оноор, сумдаар, хувиар**




Эх үүсвэр: Түүвэр судалгааны үр дүн, А дансны мэдээлэл

Дээрх графикаас харахад Өвөрхангай аймгийн Бат-Өлзий сум, Завхан аймгийн Их-Уул сумдын хувьд 2023 онд зээл авсан малчид малын тоогоо бууруулаагүй байгаа нь нөлөөлсөн гэж үзэж байна.

Зээл авсан малчин өрхийн судалгаанд хамрагдсан өрх бүрээр зээлийн үндсэн шаардлага болох малын тоог жил бүр 5 хувь бууруулах зорилгоо биелүүлсэн эсэхийг дараах графикаар харууллаа. Судалгаанд хамрагдсан 2021 онд зээл авсан өрхүүдийн 64.4 хувь нь малынхаа тоог 5 хувиас илүү хувиар бууруулсан бол, 4.1 хувь нь малынхаа тоог бууруулсан ч, 5 хувь бууруулах зорилгоо биелүүлээгүй байна. Харин 31.5 хувь нь малынхаа тоог өсгөжээ. 2022 онд зээл авсан өрхүүдийн 67.1 хувь нь малынхаа тоог 5 хувиас илүү хувиар бууруулсан бол, 9.2 хувь нь бууруулсан ч, 5 хувь бууруулах зорилгоо биелүүлээгүй байна.

**График 34. Малын тоо бууруулах зорилгоо биелүүлсэн байдал, зээл авсан оноор**




Харин 2022 онд зээл авсан өрхүүдийн 23.7 хувь нь малынхаа өсгөжээ. Үүнээс харахад малчдын малынхаа тоог бууруулах зорилгоо биелүүлсэн малчдын тоо өссөн, малынхаа тоог өсгөж байгаа малчдын тоо буурч байгаа нь малчид малынхаа тоонд анхаардаг болсон эерэг үр дүн харагдаж байна. Харин малынхаа тоог бууруулсан ч, 5 хувьдаа хүрэх зорилгоо биелүүлээгүй малчдын тоо бага зэрэг өсжээ.

**4.2.1.3 Зээл аваагүй малчин өрх болон зээл авсан малчин өрхийн малын тооны өөрчлөлтийн харьцуулалт**

Бид судалгаандаа зээл аваагүй малчин өрхийг хяналтын өрх болгон сонгон авсан бөгөөд зээл аваагүй малчин өрхүүдийн хувьд тухайн онуудад малын тоо нь хэрхэн өөрчлөгдсөнийг дараах графикаар харууллаа. Зээл аваагүй малчин өрхүүдийн хувьд малын тоо нь А дансаар 2020-2023 оны хооронд 5.6 хувиар, асуулгаар 10.1 хувь өссөн нь харагдаж байна.

**График 35. Судалгаанд хамрагдсан зээл аваагүй малчин өрхүүдийн малын тооны өөрчлөлт, хувиар,**




Эх үүсвэр: Түүвэр судалгааны үр дүн, А дансны мэдээлэл

Төслийн зорилтод сумдаар авч үзвэл Архангай аймгийн Их-Тамир сумын зээл аваагүй малчин өрхийн хувьд малын тоо 2 хувиар буурсан бол, Цэнхэр сумын хувьд 9.1 хувиар өсжээ. Харин Хөвсгөл аймгийн Улаан-Уул сумын хувьд 22.3 хувиар малын тоо өссөн нь хамгийн өндөр үзүүлэлт байгаа юм. Өвөрхангай аймгийн Бат-Өлзий сум, Завхан аймгийн Их-Уул сумдын хувьд зээл аваагүй малчин өрхүүдийн хувьд малын тоо нь 0.2 хувь, 1.1 хувиар тус тус буурсан нь харагдаж байна.

Зээл авсан малчин өрхийн малын тооны өөрчлөлт болон зээл аваагүй малчин өрхийн малын тооны өөрчлөлтийг харьцуулахад зээл авсан малчин өрхүүдийн хувьд малын тоогоо 8.6 хувиар бууруулсан бол, зээл аваагүй малчин өрхүүдийн хувьд 5.6 хувиар өссөн байгаагаас харахад зээлийн зорилтдоо хүрсэн нь харагдаж байна.


**График 36. Зээл авсан болон зээл аваагүй малчин өрхүүдийн малын тооны өөрчлөлт, хувиар**



Эх үүсвэр: Түүвэр судалгааны үр дүн, А дансны мэдээлэл

Зээл авсан болон зээл аваагүй малчдын малын тооны өөрчлөлтийг 2021-2023 оны хооронд авч үзвэл зээл авсан малчид маань малын тоогоо хонин толгойд шилжүүлснээр 13458.8 тоогоор бууруулсан бол, зээл аваагүй малчдын хувьд малын тоо нь 1600.1 хонин толгойгоор өссөн байна.

**График 37. Зээл авсан болон зээл аваагүй малчин өрхүүдийн малын тооны өөрчлөлт, хонин толгойд шилжүүлсэн дүнгээр, А дансны мэдээллээр**




Дээрх графикаас харахад зээл нь малын тоог бууруулах бодит хөшүүрэг болж, ТХГН-ийн орчны бүс дэх малын тоо буурч, бэлчээрийн талхлалт болон бэлчээрийн даацыг бууруулахад бодит хувь нэмрээ оруулсан гэж харж байна.

#### 4.2.2. Өрхийн амьжиргаанд гарсан үр нөлөө


Судалгаанд хамрагдсан нийт малчдын хувьд өрхийн орлого нь 2020 онд 23.4 сая төгрөг байсан бол 2023 онд 24.8 сая төгрөг болж өссөн байв.

График 38. Малчин өрхийн орлого, сая төгрөгөөр, n=107



Судалгаанд хамрагдсан зээл авсан малчин өрхийн орлого дунджаар 3.8 хувиар өссөн байхад зээл аваагүй малчин өрхүүдийн орлого дунджаар 0.1 хувь өсөж, зээл авсан малчдын хувьд зээлийн нөлөөгөөр 3.7 хувийн орлогын эерэг нөлөө бий болсон байна.

График 39. Зээлийн нөлөө, хувиар, n=107






#### 4.2.3. Өрхийн мал аж ахуйн бус үйлдвэрлэлд гарсан өөрчлөлт

Зээлд хамрагдсан малчин өрхүүдийн 16<sup>21</sup> нь МАА-н бус орлоготой бөгөөд эдгээрийн 10 нь ОБЗЭС-ийн зээлээ энэхүү орлогоо нэмэгдүүлэхэд ашиглаж чадсан гэж хариулжээ. Дараах МАА-н бус орлогын эх үүсвэртэй болсон байна. Үүнд:

- Аялал жуулчлал
- Гэрийн мод хийж борлуулдаг
- Ногоон тэжээл тариалсан
- Оёдлоо үйлдвэрлэлээ сайжруулсан
- Хадлангийн талбайтай болсон

Дээрх 10 малчин өрх МАА-н бус орлогоосоо 1,000,000-3,000,000 төгрөгийн орлого олж байна.

**График 40. Танайх МАА-с гадна орлогын өөр эх үүсвэртэй юу?, n=107, хувиар**



Харин зээлд хамрагдаагүй малчин өрхүүдийн 7<sup>22</sup> нь МАА-н бус орлого олдог бөгөөд дунджаар 1,000,000 төгрөгийн орлого олж байна.

#### 4.2.4. Байгаль орчин, нийгэмд гарсан өөрчлөлт


Зээл авснаар эцэг мал авч малын чанар сайжирсан гэж 30.3 хувь нь, мөн 30.3 хувь нь өрхийн хэрэгцээг хангаж чадсан, 25.0 хувь нь хашаа, хороо барьсан, сайжруулсан, 23.7 хувь нь өрхийн амьжиргаа сайжирсан, 21.1 хувь нь өвс, тэжээл, хадлангийн хэмжээ нэмэгдсэн, 10.5 хувь нь оюутны төлбөр төлсөн зэрэг нь эерэг нөлөөлөл байсан гэж хариулсан байна.

<sup>21</sup> Ихтамир суманд 1, Улаан-Уул суманд 4, Бат-Өлзий суманд 8, Их-Уул суманд 3

<sup>22</sup> Бүгд орлого олдог


**График 41. Малчин өрхүүдэд бий болсон зэрэг нөлөө, n=76**

Харин сөрөг нөлөөлөл байхгүй гэж зээл авсан малчдын 90.8 хувь нь хариулжээ. 5.3 хувь нь өрхийн амьжиргаанд сөргөөр нөлөөлсөн гэж хариулсан малчдаас ямар шалтгаантай болохыг тодруулахад малын тоог цөөлснөөс болж ноолуур, сүү, цагаан идээ гэх мэт малын гаралтай бүтээгдэхүүнээс олох орлого багассантай холбон тайлбарлаж байсан.

**График 42. Малчин өрхүүдэд бий болсон сөрөг нөлөө, n=76**

Малчдад зээл олгосноор байгаль орчинд ямар нөлөө үзүүлснийг тодруулахад 89.5 хувь нь малын тоог бэлчээрийн даацад тохируулан бууруулсан нь бэлчээрийн доройтлыг багасгасан, 46.1 хувь нь гэрээт бэлчээр ашиглалт, хамгаалалт сайжирсан, 39.5 хувь нь ТХГН-ийн орчны бүсийн бэлчээрийн талхагдал буурч, ургамлын төрөл зүйл, зэрэг ан амьтдын амьдрах орчин тэлсэн, 9.2 хувь нь одоогоор үр дүн хараахан мэдэгдэхгүй байна гэж үзсэн.


**График 43. ОБЗЭС-ийн зээлийн байгаль орчинд үзүүлсэн нөлөө, n=76**



### 4.3. ЗЭЭЛДЭГЧДИЙН ЗЭЭЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНД ӨГСӨН СЭТГЭЛ ХАНАМЖИЙН ҮНЭЛГЭЭ


Судалгаанд оролцсон зээл авсан малчдаас ОБЗЭС-ийн зээлийг санхүүжүүлэгчийн талаар мэддэг эсэхийг асуухад 56.6 хувь нь буюу талаас илүү хувь нь мэдэхгүй гэсэн байв.

**График 44. ОБЗЭС-ийн зээлийг санхүүжүүлэгчийн талаар мэдэх эсэх, n=76**




Зээлийн зорилгыг хэр мэдэж байгааг тодруулахад 56.6 хувь нь малын тоог бууруулах, 39.5 хувь нь бэлчээрийн тогтвортой байдлыг дэмжих, 25.0 хувь нь ОБ-д амьдарч байгаа иргэдийн амьжиргааг сайжруулах, 19.7 хувь нь ТХГН-ийн захиргаатай хамтран ажиллаж байгалийг хамгаалах, 3.9 хувь нь шинэ бизнес эхлүүлэх, 10.5 хувь нь мэдэхгүй гэж хариулсан.

**График 45. ОБЗЭС-ийн зээлийн зорилгыг мэдэх эсэх, n=76**




ОБЗЭС-аас зээл авахад судалгаанд оролцсон зээлдэгчдийн 92.1 хувьд нь ямар нэгэн хүндрэл бэрхшээл учраагүй гэж хариулсан. Хүндрэл учирсан гэж хариулсан оролцогчдоос учир шалтгааны тодруулахад банкны ачаалал их тул удаан хүлээлгэдэг, бичиг баримт бүрдүүлэхэд хүндрэлтэй байдаг, давхар зээлтэй болохоор шалгуур хангадаггүй, банкаар биш өөр байгууллагаар өгдөг бол сайн байна гэх зэргээр хариулсан.

**График 46. ОБЗЭС-аас зээл авахад ямар нэгэн хүндрэл, бэрхшээл учирсан эсэх, n=76**




“Байгальд зээлтэй малчны зээл”-ийн зээл авсан малчид малын тоог 5 хувь бууруулах үүргээ биелүүлсэн эсэхийг тодруулахад 93.4 хувь нь тийм гэж хариулсан байв.

**График 47. “Байгальд ээлтэй малчны зээл”-ийн зээл авсан малчид малын тоог 5 хувь бууруулах үүргээ биелүүлсэн эсэх, n=76**




Зээл авсан малчдын 85-аас дээш хувьд нь зээлийн эргэн төлөх нөхцөл, зээлийн хугацаа, зээлийн нөхцөл таалагдаж байгаа гэдгээ илэрхийлсэн.

**График 48. Зээлтэй холбоотой сэтгэгдэл, хувиар, n=76**



Ямар нэгэн нөхцөл нь таалагдаагүй гэж хариулсан оролцогчдоос шалтгааныг тодруулахад эргэн төлөлтийн хугацаа бодит биш байсан, олгож байгаа зээлийн хэмжээ бага байсан, хүү нь өндөр байсан гэж хариулсан.

**График 49. Ямар нэгэн нөхцөл таалагдаагүй бол шалтгаан нь юу вэ, n=19**




Зээл авсан малчдаас сэтгэл ханамжийг 3 дэд үзүүлэлтийн хүрээнд тодруулсан. Судалгааны үр дүнгээс үзэхэд зээл авсан малчдын сэтгэл ханамжийн дундаж үнэлгээ 4.3 буюу ихээхэн сэтгэл ханамжтай байна. Цаашид төслийн үйл ажиллагааг

үргэлжлүүлэхдээ уг сэтгэл ханамжийн түвшнийг хадгалах, илүү сайжруулахад анхаарч ажиллах шаардлагатайг илэрхийлсэн үр дүн юм.


Сэтгэл ханамжийг үнэлүүлсэн 3 дэд үзүүлэлтийн хувьд зээлд өгч байгаа сэтгэл ханамжийн үнэлгээ 4.3, зээл олголтын үйл явцад өгсөн үнэлгээ 4.2, зээлийн талаар ойлголт, мэдээлэл өгөх сургалтад өгсөн үнэлгээ 4.4 байна. 3 дэд үзүүлэлтийн үнэлгээ ойролцоо байгаа хэдий ч малчид сургалтын үйл ажиллагаанд илүү сэтгэл ханамжтай байжээ.

**График 50. Сэтгэл ханамжийн үнэлгээ, n=76 (үнэлгээний дээд утга 5)**




Зээл аваагүй малчдын сэтгэл ханамжийн үнэлгээ дунджаар 3.5 оноогоор үнэлэгдсэн. Энэ нь төслийн зүгээс зээл олголтын үйл ажиллагаа болон сургалтын хүртээмжийг илүү нэмэгдүүлэх шаардлагатай илэрхийлсэн үр дүн юм.

**График 51. Сэтгэл ханамжийн үнэлгээ, n=31(зээл аваагүй малчин өрх(үнэлгээний дээд утга 5))**



ОБЗЭС-ийн зээлийн шалгуурын талаарх сэтгэгдлийг тодруулахад нийт судалгаанд оролцсон малчдын 57.9 хувь нь таалагдсан, оновчтой байсан, 11.8 хувь нь хүү, мөнгөн дүн, хугацаа дээр анхаарах хэрэгтэй, 11.8 хувь нь хүндрэл бэрхшээл байхгүй, 2.6 хувь нь шударга байсан зэргээр хариулжээ. Эндээс үзэхэд төслийн зүгээс тавьсан зээлийн шалгуур малчдад биелүүлэх боломжтой санагдаж байсан нь харагдаж байна.

**График 52. ОБЗЭС-ийн зээлийн шалгуурын талаарх сэтгэгдэл, n=107**



“Орчны бүсийн зээлийн эргэлтийн сан”-ийн хүрээнд байгаль хамгаалах, малчдын амьжиргааг нэмэгдүүлэх холбоо хамаарлыг сайжруулахын тулд юу хийх шаардлагатай вэ гэсэн асуултад судалгаанд оролцсон нийт малчин өрхийн 34.2 хувь нь зээлийг илүү хүртээмжтэй болгох хэрэгтэй гэж хариулсан байна.



**График 53. “Орчны бүсийн зээлийн эргэлтийн сан”-ийн хүрээнд байгаль хамгаалах, малчдын амьжиргааг нэмэгдүүлэх холбоо хамаарлыг сайжруулахын тулд юу хийх шаардлагатай гэж үзэж байна вэ, n=107**



Зээл аваагүй малчин өрхийн 93.5 хувь нь энэхүү зээлийг цаашид үргэлжлүүлэх хэрэгцээ, шаардлага байна гэж үзжээ. Харин ямар хэрэгцээ шаардлага байгааг тодруулахад иргэдийн амьжиргааг дээшлүүлэх, нэмэлт орлоготой болох, бэлчээрийн даац, байгалиа хамгаалах болон малыг чанаржуулах ихээхэн хувь нэмэр оруулна гэж хариулжээ. Мөн зээл аваагүй малчин өрхийн 93.5 хувь нь уг зээлийн үйл ажиллагаа цаашид өргөжөөд хэрэгжих бол зээлд хамрагдахаар материалаа өгнө гэсэн байна. Зээлд хамрагдахаар материалаа өгөхгүй гэж хариулсан 2 малчнаас яагаад гэдэг шалтгааныг нь тодруулахад “Малынхаа тоог бууруулмааргүй байна” хэмээжээ.

## БҮЛЭГ 5. САЙН ТУРШЛАГА, СУРГАМЖ, ЭРСДЭЛИЙН ШИНЖИЛГЭЭ

### 5.1. САЙН ТУРШЛАГА БОЛОН СУРГАМЖ

Судалгааны багийн талбарт ажилласан тэмдэглэл, чанарын судалгаанд оролцогчдын ярилцлагад үндэслэн дараах хүснэгт дэх мэдээллийг боловсруулсан болно.

**Хүснэгт 41. Сайн туршлага болон сургамжийг нэгтгэсэн хураангуй үр дүн**

№	Аймаг	Сум	Сайн туршлага	Сургамж, алдаа дутагдал
1	Архангай	Их тамир	<ul style="list-style-type: none"> <li>Зээлээс авсан мөнгөөрөө үхрийн арьс худалдаж аваад сур хийдэг болсноор өрхийн орлого нь сайжирсан тохиолдол байсан.</li> <li>Малын үүлдэр угсаа сайжирсан. Өмнө нь малынх нь цус ойртоод бие нь жижгэрсэн байсан. Үүнээс болоод ашиг шимийг бууруулж байжээ.</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>Зээл олголтын талаарх мэдээлэл дутмаг, мэдээллийн хүртээмж маш муу</li> <li>ОБЗ-ийн үйл ажиллагааны талаар хүмүүс төдийлөн мэддэггүй</li> <li>Зээлийг зориулалтын дагуу ашиглаагүй өрхүүдээс шалтгааныг тодруулахад зээлийн нэмэлт юм яг хийх гэхээр зээлээс олгосон мөнгө бүрэн хүрэлцэхгүй байдаг гэсэн. Өөрөөр хэлбэл 10 сая төгрөгийн зээл аваад 4 саяыг нь өрхийн хэрэглээндээ хэрэглэхээр үлдсэн 6 сая төгрөгөөрөө 1 бух худалдаж аваад мөнгө нь дуусчихдаг. Дараагийн алхмаа хийх гэхээр мөнгөгүй болчихдог. Тиймээс зээлийн хэмжээг 20 сая төгрөг хүртэл нэмэгдүүлэх саналыг гаргаж байсан.</li> <li>Малчдын хувьд зээлийн хүүг сар бүр төлөх нь хүндрэлтэй байдаг. Тиймээс зээлийн хүүг үндсэн зээлийн төлөлттэй нь хамт төлдөг болох талаар дурдаж байв. Учир нь зээлийн хүүгээ 1 сар төлөөгүй бол чанаргүй зээлийн ангилалд орчдог учраас аль болох малчдыгаа заавал төлөөрэй гэж гуйдаг.</li> <li>Малчдын хувьд малын тоо нь зээл авахад гол шалгуур болдог учраас зарим тохиолдолд цөөн малтай малчин өрхөд тухайн зээлийг олгох боломжгүй байдаг. Тиймээс банкны зээлийн шаардлага хангахгүй байгаа малчин өрхүүд зээлд хамрагдаж чаддаггүй.</li> <li>Оролцогч талууд гэрээ болон удирдамжийн талаар мэдээлэл муу, сайтар уншиж танилцаагүй байсан</li> </ul>

№	Аймаг	Сум	Сайн туршлага	Сургамж, алдаа дутагдал
2	Архангай	Цэнхэр	<ul style="list-style-type: none"> <li>Зээлээс авсан мөнгөөрөө өвөлжөөндөө ногоон тэжээл тариалаад малаа тэжээж зардлаа хэмнэсэн малчид олон байсан.</li> <li>Бүлгээрээ зээл авсан малчид зээлээс авсан мөнгөөрөө цагаан идээ хийж зах зээлд нийлүүлэн нэмэлт орлого олдог болсон. Мөн малчид малаа нийлүүлээд зах зээлд нийлүүлдэг болсон нь тээврийн зардлыг хэмнэсэн.</li> <li>Малын үүлдэр угсаа сайжирсан.</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>Зээл олголтын талаарх мэдээлэл дутмаг, мэдээллийн хүртээмж маш муу.</li> <li>ОБЗ-ийн үйл ажиллагааны талаар хүмүүс төдийлөн мэддэггүй.</li> <li>Малчдын хувьд баг нь сумын төвөөс хол байдаг учраас сарын хүүгээ төлөх нь хүндрэлтэй байдаг. Учир нь 50-60 мянган төгрөг төлөх гээд 60-70 км хол газраас заримдаа 100-120 км газраас ирэх шаардлага гардаг. Энэ нь малчдад зээлийн хүүгээ төлөхөөс илүү шатахууны зардал их гарах гэх мэт хүндрэлийг учруулдаг байна.</li> <li>Зээлд хамрагдахын тулд өөр бүс нутгаас Орчны бүс рүү нүүх тохиолдол гарсан нь бэлчээрийг хамгаалахад сөргөөр нөлөөлж байсан</li> <li>Ихэнх тохиолдолд мал ихтэй малчдад, эсвэл танил талдаа зээл өгсөн гэж ганцаарчилсан ярилцлагад оролцсон төлөөллүүд дурдаж байсан</li> <li>Оролцогч талууд гэрээ болон удирдамжийн талаар мэдээлэл муу, сайтар уншиж танилцаагүй байсан</li> </ul>
3	Өвөрхангай	Бат-Өлзий	<ul style="list-style-type: none"> <li>ОБЗ-ийн үйл ажиллагаа нь тогтворжсон, гишүүд нь үйл ажиллагаанд идэвхтэй оролцдог, хурлын материал, зээл олголтын бүртгэл, зээлийн эргэн төлөлт гэх мэт үйл ажиллагаа үлгэр жишээ сайн явагддаг нь ажиглагдсан.</li> <li>Зээл олголтын хувьд малчдыг ээлж дараалан олгох байдлаар өргөдөл хүсэлтийн хугацааг үндэслэн шийдвэрлэж байсан.</li> <li>Зээл авах малчидтай сумын Засаг дарга тусгайлан малын тоог бэлчээрийн даацад нийцүүлэх гэрээг байгуулж байсан. Энэ нь малчид эрх үүргээ ухамсарлах, зээлийг зориулалтын дагуу зарцуулах хөшүүрэг болсон байна.</li> <li>Малын үүлдэр угсаа сайжирсан.</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>Энэ сумын тухайд алдаа дутагдал, сургамж болохоор зүйлс ажиглагдаагүй. Харин Орчны бүсийн малчдаас гадна бусад бүсийн малчдыг хамруулдаг болох хувиараа бизнес эрхлэгчдийг хамруулдаг болох талд анхаарч өгөхийг хүсэж байсан. Түүнчлэн зээлийн санг нэмэгдүүлэх, зээлийн хэмжээг өөрчлөх талд тодорхой саналуудыг гаргаж байсан. Тухайлбал зээлийн хамрах хүрээг өргөтгөх, нэг удаагийн зээлийн хэмжээг 15.0 сая төгрөг болгох, зээлийн эргэлтийн сангийн хэмжээг нэмэгдүүлэхэд голлон анхаарахыг хүссэн.</li> </ul>
4	Завхан	Их-Уул	<ul style="list-style-type: none"> <li>Орчны бүсийн малчдад зээл олгосноор малын тоо толгойнд тодорхой хэмжээний хязгаарлалт тавьдаг болсон нь бэлчээрийн доройтлыг</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>Зээл олголтын талаарх мэдээлэл дутмаг, мэдээллийн хүртээмж маш муу</li> <li>Орчны бүсийн малчдад бүрэн мэдээлэл хүргээгүй</li> </ul>

№	Аймаг	Сум	Сайн туршлага	Сургамж, алдаа дутагдал
			<p>бууруулах гол арга хэмжээ гэж үзэж байсан. Энэхүү үйл ажиллагааны үр дүнд энэ жил бэлчээрийн гарч өмнөх жилүүдээс илүү сайн байсан талаар малчид болон бусад оролцогч талууд санал нэгтэй дэмжиж байсан</p> <ul style="list-style-type: none"> <li>• Малыг илүү чанаржуулах, малчид өөр орлогын эх үүсвэртэй болох, малын тоо толгой өсөх нь малын бэлчээр байгаль орчинд сөрөг нөлөө үзүүлж байгаа тул цаашид малын тоог хязгаарлаж бэлчээрээ хамгаалах нь зөв гэсэн ойлголт мэдлэгийг олгосон нь илүү дэвшил гэж үзэж байна. Малчид малын тоонд анхаарахгүй, чанарт анхаарах хэрэгтэй талаар санал нэгтэй дэмжиж байсан.</li> <li>• Гэр буудал ажиллуулдаг иргэдийн тоо нэмэгдсэн. Зээлийн мөнгөөрөө цагаан хэрэглэл, угаалгын машин зэргийг худалдан авч үйл ажиллагаагаа сайжруулж байгаа талаар дурдаж байсан.</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>• Зээл авах шалгуур үзүүлэлт, түүний шаардлагын талаар мэдээлэл маш муу</li> <li>• Зээлд хүсэлт өгсөн хэдий ч хасагдсан иргэдэд учир шалтгааныг тайлбарлаагүй</li> <li>• Зээлийн ашиглалтын үйл ажиллагаанд хяналт сайн хийгээгүй</li> <li>• Зээлийг орчны бүсийн малчин бус айл өрхөд олгосон</li> <li>• ОБЗ-ийн гишүүдэд зээл олгосон</li> <li>• Оролцогч талууд гэрээ болон удирдамжийн талаар мэдээлэл муу, сайтар уншиж танилцаагүй байсан</li> </ul>
5	Хөвсгөл	Улаан-Уул	<ul style="list-style-type: none"> <li>• Тухайн сумын газар нутгийн онцлогоос шалтгаалан бэлчээр нэлээд хомсдолтой. Үүнээс болон малчдын дунд бэлчээрийн маргаан маш их гардаг. ОБЗЭС-аас авсан зээлээрээ бэлчээрээ хашаалж маш сайн хамгаалсан байсан. Үүнээс шалтгаалаад малчдын хооронд гарах маргаан багассан талаар иргэд дурдаж байсан.</li> <li>• Малыг үүлдэр угсаа сайжирсан.</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>• ОБЗ-өөс зээлийн асуудлыг түргэн шийдвэрлэж өгдөг хэдий ч Төрийн банкны хүний нөөцийн хүртээмжээс болоод зээл удаашралтай олгогддог</li> <li>• Төрийн банкны зүгээс зээлийг зориулалтын дагуу зарцуулж байгаа эсэхэд хяналт хийдэггүй</li> <li>• Зээлийн мөнгөө дахин өөр нэг өрхөд хүүтэй дамжуулан зээлдсэн нэг тохиолдол илэрсэн</li> <li>• Багийн дарга нараар дамжуулан зээлийн талаар мэдээлэл өгдөг. Харин багийн дарга нарын танил тал зээл авсан тохиолдлууд нэлээдгүй тохиосон</li> <li>• ОБЗ зээлийн хүүний орлогоо хэрхэн ашиглах талаар мэдээлэл маш муу</li> <li>• Энэ сум үндсэн 6 багтай. 6 баг нь бүгд тусгай хамгаалалттай газар нутагт байрладаг. Харин 3 баг нь Орчны бүсэд байршдаг учраас зээлд хамрагдах шаардлага хангасан. Үүнд үлдсэн 3 багийн малчид бухимдалтай хандаж байсан</li> </ul>



№	Аймаг	Сум	Сайн туршлага	Сургамж, алдаа дутагдал
				<ul style="list-style-type: none"> <li>• Энэ сумын малчид маш алслагдмал газар байрладаг тул мал, малын гаралтай бүтээгдэхүүнээ зах зээлд нийлүүлэн орлогоо сайжруулах боломж хязгаарлагдмал</li> <li>• Тус сумын ОБЗ-ийн гишүүд бусад сумын ОБЗ-ийн үйл ажиллагаатай танилцаж, туршлага судлах хүсэлтэй байсан</li> <li>• Оролцогч талууд гэрээ болон удирдамжийн талаар мэдээлэл муу, сайтар уншиж танилцаагүй байсан</li> </ul>

## 5.2. ЭРСДЭЛИЙН ШИНЖИЛГЭЭ

### Хүснэгт 42. Эрсдэлийн шинжилгээ

Төрөл	Эрсдэл		Бичиг баримтын шинжилгээ болон үнэлгээ		Хэрхэн урьдчилан сэргийлэх вэ? Хэрхэн шийдэх вэ?
	№	Боломжит эрсдэл	Үнэлгээгээр илэрсэн эсэх	Тоон мэдээллээр баталгаажиж байгаа эсэх	Урьдчилан сэргийлэх / Шийдэл
Эдийн засгийн	1	Зээл авсан малчид зээлийн хүүгээ сар бүр төлөхгүй байх	Өнөөдрийн байдлаар үндсэн зээлээ болон зээлийн хүүгийн төлөлтөө төлж чадаагүй малчин, чанаргүй зээлд багтсан зээл байхгүй байна. Учир нь малчид орлого их олдог үе болох хавар болон хамрын улиралд үндсэн зээлээ тэнцүү хуваан төлж байгаа бөгөөд зээлийн хүүгийн төлөлтийг сар бүр төлж байгаа. Зээлийн хүүгийн төлөлтийг сар бүр төлөх нь зарим малчдын хувьд хүндрэл учруулдаг. Тухайлбал, зарим үед орлогогүй байх үе байна, зарим үед сумын төвөөс хол нүүдэллэх нь зээлийн хүүгийн төлөлтийг хийхэд хүндрэл учруулдаг. Төв газраас хол нүүдэллэж байгаа малчдын хувьд зээлийн хүүгээ төлөх гээд сумын төв орох нь хүүгийн зардлаасаа ч илүү зардал гарах нь элбэг байдаг.	Төрийн банкны 2023 оны 07 сарын 31-ний байдлаар ОБЗЭС нь 2.5 тэрбум гаруй төгрөгийн зээлийг 289 малчдад олгосон ба өнөөдрийн байдлаар 242 малчны 1.2 тэрбум гаруй төгрөгийн зээлийн үлдэгдэлтэй байна. Эдгээр зээлийн төлөлтүүд хэвийн үргэлжилж байна.	"Байгальд ээлтэй малчны зээл"-ийн удирдамж болон ОБЗЭС-ийн зээлийг дамжуулан зээлдүүлэх гэрээний дагуу Төрийн банк нь ОБЗ-ийн зээл олгох шийдвэрт үндэслэн зээлдэгчийн санхүүгийн орлого, зардал, эрсдэлийн судалгааг хийн, банкны журмын дагуу барьцаа хөрөнгө шаардах, зээлийн эргэн төлөлтийг малчдын төлөх чадварт нь тохируулан уян хатан хийх. Зээлийн хүүгийн төлөлтийг зээлийн үндэн төлөлтийн хамт малчдын орлого олдог үетэй нь уялдуулан зохион байгуулдаг байх.



Төрөл	Эрсдэл		Бичиг баримтын шинжилгээ болон үнэлгээ		Хэрхэн урьдчилан сэргийлэх вэ? Хэрхэн шийдэх вэ?
	№	Боломжит эрсдэл	Үнэлгээгээр илэрсэн эсэх	Тоон мэдээллээр баталгаажиг байгаа эсэх	Урьдчилан сэргийлэх / Шийдэл
	2	ОБЗЭС-ийн зээл нь малчин өрхийн дунд болон урт хугацаанд тогтмол орлогын эх үүсвэртэй болох нөхцөлийг дэмжихгүй байх.	Зээл авсан малчдын хувьд авсан зээлийн 40 хүртэл хувийг өрхийн хэрэглээнд, үлдсэн 60 хүртэл хувийг орлого нэмэгдүүлэх бизнес болон байгаль орчинд ээлтэй ямар ч үйл ажиллагаанд зарцуулж болохыг заасан байсан нь малчид голдуу сайн үүлдрийн эцэг мал авах, малын хашаа хороогоо сайжруулах, ногоон тэжээл тариалах, өрхийн хэрэглээнд зарцуулсан байсан. МAA-н бус орлогын эх үүсвэртэй болох, өрхийн орлогоо нэмэгдүүлэх бизнесийн чиглэлээр зарцуулсан зээл байхгүй байв.	Судалгаанд хамрагдсан зээл авсан малчин өрхүүдийн 47.3 хувь нь малын чанарыг сайжруулах зорилгоор сайн үүлдрийн эцэг мал худалдан авсан бол, үлдсэн хувь нь малын хашаа хороогоо засах, сайжруулах чиглэлээр, өрхийн хэрэглээ, ногоон тэжээл тарих гэх мэт чиглэлээр зарцуулсан байна.	Малчин өрхийн МAA-с өөр орлогын эх үүсвэртэй болох дэд төслүүдийг дэмжих шаардлагатай. Энэ нь малчдын хувьд МAA-с үл хамаарсан орлогын эх үүсвэртэй болох боломжийг нэмэгдүүлэх юм.
	3	Зээлийн хүү тогтмол байгаа үед инфляци өсөх нь ОБЗЭС-ийн хүүгийн орлогын худалдан авах чадварыг бууруулахад нөлөөлнө(ОБЗ-ийн хувьд).	ОБЗ-ийн үйл ажиллагааны санхүүжилтийн орлогын гол эх үүсвэр нь ОБЗЭС-ийн 1.5 хувийн хүүгийн орлого бөгөөд инфляци өсөх нь энэхүү хүүгийн орлогын худалдан авах чадварыг бууруулах эрсдэлтэй.	ОБЗ-ийн үйл ажиллагааны санхүүжилтийн орлого нь жилдээ 4 гаруй сая төгрөг бөгөөд энэхүү санхүүжилтийн 60 хүртэлх хувийг ОБЗ-ийн үйл ажиллагаанд, 40 хүртэлх хувийг байгаль орчныг хамгаалах чиглэлээр зарцуулж байна. Гэвч зарим ОБЗ-ийн хувьд зээлийн хяналтаар явахад малчдын хувьд хол нутаглаж байгаа тохиолдолд шатахууны зардалдаа ч хүрдэггүй талаар дурьдаж байв. Мөн зам хэцүү тохиолдолд машин эвдрэх зэрэг асуудал үүсвэл энэхүү мөнгө нь хүрэлцдэггүй талаар хэлж байсан.	ОБЗ-ийн үйл ажиллагааны санхүүжилтийн орлогын гол эх үүсвэр нь ОБЗЭС-ийн 1.5 хувийн хүүгийн орлого бөгөөд инфляци өсөх нь энэхүү хүүгийн орлогын худалдан авах чадварыг бууруулах эрсдэлтэй. Тиймээс ТХН энэхүү эрсдэлээс урьдчилан сэргийлэхийн тулд ОБЗ-тэй хамтран ажиллаж, энэхүү хүүгийн орлого хүрэлцэж байгаа эсэх, цаашилбал нэмэгдүүлэх боломж байгаа эсэх талаар судлах шаардлагатай.



Төрөл	Эрсдэл		Бичиг баримтын шинжилгээ болон үнэлгээ		Хэрхэн урьдчилан сэргийлэх вэ? Хэрхэн шийдэх вэ?
	№	Боломжит эрсдэл	Үнэлгээгээр илэрсэн эсэх	Тоон мэдээллээр баталгаажиг байгаа эсэх	Урьдчилан сэргийлэх / Шийдэл
	4	Малын үнэ буурах (малын өвчлөлтэй холбоотой).	Төсөл хэрэгжиж байгаа өнгөрсөн 2 жилийн хугацаанд тухайн эрсдэл гараагүй.	Байхгүй.	Малчид малын өвчлөл гарахаас урьдчилан сэргийлэхийн тулд малаа вакцинжуулах, малынхаа эрүүл мэндийн үйлчилгээг чанаржуулах нь чухал.
	5	Малчдын орлогын эх үүсвэр нь зөвхөн мал аж ахуй дээр төвлөрч байгаа үед малын тоог бууруулах хөшүүрэг нь өрхийн амьжиргаанд сөргөөр нөлөөлөх.	Цөөн малтай малчин өрхийн хувьд малын тоогоо бууруулах сонирхол байхгүй тул мал ихтэй өрхүүд голдуу зээлийг авсан байна. Учир нь цөөн малтай өрхүүд банкны шалгуурыг хангаж чадахгүйн улмаас зээлд хамрагдаж чадаагүй байна. Мөн зарим сумдын хувьд цөөн малтай өрхүүд зээлээр мал авсан тохиолдол байсан.	Малчид зээлээ зориулалтын дагуу ашиглаагүй тухайлбал, цөөн малтай өрх мал худалдан авсан тохиолдол байсан хэдий ч, хяналт шалгалтаар сануулах арга хэмжээ авсан байна.	Тиймээс ТХН-ийн зүгээс энэхүү эрсдэлээс сэргийлэхийн тулд ОБЗ-ийн үйл ажиллагааг хянаж, сайжруулах зөвлөмжийг тогтмол өгч байх. Мөн зээлийг авсан хугацаагаар малын тоог бууруулах үүргийг хүлээлгэх нь чухал байна. Зээлийн зорилго нь байгаль орчныг хамгаалахад чиглэж байгаа учраас малын тоог бууруулж, бэлчээрийн даац, байгаль орчныг хамгаалах учраас малчдын хамтарсан бизнесийн дэд төслүүдийг дэмжих чиглэлээр зээлийг олгох хэрэгтэй.



Төрөл	Эрсдэл		Бичиг баримтын шинжилгээ болон үнэлгээ		Хэрхэн урьдчилан сэргийлэх вэ? Хэрхэн шийдэх вэ?
	№	Боломжит эрсдэл	Үнэлгээгээр илэрсэн эсэх	Тоон мэдээллээр баталгаажиг байгаа эсэх	Урьдчилан сэргийлэх / Шийдэл
НИЙГМИЙН	1	ОБЗЭС нь малчдын МАА-н бус орлогын эх үүсвэрийг бий болгох чиглэлээр зээлийг олгохгүй байх нь малчин өрхийн амьжиргаа, хөдөөгийн амьжиргааны түвшинг тогтмол нэмэгдүүлэх боломжийг хязгаарлах эрсдэлтэй.	Малчид нийлж бүлэг байгуулан зээл авсан хэдий ч, орлогын тогтмол эх үүсвэртэй болох зорилгоор хамтарч эхлүүлсэн бизнесийн үйл ажиллагаа огт байхгүй байв. Малчид бүлэг болж зээл авсан ч, өрхүүд зээлээ тэнцүү хуваан авсан байна.	Зээл авсан малчин өрхүүдийн орлого 3.8 хувиар өссөн байхад, зээл аваагүй малчин өрхүүдийн орлого 0.1 хувиар өсч, зээл авсан малчин өрхүүдийн хувьд зээл авснаар өрхийн орлогод 3.7 хувийн цэвэр өгөөжтэй байсан.	Тиймээс цаашид малаас өөр орлогын эх үүсвэртэй болох бизнесийн дэд төслүүдийг дэмжих нь малчин өрхүүд тогтмол орлогын эх үүсвэртэй болохоос гадна малчдад ажлын байрыг бий болгох боломжтой.
	2	ОБЗЭС-ийн зээлийг зөвхөн орчны бүсийн малчдад олгож байгаа нь хөдөөгийн амьжиргааг бүрэн дэмжихгүй байна.	ОБЗЭС нь тухайн орчны бүсэд амьдарч байгаа зөвхөн малчдад зээлийг олгосон.	Өнөөдрийн байдлаар төсөл хэрэгжиж байгаа сумдын орчны бүсэд амьдарч байгаа нийт 816 өрхийн 38.9 хувь нь зээлд хамрагдсан байна.	Хөдөөгийн амьжиргааг дээшлүүлэхийн тулд малчдын МАА-н бус орлогын эх үүсвэртэй болох малчдын үйл ажиллагааг дэмжиж зээлийг олгох.
	3	Цөөн малтай малчин өрх ОБЗЭС-ийн зээлд хамрагдах боломж нь хязгаарлагдмал.	Зарим сумдын хувьд цөөн малтай, амьжиргааны баталгаажих түвшингээс доогуур малтай өрхүүд нь банкны шалгуурыг хангадаггүй учраас зээлд хамрагдаагүй байна. Харин мал цөөн ч, банкны барьцаа хөрөнгө, зээлийн шалгуурыг хангаж байгаа өрхүүд зээлд хамрагдаж чадсан байна.	Судалгаанд хамрагдсан зээл авсан малчин өрхүүдийн хувьд зээл авсан хамгийн бага малтай өрх 30 гаруй малтай байсан бол, зээл авсан хамгийн их малтай өрх 950 гаруй малтай байна.	Тиймээс ТХН малчин өрх, хөдөөгийн амьжиргааг дээшлүүлэхийн тулд мал багатай, барьцаа хөрөнгө багатай өрхүүдийг хамрагдах боломжийг Төрийн банктай зөвшилцөх.
	4	ОБЗ-ийн гишүүдийн өөрийн давуу талаа зээлийн шийдвэрт ашиглах.	Үнэлгээ хийх явцад зарим сумдын ОБЗ-ийн үйл ажиллагаанд танил талаа ашиглан зээл авах, зээлийг олгох шийдвэрүүд гаргах, цөөн малчдад мэдээллийг хүргэх байдлаар бусад малчдын боломжийг хязгаарласан тохиолдлууд байсан.	-	Тиймээс ТХН болон ОБЗ малчдад мэдээллийг тэгш хүртээх нь чухал байна.

Төрөл	Эрсдэл		Бичиг баримтын шинжилгээ болон үнэлгээ		Хэрхэн урьдчилан сэргийлэх вэ? Хэрхэн шийдэх вэ?
	№	Боломжит эрсдэл	Үнэлгээгээр илэрсэн эсэх	Тоон мэдээллээр баталгаажиг байгаа эсэх	Урьдчилан сэргийлэх / Шийдэл
	5	ОБЗ-ийн гишүүд хүүгийн орлогыг зорилгогүйгээр зарцуулах.	Үнэлгээний судалгаагаар энэхүү тохиолдол илрээгүй.	ОБЗ-ийн хүүгийн орлогын зарцуулалтыг авч үзвэл, нийт орлогын 53.9 хувийг ОБЗ-ийн үйл ажиллагаанд, 39.7 хувийг байгаль хамгаалах үйл ажиллагаанд зарцуулсан байв.	Цаашид ОБЗ-ийн гишүүдийн урамшууллын хөшүүргийг тодорхой зааж өгөх. Тухайлбал, хуралд ирж суусан болон ОБЗ-ийн үйл ажиллагаанд тогтмол оролцдог хүмүүсийн ажлыг үнэлдэг байх.
	6	Орон нутгийн хэмжээнд улс төрийн тогтворгүй байдал бий болох нь ОБЗ-ийн үйл ажиллагааг тогтворгүй болгох нөлөөтэй. Төсөл хэрэгжих ирэх жилүүдэд сонгууль болох ба сонгуулийн үр дүнд сумдын ОБЗ-ийн нишүүд солигдох магадлалтай.	Үнэлгээгээр улс төрийн нөлөөнөөс бий болсон эрсдэл илрээгүй.	Байхгүй.	Тиймээс энэхүү үйл ажиллагаанаас урьдчилан сэргийлэхийн тулд ОБЗ-ийн жилийн үйл ажиллагааны төлөвлөгөөг ТХН-ээс баталж, үйл ажиллагааг тасралтгүй үргэлжлэх боломжийг олгох.
Байгаль орчны	1	Ган, зуд болох.	Үнэлгээгээр ган, зудын нөлөө байхгүй байсан.	Гэхдээ судалгаанд хамрагдсан малчин өрхүүдийн хонин толгойд шилжүүлсэн дүнгээр нийтдээ 13458.8 малаар буурсан байсан ба үүний 54.9 хувь нь борлуулалт, үлдсэн хувь нь бусад шалтгаанаар хорогдсон байв.	Ган, зуд болох нь малчдын малын тоог бууруулах учраас ТХН-ийн хувьд зээлийн шалгуурыг зах зээлд борлуулж байгаа малын тоогоор үргэлжлүүлэн тогтоох нь чухал.



Төрөл	Эрсдэл		Бичиг баримтын шинжилгээ болон үнэлгээ		Хэрхэн урьдчилан сэргийлэх вэ? Хэрхэн шийдэх вэ?
	№	Боломжит эрсдэл	Үнэлгээгээр илэрсэн эсэх	Тоон мэдээллээр баталгаажиг байгаа эсэх	Урьдчилан сэргийлэх / Шийдэл
	2	Малын тоог бууруулах нь бэлчээрийн доройтлыг бууруулах гол хүчин зүйл болохгүй байх.	Үнэлгээгээр орчны бүсэд амьдарч байгаа малчин өрх нь зээл аваад малын тоогоо бууруулсан ч, орчны бүсийн хилийн заагт амьдардаг өрхүүд нь зээл авч чаддаггүй ч, мал нь орчны бүс рүү бэлчдэг тохиолдлууд байсан. Тиймээс орчны бүст байгаа малчны малын тоог бууруулах нь учир дутагдалтай байна.	Зээлийн өргөдөл өгсөн ч, зээлд хамрагдаж чадаагүй малчин өрхүүдийн 44.4 хувь нь орчны бүсийн хил хязгаарт багтдаггүй өрхүүд байсан.	Орчны бүсийн хил хязгаарт радиус тогтоож өгөх. Тухайлбал, орчны бүсэд багтдаггүй ч, мал нь орчны бүс рүү бэлчдэг малчдын хувьд энэхүү зээлд хамрагддаггүй тул, орчны бүсийн радиусыг тогтоож өгснөөр энэхүү асуудлыг шийдэх боломжтой.
	3	ОБЗ-ийн гишүүдийн тогтворгүй байдал, гишүүдийн чадавхи сул байдалтай холбоотойгоор хүүгийн орлогыг зарцуулахгүй байх.	Үнэлгээгээр энэхүү эрсдэл нь илрээгүй. Хөвсгөл аймгийн Улаан-Уул сумын хувьд байгаль орчныг хамгаалах чиглэлээр хүүгийн орлогоо зарцуулахаар хуримтлуулж байгаа сайн туршлага байна.	Төсөл хэрэгжиж байгаа 5 сумдын 4 сум нь байгаль хамгаалах чиглэлээр мод тарих, ТХГН-ийн хилийн хязгаарыг заасан мэдээллийн самбар, таних тэмдгийн самбар, хөшөө зэргийг хийсэн байсан. Харин нэг сумын хувьд хүүгийн орлогыг одоогийн байдлаар байгаль хамгаалах ямар нэгэн үйл ажиллагаанд зарцуулаагүй байна.	ТХН ОБЗ-ийн жилийн турш хийсэн ажлын тайланг хэлэлцэж, ирэх жилийн үйл ажиллагааны төлөвлөгөөг тогтмол баталдаг болох нь ОБЗ-ийн үйл ажиллагааг тогтмолжуулж, хүүгийн орлогын үр ашиггүй зарцуулалтаас сэргийлнэ. Мөн ТХН ОБЗ-ийн гишүүдийг чадавхижуулах чиглэлээр хувь хүний хөгжил, ОБЗ-ийн гишүүдийн үүрэг, хариуцлагын талаарх чиглүүлэх сургалтуудыг зохион байгуулах нь чухал байна. Мөн ОБЗ-үүдийн үйл ажиллагааны сайн туршлагаудыг сурталчилдаг байх.

Төрөл	Эрсдэл		Бичиг баримтын шинжилгээ болон үнэлгээ		Хэрхэн урьдчилан сэргийлэх вэ? Хэрхэн шийдэх вэ?
	№	Боломжит эрсдэл	Үнэлгээгээр илэрсэн эсэх	Тоон мэдээллээр баталгаажиг байгаа эсэх	Урьдчилан сэргийлэх / Шийдэл
	4	ОБЗЭС-ийн зээл нь орчны бүс рүү бусад малчид нүүж ирэх сонирхлыг нэмэгдүүлэх.	Өнөөдрийн байдлаар орчны бүс рүү зээл авахын тулд нүүж ирсэн малчин өрх байхгүй байна.	-	Малчдыг орчны бүсээс нүүвэл гэсэн хөшүүргийг хэрэглэж болох юм. Тухайлбал, орчны бүсээс нүүвэл олгох зээлийн хэмжээ нь орчны бүсэд амьдардаг малчдад олгож байгаа малчдаас өндөр байх гэх мэт.
	5	Орчны бүсийн гадна амьдарч байгаа малчдын мал нь орчны бүс рүү бэлчсээр байна.	Зээл нь орчны бүсэд байгаа малын тоог бууруулах зорилготойгоор орчны бүсэд амьдарч байгаа малчдын малын тоог бууруулж, малчдын амьжиргааг дээшлүүлэхийн тулд МАА-с өөр орлогын эх үүсвэртэй болохыг дэмжиж олгож байгаа. Гэвч энэ нь орчны бүсийн гадна амьдарч байгаа малчдын орчны бүс рүү малаа бэлчээрлүүлэх, орчны бүсэд оторлох байдлыг хязгаарлаж чадахгүй байна.	Орчны бүсийн гадна амьдарч байгаа малчдын хувьд зээлэнд хамрагдах сонирхолтой байдаг. Гэвч орчны бүсэд амьдардаг малчинд зээлийг олгоно гэж байгаа нь учир дутагдалтай байна гэж үзэж байна.	Орчны бүсийн гадна амьдарч байгаа малчдын хувьд радиусыг тогтоож өгөх. Жишээ нь, 5 км. Гэхдээ хэдэн км радиус тогтоохыг судалгаа хийж тогтоох шаардлагатай.
	6	Зөвхөн малын тоо толгойн бууралтаар хэмжиж байгаа нь нийт малын тоо толгойн бууралтын хэдэн хувийг төслийн үйл ажиллагаа тайлбарлаж байгааг хэмжихэд хэцүү.	Үнэлгээгээр төслийн үйл ажиллагаанаас болж буурсан малын тоог зөвхөн борлуулсан малын тоогоор хэмжсэн. Гэвч судалгаанд хамрагдсан зээл авсан малчин өрхүүдийн малын тоо буурсан байхад, орчны бүсийн хэмжээнд болон сумын хэмжээнд малын тоо өссөн байсан.	Малчдын зах зээлд борлуулсан малын тоо нь нийт малын бууралтын 54.9 хувийг тайлбарлаж байв. Гэвч бид малчдын А данс болон асуулгаар асуусан малын тооны хооронд 29.3 хувийн зөрүү байгааг илрүүлсэн. Мөн малын тооны бууралт нь зөвхөн цаасан дээр буурч байж болох юм.	Малчид зарсан малын тоогоо мал эмнэлгийн гэрчилгээгээр баталгаажуулж байгаа хэдий ч, энэхүү бичгийг худлаа тоогоор бичүүлэх магадлал өндөр. Тиймээс зээлийн хяналт тогтмол байх нь чухал байна. Мөн байгаль орчинд ээлтэй өөр бусад шалгууруудыг ашиглах.



Төрөл	Эрсдэл		Бичиг баримтын шинжилгээ болон үнэлгээ		Хэрхэн урьдчилан сэргийлэх вэ? Хэрхэн шийдэх вэ?
	№	Боломжит эрсдэл	Үнэлгээгээр илэрсэн эсэх	Тоон мэдээллээр баталгаажиг байгаа эсэх	Урьдчилан сэргийлэх / Шийдэл
	7	Зээлийг малын хашаа саравчаа сайжруулах, тэжээл тариалах гэх мэт зорилгоор олгож байгаа нь МАА-н үйлдвэрлэлийг дэмжсэн хэвээр байна.	Үнэлгээгээр малчдын зээл нь МАА-н үйлдвэрлэлийг дэмжсээр байсан нь ажиглагдсан. Тухайлбал, малчид малаа зараад оюутныхаа сургалтын төлбөрийг төлөх байсан бол бага хүүтэй зээл аваад, зээлээрээ төлөх. Мөн ногоон тэжээл тариалж, зөвхөн өрхийн хэрэгцээндээ ашиглахаас зарахаар их хэмжээнд тариалдаггүй.	Судалгааны үр дүнд зээл авсан малчдын 50 гаруй хувь нь малын хашаа хороогоо засах, сайжруулах, ногоон тэжээл тариалах, өрхийн хэрэглээнд зарцуулах гэх мэтээр зарцуулсан байсан.	Тиймээс цаашид МАА-н бус орлогын эх үүсвэрийг дэмжсэн дэд төслүүдийг санхүүжүүлэх.
	8	ОБЗЭС-ийн зээл нь малчдын малаа зарах сонирхлыг бууруулах.	Үнэлгээгээр энэхүү эрсдэл нь илрээгүй. Учир нь судалгаанд хамрагдсан малчин өрхүүдийн жил бүр зарж байгаа малын тоо нь өсөх хандлагатай байсан.	Судалгаанд хамрагдсан малчин өрхүүдийн малаа 5 хувиас дээш борлуулж байгаа өрхийн тоо өнгөрсөн 2 жилийн хугацаанд нэмэгдэж, малаа өсгөсөн малчдын тоо буурсан байсан. Тухайлбал, 2021 онд зээл авсан малчин өрхүүдийн 64.4 хувь нь малаа 5-аас дээш хувиар бууруулсан бол, 2022 онд зээл авсан малчин өрхүүдийн 67.1 хувь нь малаа 5-аас дээш хувиар бууруулсан бол, малаа өсгөсөн малчдын эзлэх хувь 31.5 - 23.7 хүртэл буурсан байсан.	ТХН энэхүү эрсдэлээс урьдчилан сэргийлэхийн тулд зээл авч байгаа малчдын хувьд зээлийн гэрээ дуустал малын тоогоо бууруулах шалгуурыг тавих нь чухал байна.
Ерөнхий эрсдэл	1	Зээл авахын тулд малчид худал мэдээлэл өгч болно.	Үнэлгээгээр илрээгүй.	-	Энэхүү эрсдэлийг бууруулахын тулд хяналт чухал.



Төрөл	Эрсдэл		Бичиг баримтын шинжилгээ болон үнэлгээ		Хэрхэн урьдчилан сэргийлэх вэ? Хэрхэн шийдэх вэ?
	№	Боломжит эрсдэл	Үнэлгээгээр илэрсэн эсэх	Тоон мэдээллээр баталгаажиж байгаа эсэх	Урьдчилан сэргийлэх / Шийдэл
	2	Малын тоо толгойн бодит байдал нь А данснаас өндөр байх.	Үнэлгээгээр малчдын А данс нь бодит байдалд байгаа малын тооноос зөрж байв.	Судалгаанд хамрагдсан малчдын А данс нь малчдын өгсөн аман тооноос 29.3 хувиар зөрж байсан. Өөрөөр хэлбэл, А дансан дээр байгаа малын тоо нь бодит байдлаас 29.3 хувиар бага байсан нь статистикийн хувьд батлагдсан. Мөн малчдын хувьд малын хөлийн татвар авч эхэлсэн нь энэхүү нөхцөл байдалд нөлөөлсөн гэж үзэж байна.	Энэхүү нөхцөл байдлаас урьдчилан сэргийлэхийн тулд зээлийн шалгуур үзүүлэлтүүдэд чанарын шалгууруудыг оруулах нь чухал. Тухайлбал, байгаль орчноо хамгаалах чиглэлээр хашаа хороогоо цэвэрлэдэг гэх мэт.



## ДҮГНЭЛТ

“Биологийн олон янз байдлыг хамгаалах, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох төслийн I үе шатанд ТХГН-ийн орчны бүсэд хэрэгжүүлсэн ОБЗЭС-ийн гүйцэтгэлд хөндлөнгийн үнэлгээ хийх” зөвлөх үйлчилгээний ажлын хүрээнд төсөл хэрэгжсэн зорилтот 5 сумын ОБЗЭС-ийн үйл ажиллагаа, орчны бүсэд амьдардаг малчдын тогтвортой амьжиргааг дэмжих, малын тоо толгойг бууруулах, бэлчээрийн чанарыг сайжруулахад дэмжлэг үзүүлэх зорилгоор олгосон зээлийн гүйцэтгэлийг үнэлсэн судалгааны үр дүнд дараах дүгнэлтүүдийг өгч байна.

ОБЗЭС-аас зээл авснаар малчдын хувьд байгаль орчин болон бэлчээрийг хамгаалах талаар ойлголт, мэдлэгтэй болсон нь хөндлөнгийн үнэлгээний үр дүнгээр тогтоогдсон нь төслийн зүгээс хэрэгжүүлж буй зээлийн үйл ажиллагааны ач холбогдолтой, цаашид ч ач холбогдол ихээхэн байгааг илэрхийлж буй чухал үр дүн юм.

“Байгаль орчинд ээлтэй малчны зээл”-ийн бүс нутгуудад шийдвэрлэж чадсан хамгийн чухал асуудал бол үр нөлөө хүртэгчдийн ухамсар, хандлагад эерэг өөрчлөлтийг бий болгосон явдал байлаа. Энэ нөлөөллийн ажлыг зөвхөн малчдаар хязгаарлалгүйгээр өргөжүүлэх нь үр дүнтэй гэж үзэж байна.

Зээл авсан малчдын ихэнх нь малын хашаа саравчаа засах, малын тэжээл тариалах, хадлангийн талбай хаших зэрэг мал аж ахуйн үйл ажиллагаагаа сайжруулахад л анхаарсан. Нэг нэгээрээ зээл авахаар хүүхдийн төлбөр төлөх ч юм уу өөр үйл ажиллагаанд зарцуулах явдал түгээмэл байгаа тул түүхий эдийнхээ нөөцөд тулгуурлаад хоршиж, цех, жижиг дунд үйлдвэрлэлийг хөгжүүлэхэд анхаарах зайлшгүй шаардлагатай. Иймд орон нутгийн засаг захиргаа нь энэхүү зээлийг илүү системтэйгээр авч үлдэж сумандаа үйлдвэрлэл байгуулж өөрийн сумын брэнд бүтээгдэхүүнтэй болох хэрэгтэй гэж үзэж байна. Мөн байгаль орчинд эерэг үйл ажиллагаа эрхэлж буй эсвэл байгаль орчныг хамгаалах чиглэлд тодорхой нөлөөлөл болж чадахуйц үйл ажиллагаа эрхэлж буй иргэд, бизнес эрхлэгчдийг дэмжих боломжтой бөгөөд энэ нь төслийн зорилготой нийцэж байгаа юм.

Хамтын ажиллагаа оролцоог сайжруулах чиглэлээр олон талт ажил зохион байгуулах шаардлагатай. Цаашид төслийн үе шатанд хяналт мониторингийг хэрхэн сайжруулах талаар ажлуудыг төлөвлөж ажиллах хэрэгтэй байна.

### **Баримт бичгийн шинжилгээний хүрээнд:**

- “Дамжуулан зээлдүүлэх гэрээ”-ний 1.1 хэсэгт орчны бүсийн малчин, мал бүхий иргэдэд зээлийг олгоно гэж зааж өгсөн нь “Байгальд ээлтэй малчны зээл”-ийн 1.5 хэсэгт заасан малчид, малчны бүлэгт зээлийг олгоно гэсэн заалттай зөрчилдсөн.
- “Дамжуулан зээлдүүлэх гэрээ”-ний 5.4.3 заалт болох орчны бүсийн иргэдээс зээлийн хүсэлтийг хүлээн авч ОБЗ нь сард 1-ээс доошгүй удаа хуралдана гэсэн заалт нь “Байгальд ээлтэй малчны зээл”-ийн заалтын 6.2 заалт болох

ОБЗ нь иргэдээс материалыг хүлээн авч, сард 2-оос доошгүй хуралдана гэсэн заалтууд зөрчилдсөн.

- Сум бүрийн ОБЗ-ийн тайлан нь “Байгальд ээлтэй малчны зээл” -ийн удирдамжид тусгагдсан агуулгын дагуу бүрэн бичигдээгүй байв.
- Малчид зээлийн хүүг сар бүр, үндсэн зээлийн эргэн төлөлтийг хагас жилдээ 1, жилдээ 2 удаа төлж байхаар Төрийн банктэй гэрээг байгуулсан байна. Энэ нь ОБЗ-ийн ОБЗЭС-ийн мөнгийг үр ашигтай зарцуулах, эргэлтэд оруулах үйл ажиллагаанд нөлөөлж байгаа бөгөөд үүнтэй холбоотойгоор ОБЗ нь жилдээ 2 удаа хуралдаж, дараагийн малчдад зээл олгох шийдвэрийг гаргаж байна.
- ОБЗЭС-ийн 1.5 хувийн хүүгийн орлогын зарцуулалтын хувьд ОБЗ-ийн үйл ажиллагаанд 53.9 хувийг, байгаль орчныг хамгаалах чиглэлд 39.7 хувийг дунджаар зарцуулсан байгаа нь удирдамжид заасан зарцуулалтын хувьтай нийцэж байна. Гэсэн хэдий ч зарим сумын хувьд хүүгийн орлогоо юунд зарцуулах талаар мэдлэг, мэдээлэл хомс, юунд, яаж зарцуулахаа мэдэхгүй байв. Тухайлбал, Хөвсгөл аймгийн Их-Уул сумын ОБЗ-ийн хувьд өнгөрсөн 2 жилийн хугацаанд хүүгийн орлогоо юунд ч зарцуулаагүй, одоогийн байдлаар дансанд нь байгаа юм. Төслийн зүгээс энэ чиглэлд анхаарч ажиллах, хянах, зөвлөх, чиглүүлэх хэрэгцээтэй байгааг илэрхийлж байна.
- Зарим ОБЗ-ийн хувьд дээрх хүүгийн орлого нь зээлийн хяналтаар явахад малчид хол нутаглаж байгаа тохиолдолд шатахууны зардалдаа ч хүрдэггүй талаар дурьдаж байв. Мөн зам хэцүү тохиолдолд машин эвдрэх зэрэг асуудал үүсвэл зардлыг хаанаас гаргах нь тодорхойгүй, энэхүү мөнгө нь хүрэлцдэггүй талаар хэлж байсан.
- Байгаль орчныг хамгаалах чиглэлээр зарим сумдын ОБЗ нь ТХГН-ийн хил хязгаарыг заасан мэдээллийн болон таних тэмдгийн самбар, хилийн багана зэргийг хийсэн байсан бол, зарим сумдын ОБЗ нь нийгэмд чиглэсэн “Бид өөрсдөө байгаль хамгаалагчид” хэлэлцүүлэг, сурагч, цэцэрлэгийн хүүхдүүдийн дунд “Цэнхэр алтаа хайрлая” сэдвийн дор гар зураг, эсээ бичлэгийн уралдаан, сумынхаа амьжиргааны түвшин доогуур айл өрхүүдийн хүүхдийн хичээлийн хэрэгсэл өгсөн, мэдээллийн брошур тараах зэрэг үйл ажиллагаануудыг зохион байгуулжээ.
- Нийт зээлдэгчдийн 40.9 хувь нь малынхаа үүлдэр, угсааг сайжруулах зорилгоор зээлийг авсан нь нийт зээлийн төрөлд хамгийн өндөр хувийг эзэлж байгаа бөгөөд “Байгальд ээлтэй малчны зээл”-ийн малын тоог бууруулах, бэлчээрийн даацыг багасгах, малыг чанаржуулах зорилготой нийцэж байна.
- 2023 оны 07 сарын 31-ны байдлаар чанаргүй зээлийн ангилалд багтсан зээл байхгүй, бүгд хэвийн ангилалд байна.

#### **Төслийн үйл ажиллагаанд оролцогч талуудын оролцоо, үүрэг, хариуцлагын хүрээнд:**

- Төсөл амжилттай хэрэгжихэд ОБЗ-ийн үйл ажиллагаа чухал нөлөөтэй бөгөөд ОБЗ-ийн дарга, гишүүдийн идэвхтэй үйл ажиллагаа чухал байна. Иймд ОБЗ-ийн гишүүдийг идэвхжүүлэх, шударга ажиллах, малчдад мэдээллийг бүрэн

түгээх, орчны бүсийн малчдыг бүрэн хамруулах чиглэлээр ажиллахыг зөвлөх шаардлагатай.

- Төслийн үйл ажиллагаа нь бүс нутаг бүрд харилцан адилгүй зохион байгуулалттай хэрэгжсэн байна. Зарим сумдад ОБЗЭС-ийн гишүүдийн идэвх санаачилгаас шалтгаалан амжилттай сайн хэрэгжиж байсан бол зарим сум нь анхаарах асуудал багагүй байлаа. Жишээ нь, Хөвсгөл аймгийн Улаан-Уул сумын хувьд Төрийн банкны үйл ажиллагаатай холбоотойгоор зээл олголтын үйл ажиллагаа удаашралтай явагдсан талаар хэлэлцүүлгийн үеэр оролцогчид дурдаж байсан. Үүнийг Төрийн банкны ажилтнаас тодруулахад хүний нөөцийн дутагдалтай байдлаас шалтгаалсан болохыг онцолсон юм.
- Төслийн талаарх мэдээллийг ОБЗ нь янз бүрийн аргыг ашиглан олон нийтэд хүргэж байна. Тухайлбал, зээлийн материал хүлээн авч эхлэх гэж байгаа талаарх мэдээллийг багийн даргаар дамжуулан, мөн олон нийтийн сүлжээ ашиглан малчдад түгээж байна. Гэвч зарим малчдын хувьд энэхүү сангийн талаар мэдээлэл огт аваагүй байв.
- ОБЗЭС-ийн үндсэн оролцогч тал болох Төрийн банкны хувьд өөрийн үүрэг хариуцлагын хүрээнд зээлийн эргэн төлөлтийн талаарх мэдээллийг эргэн төлөлт орж ирсэн даруйд мэдэгдэж, ОБЗЭС-ийн үйл ажиллагааг тасралтгүй удирдан зохион байгуулах ажлыг сайн зохион байгуулж байна.
- Малчдын хувьд ОБЗЭС-ийн зээлийн хүүгийн төлөлтийг сар бүр төлөх нь хүндрэлтэй байдаг талаар дурдаж байв.

#### **ОБЗЭС-ийн зээлийн малын тооны өөрчлөлтөд нөлөөлсөн байдалд:**

- Төсөл хэрэгжиж байгаа зорилтот сумдын малын тоог 2020 оноос хойш авч үзвэл хонин толгойд шилжүүлсэн дүнгээр 345222.9 толгой буюу 5.5 хувиар өссөн бол, орчны бүсэд байгаа малын тоо хонин толгойд шилжүүлсэн дүнгээр 74971.4 толгой буюу 3.2 хувиар тус тус өсжээ.
- Судалгаанд хамрагдсан зээл авсан малчдын малын тоо нь А дансаар 2020 онтой харьцуулахад хонин толгойд шилжүүлсэн дүнгээр 13458.8 толгой буюу 8.6 хувиар буурсан байхад зээл аваагүй малчдын хувьд 2020 онтой харьцуулахад хонин толгойд шилжүүлсэн дүнгээр 1600.1 толгой буюу 5.6 хувиар дунджаар өссөн байна.
- Судалгаанд хамрагдсан зээл авсан малчдын малын тооны нийт бууралтын 54.9 хувийг малчид малаа зах зээлд борлуулсан малын тоо эзэлж байгаа бол, үлдсэн 55.1 хувь нь бусад хүчин зүйлийн нөлөөгөөр буурчээ.
- Судалгаанд хамрагдсан нийт малчдын 64.4 хувь нь 2021 онд малын тоогоо 5 хувь бууруулах зорилтоо биелүүлсэн бол, 2022 онд 67.1 хувь болж өсжээ. Харин малын тоогоо бууруулсан ч 5 хувьдаа хүрээгүй малчид 2021 онд 4.1 хувь байсан бол 2022 онд 9.2 хувь болж өсжээ. Малын тоогоо өсгөсөн малчид нийт судалгаанд хамрагдсан малчдын 31.5 хувь нь 2021 онд малын тоогоо өсгөсөн байсан бол, 2022 онд 23.7 хувь болж буурснаас харахад малчид малын тоогоо өсгөх хандлага буурч байгаа нь харагдаж байна.

- Судалгаанд хамрагдсан зээл авсан малчдын хувьд дунджаар нийт малынхаа 9.5 хувийг борлуулсан байхад, зээл аваагүй малчдын хувьд нийт малынхаа 3.3 хувийг борлуулсан байна.

#### **ОБЗЭС-ийн зээлийн үр шим хүртэгчдийн амьжиргаанд нөлөөлсөн байдалд:**

- Энэхүү төслийн үйл ажиллагааны үр дүнд малчид малын тоо толгойд анхаарах бус малын тоог тодорхой хэмжээнд хязгаарлаж, бэлчээрээ хамгаалах, малын үүлдрийг сайжруулж, мал аж ахуйд түшиглэсэн бизнесийн орлоготой болох ёстой юм байна гэсэн мэдлэгтэй болсон байгаагаас харахад малчид байгалиа хамгаалах, бэлчээрийн доройтлоо багасгах нь чухал гэдгийг ойлгосон байгааг илэрхийлж байна. Төсөлд хамрагдсан орчны бүсийн болон бусад бүсийн малчин, малчин бус бүхий л иргэд энэ талд 100 хувь санал нэгдэж байсан нь чухал үр дүн гэж үзэж байна. Мөн малчдын амьжиргааг дэмжих замаар малчдын орлогын эх үүсвэрүүдийг нэмэгдүүлэх замаар малын тоо толгойг хязгаарлаж байгаа нь зөв зүйтэй талаар бүгд санал нэгдэж байв. Хэдий малын тоо нь малчдын хувьд амьжиргааны чухал үзүүлэлт хэдий ч, малаа борлуулж, хурдан эргэлтэд оруулах нь чухал гэдгийг бүгд ойлгосон байв. Тиймээс төсөл цаашид үргэлжлэх нь малчдын хувьд малынхаа тоог тодорхой түвшинд барьж, малаа хурдан эргэлтэд оруулж, орлогын тогтмол эх үүсвэртэй болох боломжийг нэмэгдүүлнэ гэж үзэж байна. Гэхдээ зээлийн хэмжээ нь ямар нэгэн бизнес эрхлэхэд хангалттай хүрэлцдэггүй гэж зээл авсан малчид үзэж байв. Тиймээс цаашид зээлийн хэмжээг нэмэгдүүлэх, бизнес эрхлэхэд нь шаардлагатай хэмжээний зээлийг олгох уян хатан нөхцөлийг бүрдүүлж өгөх шаардлагатай.
- Судалгаанд хамрагдсан зээл авсан малчин өрхийн орлого дунджаар 3.8 хувиар өссөн байхад зээл аваагүй малчин өрхүүдийн орлого дунджаар 0.1 хувь өсөж, зээл авсан малчдын хувьд зээлийн нөлөөгөөр 3.7 хувийн орлогын эерэг өөрчлөлт бий болжээ.
- Зээл авсан малчдын дийлэнх нь зээлээ зориулалтын дагуу ашигласан гэж өөрсдийгөө үнэлж байгаа ч тэдгээрийн дунд ОБЗЭС-аас авсан зээлээрээ бусад зээлээ төлсөн, бусад малчдад хүүтэй зээлсэн тохиолдол илэрсэн юм. Иймд төслийн зүгээс хяналтыг үе шаттай сайжруулах хэрэгтэй.
- Зээл авсан болон аваагүй малчдын хувьд ямар төрлийн сургалт хэрэгцээтэй байгаагаа “мэдэхгүй” гэж хариулсан хариулт өндөр хувийг эзэлж байгаагаас үзэхэд төслийн зүгээс дараагийн үйл ажиллагаагаа төлөвлөхдөө малчдын хэрэгцээ шаардлагыг бүрэн судалсны үр дүнд төлөвлөлтөө хийх нь зүйтэй гэж үзэж байна. Өөрөөр хэлбэл малчдад тулгарч болох сургалтын хэрэгцээний талаар ухуулга сурталчилгаа, танилцуулга үе шаттай хийсний дараа төслийн үйл ажиллагаанд хамгийн сайнаар нөлөөлөх сургалтыг сонгох хэрэгтэй.
- Төсөл амжилттай үр дүнд хүрсэн хэдий ч ОБЗ-ийн үйл ажиллагаатай холбоотой тодорхой асуудлуудыг шийдвэрлэх нь чухал юм. ОБЗ-ийн гишүүдийн идэвхтэй оролцоо нь төслийг амжилттай хэрэгжүүлэхэд чухал нөлөө үзүүлсэн. Иймд тус зөвлөлийг урамшуулах, алдаа гаргахгүй байх арга

хэмжээг хэрэгжүүлэх, гишүүдийг үр ашигтай, шударга ажиллах сэдэл төрүүлэх шаардлагатай байна. Төслийн талаарх мэдээллийг олон нийтэд түгээх, зээл олгох үйл явцын нээлттэй, ил тод байдлыг хангахад онцгой анхаарах нь чухал.

Малын тоог 5 хувь бууруулах зээлийн гол шалгуур нь малын тоог бууруулахад гол нөлөө үзүүлж байгаа нь малын тооны өөрчлөлтөөс харагдаж байна. Тухайлбал, сумын хэмжээнд, орчны бүсийн хэмжээнд малын тоо өссөн байхад, зээл авсан малчдын хувьд малын тоо буурсан байгаа үр дүнгээс харахад зээл нь малын тоог бууруулах бодит хөшүүрэг болж, бэлчээрийн талхлалт болон бэлчээрийн даацыг бууруулахад бодит хувь нэмрээ оруулж байна гэж дүгнэж байна.

## САНАЛ ЗӨВЛӨМЖ

Малчдын хувьд малын тоогоо бууруулж, богино хугацаанд малаа эргэлдүүлэх нь өрхийн орлогыг нэмэгдүүлэхээс гадна, бэлчээрийн даац, доройтлыг багасгахад чухал нөлөөтэй, олон тооны их малтай байхаас илүүтэй цөөн тооны, чанартай малтай болох нь зөв юм байна гэсэн ойлголттой болсон нь ОБЗЭС-ийн эхний шатны судалгааны үр дүнгээр батлагдсан. Тиймээс цаашид байгаль орчныг хамгаалах, бэлчээрийн даацыг багасгах зорилгоор малын тоог бууруулах шалгуурыг баримтлах нь зөв бөгөөд үүнийг зөвхөн зах зээлд борлуулсан малын тоогоор хэмжих нь малын тоог бодитоор бууруулах боломжийг олгож байна. “Байгальд ээлтэй малчны зээл”-ийн удирдамжийн дагуу малчид зах зээлд борлуулсан малдаа мал эмнэлэг, үржлийн албаны гэрчилгээ авч, энэхүү гэрчилгээгээр зах зээлд борлуулсан малын тооны бууралтыг баталгаажуулна гэж байгаа хэдий ч, малчид энэхүү гэрчилгээг авч хэвшээгүй байна. Тиймээс зээл авсан малчдын малын тооны бууралтыг энэхүү гэрчилгээгээр баталгаажуулахын тулд ТХН болон ОБЗ, Төрийн банкнаас хяналтыг тогтмол хийж, гэрчилгээний дүнгээр буурсан малчдын зээлийг хэвээр хадгалан үлдээх заалтын хэрэгжилтийг хангах хэрэгтэй байна.

ОБЗЭС-аас зээл олгох үйл ажиллагаа одоогийн амжилтаа хадгалах, илүү сайжруулахын тулд анхаарах асуудлуудад чиглэсэн дараах зөвлөмжийг судалгааны багийн зүгээс хүргүүлж байна.

№	ЕРӨНХИЙ ЧИГЛЭЛ	ЗӨВЛӨМЖ
<b>Ерөнхий зөвлөмж</b>		
	<b>1. Төслийн үйл ажиллагааг хэрэгжүүлэхийн өмнө суурь судалгаа хийх</b>	ОБЗЭС-ийн “Байгальд ээлтэй малчны зээл” нь малчдын хувьд малын тоогоо бууруулах үндсэн хөшүүрэг болж байгаа нь судалгаанд хамрагдсан зээл авсан малчин өрхүүдийн малын тооны бууралтаас харагдаж байна. Гэвч судалгааны үр дүнгээр малчдын А дансны бүртгэл болон судалгаагаар хэлж байгаа малын тооны бууралтын хувьд 29.3 хувийн зөрүү байсан учраас төслийн дараагийн шатыг хэрэгжүүлэхдээ үүнийг харгалзан үзэх зайлшгүй шаардлагатай юм. Хэдийгээр А данс нь малын тооны албан статистик мэдээллийг илэрхийлдэг хэдий ч, бодит байдлаас өөр байгаа тул цаашид төслийн II үе шатыг хэрэгжүүлэхдээ төсөл хэрэгжүүлэхийн өмнөх суурь судалгааг хийх шаардлагатай. Төсөл хэрэгжүүлэхийн өмнөх суурь судалгааг хийж, төсөл хэрэгжүүлэхээс өмнө малчдын А данс болон аман судалгаагаар хэлж байгаа малын тооны зөрүүг тогтоож, төсөл хэрэгжээд дууссаны дараах малын тооны зөрүүтэй харьцуулж, малын тооны бодит бууралтыг зөв тогтоох боломжтой.
	<b>2. Малын тоог бууруулах хувийг суурь судалгаагаар тогтоох</b>	ОБЗЭС-ийн “Байгальд ээлтэй малчны зээл” нь малын тоог бууруулах хөшүүрэг болж байгаа учраас суурь судалгаагаар малын тоог хэдэн хувиар бууруулах ёстойг тухайн газарзүйн онцлог, байршил, малчдын орлогоо олж буй эх үүсвэр зэргийг харгалзан үзэж тогтоох нь үр дүнтэй.
	<b>3. ОБЗЭС-ийн “Байгальд ээлтэй малчны зээл”-ийг дараах үйл ажиллагаануудыг дэмжих байдлаар олгох</b>	Малын гаралтай түүхий эдийг боловсруулах, мал аж ахуйн бүтээгдэхүүний нийлүүлэлтийн сүлжээг сайжруулах чиглэлийн үйл ажиллагааг дэмжих чиглэлээр олгох нь илүү үр дүнтэй байна. Мөн байгаль орчныг хамгаалах, байгаль орчинд ээлтэй үйл ажиллагаа явуулж байгаа иргэд, ААН, ТББ, малчдын бүлэгт зээлийг олгох нь зүйтэй.
	<b>4. Төслийн үйл ажиллагааг хянахдаа техник, технологийн дэвшлийг ашиглах боломжийг судлах</b>	Төслийн зүгээс хэрэгжүүлж буй зээлийн үйл ажиллагааг цаашид үргэлжлүүлэн хэрэгжүүлэхдээ малын тоог бууруулах болгох шалгуур үзүүлэлтийг үндсэн хөшүүрэг болгон баримтлах нь зүйтэй хэдий ч малын тоог бодитоор хянах зайлшгүй шаардлагатай байгааг судалгааны үр дүн тогтоосон. Иймд зээл авсан малчдын малын тоог бодитоор хянах аргачлал боловсруулах, уг аргачлалд технологийн боломж ашиглахыг зөвлөж байна. Өөрөөр хэлбэл зээл авснаас хойш хэдэн удаа ямар давтамжаар, хэрхэн малын тоог хянах тухай гарын авлага боловсруулах, үүндээ ямар технологи ашиглах талаар тодорхой тусгаж анхан шатны хяналтыг хийж байгаа



№	ЕРӨНХИЙ ЧИГЛЭЛ	ЗӨВЛӨМЖ
<p>оролцогч тал болох ОБЗ-ийн гишүүдэд хүргүүлэх хэрэгтэй. Технологи ашиглаж байгаа тул ТХН-ий зүгээс ОБЗ-ийн хяналтын үйл ажиллагааг давхар хянах боломж үүсгэнэ. Мөн технологийн шийдэлд зарцуулж буй зардал нь малчдын байршиж буй газар луу явах унаа машины эвдрэл гэмтэл, шатахууны зардал зэргийг хэмнэх юм.</p>		
<p><b>5. Төслийн үйл ажиллагааг хэрэгжүүлэхдээ техник, технологийн дэвшлийг ашиглах боломжийг судлах</b></p>		
<p>Малчдад зээл авах, зээлийн эргэн төлөлтөө хийх, зээлийн үлдэгдлээ хянах зэрэг боломжийг нээлттэй болгох хэрэгтэй. Өөрөөр хэлбэл малчид зээл авах, зээлийн эргэн төлөлтөө хийх гэж суманд байрлах банканд ханддаг нь тэдний хувьд томоохон бэрхшээл болж байна. Иймд малчдын хэрэгцээнд тохируулан ашиглаж болох технологийн шийдлүүдийг судлах шаардлагатай.</p>		
<p><b>6. Хүүхэд байхаас нь иргэдэд байгаль орчны мэдлэг мэдээллийг түгээх хэрэгтэй.</b></p>		
<p>Байгаль орчныг гэмтээхгүйгээр хийх боломжтой олон үйлдвэрлэл, үйл ажиллагаа эрхлэх боломж байдаг гэдэг сэтгэлгээг суулгахад чиглэсэн нөлөөллийн ажлын сонгогдсон бүс нутгуудад зохион байгуулах хэрэгтэй.</p>		
<p><b>Зээлийн үйл ажиллагаатай холбоотой баримт бичгийг сайжруулах хүрээнд дараах зөвлөмжийг хүргүүлж байна. Үүнд:</b></p>		
1	<p><b>“Орчны бүсийн зээлийн эргэлтийн сангийн зээлийн дамжуулан зээлдүүлэх гэрээ”-ний зүйл, заалтуудыг сайжруулах шаардлагатай.</b></p>	<ul style="list-style-type: none"> <li>• ОБЗЭС-ийн үйл ажиллагааг зохицуулахтай холбоотой үндсэн баримт бичгүүд болох “Дамжуулан зээлдүүлэх гэрээ” болон “Байгальд ээлтэй малчны зээл”-ийн удирдамжид хийсэн шинжилгээний үр дүнд нэр томъёоны тайлбарт оролцогч талуудын тайлбарыг бүрэн тусгаагүй, орхигдуулсан. Тиймээс цаашид засаж сайжруулах. Тухайлбал, үндсэн оролцогч тал болох малчид гэж байгаа ч яг малчид гэдэгт хэнийг ойлгох талаарх ойлголтыг нэр томъёоны тайлбар хэсэгт оруулж өгөх шаардлагатай.</li> <li>• Оролцогч талуудын гэрээгээр хүлээсэн үүрэг, хариуцлагыг нарийвчлан тодорхой тусгаж өгөх. Тухайлбал, хяналт, мониторингийн үйл ажиллагааг тогтсон хугацаанд тогтмол явуулах, шаардлагатай хугацаанд тайлан, зээлийн үйл явцын тайлан мэдээг илгээдэг, хүлээн авдаг, сонсдог байх талаар тусгаж өгөх.</li> <li>• БОАЖЯ болон ТХН хяналтыг сайжруулах, ОБЗ-ийн үйл ажиллагааг жил бүр дүгнэж, тухайн жилийн ажлын төлөвлөгөөг баталдаг талаар гэрээнд тусгаж өгөх. Мөн ОБЗ-ийн 1.5 хувийн хүүгийн зарцуулалтын талаар нарийн тусгаж өгөх. Тухайлбал, ОБЗ-ийн жил бүрийн ажлын төлөвлөгөөг батлахдаа ялангуяа байгаль орчныг хамгаалах чиглэлээр явуулах үйл ажиллагааг тодорхой, нарийн тусгасан эсэхийг харж, батлах.</li> <li>• Цөөн малтай малчин өрх нь банкны шалгуураар зээлд хамрагдах боломж хязгаарлагдмал байгаа тул цөөн малтай малчин өрхүүдийг зээлд хамрагдах боломжийг нэмэгдүүлж, нэмэлт орлогын эх үүсвэрийг бий болгохын тулд зээлийн батлан даалт гаргах боломжийг ТХН-ийн зүгээс судлах, боломжтой бол хэрэгжүүлж, гэрээний заалтад оруулж өгөх.</li> </ul>
2	<p><b>“Байгальд ээлтэй малчны зээл”-ийн удирдамжийг сайжруулах шаардлагатай.</b></p>	<ul style="list-style-type: none"> <li>• Үндсэн оролцогч тал болох “Малчин” өрх гэдэгт хэнийг ойлгох талаар нэр томъёоны тайлбарыг нэмж оруулах. Учир нь малчин өрх, мал бүхий иргэд нь ялгаатай учир энэхүү нэр томъёог оновчтой болгох.</li> <li>• Зээл олгох зориулалтыг нарийвчилж өгөх. Тухайлбал, малчдын бүлэг, малчдын орлогын шинэ эх үүсвэрийг бий болгох дэд төслүүдийг дэмжих, мал аж ахуйн бус орлогын эх үүсвэртэй болох үйл ажиллагааг дэмжих.</li> <li>• Ялангуяа МАА-н бүтээгдэхүүний нийлүүлэлтийн сүлжээнд оролцох, малаас өөр орлогын эх үүсвэртэй болох дэд төслүүдийг дэмжихэд чиглэх нь малчдын хувьд малаас өөр</li> </ul>



№	ЕРӨНХИЙ ЧИГЛЭЛ	ЗӨВЛӨМЖ
		<p>бусад орлогын тогтмол эх үүсвэртэй болох нөхцөлийг бий болгоно.</p> <ul style="list-style-type: none"> <li>• Малчдын хувьд ОБЗЭС-ийн зээлийн хүүг сар бүр биш, зээлийн үндсэн төлөлттэй хамт төлдөг байхаар шийдэж өгөх. Өөрөөр хэлбэл, Төрийн банкны малчны зээлийн үйлчилгээний дагуу зээлийн хүүгийн төлөлтийг үндсэн зээлийн хамт малчдын орлого олдог үетэй нь уялдуулан зээлийн эргэн төлөлтийн графикийг хийдэг болох.</li> <li>• Малчдын хувьд зээл аваад эхний 12 сарын хугацаанд малаа 5 хувь бууруулах үүрэг хүлээж байгаа ба судалгааны үр дүнд зээл авсан малчид эхний жилээ малынхаа тоог 5 хувь бууруулж, дараагийн жилээс малын тоо нь өссөн байдал ажиглагдаж байсан тул зээлийн гэрээг дуустал малын тоог бууруулах үүргийг хүлээлгэх. Тухайлбал, нэг удаа зээл авсан малчин дахин зээл авах хүсэлт гаргавал энэхүү шалгуураар олгох. Үүнийг удирдамжид тодорхой тусгах. Судалгааны үр дүнгээс малчид малынхаа тоо толгойг бууруулж бэлчээр болон байгаль орчноо хамгаалах нь зүйтэй гэдгийг сайтар ухамсарласан байсан. Тиймээс төслийн үйл ажиллагаанд хамрагдах хугацаанд нь цаашид малынхаа тоо толгойг хэрхэн зохистой түвшинд барьж амьжиргаагаа дэмжих талаар мэдлэг олгох сурталчилгааг төлөвлөн хэрэгжүүлэх нь зүйтэй.</li> <li>• Бэлчээрийн даац болон биологийн олон янз байдалд өөрчлөлт орсон эсэхийг хэрхэн хэмжих талаар тодорхой заалтыг удирдамжид тусгаж өгөх.</li> <li>• Орчны бүсэд амьдардаггүй ч, мал нь орчны бүс рүү бэлчээрлэдэг орчны бүсийн хил заагт амьдарч байгаа малчдын хувьд энэхүү зээлд хамрагддаггүй. Тиймээс энэхүү нөхцөл байдлыг ТХН-ийн зүгээс харгалзан үзэх.</li> <li>• Нэг удаа зээл авсан малчин өрх нь зээлд дахин хандаж болох эсэх талаар удирдамжид тодорхой тусгах.</li> </ul>
<p><b>Төслийн үйл ажиллагаанд оролцогч талуудын оролцоо, үүрэг, хариуцлагыг сайжруулах хүрээнд дараах зөвлөмжийг хүргүүлж байна. Үүнд:</b></p>		
	<p><b>Төрийн банкны үйл ажиллагааны хувьд:</b></p>	<ul style="list-style-type: none"> <li>• Хяналт мониторингийн үйл явцад зөрчил илэрсэн тохиолдолд богино хугацаанд зөрчлийг шийддэг байх. Өөрөөр хэлбэл, удирдамжид заасны дагуу малынхаа тоог өсгөсөн малчдын зээлийн гэрээг цуцалж, энгийн зээл рүү шилжүүлэх үүргээ биелүүлдэг байх.</li> <li>• Гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлж, зээлийн судалгааг ОБЗ-өөс материал ирснээс хойш ажлын 10 хоногийн дотор зээлийн шийдвэрээ гаргадаг байх.</li> </ul>
	<p><b>ОБЗ-ийн үйл ажиллагааны хүрээнд:</b></p>	<ul style="list-style-type: none"> <li>• ОБЗ нь зээлийн талаар болон зээл олголтын талаарх мэдээллийг сайн түгээдэг байх. Орчны бүсэд амьдарч байгаа зарим малчдын хувьд мэдээлэл дутмаг, зээлийн талаар мэдээлэл хомс байсан.</li> <li>• ОБЗ-ийн гишүүдийг үүрэг, хариуцлага, ямар чиглэлээр ажиллах зорилготой байгууллага зэргийн талаар мэдээлэл өгөх сургалтуудыг зохион байгуулах. Учир нь ОБЗ-ийн гишүүд зээл олгох шийдвэр гаргах хурал зохион байгуулах, зээлийн мониторинг хийх үүрэгтэй гэсэн ойлголтоор тэдний үйл ажиллагаа хязгаарлагдаж байна. Мөн зарим ОБЗ-ийн хувьд 1.5 хувийн хүүгийн орлогоо хэрхэн, яаж, юунд зарцуулахаа мэдэхгүй байсан тул, 1.5 хувийн хүүг юунд зарцуулж болох талаар сургалтыг өгөх. ОБЗ-ийн дарга болон гишүүдийн хувьд гэрээ болон удирдамжаар ямар үүрэг хүлээсэн, тайлангийн агуулгад юу бичих, хэрхэн яаж ажиллах талаарх мэдлэг дутмаг байна.</li> </ul>

№	ЕРӨНХИЙ ЧИГЛЭЛ	ЗӨВЛӨМЖ
		<ul style="list-style-type: none"> <li>• Бусад сумдын ОБЗ хэрхэн ажилладаг талаар туршлага судалдаг байх. Сайн туршлагуудыг бусдадаа хуваалцдаг байх талаар уулзалт, ярилцлагыг зохион байгуулдаг байх.</li> <li>• ОБЗ-ийн үйл ажиллагааны тайлангийн бүтцийг тодорхой болгох, бусад оролцогч талуудад тайлагнах хугацаанд нь ТХН-ийн зүгээс хяналт тавьж, тайланг нь хүлээн авдаг байх. Мөн ТХН-ийн зүгээс ОБЗ-ийн үйл ажиллагааг тогтмол хянах, үйл ажиллагааг нь сайжруулах чиглэлээр дэмжин ажиллах, хэрхэн ажиллах чиглэлийг өгөх шаардлагатай.</li> <li>• ОБЗ нь хяналт, мониторингийг тогтмол хугацаанд хийдэг байх, зөрчил илэрсэн тохиолдолд зөрчлийг арилгах талаар арга хэмжээг тогтмол авдаг байх.</li> </ul>
	<p><b>ТХН-ийн үйл ажиллагааны хүрээнд:</b></p>	<ul style="list-style-type: none"> <li>• ТХН-ийн хувьд одоогийн байгаа “Байгальд ээлтэй малчны зээл”-ийн удирдамжийн хэрэгжилтийг хянах төлөвлөгөө гаргаж, төлөвлөгөөний дагуу мониторингийг тогтмол хийдэг байх.</li> <li>• ОБЗ-ийн гишүүд нь тогтмол цалингүй учраас үндсэн ажлынхаа хажуугаар давхар хийж байгаа нь ОБЗ-ийн үйл ажиллагаанд бүрэн цагаа зарцуулж чаддаггүй байна. Тиймээс орон тооны ажилтан ажиллуулах.</li> <li>• ОБЗ-ийн хувьд үйл ажиллагааны тайлан бичих ерөнхий загвар байхгүй тул сумуудын ОБЗ-ийн бичсэн тайлан нь агуулгын хувьд ялгаатай байгаа нь үнэлгээ хийхэд хүндрэл учруулж байсан. Үүнийг сайжруулахын тулд тайлангийн ерөнхий загварыг гаргах, тайланг үнэлэх үнэлгээний аргачлалыг боловсруулах шаардлагатай.</li> <li>• ОБЗ-ийн үйл ажиллагааг санхүүжүүлж байгаа 1.5 хувийн хүүгийн орлого нь зарим ОБЗ-ийн хувьд хяналт, мониторингоор явах үед шатахууны зардалд хүрэлцдэггүй талаар дурдаж байсан тул ТХН нь ОБЗ-тэй хамтран ажиллаж, цаашид ОБЗ-ийн орлогын эх үүсвэрийг нэмэгдүүлэх боломжтой эсэхийг судлах.</li> <li>• Орчны бүсийн зөвлөлөөс зээл олголтын үйл ажиллагаа хэрэгжилтийн тухай тайлан мэдээг тодорхой хугацаанд тогтмол авч, үнэлэлт дүгнэлт хийж байх. Энэ нь орчны бүсийн зөвлөлийн үйл ажиллагаа идэвхжүүлэхээс гадна гарсан алдаа дутагдлаа тухай бүрд нь засаж залруулах, зээлийн үйл ажиллагаа тогтвортой явагдахад эергээр нөлөөлөх боломжтой.</li> <li>• ОБЗ-ийн гишүүдийг жилдээ хамгийн багадаа 1 удаа цуглуулан, жилийн ажлын тайланг нь хэлэлцэх, бусдаасаа туршлага судлах боломжийг олгодог байх.</li> <li>• Малчдын зээлийн хүсэлт, хэрэгцээ шаардлага их байгаа ч, ОБЗЭС-ийн эх үүсвэрийн хүрэлцээ бага байна. Тиймээс ОБЗЭС-ийн зээлийг орчны бүсийн малчид болон байгаль орчныг хамгаалах чиглэлээр ажилладаг байгууллага, хувь хүмүүс болон байгаль орчныг хамгаалах чиглэлийн дэд төслүүдийг санхүүжүүлэх шаардлагатай.</li> <li>• Төслийг цаашид үргэлжлүүлэхдээ тухайн орон нутгийн газарзүйн онцлог, малчдын орлого олох эх үүсвэр, зах зээлийн нөхцөл байдалтай нь уялдуулан зээлийн дээд хэмжээг тогтоох. Ингэхдээ төсөл хэрэгжих газрын суурь судалгааг мэргэжлийн түвшинд хийх шаардлагатай.</li> </ul>

Тиймээс цаашид төслийг үргэлжлүүлэн хэрэгжүүлэхдээ төслийн үндсэн зорилгоо биелүүлэхийн тулд орчны бүсэд амьдарч байгаа малчдад зээлийг үргэлжлүүлэн олгохоос гадна, малын гаралтай түүхий эдийг боловсруулах, нийлүүлэлтийн сүлжээнд

оролцох сонирхлыг нэмэгдүүлэх дэд төслүүдэд зээлийг олгох нь илүү үр дүнтэй байна. Мөн байгаль орчныг хамгаалах, байгаль орчинд ээлтэй үйл ажиллагаа явуулж байгаа иргэд, ААН, ТББ, малчдын бүлэгт зээлийг олгох нь зүйтэй гэж үзэж байна. Энэ нь орон нутгийн малчдын тогтвортой амьжиргааг дэмжихэд чухал нөлөөтэй.

## ХАВСРАЛТ

### ХАВСРАЛТ 1. САЙН ТУРШЛАГА БОЛОН СУРГАМЖ – ДЭЛГЭРЭНГҮЙ ҮР ДҮН

#### **А. Их тамир сум**

##### **Сайн туршлага**

Их-Тамир сумын зээл авсан малчдын хувьд ногоон тэжээл тариалах, малын хашаа хороогоо засварлах, хэрэглээний зориулалтаар, мөн бага оврын тоног төхөөрөмж тухайлбал, хадуур авах гэх мэт зүйлсэд зарцуулжээ. Зарим малчдын хувьд аарц худалдан авч цагаан идээ боловсруулах, үхрийн арьс худалдан авч суран эдлэл хийх зэргээр малын бус орлогын эх үүсвэртэй болсон байв. Мөн малчдын хувьд сайн үүлдрийн эцэг мал худалдан авснаар малын үржил сайжирч, махны гарц нэмэгдэх, малын бие томрох болсон зэрэг үр дүнгүүд гарч эхэлсэн байна.

##### **Сургамж, алдаа дутагдал**

Их-Тамир сумын хувьд зарим малчдын хувьд зээлийн талаар огт мэдээгүй, мөн мэдээлэл хүртээмжтэй биш байдаг талаар дурдаж байв. ОБЗ-өөс зээлийн талаарх мэдээллийг олон нийтийн сүлжээ фэйсбүүк болон багийн даргаар нь дамжуулан зээлийн материал хүлээн авах зарыг түгээдэг гэж байгаа ч малчид байнга сүлжээтэй газар байхгүй, мөн сумын төвөөс хол байх нь мэдээллээс хоцордог талаар дурдаж байв.

Мөн ОБЗ -ийн үйл ажиллагааны талаар төдийлөн сайн мэдэхгүй байлаа. Судалгаанд хамрагдсан оролцогч талуудын хувьд ялангуяа малчдын хувьд зээлийн хэмжээ нь бага байдаг, сайн үүлдрийн эцэг мал худалдаж аваад, зээлийн мөнгө нь дуусчихдаг, өөр зүйл хийж чаддаггүй талаар дурьдаж байв. Бусад оролцогч талуудын хувьд ч гэсэн зээлийн хэмжээг нэмэгдүүлэх, хамрах хүрээг өргөтгөх, зөвхөн орчны бүсийн малчдад өгч байгаа нь учир дутагдалтай байгаа талаар хэлж байлаа. Тиймээс зээлийн дээд хэмжээг 20 сая төгрөг хүртэл нэмэгдүүлэх саналыг гаргаж байв.

Малчдын хувьд зээлийн хүүг сар бүр, үндсэн зээлийн төлөлтийг улиралдаа төлж байгаа ч, зарим малчдын хувьд хол нүүдэллэдэг нь зээлийн хүүг сар бүр төлөхөд хүндрэлтэй байдаг байна. Тиймээс Төрийн банкнаас тухайн малчны зээлийг чанаргүй зээл рүү оруулахгүйн тулд зээлээ сар бүр төлж байхыг байнга сануулдаг байна. Энэ нь зээлийн эрсдэлийг нэмэгдүүлэх нэг сул тал болох учраас, цаашид зээлийн хүүгийн эргэн төлөлтийг сар бүр биш, үндсэн зээлийн хамт төлж байх боломжоор хангахыг хүсэж байлаа. Малын тоо нь малчдын зээл авах гол шалгуур болдог учраас цөөн малтай зарим малчдын хувьд банкны шалгуур хангахгүйн улмаас тус зээлд хамрагдаж чаддаггүй байна.

#### **В. Цэнхэр сум**

##### **Сайн туршлага**


Цэнхэр сумын зээл авсан малчдын хувьд өвөлжөөндөө ногоон тэжээл тариалах, малын үүлдрээ сайжруулах, бага оврын трактор авах, цагаан идээ боловсруулах зэргээр зээлийг зарцуулжээ. Малчдын хувьд ногоон тэжээл тариалж эхэлсэн нь малчин өрхийн

хувьд тэжээл худалдан авах зардлыг хэмнэх нэг том давуу талыг бий болгож байгаа нь малчин өрхийн амьжиргааг дэмжихэд чухал нөлөөтэй байна гэж малчид болон судалгаанд оролцсон оролцогч талууд дурдаж байв. Энэ сумын тухайд “Боргио бүлэг” гээд 1 малчны бүлэгт зээлийг олгосон бөгөөд малчны бүлгийн хувьд малчдын зарах гэж байгаа малыг нэгтгэн, зах зээлд хүргэх ажлыг зохион байгуулсан бөгөөд энэ нь малчдын тээврийн зардлыг хэмнэх нэг том давуу талыг бий болгож байна.

Малчдын хувьд малын үүлдрээ сайжруулсан нь төл том төрөх, мөн малын ашиг шим нэмэгдэх боломжтой гэж үзэж байв. Одоогийн байдлаар дөнгөж сайн үүлдрийн эцэг малын төл нь одоо л зах зээлд эргэлтэд орох боломжтой болж байгаа талаар судалгаанд хамрагдсан малчид дурдаж байсан юм.



Мөн зээл авсан малчин өрхөөс ногоон тэжээл тариалж, өрхийн тэжээлийн зардлыг хэмнэж чадсан бол, зарим зээл авсан малчин өрхүүдийн хувьд малын хашаа хороогоо сэлбэж, засварлах ажлыг хийж гүйцэтгэжээ.



**Сургамж, алдаа дутагдал**

Гэвч судалгаанд оролцогч тухайлбал, малчин биш иргэдийн төлөөллийн хувьд тухайн зээлийг танил талаараа олгодог, мөн зээлийн талаарх мэдээлэл дутмаг, судалгаанд оролцохдоо л тухайн зээлийн талаар мэдэж авсан, мөн малчин, гэхдээ тухайн зээлийг аваагүй малчдын хувьд зээлийн талаар огт сонсоогүй талаар дурдаж байгаагаас харахад зээлийн талаарх мэдээлэл хангалтгүй байдаг нь ажиглагдаж байв. Мөн судалгаанд оролцогчид тухайн зээлийг малчин гэж хязгаарлахгүйгээр олгох хэрэгтэй гэж үзэж байв. Ялангуяа байгаль хамгаалах чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг, мод тарьдаг, ойн нөхөрлөлүүдэд тухайн зээлийг олгодог болох нь байгаль орчныг хамгаалах чиглэлийн



зорилготой нь нийцнэ гэж байлаа. Мөн тус сумын хувьд орчны бүс нь сумын төвөөс хол, зам хэцүү байдаг тул зарим үед хяналтаар явахад 1.5 хувийн хүүгийн орлого нь шатахуунд хүрэлцдэггүйгээс гадна машин эвдэрсэн үед засуулах мөнгө байдаггүй.


### **С. Бат-Өлзий сум**

Орчны бүсийн малчдад хөнгөлөлттэй зээл олгох үйл ажиллагааг сумын ОБЗЭС Төрийн банктэй хамтран зохион байгуулж байсан. ОБЗ-ийн үйл ажиллагаа нь тогтворжсон, гишүүд нь үйл ажиллагаанд идэвхтэй оролцдог, хурлын материал, зээл олголтын бүртгэл, зээлийн эргэн төлөлт гэх мэт үйл ажиллагаа үлгэр жишээ сайн явагддаг нь ажиглагдсан.

Оролцогч талууд болон малчдын төлөөлөлтэй уулзаж ярилцахад ОБЗЭС-ийн үйл ажиллагаанд сэтгэл ханамжтай байдал ажиглагдаж байлаа. Зээл олголтын хувьд малчдыг ээлж дараалан олгох байдлаар өргөдөл хүсэлтийн хугацааг үндэслэн шийдвэрлэж байсан.

### **Сайн туршлага**

Зээл авсан малчидтай хамтран ажиллах байдал үлгэр жишээч байлаа. Зээл авах малчидтай сумын Засаг дарга тусгайлан малын тоог бэлчээрийн даацад нийцүүлэх гэрээг байгуулж байсан.



Энэ нь малчид эрх үүргээ ухамсарлах, зээлийг зориулалтын дагуу зарцуулах хөшүүрэг болсон байна.

Зээлийн зориулалтын дагуу захиран зарцуулалтад тавьж буй хяналт маш сайн байсан. Зээлийн зарцуулалтыг баримтжуулан малчдаас ОБЗЭС нь авч байсан бөгөөд энэхүү арга хэмжээ нэг талаар малчдад хүндрэлтэй нөхцөл байдал мэт боловч нөгөө талд энэ нь зээлийн зарцуулалтыг хянах зөв арга хэмжээ болсон байна. Малчдын хувьд энэхүү арга хэмжээ нь хүндрэлтэй биш байдаг талаар саналаа хэлж байсан.

Зээлд хамрагдсан малчид зээлийг зориулалтын дагуу зарцуулах, өрхийн амьжиргааг дэмжих чиглэлд илүү анхаарч тодорхой үйл ажиллагаа явуулсан байсан. Ихэнх малчид малын ашиг шим сайжруулах чиглэлд анхаарч эцэг малыг сайжруулах чиглэлээр зээлээ

зарцуулсан бол зарим малчид аялал жуулчлалын бизнес эрхлэхэд шаардлагатай эд материал, эд хогшил бэлдэхэд ашиглаж тодорхой хэмжээний ашиг орлоготой ажиллах нөхцөл боломжийг бүрдүүлсэн байсан.

Түүнчлэн бэлчээрийг нөхөн сэргээх, хуучин уул уурхайн хүрээнд сүйдлэгдсэн газрыг нөхөн сэргээх чиглэлд малчдын бүлгийг татан оролцуулах идэвх санаачилгыг нэмэгдүүлэх талд анхаарч зээл авсан өрхийг татан оролцуулах үйл ажиллагааг зохион байгуулсан байлаа.

Бат-Өлзий сумын хувьд ОБЗЭС-ийн гишүүд санаачилгатай идэвхтэй ажилласан байна. ОБЗЭС-ийн гишүүд хагас жилийн мал тооллогоор өрхүүдээ хянадаг ба энэ үйл ажиллагаанд тусгай хамгаалалтай газрын захиргааны албан хаагчид хамтран ажилладаг нь сайн талтай байлаа. Малчдаас зээлийн зарцуулалтын тайланг нотлох баримтаар авдаг, ТХГН-ийн Хамгаалалтын захиргааны-ны албан хаагчид идэвх санаачилгатай хамтран ажилладаг нь бусад газруудтай харьцуулахад үлгэр жишээ болохуйц байлаа.

Цаашид төслийн үйл ажиллагааг үргэлжлүүлэх, илүү өргөжүүлэх, цар хүрээг нэмэгдүүлэхэд анхаарч өгөхийг хүсэж байсан. Орчны бүсийн малчдаас гадна бусад бүсийн малчдыг хамруулдаг болох хувиараа бизнес эрхлэгчдийг хамруулдаг болох талд анхаарч өгөхийг хүсэж байсан. Түүнчлэн зээлийн санг нэмэгдүүлэх, зээлийн хэмжээг өөрчлөх талд тодорхой саналуудыг гаргаж байсан. Тухайлбал зээлийн хамрах хүрээг өргөтгөх, нэг удаагийн зээлийн хэмжээг 15.0 сая төгрөг болгох, зээлийн эргэлтийн сангийн хэмжээг нэмэгдүүлэхэд голлон анхаарахыг хүссэн.

#### **D. Их-Уул сум**

Зээл олгох процессын хувьд сумын ОБЗ нь малчдаас зээлийн хүсэлтийн материалыг хүлээн авч, ОБЗ-ийн хурлаар хэлэлцэн, шаардлага хангаж байгаа малчдын зээлийн хүсэлтийн материалыг Төрийн банканд хүргүүлдэг. ОБЗ-ийн хурал нь сумын Засаг даргын тушаалаар батлагдсан ОБЗ-ийн гишүүдээс бүрддэг. Зээлийн хүсэлтийн материалын хувьд Төрийн банкнаас олгодог энгийн малчны зээлийн бүрдүүлбэртэй ижил байсан. Бүрдүүлэх материалын хувьд бүрдлийг хангахад төдийлөн хүндрэлтэй зүйл байхгүй байсан. Малчид зээлд хамруулах хүсэлтээ ирүүлсэн хэдий ч зээлд хамрагдаагүй талаар тодруулахад давхар зээлтэй байснаас шалтгаалан хасагдах тохиолдол гарч байсан талаар тайлбарлаж байсан.

Зээлд хамрагдсан болон хамрагдаагүй малчдын төлөөлөлтэй уулзаж ярилцахад энэхүү зээлийн мэдээлэл маш дутмаг цөөн хүрээнд мэдээлэл хүргэснээс шалтгаалан олон малчид мэдээлэл авч чадаагүй, огт сонсоогүй байлаа. Зээлийн хүсэлт өгөөд авч чадаагүй малчдын хувьд ямар шалтгаанаар зээл олгоогүй талаар мэдэхгүй, яагаад хасагдсан талаар тайлбар өгөөгүй, зээл олгохгүй болсон гэх ганц үг л хэлсэн яагаад хасагдсан, эсвэл шаардлага хангаагүй талаар огтоос тайлбарлаагүй талаар гомдол мэдүүлж байсан. Түүнчлэн танил тал, ах дүү нарын хүрээнд хөнгөлөлттэй зээл тусламж явдаг талаар саналаа хэлж байсан ба цаашид малчдад мэдээлэл сайн хүргэж байх, хүртээмжтэй байх, шударга байх талд анхаарч ажиллаасай гэсэн саналыг хэлж байсан.

Зээлд хамрагдсан малчдын хувьд сэтгэл ханамж сайтай байсан бөгөөд хүү багатай малчдын амьжиргааг дэмжсэн зээлийн эрэлт хэрэгцээ их байдаг талаар ярьж байсан. Иймд цаашид энэхүү зээлийн хөтөлбөрийн үргэлжлүүлэх, илүү олон малчдыг хамруулах боломж нөхцөлөөр хангах талд анхаарч ажиллахыг уламжилж өгөхийг хүсэж байлаа.

Фокус бүлгийн ярилцлагад оролцогчид болон ганцаарчилсан ярилцлагад оролцогчдын хувьд хувьд энэхүү төсөл нь ашиг тустай төсөл гэж санал нэгтэй дэмжсэн. Түүнчлэн энэхүү төслийг цаашид хэрэгжүүлэх нь зүйтэй гэсэн саналыг өгсөн. Хэдий олон өрх айлын хүрээнд хэрэгжих боломжгүй хэдий ч хамрагдсан айл өрхийн хувьд үр өгөөжөө өгсөн амьдралд ойр зөв төсөл гэж үзэж байлаа.

Малчдын хувьд малын тоо толгойг жил тутам 5 хувиар бууруулах гол шаардлага нь амьдралд хэрэгжүүлэхэд хүнд байдаг хэдий ч цаашид жил ирэх бүр доройтож буй бэлчээрийн гарцыг сайжруулах, илүү олон жил мал аж ахуйг тогтвортой эрхлэхийн тулд зайлшгүй малын тоонд хязгаарлалт тавихаас өөр аргагүй гэсэн саналыг хэлж байлаа. Малчдын хувьд цаашид малын тоо толгойд анхаарах бус малын чанарт анхаарах, малыг эдийн засгийн эргэлтэд жил бүр оруулж үр шимийг хүртэж байх нь чухал гэдгийг ойлгосон байгаа нь энэхүү төслийн гол үр дүнгийн нэг байсан гэж үзэж байна. Мөн малчдын хувьд төсөл хэрэгжих үйл явцад гарч буй алдаа дутагдлыг засаж залруулан цаашид төслийг үргэлжлүүлэн явуулах хэрэгтэй гэсэн саналыг гаргаж байсан. Тухайлбал, зээлийн талаарх мэдээллийн дутмаг байдал, зөвхөн орчны бүсийн малчдаар хязгаарлагдаж байгаа гэх мэт. Тиймээс цаашид төслийн мэдээллийг олон нийтэд нээлттэй ил тод болгох, мэдээллийг сайн хүргэх, зөвхөн орчны бүсийн малчдаас гадна бусад бүс нутгийн малчид болон хувиараа хөдөлмөр эрхлэгч иргэдийг хамруулдаг болох талд анхаарах нь зүйтэй гэсэн саналыг гаргаж байв.

### ***Сайн туршлага***

- Орчны бүсийн малчдад зээл олгосноор малын тоо толгойнд тодорхой хэмжээний хязгаарлалт тавьдаг болсон нь бэлчээрийн доройтлыг бууруулах гол арга хэмжээ гэж үзэж байсан. Энэхүү үйл ажиллагааны үр дүнд энэ жил бэлчээрийн гарц өмнөх жилүүдээс илүү сайн байсан талаар малчид болон бусад оролцогч талууд санал нэгтэй дэмжиж байсан.

- Зээл авсан малчдын малын тоо толгой буурах нь сумын нийт малын тоо хэмжээнд өөрчлөлт авчрах боломжгүй хэдий ч малыг илүү чанаржуулах, малчид өөр орлогын эх үүсвэртэй болох, малын тоо толгой өсөх нь малын бэлчээрт, байгаль орчинд сөрөг нөлөө үзүүлж байгаа тул цаашид малын тоог хязгаарлаж бэлчээрээ хамгаалах нь зөв гэсэн ойлголт мэдлэгийг олгосон нь илүү дэвшил гэж үзэж байна. Малчид малын тоонд анхаарахгүй, чанарт анхаарах хэрэгтэй талаар санал нэгтэй дэмжиж байсан.

### ***Сургамж, алдаа дутагдал***

- Мэдээллийн хүртээмж маш муу
- Орчны бүсийн малчдад ч бүрэн мэдээлэл хүргээгүй
- Зээл авах шалгуур үзүүлэлт, түүний шаардлагын талаар мэдээлэл маш муу
- Зээлд хүсэлт өгсөн хэдий ч хасагдсан иргэдэд учир шалтгааныг тайлбарлаагүй



- Зээлийн ашиглалтын үйл ажиллагаанд хяналт сайн хийгээгүй
- Зээлийг орчны бүсийн малчин бус айл өрхөд олгосон (эдгээр нь “Байгальд ээлтэй малчны зээл”-ийн шалгуурыг хангаагүй, танил талаараа авсан зээл байсан)
- ОБЗЭС-ийн гишүүдэд зээл олгосон

### **Е. Улаан – Уул сум**

#### **Сайн туршлага**

- Тухайн сумын газар нутгийн онцлогоос шалтгаалан бэлчээр нэлээд хомсдолтой тул малчдын дунд бэлчээрийн маргаан маш их гардаг. ОБЗЭС-аас авсан зээлээрээ бэлчээрээ хашаалж маш сайн хамгаалсан байсан. Үүнээс шалтгаалаад малчдын хооронд гарах маргаан багассан талаар иргэд дурдаж байсан. Улаан-Уул сумын хувьд бэлчээр маш хязгаарлагдмал, өндөр сүрлэг уулсаар хүрээлэгдсэн тул малчдын дунд бэлчээрийг булаацалдаж маш их маргаан гардаг байсан. Хөндлөнгийн үнэлгээний баг талбарт ажиллах үеэр бэлчээрийг хамтаараа хашиж хамгаалсан өрхүүд олон байсан.
- Малын үүлдэр угсаа сайжирсан. Зээл авсан зарим малчдын хувьд өөр бүс нутгаас эцэг мал худалдаж авсан талаар дурдаж байсан. Ингэснээр малын чанар сайжирч бүтээгдэхүүний гарц нэмэгдсэн. Ингэснээр өрхийн орлогод эерэг нөлөө үзүүлсэн, зээлийн үйл ажиллагаанд сэтгэл ханамжтай байгаа талаар хөндлөнгийн үнэлгээний багт сэтгэгдлээ илэрхийлж байв.

#### **Сургамж, алдаа дутагдал**

- ОБЗ-өөс зээлийн асуудлыг түргэн шийдвэрлэж өгдөг хэдий ч Төрийн банкны хүний нөөцийн хүртээмжээс болоод зээл удаашралтай олгогддог. Төрийн банкны зүгээс зээлийг зориулалтын дагуу зарцуулж байгаа эсэхэд хяналт хийдэггүй. Төрийн банкны зүгээс орон тоо цөөн байдаг тул үйлчилгээ удаан хүрдэг. ОБЗ рүү төслөөс холбогдоод танай банкны үлдэгдэл их байна яагаад та нар зарцуулахгүй байна гэж байсан. Банкны тайлбар хүн хүч муу ганцхан энэхүү зээлийг судалдаггүй гэж хариу өгч байсан. Банк хүн авч болдог бол аваад хурдан шуурхай зээлийг өгөх хэрэгтэй гэж судалгаанд оролцогчид дурдаж байв.
- ОБЗ бол мэдээлэл хүргэх тал дээр бүх л боломжит хувилбарыг сонгодог. ОБЗ бүгд төрийн албан хаагч нар байдаг. Иймээс давхар зөвлөлийнхөө ажлыг хийхэд цаг хүрэлцдэггүй. Эдгээр хүмүүс энэ чиглэлээр мэргэжлийн бус хүмүүс тийм учраас зөвлөл дотор энэ мэргэжлээр дагнаж, зөвлөлийнхөө данснаас цалинжаад тухайн ажлаа хийдэг өөр төрлийн ажилд анхаарал хандуулдаггүй болно. Бусад нь бол удирдлагаа юм уу чиглүүлэх ажлаа хийгээд явах 1 хүн тогтмол хяналт тавьж малчидтайгаа харьцаж байх шаардлагатай.
- Зээлийн мөнгөө дахин өөр нэг өрхөд хүүтэй дамжуулан зээлдсэн нэг тохиолдол илэрсэн.
- Багийн дарга нараар дамжуулан зээлийн талаар мэдээлэл өгдөг. Харин багийн дарга нарын танил тал зээл авсан тохиолдлууд нэлээдгүй тохиосон. *“Танилын хүрээнд зээлээ олгоод байгаа санагдсан. Зээл олгох бүрэн боломж байсан. Хаан банкнаас байнга зээл авдаг ч ямар нэгэн зээлийн асуудал байгаагүй. Тухайн үед*

*энэ зээлд хамрагдах хүсэл их байсан ч авч чадаагүй талаар зээл авахаар материалаа өгсөн ч авч чадаагүй оролцогч сэтгэгдлээ илэрхийлж байсан.”*

- ОБЗ зээлийн хүүгийн орлогоо хэрхэн ашиглах талаар мэдээлэл маш муу. Төрийн банк ОБЗ хоорондын холбоо муу мэдээлэл гаргаж өгдөггүй, цааргалсан байдалтай байдаг. Хүүгээс орж ирсэн орлогын бага хувийг зарцуулсан. Ихэвчлэн урамшуулал хурлын зардалд зарцуулсан. Байгаль орчинд зарцуулах мөнгөө ажил хийгдээгүй учир зарцуулаагүй байна. Хүүгийн орлогын зарцуулалтын талаар анх ийм үйл ажиллагаандаа зарцуулна гэдэг мэдээлэл өгч байсан. Тэрнээс хойш төслөөс мэдээлэл өгөөгүй байв.
- Энэ сум үндсэн 6 багтай. 6 баг нь бүгд тусгай хамгаалалттай газар нутагт байрладаг. Харин 3 баг нь Орчны бүсэд байршдаг учраас зээлд хамрагдах шаардлага хангасан. Үүнд үлдсэн 3 багийн малчид бухимдалтай хандаж байсан. Энэ талаар бүлгийн ярилцлагад оролцогчид Шивлэг баг хамаардаггүй учир бүх багийг эрх тэгш хамруулах хэрэгтэй. Жинхэнэ Хорьдол Сарьдгийн бүсэд амьдардаг иргэд хамрагдаж чаддаггүй хэмээн дурдаж байсан.
- Энэ сумын малчид маш алслагдмал газар байрладаг тул мал, малын гаралтай бүтээгдэхүүнээ зах зээлд нийлүүлэн орлогоо сайжруулах боломж хязгаарлагдмал.
- Тус сумын ОБЗ-ийн гишүүд бусад сумын ОБЗ-ийн үйл ажиллагаатай танилцаж, туршлага судлах хүсэлтэй байсан.
- Оролцогч талууд гэрээ болон удирдамжийн талаар мэдээлэл муу, сайтар уншиж танилцаагүй байсан.



Судалгаа, зөвлөх үйлчилгээний “Эс Ай Си Эй” ХХК боловсруулав.

Хаяг: Монгол Улс, Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8-р хороо,  
Ж.Самбуугийн гудамж, Блю Мон оффис, 7 давхар

Утас: +976 7012 6009